ЗОНХАВА ЛУВСАНДАГВА

ИХ БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ

Улаанбаатар 2006 он

Монголын Бурханы Шашны Төв-Гандан Тэгчэнлин Хийд
Өндөр Гэгээн Занабазарын нэрэмжит Монголын Бурхан Шашны Их Сургууль
Азийн Буддистуудын Энхтайвны Бага Хурал

ЗОНХАВА ЛУВСАНДАГВА

ИХ БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ



II дэвтэр
(Их төрөлхтний мөр)

Улаанбаатар 2006 он

"Цастын орны мэргэдийн оройн чимэг хэмээн алдаршсан Зонхава Лувсандагва (1357-1419) богдын туурвисан "Их бодь мөрийн зэрэг" хэмээх энэ их бүтээл нь "Гурван төрөлхтний мөр" буюу хүний оюун ухааны гурван их үе шатаар дамжуулан сэтгэл оюуны гэгээрэхүйн их хутагт хүрэх арга замыг Бурхан Буддхагийн заасан гэгээн үзэл онол, явдал мөрийн суртгаалд үндэслэн Хутагтын орны мэргэд дээдсийн оюуны бүтээлийн охь шимээр баяжуулан, хүний оюуны хөгжлийн дээд шатанд хүрэх арга замыг арга билгийн үүднээс тодорхойлон тайлбарласан гүн ухаан, оюун сэтгэлгээ, анхааран авах бясалгалын аньс шимийг хураасан оюуны их бүтээл бөлгөө"

Copyright © Т.Булган 2006
All rights reserved
No part of this work may be reproduced by any means without the priority written permission of the publisher

"Их бодь мөрийн зэрэг"

Түвд хэлнээс орчуулсан: доктор (Ph.D) Т.Булган
Ариутган шүүсэн: гавж Ө.Гүндсамбуу
гавж Д.Цэрмаа
Эрдэм шинжилгээний зөвлөх:
доктор, профессор Г.Лувсанцэрэн
Техник редактор: З.Эрдэнэжаргал
Компьютерт оруулж, хянасан: Э.Болор
Компьютерт эхийг бэлтгэсэн: С.Адъяа

ISBN

Хэвлэлийн эхийг "Нью Майнд" ХХК-д бэлтгэв. 2006 он

Агуулга

Өмнөх үг I
III. Их төрөлхтний мөрийн зэрэгт оюунаа судлах 1
(Ерөөхүйн бодь сэтгэлийг судлах ба бодисадвын явдалд суралцах ерөнхий ёсон)
А. Их хөлгөнөө орох үүд нь зөвхөн бодь сэтгэл болохыг үзүүлэх 3
Б. Энэхүү сэтгэлийг хэрхэн төрүүлэхийн ёсон 9
1. Ямар шалтгаанд шүтэж хэрхэн төрөх 9
2. Бодь сэтгэлийг судлахын зэрэг 11
а. Жову Атиша гэгээнээс дамжсан шалтгаан ба үрийн долоон увдис 12
1) Эрэмбэ зэргийг танин барих 12
а) Нигүүлсэхүй сэтгэл нь их хөлгөний язгуур болох 12
(1) Эхэнд их хэрэгтэй болох нь 12
(2) Дунд их хэрэгтэй болох нь 12
(3) Эцэст их хэрэгтэй болох нь 13
б) Бусад шалтгаан, үрүүд нь түүний шалтгаан, үр болох ёсон 14
2) Зэрэгчлэн бодитой суралцах 16
а) Бусдын тусыг чухалчлах ухаанд суралцах 16
(1) Тэрхүү сэтгэл төрөхийн суурь тавих 17
(а) Тэгш сэтгэлээр амьтанд хандах 17
1/ Эх хэмээн бясалгах 18
2/ Ачийг санахуйг бясалгах 19
3/ Ачийг хариулахуйг бясалгах 19
(б) Сэтгэлд зохистойгоор амьтныг үзэх 21
(2) Тэрхүү сэтгэлийг бодитой төрүүлэх 22
(а) Асрахуй сэтгэлийг бясалгах 22
(б) Нигүүлсэхүй сэтгэлийг бясалгах 23
(в) Үлэмж сэтгэлийг бясалгах 26
б) Бодь хутгийг чухалчлах ухаанд суралцах 26
в) Суралцсаны үр – Бодь сэтгэлийг бодитой танин барих 27
б. Бодисадва Шантидэва гэгээний номоос гарснаа шүтэж суралцах 27
1) Өөр бусдыг сольж бясалгахын тус эрдэм ба сольж бясалгаагүйн гэм 28
2) Түүнд дадаж сурваас төрүүлэх чадал 29
3) Өөр, бусдыг солих талаарх гэмийг арилгахад бодитой бясалгах ёсон 30
3. Төрөх хэмжээ 35
4. Зан үйлээр авах ёсон 35
а. Олоогүйгээ олж үйлдэх 36
1) Авах орон алин 36
2) Авах шүтээн алин 36
3) Хэрхэн авах зан үйл 36
а) Бэлтгэл ажил 36
(1) Ялгамжтай аврал одуулах 37
(а) Орноо чимэж шүтээнээ дэлгээд тахилын идээг бэлтгэх 37

(б) Соёрхол талбин авралыг одуулах 38
(в) Авралыг одуулах суртгаалыг өгүүлэх 39
(2) Буяныг хураах 39
(3) Сэтгэлээ судлах 39
б) Бодит зан үйл 39
в) Төгсгөлийн зан үйл 41
б. Олсноо үл доройтуулан сахих 41
1) Энэ насанд бодь сэтгэлээ үл доройтуулах шалтгаанд суралцах 41
а) Бодь сэтгэлд дурлах сэтгэлийг хүчтэй арвижуулахын тулд тус эрдмийг санан суралцах 41
(1) Орны дээд болох талаар 41
(2) Хорлолгүй буяныг огоот барих талаар 42
б) Тэр сэтгэлийг бодитой арвижуулахын тулд зургаан удаа үүсгэн суралцах 43
(1) Ерөөхүйн сэтгэлийг үл орхих 43
(2) Арвижуулахуйд суралцах 45
в) Юуны тухайд ч бодь сэтгэлийг амьтныг сэтгэлээр үл тэвчихэд суралцах 45
г) Бинавадын болон билгэ билгийн буяны чуулганыг хураахад суралцах 45
2) Бусад төрөлд ч үл хагацах шалтгаанд суралцах 45
а) Доройтуулан үйлдэгч дөрвөн хар зүйлийг тэвчих 45
б) Үл доройтуулагч дөрвөн цагаан номонд суралцах 48
в. Доройтуулваас жич засахын арга 49
В. Бодь сэтгэлийг эгүүсгээд бодисадвын явдал мөрд суралцах ёсон 53
1. Бодь сэтгэлийг төрүүлчихээд суртгаалд суралцах хэрэгтэйн учир шалтгаан 53
2. Нижгээд нижгээд арга билигт суралцсанаар бурхан болохгүйг үзүүлэх 54
3.Суртгаалд суралцахын эрэмбэ зэргийг номнох 64
а. Их хөлгөнөө ерөнхий суралцах ёсон 65
1) Бодисадвын суртгаалд суралцах хүслийг төрүүлэх 65
2) Хүсэл төрсний дараа бодисадвын санваар авах 65
3) Санваар аваад хэрхэн суралцах ёсон 66
а) Суртгаалын суурь алин 66
б) Түүнээ суртгаалууд хурах ёсон 66
(1) Бодит тооцоо учир (ялгалууд) 66
(а) Өндөр язгуурт харгалзах тооцоо 66
(б) Тиймд хоёр тусыг бүтээхэд харгалзах тооцоо 67
(в) Хамаг их хөлгөн бүгд хурахад харгалзсан тооцоо 69
(г) Хамаг мөр болон арга бүгдийн эрхэт болох тооцоо 69
(д) Гурван суртгаалд харгалзах тооцоо 70
(е) Амьтныг боловсруулах болон даган зохилдохын эрхнээ үйлдэх тооцоо 71
(2) Дашрамд эрэмбэ зэргийг танин барих 71
(а) Төрөхийн эрэмбэ 71
(б) Дээд, доод эрэмбэ 72
(в) Бүдүүн, нарийн эрэмбэ 72
в) Түүнээ хэрхэн суралцах ёсон 73
(1) Ерөнхий явдалд суралцах ёсон 73

(а) Өөрийн үндсийг бурханы номонд боловсруулах барамидад суралцах 73
1/ Өглөгт суралцах ёсон 73
а/ Өглөгийн мөн чанар 73
б/ Түүний төрүүлэх арга 74
в/ Өглөгийн тийн ялгал 79
/1/ Хамаг шүтээн бүгдээр хэрхэн үйлдэх 79
/2/ Шүтээн тус бүрт харгалзах тийн ялгал 80
/3/ Өглөгийн мөн чанарын тийн ялгал 80
/а/ Номын өглөг 80
/б/ Үл аюух өглөг 80
/в/ Эд өлгийн өглөг 81
1' Эд өлгийг бодитой өгөх өглөг 81
а' Эд өлгийг өгөх ёсон 81
1" Өглөгийн орон алин 81
2" Өгөх сэтгэл алин 81
а" Ямар санаатай байх вэ? 81
б" Ямар санааг тэвчих хэрэгтэй вэ? 82
3" Хэрхэн өгөх үйл ажил 84
а" Ямар зүйлүүд өглөг болохгүй вэ? 84
б" Ямар байдалтай өгөх 84
4" Бодит өглөг өгөх алин 85
а" Өгөх, эс өгөх бодит юмсыг хураангуйлан үзүүлэх 85
б" Дэлгэрэнгүй номнох 85
1* Дотоод эд зүйлээ өгөх ба эс өгөх 86
а* Цагийн үүднээс үл өгөх 86
б* Хэрэг шаардлагатай үүднээс үл өгөх 86
в* Гуйлгачны зүгт өгч болохгүй зүйл 87
2* Гадаад эд зүйлээ өгөх, эс эсэхийг дэлгэрэнгүй номнох 87
а* Гадаад зүйлээ эс өгөх ёсон 87
1** Цагийн үүднээс эс өгөх нь 87
2** Өгөх зүйлийн үүднээс өгч болохгүй нь 87
3** Шүтээний үүднээс өгч болохгүй нь 88
4**Бодит зүйлийн талаас өгч болохгүй нь 89
5** Хэрэгтэй үүднээс өгч үл болох нь 89
б* Гадаад зүйлээ өгөх ёс 90
б' Өгч эс чадваас хэрхэх ёсон 91
в' Өглөгт тотгорлох ерөндөгийг шүтэх 91
1" Үл дадах 91
2" Доройтох 92
3" Шунах 92
4" Үрийг үл үзэх 92
2' Санаа төдийгөөр өгөх 92

г/ Тэдгээрийн утгын хураангуй 93
2/ Шагшаавадын чинад хүрэхүй (барамид)-д суралцах 94
а/ Шагшаавадын (ёс суртахуун) мөн чанар 94
б/ Түүнийг бясалгалд орох арга 95
/1/ Сүрэгнэж сахихгүйн гэм эргүү 95
/2/ Сүрэгнэж сахихын тус эрдэм 95
в/ Шагшаавадын тийн ялгал 98
/1/ Боомтлох шагшаавад 98
/2/ Буяны номыг хураах шагшаавад 98
/3/ Амьтны тусыг үйлдэх шагшаавад 98
г/ Тэдгээрийг бүтээхийн үест хэрхэн үйлдэх 99
д/ Тэдгээрийн утгын хураангуй 99
3/ Тэсвэрлэхүйн чинад хүрэхүйд суралцах 101
а/ Тэсвэрлэхүйн (тэсэхүй) мөн чанар 101
б/ Түүнийг бясалгахаар орох арга 102
/1/ Тэсвэрийн тус эрдэм 102
/2/ Уурлахын гэм эргүүг үл мэдэхийн гэм нь 103
в/ Тэсвэрийн ялгал 107
/1/ Хорлол үйлдэхэд юунд ч үл тоох тэсвэр 107
/а/ Хорлогч хорлол үйлдэхэд үл тэсэх байдлыг хориглох 107
1' Амгаланд тотгорлож зовлонт болоход үл тэсэхийг хориглох 108
а' Уурлах зохисгүйг үзүүлэх 108
1" Орныг шинжвээс уурлах зохисгүй 108
а" Түр зуурын юм уу, төрөлхийн араншин алин болохыг шинжилж эс зохистой болох нь 110
б" Бодитой болон далдын аливаа хорлолыг шинжээд эс зохистой болох нь 110
в" Хорлолд хүргэх уг үндсийг шинжилж уурлах зохисгүй болох нь 111
2" Орнтыг шинжвээс уурлах зохисгүй 112
3" Шүтээнийг шинжвээс уурлах зохисгүй 112
б' Энэрэх нигүүлсэх зохистойг үзүүлэх 113
2' Өргөн хүндлэл зэргийг тотгорлож басамжлал тэргүүтэн гурвыг үйлдэхэд үл тэсэхийг хориглох 114
а' Магтаал тэргүүтэн гуравт тотгор болоход үл тэсэхийг хорих 114
1" Магтаал зэргүүд тус эрдэм байхгүй ёсыг санах 114
2" Гэмтэй болохыг санах 114
3" Тиймээс тэдгээрийг хорихдоо баясах 115
б' Басамжлал тэргүүтэн гурвыг үйлдэхэд үл тэсэхүйг хорих 115
/б/ Хорлол үйлдэх бэлтгэл ажилд үл баясах ба доройтоход үл баясахыг хориглох 117
/2/ Зовлонг аян зөнд нь авах 119
/а/ Зовлонг ая зөнд нь магадтай авах хэрэгтэйн шалтгаан 119

/б/ Түүнийг төрүүлэх арга 120
1' Зовлон гарахад ерөөс баясахгүй байхыг хориглох 120
2' Зовлонг зөнд нь авах зохистойг үзүүлэх 120
а' Зовлон өөрийн эрдмийг санах тав 121
б' Зовлон бэрхийг давагч тэсвэрийн тус эрдэм 121
1" Нирваан тэргүүтэн их тус эрдэмтэйг санах 121
2" Хэмжээлшгүй зовлонг буцаах тус эрдмийг санах 122
в' Багаас нь дадуулбал үл зовохын ёсон 122
/в/ Суурийн үүднээс дэлгэрэнгүй номнох 123
1' Орноо шүтэх нь 123
2' Ертөнц номонд шүтэх нь 123
3' Явдал мөрийг шүтэх нь 124
4' Номыг огоот барихад шүтэх нь 124
5' Гуйлгачингийн амьжиргааг шүтэх нь 124
6' Илт хичнээн алжаалыг шүтэх нь 124
7' Амьтны тусыг үйлдэхэд шүтэх нь 124
8' Даруйдаа ажлыг шүтэх нь 124
/3/ Номыг магадлах сэтгэлийн тэсвэр 125
г/ Түүнийг бүтээхээр хэрхэн үйлдэх 125
д/ Тэдгээрийн утгын хураангуй 125
4/ Хичээхүйн чинад хүрэхүй (барамид)-д суралцах 126
а/ Хичээхүйн (хичээнгүй) мөн чанар 126
б/ Түүнээ бясалгахаар орох арга 126
в/ Хичээхүйн тийн ялгал 128
/1/ Бодит тийн ялгал 128
/а/ Хөө хуягийн хичээхүй 128
/б/ Буяны номыг хураах хичээхүй 129
/в/ Амьтны тусыг үйлдэх хичээхүй 129
/2/ Хичээнгүйг төрүүлэх арга 130
/а/ Хичээхүйн тотгор буюу харшлах шалтгааныг тэвчих 130
1' Үл зохилдох зүгийг танин мэдэх 130
2' Түүнийг тэвчихийн аргыг үзүүлэх 131
а' Олох зүйлдээ хойргошихыг хорих 131
б' Түүнийг олохын арганаа хойргошихыг хорих 133
в' Хаана оршивч бүтээхийн орноос мятрахыг хорих 135
/б/ Зохилдох шалтгаан буюу өмөг буяны чуулганыг хураах 138
1' Сүсэглэх хүч 138
2' Батдах хүч 139
3' Баясах хүч 142
4' Орхих хүч 144
/в/ Эл хоёр түшиж хичээхүйг ая зөнд нь бүтээх 144
/г/ Түүнээ шүтэж бие, сэтгэлээ эдлэхүүн (эзэмших) болгох ёсон 148
г/ Бүтээхийн үест хэрхэн үйлдэх 148
д/ Тэдгээрийн утгын хураангуй 148

5/ Бясалгал (самади)-ын чинад хүрэхүйд суралцах 150
а/ Бясалгалын мөн чанар 150
б/ Түүнийг бясалгахаар орох арга 150
в/ Бясалгалын тийн ялгал 150
/1/ Чадлын үүднээс ялгаваас энэ насандаа бие, сэтгэлийг амар байлгагч бясалгал 150
/2/ Эрдмийг илт бүтээгч бясалгал 150
/3/ Амьтны тусыг үйлдэгч бясалгал 150
г/ Бүтээхийн үест хэрхэн үйлдэх 151
д/ Тэдгээрийн утгын хураангуй 151
6/ Билгийн чинад хүрэхүйд суралцах 152
а/ Билиг ухааны мөн чанар 152
б/ Түүнийг төрүүлэхээр орох арга 152
в/ Билгийн тийн ялгал 162
/1/ Үнэмлэхүйг онох билиг 162
/2/ Янагуухийг онох билиг 162
/3/ Амьтны тусыг үйлдэхийг онох билиг 162
г/ Бүтээх үед хэрхэн үйлдэх 162
д/ Тэдгээрийн утгын хураангуй 162
(б) Бусдын үндсийг боловсруулах дөрвөн хураангуйд суралцах 164
1/ Дөрвөн хураангуйн мөн чанар 164
2/ Дөрөвт хураахын учир шалтгаан 164
3/ Дөрвөн хураангуйн чадал 165
4/ Нөхдийг хураасан тул тэднийг шүтэх хэрэгцээ 165
5/ Өчүүхэн дэлгэрэнгүй өгүүлэх 165
(2) Ялгавартай сүүлийн хоёр барамидаа суралцах ёсон
б. Ялангуяа Очирт хөлгөнөө суралцах ёсон

Хавсралт 171

Түвд эх

Ном зүй

Зарим үгийн тайлбар

Ерөөлийн үг

ИХ БҮТЭЭЛИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХҮЙ

ӨМНӨХ ҮГ

Аливаа мэдэгдэхүүн бүхэнд төрвөл үгүй Зөөлөн эгшигт
Асар хязгаарлашгүй амьтны эх болсон Нүдээр үзэгч
Атгагт шимнусын өмөг хоцрол үгүйг даран зохиогч Нууцын эзэн
Авралт гурван язгуурын мөн чанар Богдын гэгээнээ мөргөмү ①

(Цахар гэвш Лувсанцүлтим)

Оршихуйн "Цагийн хүрдэн" орчилдон эргэсээр нэгэн мянганыг үдэж нэгэн шинэ мянганыг угтав хэмээн хүмүүн төрөлхтөн хотлоор догдлон баяснам.

Зөвхөн өнгөрсөн зуунд гэхэд хүн төрөлхтөн хүн нийгмийн хөгжил дэвшилд их буян, их амгалан жаргаланг бүтээсэн гэдэгтэй хэн ч маргахгүй билээ л. Гэвч хүн төрөлхтөн тэргүүтэн эх болсон зургаан зүйл хамаг амьтан хичнээн зууныг элээж, хичнээн ч мянганыг угтавч, орь ганц хүсэл эгээрэлд хүлэгдэж ирснийг "Хамаг амьтан ялгалгүй бүгдээр, зөвхөн жаргахыг хүснэ. Хэн ч зовохыг үл хүснэ" хэмээн дээдэс зарлиглажээ.

Тийм ээ, өнөөдөр шинэ зуун, шинэ мянганы босгыг алхсан хэдий ч тэрхүү мөнхийн гэмээр, хүн төрөлхтний хүсэл эгээрэл урьдын адил хэвээрээ л байна. Гэвч тэрхүү мөнхийн гэмээр хүсэл эгээрэл болсон жинхэнэ аз жаргал, энх амгалан амьдрал сайн сайхан бүхэндээ хүрч чадав уу?

Хүн төрөлхтөн анх үүсэн бий болсон тэр цагаас хойш мөн түүний дараа туулсан хөгжил түүхийн олон янзын үе шат, орон зай, цаг хугацаа хангирсах тусам материаллаг эд баялгийн буюу техник технологийн өндөр хөгжлийн ач тусаар зүйрэлшгүй хөгжил дэвшлийн их амжилтанд хүрсэнтэй хэн ч маргахгүй.

Үүний дээр энэхүү шинэ зууны гараан дээр хүн төрөлхтний оюун санаа, сэтгэлгээ, шинжлэх ухаан танин мэдэхүйн өндөр хөгжлийн ачаар, цахим техник, мэдээллийн их сүлжээ, даяарчлалын их үйл явц зэрэг урьд өмнө байгаагүй хүний нийгмийн хөгжлийн өндөр төвшинд хүрчээ.

① *Цахар гэвш Лувсанцүлтим "Богд Зонховын намтар" (Д.Цэрэнсодном, Д.Нарантуяа нарын крилл бичигт хөрвүүлсэн. УБ 2004 он 128-р тал)*

Гэвч нөгөө талаас харвал хүний төрөлхтний зовлон хэвээрээ л байх шиг. Өвчин зовлон, үгүйрэл хоосрол, дайн дажин, цөмийн дайны аюул занал, байгалын гай гамшиг, хүрээлэн байгаа сав шим ертөнцийн тэнцвэргүй байдал, баян ядуугийн ялгарал, тогтворгүй хөгжил гээд олон зүйлийн шийдвэрлэх ёстой асуудалтай бид яг энэ мөчид тулгарсаар байна.

Бас нэг дурдахгүй өнгөрч болохгүй хүн төрөлхтний өмнө тулгараад байгаа нэг аймшигт зовлон бол олохуй яа бэрх эрдэнээс илүү үнэтэй хүний амь насыг тэр тусмаа гэм зэмгүй энгийн иргэдийн амь насыг хөнөөх "аллага хядлага" хэмээх аймшигт нүгэлт явдал энэ шинэ зууны эхэн дээр бүр гааран хамаг амьтны энх амгалан амьдрал, дэлхий ертөнцийн хөгжил дэвшлийн замд бодит аюул занал учруулах болов. Бурхан багш бээр алтнаас илүү үнэтэй амьтны амийг хөнөөх гэдэг ямар аймшигтай нүгэл болохыг басхүү тийм хүнд нүглийг үйлдэхгүй тэвчиж явахыг эрхэмлэн захиж, энэрэн нигүлсэхүйн сэтгэлээр эгнэгт амьтныг хайрлаж байх учиртайг:

Аяа, Хаан та амьтны амийг бүү бүрэлгэхтүн ②
Амь нас гэдэг амьтан бүхнээ хамгийн эрхэм буюу
Ашид мөнх амьдрахыг хэн хүн хүсэх аваас л
Алин байдгаараа амь таслахыг ер бүү санагтүн хэмээн айлдсан буй.

Мөн мэргэд дээдэс Бурхан багшийн ном сургаалын мөн чанар, утга агуулгыг олон талаас нягтлан тодорхойлсон байдгаас нэгийг дурдваас,

Элдэв муу хилэнц нүглийг үл үйлдэх ба ③
Эрхэм сайн буяны чуулганыг хотол хурааж
Өөрийн сэтгэлээ гэгээрүүлэх явдал болвоос
Өнөөх бурханы ном болно хэмээсэн буй.

Энэ бүх аюулаас ангижрах оюун ухаан, сэтгэл санаа, чадал боломж хүн төрөлхтөнд бий. Түүнийгээ олж нээж амьдралд зөв хэрэгжүүлснээр, зөв хөгжүүлснээр л бид өнө мөнхийн хүсэл эгээрэл болсон эрхэм дээд аз жаргалдаа хүрнэ гэдэгт эргэлзэх юун.

Чинхүү энэ л хүсэл эгээрлийг хангахын төлөө, эдүгээгээс хоёр мянга хагас илүүтэй жилийн өмнө Буддха (МТӨ-VI зуун) буюу Бурхан багш хэмээх олноо алдаршсан нэгэн бээр хутагтын орон Энэтхэгт хамаг амьтныг үл хүсэх зовлонгоос гэтэлгэх болон үргэлжийн мөрөөдөл болсон тэрхүү их амгалан жаргалд хүрэх мөр болсон "гэгээрэхүйн хутагт зорчих бодь мөр"-ийн эрхэм зарлигаа эх болсон хамаг амьтны тусын тулд айлдсан гэдэг.

② *Төвд Ганжуур "Олон судрын аймаг" 199-р тал*

③ *Дхармапада "Винайн аймаг" 1963 он Коломба*

Гэвч дээд мэргэдийн айлдсан ном суртгаал нэгэн хэрэг гэх ч бий. Харин түүнийг анхааран авч амьдрал ахуйдаа тухайлбал, өөрийн сэтгэлдээ тогтоон суулгах гэдэг түүнээс эрхэм нэгэн билээ.

Чухам үүнийг Монголын их эрдэмтэн лам Агваан Ишсамбуу бээр:

Энэ нас ахар, мэдэх зүйл их буй
Үхлийн эзэн хэзээ ирэхийн болзоогүй тул
Эрхэм зарлиг бүхний үг, утгыг хуйлруулсан гол ном
Энэхүү бодь мөрийн зэргийг анхааран суралцахыг хичээсүгэй (4)
хэмээн айлдсан буй.

Золгон буй шинэ мянганд ч хүн төрөлхтний хүсэл эгээрэл урьдын адил хэвээр үргэлжлэх нь дамжиггүй. Харин түүнийг биелүүлэхийн тулд тэрхүү гэгээн зорилгодоо хүрэхийн тулд хүний нийгмийн хөгжил, дэвшлийг хангах олон талын эрдэм ухааныг шинжлэн судалж, суралцах хэрэгтэй болж байна. Үүний нэг нь "Оюуны хөгжил, оюуны тогтвортой хөгжил"-ийн асуудал чухлаар шаардагдаж байгааг дэлхийн ухаантан мэргэд олонтаа зарлиглах болов.

Тэрхүү оюуны хөгжлийн хэрэгцээг адбиш хангахад Бурхан багшаас үндэслэн дамжиж түүний шавь эрдэмтэн мэргэдийн ухаанаар "Оюуны хөгжлийн дээд шат гэгээрэхүйн хутагт хүрэх арга замын увдис" болон дэлгэрсэн "Бодь мөрийн зэрэг" хэмээх эл ухаан тус болно хэмээн санаж Зонхава Лувсандагва буюу Сумадигирди Богдын (1357-1416) туурвисан "Их Бодь мөрийн зэрэг" хэмээх агуу увдис бүтээлийг орчуулан эрхэм уншигч танаа толилуулж байна.

"Эрдэнэт сайхан галбирваас модны дэргэд илч шимгүй зэгс суулгасан мэт" хэмээсэн адилаар өтөл өчүүхэн миний бие ухаж онохын чадал мөхөс, оносон гэвч буруу талаас ухаарах, эсвээс тээнэгэлзэх сэжиглэх зэргийн өөрийн гэм буруугаас шалтгаалж дээдийн номын гүн утгыг эндүү ташаа буулгасан вий гэж ихэд эмээж хүлцэл өчнөм. Эрхэм та бүхэн эхийн энэрэнгүй сэтгэлийн, эцгийн уужим ухаанаа ач буянтай санал зөвлөгөө юүгээн хайрлаарай.

А. Богд Зонхавын намтрын хураангуй

Хамаг Ялгуусан бүгдийн айлдал, энэрэл, чадал гурван эрдмийн мөн чанар болсон, Гурван язгуурын бурханы хувилгаан, Цаст Төвдийн мэргэдийн оройн чимэг, Хоёрдугаар ялгуусан Богд Зонхава Лувсандагва

(4) *"Зүрхэнд хадгалваас зохист үг хэмээгдэх захиас суртгаал оршвой" (гар бичмэл 7 тал)*

(1357- 1419) хэмээн алдаршсан энэ их хүний намтар цадиг, зохиол бүтээл, шашин амьтны төлөөх үйлс хэрэг нь санаанд багташгүй гайхамшигт их бөлгөө.

Монголын их эрдэмтэн Цахар гэвш Лувсанцултим тэргүүтэн олон дээдэс мэргэдийн туурвисан Богд Зонхава ламын гайхамшигт намтар цадиг зэргийг түшиж, Их богдын намтраас товч хураангуйлан өгүүлсүгэй.

Бидний бурхан багш Шагжамуни цагаан мичин жилд хувилж төрөөд хорин есөн насны шар хулгана жилд тойн болж зургаан жил болтол бясалгал бүтээлийг үйлдэв.

Гучин таван насны хөх морин жилийн дөрвөн сарын арван тавнаа илт туулж Бурхан болоод мөн тэр жилийн зургаанаа анх эхэлж олон амьтанд ном номлов. Шагжамуни шашин гарах эх нь тэр буй.

Тэр морин жилээс хоёр мянга хоёр зуун наян жил төгсөөд, Төвдийн Амду нутгийн Зонха хэмээх газарт эцэг Лүмбүмгэ, эх Шинса Ачой нарын хөвгүүн болж 6 дугаар жарны улаагчин тахиа жилд (1357) Зонхава гэгээнтэн хувилж мэндэлжээ. Гурван настай байхдаа Монголын Тогоонтөмөр хаан Гармава Ролбидорж хэмээх ламыг залах үеэр гэгээн багштай учирч гэнэн сахил хүртжээ. Долоон насандаа цорж Дондүврэнчин ламаас гэцэл сахил хүртэн багшийн дэргэд бараа болж олон ном хүртэв. Сахилын алдар Лувсандагва (санск: Сумади Гирди) хэмээн алдаршжээ.

Арван долоон настайдаа Төвдийн Үй зан зүгт морилж Дэважин хийд зэрэгт саатаж Сажийн их багш Рэндава, Ёндонжамц лам, Нябо лам тэргүүтэн олон багшаас судрын аймгийн олон эш номыг сонсож судлав. Мөн Чонба лам, Чойжибал лам тэргүүтнээс тарнийн аймгийг сонсож судлав. Бас бус олон лам нараас судар дандарын ном цаглашгүй олон зүйлийг сонссоноор мэргэд бүхний оройн чандмань мэт болжээ. Хорин дөрвөн наснаа Цүлтимринчэн ламаас аяга тахимлагийн санваарыг хүртжээ.

Гучин зургаан сүүдэртэйдээ гэгээн эрдэм төгс найман шавийн хамт есүүл аглагт гараад, Жормүлүнгээс Олхад морилж судар тарни хослон барилдсан гүн мөрийг бясалган бүтээснээр үлэмж онолын эрдэмд төгс боловсорчээ.

Гучин есөн сүүдэртэйдээ Түвдийн Нялын Лүнра хэмээх газар номын хүрдийг эргүүлжээ.

Дөчин зургаан сүүдэртэйдээ (1402) "Ялгуусан бурхадын эрхэм зарлиг бүгдийн аньсийн хураангуй", "Хамгийг болгоогчийн газар зорчих дээд төрөлхтний номын ёс", "Гурван төрөлхтний бясалгалын зэргийг үлдээлгүй

хураагч" зэргээр ихэд алдаршсан, Буддын гүн ухаан, оюун сэтгэлгээ, бясалгалын бүтээлийн агуу их цогц тайлбар, гайхамшигт бүтээлүүдийн нэг болсон **"Их бодь мөрийн зэрэг"** хэмээх бүтээлээ туурвижээ.

Дөчин найман сүүдэртэйдээ (1405) "Түгээмлийн их эзэн бурхан Очирдарагийн мөрийн зэрэг, нууц бүхний утгыг сайтар ялгасан хэмээхүй" бурхан багшийн эрхэм зарлигийн манлайн дээд оргил болсон нууц тарнийн ёсны гайхамшигт их тайлбар, нэвтэрхий толь болох бүтээлээ туурвижээ.

Чингэж Их богд бээр зөвхөн дээрх хоёр "мөрийн зэрэг" бүтээлээрээ бурханы айлдсан хамаг судар тарнийн номын утгыг хойчийн шавь нар бээр үнэн зөвөөр анхааран авч судлах "Зүрхэн тайлбар"-ыг бүтээж үлдээсэн цаглашгүй их номын ачтан бөлгөө.

Тавин хоёр сүүдэртэйдээ Лхасын их чонпрүл ерөөлийг эхэлж хуруулжээ. Энэчлэн Гандан хийд тэргүүтэн хийд орон байгуулах, бурхан шүтээн бүтээх, хурал сургууль тогоох, ном бүтээл тууурвих зэргээр шашин амьтны тусыг агуу ихээр зохиожээ. Чингээд их Богд бээр 7 дугаар жарны шороон гахай жил (1419) шашин, амьтны тусын тулд дүрс лагшинаа хураах ёсыг үзүүлж жанч хальжээ. Тэрээр буддын мэдлэг ухааны олон салбараар олон зуун зохиол, бүтээл туурвисныг 19 боть болгон эмхэтгэсэн байна.

Түүний бүтээсэн хиргүй гэгээн номын энэ мөрийг эрдэмт сайн шавь нар болох Жалцав хайдүв тэргүүтэн болон үндэслэн баригч багш дээдэс, мэргэд, сүсэгтэн олон шавь нар, хүндлэн бишрэгч номч бүтээлчин зэрэг олон ардууд эдүгээ хүртэл тэтгэн дэлгэрүүлснээр зүг бүхнээ түгээмэл оршиж буй нь энэ болой.

Б. "Их бодь мөрийн зэрэг"-ийн товч агуулга

Богд Зонхава (1357-1419) бээр "Их бодь мөрийн зэрэг" хэмээх энэхүү бүтээлдээ нэгэн бодьгалийг гурван төрөлхтний мөрөөр дагуулан хөтөлж бурханы хутагт хүргэх арга замыг дэлгэрүүлэн айлдсан онцлогтой. Чингэхдээ бурхан багшийн үндэслэсэн гэгээрхүйн хутагт хүрэх билиг барамидын эрхэм зарлигууд болон түүнийг залгамжлан увидас дамжлагын эзэд Майдарын гэгээн, "Замбу тивийн чимэг", "Их тэрэгчин" хэмээн алдаршсан Нагаржуна Асанга, Адиша тэргүүтэн их мэргэдийн туурвисан тааллын тайлбар, их шастар номлолоор чимэглэн энэхүү увдисаа айлджээ. Тийм учраас эл увдис гурван төрөлхтний мөр хэмээн алдаршжээ.

Богд бээр энэхүү бүтээлээ туурвих өлзий учрал бүрдэх тэр үед ямар

гайхамшигт сонин бэлэг дэмбэрэл сүндэлсэн талаар Цахар гэвшийн намтарт: "Ялангуяа Радэнгийн дээд сүм Гүнбигүн хэмээхэд тэргүүн хэвийсэн их дүр хэмээн алдаршсан, Адишагийн гэгээн лүгээ дүрс бодат Жову Адиша лугаа их адистэдэт шүтээний өмнө олон хоног залбирснаар, Бурхан багшаас Намхайжалцан ламд хүртэл үндэслэсэн зарлиг увьдастний мөрийн зэргийн үндсэн лам нарыг илт үзэв.

Ялангуяа Жову Адиша, Бром багш, Бодова, Шарава нугууд сар болтол илтүзэгдэж увдис ба даган үзүүлэх нүгүүдийг олонтаа хайрлаад, сүүлд Бром багш тэргүүтэн гурвуул Жову Адишад шингэв. Адиша бээр Богд Зонхавын тэргүүн дээр талбиж бүрүүн, Шашанд үйлийг агуу их үйлдээд бодийг бүтээх ба амьтны тусыг үйлдэх нөхрийг би үйлдсүгэй хэмээн айлдаад, үл үзэгдэх болсон тэргүүтэн гайхамшиг тэмдэг олон болов.

Тэр цагт бодь мөрийн зэргийн үндсэн лам нарын залбирал "Дээд мөрийн хаалгыг нээгч"-ийг зохиов. Энэ үеийн урьдаас Гог хэлмэрч Лэгвийшарав ламын байгуулсан Санбо хийдийн лам Гончогцултим ба Жадолжаны хийд Цолбугийн ширээний лам Гончогбалсан лам тэргүүтэн Түвдийн лам нар мэргэд олон нугууд бээр хэдэнтээ дуртган айлтгасан бөгөөд энэ үед их хэлмэрч Жавцогбалсан-бэр их шамдлаар айлтгасан ба Жову Адишагийн гэгээн адислах тэргүүтэн дээрхи сайн тэмдгүүд нийлсний тул бодь мөрийн зэргийг зохиосугай хэмээн айлдаад, ялгуусны сайн зарлиг бүгдийн оньсны хураангуй их тэргэний зам мэтийн журам гаргасан Нагаржуна багш ба Төрвөлгүй хутагт хоёр багшийн мөрийн журам, гурван төрөлхтний мөрийн үүднээс сайн хувьтныг бурханы хутагт удирдахын ёсыг дэлгэрэнгүйеэ номлосон их мөрийн зэргэ Ламрим чэнмо зохиов. Энэ ламрим нь ариун ном үйлдэхийг хүсэгч төгс хувьтанд гагц нүд мэт бөгөөд гурван ертөнцийн гагц наран мэт гайхамшигтайяа алдаршин дэлгэрсээр байх нь буй" хэмээсэн нь гайхамшигтай.

Чингээд гэгээрэхүйн дээд хутагт хүрэх гурван төрөлхтний мөрийг үзүүлсэн бодь мөрийн увдисын утгаас хураангуйлан өгүүлсү.

Ер Бурхан багш анхлан бодь сэтгэлийг эгүүсгэн улмаар буяныг хурааж эцэст илт туулсан бурхан хутаг олсон зэрэг эл бүгд зөвхөн хамаг амьтны тусын тулд үйлдсэн бөлгөө. Тиймээс түүний айлдсан зарлиг ном бүгдээр мөн л амьтны тус ямагтад зорьсон буюу. Тийнхүү бүтээх амьтны тус нь хоёр зүйл бөгөөд ахуй үест өндөр язгуур сайн төрлийг бүтээх ба эцэс хойдод тонилохуйн хутгийг бүтээх тустай билээ. Түүний дотроос ахуй үесийн өндөр язгуурыг бүтээхийн төлөө айлдсан ном зарлиг бүгд бага төрөлхтөн буюу бага төрөлхтөн лүгээ нийтийн номын аймагт багтана. Бага

төрөлхтнийг ухааны үүднээс гурав ялгах бөгөөд ялгамжаатай бага төрөлхтөн гэдэг энэ насны ажлыг ихэд чухалчлан хойд насны өндөр язгуур зэргийг чухалчлан түүнийг бүрдүүлэхээр хичээгч нэгэн болой.

Мөн Энэтхэгийн их бандида Жову Адиша (982-1054) “Бодь мөрийн зул” бүтээлдээ гурван төрөлхтний мөрийн мөн чанарыг тодорхойлон айлдсан буй.

Тонилохуй хутагт зовлонгоос тонилох төдийн хутаг болон хамгийг айлдагч бурханы хутаг хоёр буй ажээ. Сонсоод сонсогч (шарвака) болон Өөрөө ялгуугсадын (брадигабуддха) хөлгөнөөс эхлэн номносон зарлигласан бүгд бодит дунд төрөлхтөн буюу дунд төрөлхтөн лүгээ нийтийн мөрийн аймагт багтана. Дунд төрөлхтөн нь хамаг орчлонгоос уйдаж түүнээс тонилох хутгийг өөрийн тусад олж үйлдсүгэй хэмээн түүнд хүрэх арга зам болсон гурван суртгаалд суралцах болой.

Хамгийг айлдагч бурханы хутгийг бүтээх арганаа судрын болон нууц тарнийн хэмээх хоёр хөлгөнөө суралцах явдал багтана. Тэрхүү хоёр хөлгөнөө их төрөлхтний мөрд суралцан судлах ном суртгаал, анхааран авах зам мөр, хослон орох арга ухаан бүхэн хураагдах аж. Их төрөлхтөн болвоос их нигүүлсэхүй сэтгэлээр эзлэгдэн хамаг амьтны зовлон зүдгүүрийн мөн чанарт болохыг болгоон үл тэсэж улмаар тэрхүү зовлонгоос гэтэлгэхээр хамаг амьтны тусад бурханы хутаг олохоор судар тарнийн их зам мөрд суралцагч бас басхүү тэр зам мөрийг илт туулан төгссөн дээдэс мэргэд бөлгөө.

Нэг. Бага төрөлхтөн болон түүн лүгээ нийтийн мөрд суралцах :

Энэ үед үзүүлэх бага төрөлхтөн энэ насны ажлыг төдийлэн чухалчлах бус харин хойд насны өндөр язгуур буюу хойд насандаа сайн заянд төрөх арга ухаанаа эрхэмлэн суралцагч нэгэн билээ. Тэрээр хойд төрөлдөө сайн заянд очихын тулд эдүгээгээс эхлэн дараах бага төрөлхтөн болон бага төрөлхтөн лүгээ нийтийн мөр эрдэмд суралцаж тэдгээрээр оюунаа боловсруулах хэрэгтэй аж. Тэрхүү мөрд анхааран авах орныг дараах байдлаар Богд лам болгоожээ. Үүнд:

1. *Бодь мөрийн үндэс -Буяны садныг шүтэх*
2. *Чөлөө учралыг санах*
3. *Мөнх бусыг санах*

4. Муу заяаны зовлонг санах
5. Аврал одуулах
6. Үйлийн үрийг санах эдгээр болой.

Гэхдээ эдгээрээс эхний хоёр бодол нь дараа зэрэгчлэн бясалгах мөр бүхний өмнө зайлшгүй мөрдөгдөх бясалгал учраас удиртгал мөрд багтаан айлдсан байна.

Хоёр. Дунд төрөлхтний мөр ба түүн лүгээ нийтийн мөрд суралцах:

Дээрх бага төрөлхтний мөрийг анхааран авч суралцаж ухаарсны дараа дунд мөрийн эрдэм ухаанд суралцах нөхцөл бүрдэнэ. Энэ үед зөвхөн хойд төрлийн сайн заяаг олох гэж бодож байсан бодол зорилго өөрчлөгдөх буюу ер орчлонгийг ямар ч өндөр язгуур сайн төрөлд төрлөө аанай л эдлэх зовлон ав адилхан болохыг мэдэрч хорвоогийн амгалан сайн сайханд шунах сэтгэл буцаж ерөөс зовлонгүй амар жаргалтай байх тийм тонилохуй хутагийг (нирваан) эрэх хайх бодол засваргүй үнэнээр төрөх болно. Товчлон хэлбэл дунд төрөлхтөн бол өөрийн тусад нирваан хутгийг эгээрэгч болой.

Энэ үед хорвоог зовлонгийн мөн чанарт сайтар ухаарч түүнээс гарах арга замыг чухалчлах болно. Тийнхүү дунд төрөлхтний тонилохуй хутгийг бүтээх арга болгож "хутагтын дөрвөн үнэн"–ийг авч орхихуйн орон болгож бясалгадаг аж. Дунд төрөлхтөн лүгээ нийтийн мөрийг дараах үндсэн хоёр агуулгад багтаажээ. Үүнд:

1. Бухэн гарах зүг (орхих зүг) болон
2. Тийн амарлих зүг (авах зүг)-ийг нотлон буулгах.

1. Бүхэн гарахуйн зүг буюу орхих зүгт:
а. "Зовлонгийн үнэн"–хорвоогийн гэмийг санах
б. "Бүхэн гарахуйн үнэн"-хорвоод төрөхийн зэргийг санах (Мөн арван хоёр шүтэн барилдахуйн үүднээс санах)
2. Тийн амарлих буюу авахын зүгт:
а. "Хорихуйн үнэн"- тонилохуйн хутгийг олох ёсыг санах
б. "Мөрийн үнэн"- гурван суртгаалд суралцах ёсон эдгээр болой.

Гурав. Их төрөлхтний мөрд суралцах:

Чингэж бага болон дунд төрөлхтний мөрд суралцсаар ухааны хүч чадал улам дээш боловсорч ирнэ. Түүний гэрч нь үүнээс урьд зөвхөн өөрийн сайн сайхан тусын тулд өндөр дээд язгуур эсвээс нирваан хутгийг олсу гэж байсан бодол өдгөө өөрчлөгдөж тэр төдийхнийг чухалчлан явснаар бусдын тус байтугай өөрийн тус хэргээ ч бүтээж чадахгүй гэдгээ ухаарна.

Зөвхөн өөрийн тусыг чухалчлах төдийгээр сайн үр дүнд хүрэхгүйг лавтай ухаарах нь их төрөлхтний мөрд суралцах нэгэн нөхцөл болно. Үүний дээр ганцхан өөрөө зовох бус надтай адил энэ хорвоогийн хамаг амьтан зовлонгийн хүлээсэнд хүлэгдэн зовох жамыг ухааран хамаг амьтныг энэрэн нигүүлсэж хайрлах сэтгэл хамт төрсөн байх хэрэгтэй аж. Чингэж эдгээр нөхцлүүд бүрдсэний дараа их нигүүлсэхүй сэтгэлийн эрхэнд орсон бодьгаль эх болсон хамаг амьтныг зовлонгоос гаргахын тулд хамгийг болшоогч бурханы хутгийг олсу хэмээх эрхэм дээд зорилго бүхий бодь сэтгэлийг эгүүсгэснээр их төрөлхтний үүдээр орно хэмээжээ.

Их төрөлхтний анхааран авах мөрийг дараах эрдмийн ёсоор нотлон буулгажээ. Их хөлгөнөө суралцах ёсыг товчоолвоос:

а. Их хөлгөнөө орохуйн үүд – бодь сэтгэлийг эгүүсгэх
б. Бодисадвын явдалд суралцах ёсон

б. Бодисадвын явдалд суралцах ёсноо:

1. Их хөлгөнөө нийтэд суралцах ёсон
2. Ялангуяа нууц тарнийн хөлгөнөө суралцах болой.

1. Их хөлгөнөө нийтэд суралцах ёсонд

/а/ Өөрийн үндсийг боловсруулах "зургаан чинад хүрэхүйд" суралцах ба

/б/ Бусдын үндсийг боловсруулах "дөрвөн хураангуйд" суралцана.

Тусгайлан сүүлийн хоёр чанад хүрэхүйд суралцах ёсонд Амарлингуй сэтгэл болон Үлэмж үзэхүй хоёр болой. Эдгээрийн дараа нууц тарнийн хөлгөнөө орж суралцах бөгөөд энд өөрийн биеийг бурханы лагшинтай ялгалгүй болгож бясалгах "Эгүүсгэхийн зэрэг "болон өөрийн ухааныг бурханы таалал болгож бясалгах маш гүн нарийн егүзэр болох "Төгсгөхүйн зэрэг" нууц тарнийн мөрүүдэд шамдах болно. Гэхдээ нууц тарнийн ёс дээрх судрын ёсноос илүү нарийн гүн гүнзгий мөр тул дээрх ёсноос илүү чанд ёс суртахуун, дээд бодь сэтгэл, гүн нарийн оюун ухааныг

сав болсон цагт энэ суралцах үндэс бүрддэг байна.

Ийнхүү гурван төрөлхтний мөр хэмээх гэгээрэхүйн хутагт хүрэх энэ увдис нь хэдийгээр "гурван мөр" гэж үзүүлсэн боловч чухамдаа нэг л хүний ухааны мөрийг эгэл энгийн түвшингээс дээш дээш ахиулан хөгжүүлсээр оюун ухааны эрхэм дээд түвшинд хүргэх буюу бурханы хутаг олох нэг л замд хөтөлжээ. Чингэж гурван мөрөөр дагуулсан учир нь хөтлүүлэгч шавийн ухааны чадалд харгалзуулсан аж.

Их хөлгөний мөрд бага дунд болон нийтийн мөрүүд гишүүн болж багтах бөгөөд эцсийн зорилго, хүрэх газар бол зөвхөн гагц "хамгийг болгоогчийн хутаг" буюу "үл хөдлөх нирваан хутаг" ажээ. Хураангуйлан хэлвээс, "Их бодь мөрийн зэрэг" болвоос бурхан багшийн үндэслэн айлдсан бодь хутаг буюу гэгээрэхүйн хутагт хүрэх арга зам, билиг ухаан бүхнийг хүмүүний оюуныг боловсруулах гурван үе шатаар дамжуулан судалж шинжлэх нэг мөрд нэгтгэсэн, оюун ухааны өндөр хөгжлиийн мөн чанарыг арга билгийн үүднээс нотлон буулгасан судар тарнийн онол, бясалгалын их эрдмийг цогцлоосон оюуны охь шим бүтээлийн нэг бөлгөө.

В. Бодь мөрийн зэрэг ба Монголчуудын бүтээл

Богд Зонхава "Их бодь мөрийн зэрэг" хэмээх энэхүү их бүтээлээ эдүгээгээс зургаан зууны өмнө туурвисан хэдий ч Цаст Түвдийн орноос эх авсан түүний номын цагаан буяны их мөрөн өдгөө хүртэл үргэлжлэн зөвхөн Цаст Түвдөд төдийгүй энэ Замбу тивийн олон улс орны хүн ардын сэтгэл санаа, оюун ухааныг дээшитгэн тэтгэх нэгэн их ундрага болон иржээ.

Үүний нэгэн гэрч нь зөвхөн энэ бүтээлийн талаар Цаст Түвдийн болоод бусад улс орны цаг цагийн их мэргэд дээдсийн туурвиж бүтээсэн олон зуун бүтээлүүд хэдийгээр он цагийн эрхээр бүрэн хадгалагдаж ирээгүй ч өдгөө болтол уламжлагдан аман хөтөлбөр, судар бичиг, сургалт боловсролоор дамжин иржээ. Мөн олон хэл дээр орчуулагдаж, судалгаа шинжилгээний эргэлтэнд орж, дэлхийн олон орны эрдэмтэн мэргэд болон соёлт хүн төрөлхтний анхааран авах эрдмийн орны нэгэн болж чаджээ.

Монголчууд энэ бүтээлтэй бараг зохиогдсон тэр цагаас эхлэн танилцаж сэтгэл оюун юугаа гэгээрүүлэх увдис болгож ахуй амьдрал, ёс суртахуун, хүмүүжил боловсролдоо хэрэглэх гарын авлага зэргээр авч хэрэглэсэн төдийгүй уг увдисыг улам гүнзгийрүүлэн судалж нарийн утга учрыг дэлгэрүүлэн элдэв эш үндэс, учир шалтгаан, амьдрал ахуйн бодит

жишээ зэргээр улам баяжуулсан бодь мөрийн ухааныг олон талаас шинжиж тайлбарласан бодь мөрийн зэргийн "Хөтөлбөр бичиг", "Анхааран авах бясалгал", "Элдэв үлгэр домог", "Түүх гарвал", "Тэмдэглэл", "Зүүлт тайлбар", "Үг утгын тайлбар", "Гүн дэлгэр номлол" болон бүр ном хаялцах арга ухааны үүднээс тайлбарлсан "Эцсийн шинжлэл" гэх зэрэг олон хэлбэрийн бүтээлийг монголчууд бидний ухаантан өтгөс дээдэс туурвиж үлдээжээ.

Америкийн эрдэмтэн судлаач Роберт А.Ф.Турмэн бээр "Их бодь мөрийн зэрэг зохиогдсон зургаан зуу шахам жилийн турш түүнийг чухалчлан суралцагч нар нь голдуу Түвд болон Монголчууд байжээ" [5] гэж тэмдэглэсэн нь нэгийг өгүүлнэ. Монголын эрдэмтэн мэргэд Зонхав богдын олон бүтээл зарлигийг шимтэн суралцаж оюун ухаанаа гэгээрүүлэх нэгэн сурвалж болгож ирсний нэг нь энэ бүтээл билээ. Монголчуудын туурвисан Бодь мөрийн зэргийн бүтээлүүд олон боловч цагийн эрхээр бүрэн уламжилж ирээгүй байна.

Энд зарим нэгэн бүтээлийг дурдваас: [6] Хүрээний их хамба Агваанхайдүвийн "Бодь мөрийн зэрэг-амгалант мөрийн увдис" (byan chub lam gyi rim bei bde lam gei), Сүмбэ хамба Ишбалжирын "Бодь мөрийн зэргийн дөт мөр" (lam rim byan chub nye lam), Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн "Мөрийн зэргийн хөтөлбөр-Ухааны харанхуйг арилгагч" (lam rim gyi khred blo yei mun sel), Цорж Агваанцэрэнгийн "Судар тарнийн нийтийн мөрийн зэргийг бясалгах ёсон-Сэтгэлийн шимийг баригч" (mdo sngags tun mon gei lam gyei rimba skhong tshul yed kyei bcud len), Цахар гэвш Лувсанцүлтимийн "Мөрийн зэргийн дөрвөн эрдмийн номнол" (lam rim cheba bzhe yi rnam bzhag bshad pa), Цэмбэл гүүшийн "Их бодь мөрийн зэргийн таалал утгыг тодорхой үзүүлэхүй" (lam rim chen moi dgongs don gsalbar bsdan pa), Угалзын лам Лувсанжамцын "Бодь мөрийн зэргийг анхааран авахуйг шүлэглэсэн шид бүтээлийг татагч" (byanchub lam gyi rim bei nyams len tshegs bcad ma dngos grub ngagug byed), Чойнзод ламын "Бодь мөрийн зэрэгт оюунаа судлахуй-Хамгийг болгоогчийн сайн мөр" (byan chub lam gyi rimkala blo sbyon tshul gun mkhyen lam bsang), Сайн ханы Лувсандорж гавжын "Бодь мөрийн зэргийн эцсийн шинжлэл-Эрхэм зарлигийн далайд орох хөлөг онгоц" (byan chub lam gei rim bei mtha'a dpyod gsung rab rgya mtshor ajug bei gru khzings), Бари лам Дамцигдоржийн "Бодь мөрийн зэргийн хөтөлбөр-Тус амгалангийн сайн мөр" (byan chub lam gyi rim bei khred yeid), Оргиочийн лам Лувсанбалдангийн "Бодь мөрийн зэргийн зүрхэн оньс бүхнийг хураангуйланургуулсан бясалгахын ёсон-

[5] *The Great Treatise of the Stages to the part of the Enlightenment, 2000 USA 15-р тал*

[6] *С.Гомбожав "Монголчуудын түвд хэлээр зохиосон зохиолын зүйл" 1959 УБ*

Ялгуусаны сайн мөр" (byan chub lam gyi rim bei snyin po gnad kun bsdus nai shar sgom bya tshul rgyal bei lam sang), Жалханз хутагт Дамдинбазарын "Мөрийн үндэс-Буяны садны аймаг" (lam gyi rtsaba bshes gnyin bsden tshul gyi skor), Нанзаддорж аграмбын "Их бага мөрийн зэргийн тэмдэглэл" (lam rim che chung spyei zin bris), Баарин Дарамдалагийн "Их бодь мөрийн зэрэгт чухал ишлэгдсэн эртний үлгэрүүдийг нэгтгэн эмхэтгэсэн чухал хэрэгтэй үлгэр туужийн хотол хураангуй" (byan chub lam rim chen mola nye bar mko bei sngon abyung gei dbe rnams phogs geig tu bsdus ba gdam rgyud nyer mkho gun btus), Эрэн хамбын "Бодь мөрийн зэргийн үлгэрүүд" (lam rim dbe – chos), Халхын засаг Энхдэлгэрэнгүйн зохиосон "Бодь мөрийн зэргийн анхааран авахуйн үг утгыг тодорхой өгүүлэгч" гэх зэрэг олон арван бүтээлүүд байна.

Эл бүтээлийг Монголчууд өөрийн эх хэл дээрээ XY-XYI зууны үеэс орчуулж хэрэглэж ирсэн бөгөөд гар бичмэл болон модон бард сийлэн Их хүрээ, Бээжин, Буриад газар орноо хэвлэн олон нийтэд түгээж байжээ. Энэхүү Бодь мөрийн зэргийн уламжлалт сайхан монгол орчуулгын талаар гадаад орны эрдэмтэн судлаачид тухайлбал Германы нэрт эрдэмтэн В.Хэйссиг, Энэтхэгийн эрдэмтэн Локеш Чандра нар тусгайлан судалгааны бүтээл туурвисан байна. ⑦

Эдүгээ цагийн Монголын эрдэмтэн судлаач нар өвөг дээдсээс уламжлан ирсэн энэхүү номын цагаан буяныг үргэлжлүүлэн орчин цагийн эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулж, хэл шинжлэл, түүх гарвал, гүн ухаан зэрэг олон талаас шинжлэн судалж байна. Эл бүтээлийн талаар академич Д.Цэрэнсодном, академич Д.Дагвадорж, доктор профессор Чой.Лувсанжав, доктор Д.Ёндон, доктор, гавж Ш.Сонинбаяр, доктор Ж.Тэрбиш болон зохиолч яруу найрагч О.Дашбалбар, эрдэм шинжилгээний ажилтан Б.Мягмарсүрэн, С.Баянцагаан, Т.Цэндсүрэн нарын зэрэг орчин цагийн монголын олон арван эрдэмтэн судлаач нар зохиол бүтээлээ туурвисан байна.

Монголчууд Цастын орны номын мэргэд сайчуудтай эртнээс эрдэм соёлын эрхэм сайхан баридлага харилцаатай ирсэн бөгөөд Зонхава богд хэмээх эрдэмтэй нэгэн Цастын орноо мэндэлж эрдэмд гарамгай болсныг дуулж түүнтэй ном эрдмийн харилцаа тогтоохоор сайн ерөөл талбиж, заллага айлтгаж байсан түүхтэй. Өлзий орших болтугай.

Шашны Их Сургуулийн багш, гавж Намнан овогт Түмээхүүгийн Булган

---

⑦ *W.Heissig "On the Mongolian translation of the Lam-rim chenmo" (Wiesbaden 1954) and "Byryat Annonations on Lam-rim" (New Delhi 1973) by Lokish Chandra*

(III) ИХ ТӨРӨЛХТНИЙ МӨРИЙН ЗЭРЭГТ ОЮУНАА СУДЛАХ

(ЕРӨӨХҮЙН БОДЬ СЭТГЭЛИЙГ СУДЛАХ БА БОДИСАДВЫН ЯВДАЛД СУРАЛЦАХ ЕРӨНХИЙ ЁСОН)

Их нигүүлсэл төгөлдөр богд дээдсийн өлмийд биширэн мөргөмү.

Тийнхүү олон үүднээс, орчлонгийн гэм эргүүг өнө удаан эргэцүүлж тунгааваас хамаг ертөнц гал дүрэлзсэн гуу мэт санагдаж ирнэ. Улмаар зовлон нисваанис бүхнийг чухал амарлиулах нирваан хутгийг олох хүслээр хамаг сэтгэл эзлэгдэх бий. Ийнхүү эзлэгдсэн тэрээр их эрдэнийн гурван суртгаалд суралцаж зовлонгоос тонилсон нирваан хутгийг олно.

Эл хутаг өндөр язгуурын цог мэт эргэж буцна гэж байхгүй. Гэвч хамаг гэмээ барсан, басхүү хамаг эрдэм төгөлдөр хараахан болоогүй заримдаг дутуу тул өөрийн тусыг ч гүйцээж чадахгүйн дээр, бусдын тусыг ч бүтээж амжаагүй нэгэн болох нь ойлгогдох вий. Чингээд эцэстээ бурханаар шаардуулж их хөлгөнд орох хэрэгтэй ажгуу. Тиймээс ухаантай мэргэд анхнаасаа их хөлгөнд орвоос зохистой бөлгөө. *"Билиг барамидын хураангуй"*-гаас:

Ертөнцийн тусыг бүтээхэд чадал хүчгүй
Хоёр хөлгөнийг ашид тэвчиж орхиод
Чадагчийн үзүүлсэн нигүүлсэхүйн хөлгөнөө буюу
Бусдын тусын төлөө агаар нэгэн түүнээ орох хэмээсэн ба,

Жаргах зовохыг зүүдэн мэт тооцогдох
Мунхагийн гэмээр зүдсэн амьтныг үзэх хэрнээ
Үйлийн эрхэм болсон бусдын тусад баясахаа огоорон
Өөрийн тусыг хамаг байдгаар хичээх нь юу билээ хэмээсэн мэт болой.

Тийнхүү надтай адил орчлонгийн далайд унасан амьтад ч, авч орхихыг ялгах ухааны нүд анисан учир аюул зовлонгоос ангижрах зүг рүү алхаж гишгэж чадахгүй хазгар доголон мэт аж. Үүнийг мэдсэн бурханы төгс язгууртнууд бусдыг өрөвдөж хайрлахгүй, тэдний тусыг бүтээхгүй байхын аргагүй билээ.

Дээрх номоос:

Ухааны нүд нь аниастай, хазгар доголон болсон байхад
Ертөнцийн тусыг бүтээгч Бурхадын язгуурт төрөгсөдөөс
Өрөвдөж нигүүлсэхгүй төрөлхтөн гэж хаана байх билээ
Тэдний мунхагийг арилгахаар хичээхгүй гэж үү хэмээжээ.

Ийнхүү бусдын тусыг бүтээх үүрэг үүрнэ гэдэг хүн төрөлхтөн болсны аз жаргал, цог жавхлан, ид хав буюу. (Хүн болсны гайхамшиг үүнд л гавъяарах бөлгөө авч) Зөвхөн өөрийн тусаа буюу амиа хоохойлоод явах нь адгуустай ялгаагүй нэгэн болно. Тийм л учраас ямагт бусдын тус амгалангийн төлөө хичээх нь дээдэс сайчуудын ёс журам бөлгөө.

"Шавийн захидал"-аас:

Маш олоход хялбар өмх өвс зэргээ адгуус өөрөө олоод идэх
Маш их ангаж цангавч балга усаа олоод баяртай ууж чадах
Бусдын тусыг туурвих алин энэ л төрөлхтөн хүмүүн тэдний
Цог жавхлан, баяр баясгалан, төрөлхтөн түүний ид хав, үлэмж ялгаа

"Агуу их морь хөлөглөн давхих" хамгийг гийгүүлэгч наран ба
Ачааны хүндийг үл ялган ертөнцийг өргөгч газар шороо адил
Өөрийн тусыг огоорох нь дээдсийн мөн чанар тэр адил бөгөөд
Тэд нар зөвхөн ертөнцийн тус амгалангийн хэргийг л туурвих хэмээжээ.

Тийнхүү амьтан бүхэн хаа сайгүй зовлонд нэрвэгдсэн жамыг ухаарч тэдний тусын төлөө хичээн зүтгэвээс л жинхэнэ төрөлхтөн болж ухаант мэргэн хэмээн тооцогдох ажгуу. Дээрх шастараас:

Ертөнцөд "мунхагийн үүлэн" тулалдан амьтан бүхэн хямралдаж
Зовлон бадарсан их галд өөрийн эрхгүй ойчихийг үзээд
Толгойдоо галын оч авалцсан мэт сэтгэл зовнин хичээгч тэр л
Төрөлхтөн мөн бөгөөд ухаантан нь тэдгээр болно хэмээжээ.

Тиймээс өвөр, бусад бүгдийн хамаг сайн сайхан гарах орон, доройтол бүхнийг арилгагч гагц эм, мэргэн төрөлхтөн бүхэн зорчих их зам, сонсох, санах, үзэх, мэдрэх төдийгөөр ч амьтны алжаас зовлонг арилган жаргуулах, бусдын тусыг бүтээснээр өөрийн тусыг хамтад бүтээхийн мэргэн арга ухаан төгөлдөр Их хөлгөнөө орохдоо "Аяа, би нэг сайн олз

оллоо" хэмээн сэтгэж хүмүүн өөрийн хүч чадал юу бүхнээр энэ хөлгөнөө хичээгээрэй. *"Билиг барамидын хураангуй"*- гаас:

Арилсан билгийг илт бүтээх хөлгийн дээд нь
Их Чадагчийн хамгийг болгоогч тааллаас төрөв
Тэрээр орчих ертөнцийн амьтны нүд адил бөгөөд
Ургах нарны гэрэлт туяа адил буюу

хэмээсэн мэт олон талаас их хөлгөний эрдэм чадлыг санаж сэтгэл татагдан, их бишрэл хүндэтгэлтэйгээр орох бөлгөө.

Ийнхүү их төрөлхтний мөрийн зэрэгт суралцахад гурван зүйл:

А. Их хөлгөнөө орох үүд нь зөвхөн бодь сэтгэл болохыг үзүүлэх

Б. Бодь сэтгэлийг хэрхэн эгүүсгэх (төрүүлэх) ёсон

В. Бодь сэтгэлийг эгүүсгээд бодисадвын явдал мөрд суралцах ёсон

А. Их хөлгөнөө орох үүд нь бодь сэтгэл болохыг үзүүлэх:

Тийнхүү их хөлгөнөө орох зохистой учраас орох үүд аль нь бэ? Түүний талаар Ялгуугсан бээр, судрын их хөлгөн болон нууц тарнийн их хөлгөн хоёуландаа айлдсан буй. Тэр хоёроос өөр их хөлгөн байхгүй. Тэр хоёрын алинд оровч, орох үүд нь зөвхөн бодь сэтгэл ажгуу. Бодь сэтгэл тэр л төрсөн бөгөөс, бусад сэтгэл ухаанууд төрөөгүй байсан ч их хөлгөнд орсон гэж тооцдог. Харин тэр үгүй бол, хоосон чанарыг онох зэрэг эрдэм ухаан юу байлаа ч Сонсоод сонсогч зэргийн газарт унах буюу, их хөлгөнөөс буцаж унах болно гэж их хөлгөний олон ном шастараас буулган үзүүлжээ. Тиймд их хөлгөнөө багтах эсэх нь эхнээсээ энэ сэтгэл л төрсөн эсэхээс нотлогдох ба хожим их хөлгөнөөс гарсан гэж үзэхэд хүрвэл мөн л энэ сэтгэлээс салсан эсэхээр нь тогтоох учраас, энэ сэтгэл байна уу, үгүй юу гэдгээс л их хөлгөнт мөн эсэх нь хамаарна. *"Бодичарияаватара"*-гаас:

Бодь сэтгэл төрсөн тэр л агшинаа
Орчлонгийн гянданд хоригдсон ядарсан амьтан
Ялгуугсаны хөвгүүн (бодисадва) хэмээн өгүүлэгдэх ба,

Өнөөдөр бурханы язгуурт төрлөө
Одоо л нэг Ялгуугсаны хөвгүүн боллоо

хэмээх зэргээр бодь сэтгэл төрсөн тэр даруйд л Ялгуугсаны хөвгүүн (бодисадва) болохыг айлджээ.

"Хутагт Майдарын намтар"-аас: "Язгуурын хөвгүүн ээ, энэ буюу. Үлгэрлэвээс, их очир алмаз эрдэнэ хэдий жижиг байвч, бусад алт эрдэнэсийн чимгийг ямагт сүрээрээ дарж их очир эрдэнийн нэрээ алдалгүй, үгүйрэл ядуурал бүхнийг ялан дийлдэг буюу. Язгуурын хөвгүүн ээ, үүнтэй адил. Хамгийг болгоогчийн төлөөх их очир эрдэнэ бодь сэтгэлээс хэзээд хагацахгүй аваас Сонсоод сонсогч, Өөрөө ялгуугсад нарын эрдмийн алт эрдэнэсийн чимэг бүгдийг сүрээрээ дарж, Бодисадва нэрээ үл орхиж орчлонгийн үгүйрэл ядуурал бүхнийг ялан дийлэх бөлгөө" хэмээн бодь сэтгэл байвал явдал мөрд суралцаагүй ч бай бодисадва мөн болохыг айлджээ. Нагаржунай гэгээн бээр:

Өөрөө болон энэ ертөнцийнхэн
Ханьцашгүй бодь хутгийг хүсвээс л
Түүний язгуур бодь сэтгэлийг л
Уулсын хаан Сүмбэр уул мэт бат болго

хэмээсэн ба, *"Очирваанийн авшиг хуртэх дандар (тантр)"*-аас: "Их бодисадва нар аа, энэхүү их тогтоол тарнийн хот мандал машид агуу хийгээд машид гүн, үндсийг жишихэд бэрхтэй, нууцаас ч маш их нууц тул эдгээрийг хилэнцэт амьтнаа үзүүлэх орон бус гэж Очирваань та машид чухалчлан өгүүлэх юм. Урьд нь эс сонссон тул ямар амьтнаа номнох вэ? Очирваань өгүүлрүүн: Жамбал аа! Алин тэр бодь сэтгэлийг бясалган орох алин цагт ба, тэд нар бодь сэтгэл бүтээхийн тэр цагт, Жамбал аа!, Бодисадвын явдалт, нууц тарнийн үүдийг эхлэгч бодисадва тэд нарт, их билиг билигтэнд авшиг хүртээж тогтоол тарнийн их хот мандалд оруулж үйлдээрэй. Бодь сэтгэл төгс болоогүй бол тэднийг хот мандалд үл оруулах ба хот мандлыг харахаар ч бүү оруул. Тэдгээрт мутрын тамга болоод нууц тарнийг зааж бүү үйлд" хэмээжээ.

Чингэхээр ном нь их хөлгөний ном болох төдийгүй, тухайн бодгаль өөрөө их хөлгөнтөн байх чухал шаардлагатай ажгуу.

Чухам их хөлгөнтөн болох нь бодь сэтгэлд л харгалзах учраас, тэрхүү сэтгэлээ ухаарах төдийгээс цаашгүй бол их хөлгөнтөн ч мөн тэр адил болно. Харин тэр сэтгэл бэлэг чанар төгөлдөр нэгэн болвол жинхэнэ зөв их хөлгөнтөн болох тул түүний төлөө шамдаарай.

Энэ талаар *"Гол мод байгуулах судар"*-аас: "Язгуурын хөвгүүн ээ! Бодь сэтгэл нь бурханы ном бүгдийн хөрөнгө адил болой" хэмээн айлдсаныг магадлан мэдэхийн тул түүнийг номнов.

Арвайн хөрөнгө соёолж нь ус чийг, элч дулаан, хөрс шороо зэргүүдтэй цуглан нийлж байж арвай ургах нөхцөл шалтгаан болдог. Мөн тэдгээр нь тутрага, вандуй зэргийн хөрөнгө соёолжтой нийлж тэдгээр ногоог төрүүлэх шалтгаан болсноороо тэдний хувьд "нийтийн шалтгаан" болдог. Гэтэл буудайн хөрөнгө соёолж нь ямар ч шалтгаан нөхцөлтэй бүрдүүлж тарилаа ч, арвай тэргүүтэн бусад тариа ногоо төрөх шалтгаан болохгүй, зөвхөн буудайны "нийт бусын шалтгаан" болдог. Түүгээр эзлэгдсэн ус чийг зэргүүд ч буудай ургахын шалтгаан нөхцөл болдог. Түүнтэй адилаар, ханьцашгүй бодь сэтгэл нь, бурханы тариалангийн шалтгаан нөхцөлийн дундаас хөрөнгө соёолж адил "нийт бусын шалтгаан" болдог. Хоосон чанарыг оносон билиг ухаан зэрэг нь ус чийг зэрэгтэй адил гурван бодь хутаг гурвуулангийн "нийтийн шалтгаан" болдог. Тийн болохыг *"Дээд дамжлага"*-аас:

Их хөлгөнөө сүслэх нь хөрөнгө ба,
Билиг нь бурхан номыг эгүүсгэгч эх

хэмээн "бодь сэтгэл нь эцэг мэт хөрөнгө болох, би-үгүйг оносон билиг нь эх мэт" хэмээжээ. Үлгэрлэвээс, эцэг нь төвд бол хүүхэд нь хятад, монгол байж таарахгүй. Тиймээс эцэг бол хүүхдийн хувьд жинхэнэ язгуурыг тодорхойлох (нийт бусын үндэс) болдог. Харин Төвд эхээс янз бүрийн угсааны хүүхэд төрж болох тул нийтийн шалтгаан болдогтой адил.

Нагаржунай гэгээн бээр:

Бурхад болон Өөрөө ялгуугсад,
Сонсоод сонсогч нарын баттай шүтэх
Тонилохуйн зам нь гагц энэ буюу
Өөр бусад үгүй хэмээн та магадлав

хэмээн билиг барамидыг магтсан буй. Сонсоод сонсогч, Өөрөө ялгуугсад нар түүнийг шүтэх учраас билиг барамидыг эх хэмээжээ. Чингэж бодь сэтгэл их, бага хөлгөн хоёулангийн хөвгүүдийн эх болох учир, хоосон чанарыг оносон билиг ухааны үүднээс их бага хөлгөн гэж ялгаж үзэж болохгүй. (Харин) Бодь сэтгэл болоод агуу их явдал зэргийн үүднээс ялгах мөн.

"Их эрдэнийн эрхи"-ээс:

Сонсоод сонсогчийн хөлгөн түүнээс
Бодисадвын ерөөл болон
Явдал мөрөө төгс зориулах зэргийг эс номносон тул
Тэрээр хэрхэн бодисадва болох

хэмээсэн нь үзэл онолоор ялгах бус харин явдал мөрөөр ялгахыг айлджээ. Тэр мэт хоосон чанарыг оносон билиг нь ч их хөлгөний нийт бусын мөр болохгүй байхад бусад мөрийг хэлэх хэрэг юун.

Гэтэл бодь сэтгэлийн увдисыг голт болгож барьж судлалгүй, бясалгалын эхэнд үг төдий нэг дурдан санаад л зам мөрийн нарийн зүйл тус бүрт шамдана гэж үзвэл номын уг үндэс өчүүхэн болох нь тодорхой. Ер нь хүүхэд төрөхөд эцэг, эх хоёул хэрэгтэйн адилаар зам мөр төгс төгөлдөр гүйцэхэд арга билгийн зүг бүхэн бүрдэх хэрэгтэй байдаг.

Ялангуяа аргын эрхэм болсон бодь сэтгэл ба ухааны эрхэм болсон хоосон чанарын онол зайлшгүй шаардлагатай. Гэхдээ өрөөсгөл ганц нэгийг бясалгаагүй ч орчлонгоос гэтлэх төдий (нирваан) нэгнийг чухалчлах ч байдаг. Мөн амарлингүй амарлих орон сэтгэлийг эндүүрэлгүй олж, үлэмж үзэхийн ухаанд суралцаж, би-үгүй буюу хоосон чанарын утгыг бясалгах хэрэгтэй байлаа ч чингэж хэдий их хөлгөний хүн боллоо гэж андгайлавч, бодь сэтгэлийг л судлах хэрэгтэй буюу. Майдар гэгээн бээр:

Ухаанаар сансарт (зовлонд) үл орших ба
Нигүүлсэлээр амарлингүйд (нирваанд) үл орших буюу

хэмээн айлдсан мэт ухаан билгээр сансарын хязгаарт унахыг хорих ба нигүүлсэх сэтгэлээр амарлингүйн хязгаарт унахыг хорьдог байна. Харин билиг ухаан амарлингүйн хязгаарт унахыг хорьж чадахгүй аж. Сансарын хязгаарт унахгүй явдал бага хөлгөнд ч бий. Амарлингүйн туйлд унах явдлыг хорих бол бодисадвын мөрийн гол хоригдохуун болдог. Тиймд бурханы тааллыг тайлахдаа шалгадаг төрөлхтөн болсон бодисадва нар нь, "их эрдэнэ адил ийм сэтгэл үндсэнд төрвөөс, энэ адилын сонин гайхамшигт мөр төрлөө" хэмээн машид дээдлэн барина. Харин нялхасын баясах ганц нэг эрдэм үндсэнд төрсөн ч тэр адилаар үл барина. *"Бодичарияаватара"*- гаас:

Бусдын хувьд өөрийнхөө төлөө ч
Огт төрөөгүй байсан, алив амьтнаа туслах

Ялгамжаат сэтгэлийн их эрдэнэ энэ адил
Өмнө байгаагүй сонин гайхамшигт нэгэн мэндлэв хэмээсэн ба,

Түүнтэй ханьцах буян хаана байх
Түүнтэй адилтгах садан ч хаана байх
Түүнтэй тэнцэх буян ч хаана байх хэмээсэн ба,

Алин сэтгэлийн дээд их эрдэнэ
Түүнийг төрүүлсэн тэр лагшинаа мөргөх буюу

хэмээн айлджээ. Ийнхүү түүнийг дээдийн номын сүүг бүлж гарсан тосны охь буюу эрхэм зарлигын шимээс гарсан увдисын дээд хэмээн зарлиглажээ.

Тийн учир нь Цогт Атиша гэгээн өөрөө "төв үзэлтэн" байж, харин Сэрлинба багш нь "намба байдлыг үнэнд баригч сэтгэлийн төдийтний үзлийг баригч" байсан хэдий ч, багшаа шүтэж л бодь сэтгэлийг олсон учир "багш нарын минь зарлигийн ач их билээ" гэж үзэж ирсэн намтар цадигаас эрхэм зарлигийн аньсыг мэдэх нэгэн бээр үзээд зам мөрийн учрыг ихэд ухаарсан гэдэг.

Үүнээ шамдваас засваргүй нэгэн мэндлэх үндэс гарч түүгээр ээлэгдвээс хэрээ шувуунд атга төдий гурилыг өгөхөд ч бодисадвын явдалд тооцогдож ирнэ. Тийм сэтгэлгүй бол гурван мянган ертөнцийг эрдэнээр дүүргээд өглөг өгсөн ч бодисадвын явдалд багтахгүй аж.

Тэрчлэн шагшаавадаас билиг хүртэл үзэл онолыг бясалгах ба бурханыг бясалгах, судал, хий, дусал тэргүүтнийг бясалгавч бодисадвын явдалд багтахгүй.

Ертөнцөд өвс хадах хадуураа ирлэх ба бухал овоолохын үлгэр мэт, их эрдэнийн энэ сэтгэлийг аньсанд одуулалгүйгээр өнө удаан буяны ажилд хичээн шамдамвч мохоо хадуураар өвс хадахтай адил буюу газрын ахицаа огт гарахгүй. Энэ сэтгэлийг аньсанд одуулваас түр нэг хадахгүй байж байгаад хадуураа ирлээд бага багаар хадсаар улам ихийг хаддагтай адил агшин нижгээд нижгээдээр хилэнцийг арилгах, буяныг хураах үйлийг амар хялбар бүтээж чадна. Буян багадах болоод завсартаа барагдах зэргүүд ч зэрэгчлэн арвижиж бас барагдахаа болино. *"Бодичарияаватара"*-д:

Хилэнц нүгэл гэдэг хүч ихтэй машид барагдашгүй
Түүнийг туулсан бодь сэтгэлээс бусад

Ямар ч буян сүрээрээ дарж үл чадах хэмээсэн ба,

Тэр бээр цагийн эцсийн гал мэт их хилэнцийг
Агшин нэгнээ магадтай түлж үйлдэх хэмээсэн ба

Амьтан бүхний толгойн өвчин төдийг
Арилсугай хэмээн санасан төдийгээр
Туслах санаа төгөлдөр болж
Хэмжээлшгүй буян төгөлдөр болдог тул

Амьтан тус тусын зовлон зүдгүүр
Хэмжээлшгүй бүгдийг арилгахыг хүсэх ба
Тус тус бүгдэд хэмжээлшгүй эрдэм
Бүтээх хүслийг хэлэх хэрэг юун хэмээсэн ба,

Бусад буян бүхэн зэгс адил
Үрээ гаргаад барагдах ямагт
Бодь сэтгэлийн найлзуур модон үргэлжид
Үрээ гаргасаар барагдахгүй арвижих мөн хэмээжээ.

Б. Энэхүү сэтгэлийг хэрхэн төрүүлэхийн ёсноо дөрөв:

1. Ямар шалтгаанд шүтэж хэрхэн төрөх
2. Бодь сэтгэлийг судлахын зэрэг
3. Төрөх хэмжээ
4. Зан үйлээр авах ёсон

1. Ямар шалтгаанд шүтэж хэрхэн төрөх ёсноо дөрөв:

Дөрвөн шалтгаанаас төрөх нь.

а. Бурхан бодисадвын хүч санаанд багташгүй гэж өөрөө үзэх, сэтгэл итгэмжлэх, сонсох зэргээр аливаа оршсон, заларсан тэдгээр бодисадва хүчтэй хэмээх бодь сэтгэлийг эгүүсгэнэ (1). Тэр мэтээр үзэж сонсоогүй ч бодь хутгийг үзүүлсэн аймаг савыг сонсож бурханы билиг ухаанд сүсэглээд бодь сэтгэл төрөх бий (2).

Номыг эс сонссон ч, бодисадвын дээд ном жаргахад дөхсөнийг үзээд энэ адилын ном байваас хэмжээлшгүй амьтны зовлонг арилгаж үйлдэх тул, би бээр бодь сэтгэлийн номыг өнөд оршуулж үйлдэхийн тухайд магадтай бодь сэтгэлийг үүсгэе хэмээгээд бодь сэтгэлийг төрүүлэх бий (3). Ном жаргахыг эс үзсэн ч гэсэн, муу цаг, мунхаг сэтгэл, ичгүүр сонжуургүй, атаа жөтөө, харам тэргүүтнээр ихэд эзлэгдэх болсон энэ цагт "сонсогч" болон "өөрөө хутагт хүрэгчид" ч бодь сэтгэлийг эгүүсгэх нь ховор болсон тул ханьцашгүй бодийн дээдэд сэтгэл эгүүсгэхийг хэлэх юун.

Хэаяа би бээр бодь сэтгэлийг эгүүсгэвэл бусад тэр мэт болох болой гэж бодь сэтгэл эгүүсгэх нь ховор болсныг үзэж бодь сэтгэл эгүүсгэх (4) зэрэг дөрөв болой. Сэтгэл төрөх ёс нь "их бодийн хутагт сэтгэлийг эгүүсгэж үйлдье" хэмээн айлдсан тул бодийг олохын хүсэл төрөх болой. Ямар ч шалтгаанаар үйлдэхэд, анхдугаарт рид хувилгаан зэрэг сонин гайхамшигтуудыг үзэх буюу сонсож их бишрэл, баяр бахдал төрөх тэр адилаар "бодь хутгийг би олсугай" хэмээх мөн.

б. Номыг өгүүлэгчээс бурханы эрдмийг сонссоноор анхлан сүжиг төрөх ба түүнээс цааш тэдгээрийг олохын хүсэл төрөх болой.

в. Их хөлгөний дээдийн ном жаргаж байгааг үзээд эс тэсэж, бурханы билиг ухааныг олох хүсэл төрөх бий. Энэ дээдийн ном эс жаргаваас амьтны

зовлонг буцаана шүү гэдгийг мэдсэнээр зовлонг арилгахын тухайд зорьж бодох бий. Гэвч бодь сэтгэл үүсгэх шалтгаан нь дээдийн ном жаргах төдийд болон эс тэсэх тэр төдий бус юм. Хэрэв тийм бус бол дараа номнох нигүүлсэхүй сэтгэлд шүтэж төрүүлэх хэмээсэнтэй харшлах болно.

г. Хэрэг ихтэй тэр сэтгэл ховор болсныг ухаарч, голчлон түүгээр сануулга авч бурханы хутаг олохын хүсэл төрөх буюу. Ийнхүү бодь сэтгэл үүсэхэд бодь хутгийг олохын хүсэл төрөх үүднээс агуулах болохоос тухайлан үйлдэх үүднээс эс агуулах үзэгдэнэ. Бурханы эрдэмд сүжиг төрөх үүднээс бурханыг олох хүсэл төрөхгүй гэж үзэхгүй бол “өөрийн тусыг бүтээхэд дан ганц амарлингуй байхад болно” гэх үзлийг үл буцаах буюу. Асрахуй, нигүүлсэхүйг судлахын үүднээс бусдын тусыг (бүтээх) хэрэгтэй гэж үзээд бурханыг олох хүсэл төрнө гэх нь бусдын тусыг бүтээхэд зөвхөн амарлингуй нирваан байхад болно гэж баригч бодлыг буцааж чадна. Харин өөр буцаагч байхгүй тул дээр дурдсан “болно” хэмээн баригчийг буцааж үл чадна. Өөрийн тусыг бүтээхийг зөвхөн амарлингуйгаар болгоно хэмээгч ухааныг буцаах хэрэгтэй.

Бага хөлгөнөө зовлонгоос гэтэлсэн төдийн тэвчил онолын өрөөсгөл нэгнээс цаашгүй тул “өөрийн тусын хотол чуулган” байхгүй буюу. Тэд орчлонгийн доройтлоос гэтэлсэн хэдий ч, амарлингуйн доройтлоос гэтлээгүй байдаг. “Өөрийн тусын хотол чуулган” гэдэг бурханы номын лагшин (дхармакаяа) мөнийг айлджээ. Тиймээс бурханы эрдэмд сүсэглэн сурснаар бусдын тусыг бүтээхээр зогсохгүй, өөрийн тусыг ч бүтээхэд бурханы хутгийг олохгүй л бол болохгүй нь гэдгийг мэдэж ухаарах нь бага хөлгөнд үл урвахын их шалтгаан болмой.

Урд номносон сэтгэлийг эгүүсгэх анхдугаар, хоёрдугаар зүйл нь асрахуй ба нигүүлсэхүй сэтгэлээр татагдах албагүй ч, эрхэм зарлиг болоод бусад шастаруудаас “бурханы дүрст лагшин” болон номын лагшингийн эрдмийг үзсэн төдийгөөр татагдаж бурхан болох хүсэл төрж бодь сэтгэл үүдэж болохыг олонтой номносон үзэгдэнэ. Мөн хамаг амьтныг бурханы газар байгууया хэмээн тангараглах нь бодь сэтгэл болно хэмээн айлдсан нь үзэгдэх тул энэ хоёрыг тус тусад нь бодь сэтгэлийг үүсгэсэн, бодь сэтгэлийг төрүүлсэн хэмээн тооцох хэрэгтэй.

Бэлэг чанар төгссөн бодь сэтгэл болоход бусдын тусыг хэрэгтэйд үзэх төдийхнөөр татагдсан бурханыг олох хүсэл төрөх төдийхнээр зогсохгүй, өөрийн тусыг бүтээхэд ч бурхан болох нь хэрэгтэй гэдгийг мэдэж, түүнийг

олохын хүсэл төрөх ба бусдын тусыг ясал орхилгүй бусдын тусыг чухалчлах сэтгэлүүд хэрэгтэй болно. *“Илт онохуйн чимэг”*-ээс:

Сэтгэлийг үүсгэх гэдэг бусдын тусын баталгаа
Үнэхээр туулсан бодийг хүсэх

хэмээн бодь хутаг болоод бусдын тус хоёул хэрэгтэйг айлдсан буй.

Дөрвөн үндэснээс төрөх нь: Үндэс язгуур хотол чуулсан байх, буяны саднаар эзлэгдэх, амьтнаа их энэрэн нигүүлсэх, орчлонгийн хатуужил бэрхшээлд үл уйсах эдгээр дөрөвт шүтэж бодь сэтгэлийг үүсгэх болой.

Дөрвөн хүчээс төрөх нь: Өөрийн хүчээр туулсан хутгыг хүсэх “өөрийн хүч”, бусдын хүчээр туулсан хутгыг хүсэх “бусдын хүч”, урьд их хөлгөнөө дадан бурхан бодисадвын сайшаалыг сонссон төдийгөөр төрсөн “шалтгааны хүч”, энэ насанд шүтэж номыг сонссон сэтгэл тэргүүтний буянд өнөд удаан бясалгаж дадсан “бэлтгэлийн хүч” буюу эдгээр дөрөвт шүтэж төрөх болой.

“Тэрхүү найман шалтгаан нөхцөл тус тусдаа буюу цуглаж барилдан өөрийн учир шалтгааны хүчээс төрвөөс баттай болно. Учир шалтгаан тэдгээрт шүтсэн ч бусадтай найрах хүчээс төрвөл батгүй” гэж “Бодийн газар”-аас айлджээ.

Тийнхүү нийт дээдийн ном болоод их хөлгөний ном жаргахад ойртсон цөвүүнээс цөвүүн болсон энэ цагт сайтар ухаарч, зүрхний мухраас бодь сэтгэлийг үүсгэх нь машид ховор болсныг ойлгож, дээдэс буяны саданд шүтэн их хөлгөний аймаг савыг сонсох ба санах тэргүүтний үйлст шамдах бөгөөд бусдаар эрхгүй шаардуулах, дэмий гүйх, ёс бусаар үйлдэлгүйгээр өөрийн хүчээр, сэтгэлийн мухраас бодь сэтгэлийг үүсгэх үндэсийг тавьж үйлдээрэй. Бодисадвын хамаг явдал үүнд л суурилах учиртай билээ.

2. Бодь сэтгэлийг судлахын зэрэгт хоёр:

а/ Жову Атиша гэгээнээс дамжсан шалтгаан ба үрийн долоон увдис

б/ Бодисадва Шантидэва гэгээний номоос гарсанаа шүтэж суралцах

Шалтгаан ба үрийн долоон увдис нь: Тугуулсан (туулсан) бурхан нь бодь сэтгэлээс төрсөн, бодь сэтгэл нь үлэмж сэтгэлээс, үлэмж сэтгэл нь нигүүлсэхүй сэтгэлээс, нигүүлсэхүй сэтгэл нь асрахуй сэтгэлээс, асрахуй сэтгэл нь ачийг хариулах, ачийг хариулах нь ачийг санах, ачийг санах нь эх мэт үзэх сэтгэлээс төрөх эдгээр долоо болой.

а. Жову Атиша гэгээнээс дамжсан шалтгаан ба үрийн долоон үвдис үүнээ хоёр:

1) Эрэмбэ зэргийг танин барих

2) Зэрэгчлэн бодитой суралцах

1) Эрэмбэ зэргийг танин барихад хоёр:

а) Нигүүлсэхүй сэтгэл нь их хөлгөний язгуур болох

б) Бусад шалтгаан үрүүд нь түүний шалтгаан үр болох ёс

а) Нигүүлсэхүй сэтгэл нь их хөлгөний язгуур болоход гурав (эхэнд, дунд, эцэст их хэрэгтэй болох нь):

(1) Эхэнд их хэрэгтэй болох нь: Их нигүүлсэхүй сэтгэлээр сэтгэл өдөөгдөж хамаг амьтныг орчлонгийн зовлонгоос гаргахаар тангараглана. Нигүүлсэхүй бага байвал чингэж үйлдэхгүй тул, хамаг амьтныг гэтэлгэх үүрэг үүрнэ гэдэг түүнээ (нигүүлсэхүйд) харгалзах мөн.

Энэ үүргийг эс үүрвээс их хөлгөнөө багтахгүй тул эхэнд их нигүүлvэхүй сэтгэл их хэрэгтэй мөн. Тийн болохыг *"Лодой мэсадва айлдсан"*-аа: "Хувраг Шари бү! Бас бус, Бодисадва нарын их нигүүлсэхүй барагдашгүй болой. Юунд хэмээвээс эхэнд одуулах учраас болой. Хувраг Шари бү! Энэ мэт буюу. Үлгэрлэвээс, гадагш, дотогш гүйх амьсгал нь хүний амь эрхтэний эхэнд одох мөн. Тэрчлэн Бодисадвын их нигүүлсэхүй сэтгэл гэдэг их хөлгөнийг үнэхээр бүтээхийн эхэнд одох мөн" хэмээжээ.

"Гаягари сударт": "Жамбал аа! Бодисадва нарын явдлыг туурвих гэж юу вэ? Бодлын орон юу вэ? Жамбал өгүүлрүүн, Тэнгэрийн хөвгүүд ээ! Бодисадва нарын явдлыг туурвих гэдэг их нигүүлсэхүй болой. Бодлын орон нь амьтан болой" хэмээжээ. Тийнхүү тангараглавч агуу их хоёр буянаа эс суралцваас эс бүтэхийг мэдээд, үйлдэхэд бэрхтэй агуу их буяныг бүтээхээр орох нь бодисадвын явдалд орох суурь болой.

(2) Дунд их хэрэгтэй болох нь: Тийнхүү нэг удаа тэр адилын сэтгэл төрөвч, амьтан гэдэг тоолшгүй олон, саар явдалтай, сургахад их бэрхтэй, хэмжээлшгүй их цаг хугацаа шаардагдах зэргийг мэдээд ирэхээр шантарч бага хөлгөнөө унах явдал тохиолдоно. Гэвч их нигүүлсэхүй сэтгэлийг ганц удаа төрүүлээд зогсохгүй дээш нь нэмэн нэмж дадуулж бясалгасаар өөрийн жаргал зовлонгоо үл хайхрах ба бусдын тусад үл уйсах буян бүгдийг амар хялбар төгсгөх буюу.

“Бясалгалын эхний зэрэг”-ээс: “Тийнхүү их нигүүлсэхүйг хөлөглөсөн бодисадва нар өөрийг үл тоож, бусдад маш их тус болохыг чухалчлах тул буян хураах машид бэрхтэй, урт удаан хугацааны үйлнээ орох буюу. Хутагтууд сүжгийн хүчийг эгүүсгээд хэмээн айлдсан энэ мэт буюу. Энд их нигүүлсэхүй сэтгэлтэнгүүд хамаг амьтныг огоот боловсруулан үйлдэхийн тул зовлонт төрлийг авахгүй байна гэж үгүй. Түүгээрээ бас амгалант төрлийг орхихоос ч аргагүй. Тэр мэтээр үйлдэхэд маш бэрхтэй үйлсэд орсноор өнөд удалгүй буяныг огоот төгсгөнө. Лавтайяа хамгийг болгоогчийн хутгийг олох болой. Тиймээс бурханы ном бүгдийн язгуур нь зөвхөн их нигүүлсэхүй мөн болой” хэмээжээ.

(3) Эцэст их хэрэгтэй болох нь. Бурхад үрийг олохын цагт ч бага хөлгөнийхөн адил нирвааны амгаланд суулгүй огторгуй хаа хүртэлх амьтны тусыг зохиох нь их нигүүлсэхүйн хүч билээ. Тийм сэтгэлгүй бөгөөс Сонсоод сонсогчийн адил болох аж.

“Бясалгалын дунд зэрэг”-ээс: “Их нигүүлсэхүй бээр огоот ээлэгдсэн учир Ялж төгөлдөр нөгчигсөн бурхад ч хэдий өөрийн тусад хотол чуулган даяарыг олсон ч, амьтны орны эцэс хүртэл оршмой хэмээх ба, Ялж төгөлдөр нөгчигсөдийн үл орших нирваны шалтгаан нь их нигүүлсэхүй энэ ямагт мөн” хэмээжээ.

Үлгэрлэвээс, тариалан тариалахад эхлээд хөрөнгө, дунд нь ус чийг, эцэст үр боловсрох хэрэгтэй адилаар бурханы тариаланд ч эх, дунд, адаг гурвууланд их хэрэгтэй зүйл нь их нигүүлсэхүй сэтгэл мөн болохыг Цогт Чандракирти гэгээн бээр:

Алины тул нигүүлсэхүй нь, Ялгуугсадын хотол чуулсан тариалан үүний
Хөрөнгө болоод арвижуулах ус адил, өнөд алсдаа
Төгс эдлэхийн орон боловсрон жимс адил буюу
Тиймд их нигүүлсэхүй сэтгэлийг эхлээд магтав би хэмээн айлджээ.

Энэхүү утгын эрхийг болгоон *“Номын үнэн хураангуй”*-гаас: “Ялж төгөлдөр нөгчигсөн! Бодисадва бээр маш олон номонд үл суралцах болой. Ялж төгөлдөр нөгчигсөн! Бодисадва бээр нэг номыг машид сайн барьж, машид сайн оноож үйлдвээс бурханы ном бүгд түүний алганы толионд буйн адил мөн. Тэр ганц ном юу вэ? Энэ буюу их нигүүлсэхүй болой. Ялж төгөлдөр нөгчигсөн! Их нигүүлсэхүй сэтгэлээр бурхадын ном бүгд хамаг бодисадва нарын алганы толионд буух мөн. Ялж төгөлдөр нөгчигсөн!

Үлгэрлэвээс, Хүрдэн урвуулагч хааны их хүрдэн эрдэнэ хаана буй газраа өмөг чуулган бүгд буй мөн. Ялж төгөлдөр нөгчигсөн! Тэрчлэн бодисадвын их нигүүлсэхүй хаа оршсон тэнд бурхадын ном бүхэн буй. Ялж төгөлдөр нөгчигсөн! Үлгэрлэвээс, амь эрхтэн буй аваас бусад эрхтэн ч буй мөн. Ялж төгөлдөр нөгчигсөн! Тэр мэтээр их нигүүлсэхүй буй аваас бодисадвын бусад ном ч гарах болой" хэмээн айлджээ.

Мөрийн дээд увдис хэмээн хэмжээлшгүй олон эш ном, нотлох ухааны үүднээс баталсан энэ зүйлийг ухаарсан хэрнээ, их нигүүлсэхүй сэтгэлийн үндэст бодь сэтгэлийн номын аймгийг увдисын дээдэд юунд үл барина вэ? Шан-начүн донба бээр, Жову гэгээнд увдис айлтгахад "Ертөнцийг тэвчих бодол ч бодь сэтгэлийг бясалгахаас нааш төрөхгүй" хэмээхэд гэвш Донба ичингүйрч, "Энэ л Жову гэгээний увдисын туйл мөн дөө" хэмээж номын увдисыг болгоосон" гэдэг.

Зөвхөн үүнийг ойлгож мэдэхэд ч бэрхтэй тул, дахин дахин буян хураах, нүглээ арилгахаар суралцах ба *"Гол модон байгуулах"* зэрэг эрхэм зарлигууд болон *"Тааллын тайлбар"* зэргийг үзэж баттай мэдэхээр эрэлцэх нь зүйтэй. Балдан хол бээр:

Таны их эрдэнийн таалал болсон
Туулсан бодь хутгийн хөрөнгө түүнийг
Зөвхөн баатар та л зүрхэн хэмээн таалав
Түүнээс бусад төрөлхтөн хэмжиж яаж мэдэх вэ хэмээн айлдсан мэт.

б) Бусад шалтгаан, үрүүд нь түүний шалтгаан, үр болох ёс

"Эх хэмээн мэдэх" сэтгэлээс "асрахуй" хүртэлх сэтгэлүүд үндэс шалтгаан болох ёс:

Ер нь зовлонгоос хагацаасай гэх хүсэл төдий нэгэн бодол тухайн амьтны зовлонг дахин дахин санаснаар төрөх боловч, тийм сэтгэлийг амар хялбар, хүчтэй, баттай төрүүлэхийн тулд өмнө нь тухайн амьтнаа сэтгэлд эерэг наалтай санах, энхрийлж хайрлах учиртай гэж бодох хэрэгтэй. Садан төрөлдөө зовлон тохиоход үл тэсэх хэрнээ, дайснаа зовлон учрахад баясах бий. Харин дайсан, садан алин ч бус завсарын (танихгүй) нэгнээ зовлон гарахад ихэнхдээ "тоохгүй орхих" буюу "тэгш агуулах сэтгэл" төрдөг.

Тиймээс эхлээд сэтгэлдээ дотно зохистой болгож бодох шаардлагатай. Хичнээн энхэр дотно болох тутам төдий чинээ зовлонд нь

үл тэсэх сэтгэл төрнө. Багахан, дундуурхан энхрийлэх сэтгэл төрөөд ирэхээр үл тэсэхийн хувь багасана. Улам их энхрийлвээс нарийн зовлонд ч бүр тэсэхгүй болох байдал үзэгдэнэ.

Дайснаа зовлонтой байхыг үзээд түүнээс хагацаасай гэж бодох нь битгий хэл, одоо түүнээсээ ч бүр ихээр зовоосой, бүү хагацаасай гэж боддог чинь түүнийг сэтгэлдээ таагүй бодохоос л уршигдсан хэрэг. Сэтгэлд таагүй нэгнээ их, бага зовлон учрахад их, багын хэмжээт баясах хувь төрнө.

Дайсан, садан алин ч бус завсрын нэгнээ зовлон тохиоход үл тэсэх ч үгүй, баясах ч үгүй байдаг нь сэтгэлд таатай, таагүй алин ч бишийн үүднээс тийн уршигдана.

Тийнхүү амьтныг садан төрөл минь гэж бодохын тулд сэтгэлдээ таатай, дотно болгож бясалгах явдал юм. Төрөл садангийн дээд нь ээж хүн байдаг. Тиймээс "эх гэж бясалгах" ба "түүний ачийг санах", "ачийг хариулах" гурав нь сэтгэлд таатай зохистой болгон ухааруулагч ажээ. Амьтан бүхнийг ганц хүү шигээ сэтгэл зүрхэндээ энхрийлэн барих "асрахуй сэтгэл" нь тэр гурвын үр мөн. Тэрээр их нигүүлсэхүй сэтгэлийг төрүүлэгч болно.

Амгалан жаргалтай учруулахыг хүсэгч асрахуй ба их нигүүлсэхүй сэтгэлд (энэ нь) шалтгаан ба (тэр нь) үр болно гэсэн магадлал үзэгдэхгүй байна. Тиймээс "эх мэт мэдэх" тэргүүтэн гурван бодол нь амгалантай учруулах хүсэл болсон асрахуй, зовлонгоос хагацуулахын хүсэл болсон их нигүүлсэхүй хоёулангийн суурь болох тул түүнээ шамдах хэрэгтэй. Бодь сэтгэл төрөхийн уг нөхцөл болох амьтныг саднаа хэмээн бясалгах энэ сэтгэлийн талаар Цогт Чандракирти, Зүнбэ Даваа, ловон Камалашила нараас айлдсан буй.

Үлэмж сэтгэл ба бодь сэтгэл нь үр болох ёс:

Тийнхүү ухааны зэрэгт суралцсаар нигүүлсэхүй сэтгэл төрж, улмаар амьтны тусад бурханы хутгийг олюу хэмээх хүсэл төрчихвөл болоо юм биш үү. Түүний завсар үлэмж сэтгэлийг оруулах ямар хэрэгтэй вэ?

"Амьтан амгалантай учраасай, зовлонгоос хагацаасай" хэмээх цаглашгүй асрахуй ба нигүүлсэхүй сэтгэл нь Сонсоод сонсогч ба Өөрөө ялгуугсад нарт байх хэдий ч, хамаг амьтнаа амгаланг бүтээх, зовлонг арилгахаар үүрэг авах нь их хөлгөнөөс бусдад үгүй тул, тийм чин зориг буюу үлэмж сэтгэлийг төрүүлэх хэрэгтэй. Тиймээс хамаг амьтан

амгалантай учраасай хэмээх ба зовлонгоос гэтлээсэй гээд зогсохгүй, өөрөө тэдгээрийг бүтээх үүргийг сэтгэлийн мухраас хүлээх хэрэгтэй гэх хоёрын ялгааг ялгаж ухаарах мөн.

"Лодойжамц айлтгасан судар"-аас: "Лодойжамц аа! Үлгэрлэвээс, нэгэн худалдаачин гэрийн эзэн үзвээс үзэсгэлэнт, энхэр хайртай ганц хөвгүүнтэй байжээ. Нялх балчир хүү тоглож наадаж яваад ариун бусын нүхэнд уначихжээ. Хүүгийн ээж болон хамаатан садангууд хүүг ариун бусын нүхэнд унахыг хараад газар дэвслэн, гаслан ориловч нөгөө ариун бусын нүхэнд орж хүүгээ гаргаж чаддаггүй. Харин хүүгийн эцэг ирж хүүгээ нүхэнд унасныг үзэнгүүт, түргэн бэлтгэж ганц хүүгээ гаргаж авах ухааныг сийлэн, бөөлжис хутгалгүй ариун бусын нүхэнд орж ганц хүүгээ гаргах болой" хэмээсэн буй. Энд өгүүлэх "ариун бусын нүх" бол гурван ертөнц, "ганц хүү" нь амьтан бодгальс, "эх болон садан"нь амьтан орчлонд унасныг үзээд гаслан ориловч гаргах чадалгүй "Сонсоод сонсогч", "Өөрөө ялгуугсад" ба, "худалдаачин гэрийн эзэн" гэдэг Бодисадва нар болохыг үлгэр, утга хоёроор найруулан айлджээ. Ганц хүүгээ ариун бусын нүхэнд унахад түүний ээжид төрөх нигүүлсэхүй сэтгэл зэрэг нь "Сонсоод сонсогч", "Өөрөө ялгуугсад" байна хэмээн айлджээ.

Тиймээс нигүүлсэхүйд суурилсан амьтныг гэтэлгэх үүрэг хүлээсэн үлэмж сэтгэлийг эгүүсгээрэй. Тийн амьтныг гэтэлгэсү хэмээх ухаан төрөхийн чацуу өөрийн минь байгаа байдал энэ мэтээр бол, ганц ч амьтны хэргийг бүтээж чадахгүй бөгөөд түүгээр зогсохгүй дайснаа дарсан хоёр хутгийг олсон ч, өчүүхэн төдий ганц нэг амьтны тус хэргийг бүтээж гэтэлгэх төдийг бүтээхээс бус, хамгийг болгоогчийн хутагт хэзээ ч байгуулж чадахгүй билээ. Тиймийн учир тоолшгүй олон амьтан тэдгээрийн орон үесийн болон эцэс туйлын хамаг хэрэг тусыг хэн төгсгөж чадна вэ хэмээн сэтгэвээс, гагцхүү бурхан л чадна гэдгийг ухаж, амьтны тусын тулд бурхан болохын хүсэл төрмөй.

2) Зэрэгчлэн бодитой суралцахад гурав:

а) Бусдын тусыг чухалчлах ухаанд суралцах

б) Бодь хутгийг чухалчлах ухаанд суралцах

в) Суралцсаны үр – Бодь сэтгэлийг бодитой барих

а) Бусдын тусыг чухалчлах ухаанд суралцахад хоёр

(1) Тэрхүү сэтгэл төрөхийн суурь тавих

(2) Тэрхүү сэтгэлийг бодитой төрүүлэх

(1) Тэрхүү сэтгэл төрөхийн суурь тавихад хоёр:

(а) Тэгш сэтгэлээр амьтанд хандах

(б) Сэтгэлд зохистойгоор амьтныг үзэх

(а) Тэгш сэтгэлээр амьтанд хандах:

Дээр бага, дунд төрөлхтний үед номносон удиртгал тэргүүтний эрэмбийг мөн энд санаарай. Эхлээд зарим нэгнээ шунах, бас зарим нэгнээ уурлах зэргийг орхиж, сэтгэлээр тэгш хандаж үл сурваас, хэдий асрахуй, нигүүлсэхүй сэтгэл хэсэг бусаг төрөвч, алагчлахгүй бодол төрж гарахгүй учраас тэгш агуулахуйг бясалгаарай.

Тэгш агуулах бясалгалд хуран үйлдэхүйн тэгш агуулахуй, амсуургын тэгш агуулахуй, цаглашгүйн тэгш агуулахуй гэж гурав байдгаас энд сүүлчийнх нь мөн. Түүнээ амьтан хүнд уурлах, тачаах зэрэг нисваанисын сэтгэлгүй агуулах ба өөрөө амьтнаа тачаах, уурлах хоёроос хагацаж сэтгэл тэгш агуулах хоёр зүйл байхаас энэ үест сүүлчийнх нь болой. Үүнийг бясалгахдаа төрөхөд хялбараар бодож, эхлээд тус хорлол алиныг нь ч үйлдээгүй завсрын нэгнийг зоригдохуун болгож аваад түүнээ тачаах, уурлах зэргийг арилгаж тэгш агуулан бүтээх болой. Түүн дээр сэтгэл тэгш агуулан бүтвээс цаашдаа хамаатан садан тэргүүтнээ тэгш агуулан бүтээх мөн.

Хэрвээ тэднээ сэтгэл тэгш хандахгүй байвал шунал болон уураар таслагдах буюу шунахын хувь ихдэх, багадах зэрэг тэнцвэргүйгээс шалтгаална. Тэдгээр байдлыг тэгшитгээд дайсан дээрээ тэгш агуулах сэтгэлийг бясалгана. Түүнээ тэгш сэтгэл гарахгүй байх нь түүнд байнга эсрэг өнцгөөс хандаж байснаас болж уур хилэн хөдөлдөг аж. Үүнийг больж тэгш хандах болсноор амьтан бүхнээ тэгш агуулахуйг бясалгана.

Хэрхэн юуг бясалгавал тэдгээрт уурлах шунахыг тэвчих вэ? *Үүнд хоёр зүйл:* Амьтны талаас гэвэл, амьтан бүгдээрээ амгаланг хүсэх, зовлонг үл хүсэх нь адил тул, зарим нэгийг нь ойрхон бариад тусалж дэмжих, заримыг холд бариад хорлох буюу туслахгүй байх нь зохисгүй хэмээн үзэх. Мөн өөрийн талаас гэвэл, тэргүүлшгүй цагаас олон зуун удаа, миний садан болж яваагүй ямар ч амьтан энэ орчлонд хаана ч байхгүй тул хэнд нь шунаж, хэнд нь уурлах билээ хэмээн санаарай гэж *"Бясалгалын дунд зэрэг"*-ээс айлджээ.

Мөн садандаа шунах талаар *"Даваачог охины айлтгасан судар"*-аас:

Би ч урьд та бүгдийг алж байв
Та нар ч намайг урьд цавчиж тасалж байв
Бүгдээр янагш чинагш дайсан болж алалцсан биз
Та нарт дурлах сэтгэл хэрхэн төрөх билээ

хэмээн урьдын магад бус, гэмт үесийг номносон мэтээр дайсан садан бүгдээр түргэнээ солигдож ирсэн ёсыг сана. Чингэвээс уурлах, шунах хоёр буцах болой.

Энэ үест дайсан, садан хоёр гэж ялгаж байгаа суурийг барих хэрэгтэй. Тиймээс дайсан, садан хоёрын ухааныг буцаах хэрэггүй ч, дайсан садан мөн гэдгээр шалтаглаж, шунах уурлах зэргээр ялгаж хандаж байгаа ухааныг хорих учиртай.

Бүгдийг сэтгэлд зохистой байдлаар бүтээх талаар *"Бясалгалын дунд зэрэг"*-ээс: "Асрахуйн усаар сэтгэлийн үндсээ чийглэж алт буй газар мэт болгоод, нигүүлсэхүй хөрөнгийг талбиваас, машид амар хялбар огоот дэлгэрэх болой. Цаашид сэтгэлийн үндсээ асрахуй сэтгэлд тушаагаад их нигүүлсэхүйг дадуулж үйлдээрэй" хэмээсний "Асрахуй сэтгэл" нь амьтан бүгдийг энхрий хүү шигээ сэтгэлд дотно зохистойгоор үзэх явдал буюу. "Тэгш агуулах" бясалгалаар, тачаах, уурлах зэргээс үүдэх сэтгэлийн өөвөн сөөвөн гэмүүдээ амарлиулж, сайтар боловсруулсан "тарианы газраа", сэтгэлд зохистойд үзэх "асрахуйн усаар чийглэж", "нигүүлсэхүйн сайн хөрөнгийг талбиваас, их нигүүлсэнгүй амар хялбар төрнө" хэмээн айлдсан эдгээр машид их аньстай болохыг мэдээрэй. ***Үүнээ гурваас:***

1/ Эх хэмээн бясалгах. Орчлон тэргүүлшгүй тул миний төрөл ч тэргүүлшгүй бөгөөд төрөх үхэхийг ээлжлэн дамжсаар орчлонд энэ биеийг (төрлийг) эс авсан ба энэ зүгт төрж үйлдээгүй гэх явдал огоот үгүй буюу. Бас эх тэргүүтэн садан төрөл болж яваагүй гэж үгүй мөн. *"Газрын бодит суурь"*-аас: "Эрт урьд өнөд холын цаг өнгөрсөн ч тэнд төрөөгүй ба очоогүй, үхээгүй орон зай, газар дэлхий түүнийг олоход бэрхтэй. Өнө холын цаг өнгөрөхөд алин амьтан чиний эцэг, эх, хүү, охин, багш, лам, удирдагч болж яваагүй тийм нэгнийг олж үзэхэд бэрхтэй байна надад" хэмээн айлджээ. Урьд нь эх болж явснаар барахгүй, ирээдүйд ч эх болох хэмжээлшгүй тул тэр мэтийг санаж, миний ээж болж явсныг магадлан баттай таньж мэдэх хэрэгтэй. Ийм бодол төрвөөс цаашдаа түүний ачийг санах тэргүүтний

бодол төрөхөд хялбар болно. Эс төрвөөс ачийг санах тэргүүтний суурь үл гарах болой.

2/ Ачийг санахуйг бясалгах. Хамаг амьтныг эх хэмээн бясалгаж сурсны дараагаар, "эхлээд энэ насны ээжээ бодож бясалгаваас түргэн төрнө" хэмээн Бодава гэгээн болгоосон мэт бясалгах хэрэгтэй. Өмнөө ээжийнхээ дүрийг тодорхой санаад, "эдүгээ зогсохгүй орчлон тэргүүлшгүй цагаас тоолшгүй олон удаа миний ээж явсан юм шүү тэр гэж" хэдэнтэй санах мөн. Тийн санахдаа тэрээр ээж минь явахын цагт хамаг аюулаас намайг авран хамгаалж, тус амгалан бүгдийг бүтээж, ялангуяа энэ насанд намайг хэвлийдээ өнө удаан тээж, төрүүлэхийн цагт шар үсээ барж, мах цусаа таслуулан байж төрүүлээд, арван хуруун дээрээ тосч авч бүүвэйлэх, ангир уургаа амлуулах, сүүн мээмээ хөхүүлэх, нус цэрийг минь амаараа сорох, бөөлжис гулигдасыг минь хэлээрээ долоох, баас шээсийг минь гараараа арилгах зэрэг элдэв алжаал зүдрэлийг үл хайхран, асарч тойлон өндийлгөв намайг.

Бас өлсөж ундаасахын цагт хооллож ундлан, даарч бээрэхийн цагт гутал хувцсыг өгч, үгүйрч ядуурахын цагт өөрөө ч эдлэлгүй, эд баялгаа өгдөг билээ. Тэдгээрийг бас амар хялбар олоогүй, нүгэл буян, муу яриа хэл элдэв зүйлийн дундуур холилдон байж махаа барж, ясаа цайтал тэмцэлдэн явж олж өгсөн мөн. Хүүд нь өвчин зовлон тохиохуйд "хүү үхсэнээс би үхсэн нь дээр, хүү өвдсөнөөс би өвдсөн нь дээр, хүү зовсноос би зовсон минь яалаа" гэж сэтгэлийн мухраас андгайлан тэр бүхнийг арилгахын аргыг бүтээдэг билээ. Товчилбоос, өөрийн мэдэх чадах бүхнээр аливаа тус амгалан бүгдийг бүтээнэ. Хорлол, зовлонг арилгах арга бүхнийг нэгэн үзүүрт сэтгэлээр үйлдэнэ.

Тийнхүү бясалгасанаар ачийг хариулах ухаан үг төдий бус нэгэн төрвөөс цаашлаад эцэг тэргүүтэн бусад садныг ч эх гэж мэдэн тэр адилаар бясалгаарай. Улмаар завсрын буюу танихгүй садныг ч эх мэт гэж мэдэж бясалгаарай. Тэднийг өөрийн садан адилд бодох ухаан нэгэнт төрвөөс, дайснаа ч эх хэмээн таниж мэдэн бясалгаарай. Тэднийг эх адил мэдэхийн ухаан нэгэнт төрвөөс урьд нь арван зүгийн хамаг амьтныг эх хэмээн мэдэх зэргээр зэрэгчлэн нэмэн нэмж арвижуулан бясалгаарай.

3/ Ачийг хариулахуйг бясалгах. Тэр мэтээр төрөх, үхэх хоёр ээлжилсээр бие биенээ танихаа болисноос бус, миний ачит ээж адил тэдгээр амьтан бүхэн зовж зүдэрч, аврал өршөөлгүй болчихоод байхад

тэднийгээ тоолгүй орхичихоод өөрөө зовлонгоос гэтлэнэ гэвээс түүнээс илүү ичгүүр байхгүй биз ээ. *"Шавийн захидал"*-аас:

Ойр зуурын орчлонгийн далай доторх
Эргүүлгэ ёроолд унасан байхыг харсаар хирнээ
Үхэх, төрөхөөр солигдож биенээ танихаа байсан тэднийг орхиод
Ганцаар гэтлэнэ хэмээвээс түүнээс илүү ичгүүр үгүй хэмээжээ.

Тэр мэтээр ачитнаа орхих нь доодост ч зохисгүй тул миний ёсноо бүр ч таарахгүй хэмээн санаж ачийг хариулахын үүргийг хүлээх хэрэгтэй.

Мөн түүнээс:

Өвөр дээр нь гарч чадахгүй юуг ч үл чадах нялх байхад
Асрах сэтгэлээр мөөмөө садруулан хөхүүлэн угжих зэргээр
Алжаал зүдрэлийг туулан байж асарч бойжуулсан тэднийгээ
Хэдий доорд нэгэн байлаа ч огоорохыг хэн хүсэх

Хэний ч гэрт энэ үеийг олж амьдрах бөгөөд
Хэн хүний нигүүлсэх сэтгэлийн ач буяны нь авчихаад
Нисваанисын зовлонт аврал өршөөлгүй, адгийн бэртэгчин,
Доорд хэн байлаа ч энд орхихыг хэн дурлах вэ хэмээсэн ба,

"Хязгааргүй эрдмийн магтаал"-аас:

Алин амьтан мунхагийн харанхуйгаар сэтгэл доройтон амьтан болж
Эцэг хүү явахдаа намайг өргөн хүндэлж асарч тусалсан буюу
Тэднээ орхиод ганцаар гэтэлнэ гэдэг миний ёс биш хэмээн
Тиймийн учир авралгүй амьтсыг гэтэлгэсү хэмээн ерөөл талби хэмээжээ.

Чингэхэд хэрхэн тусыг хариулж үйлдэх вэ? Орчлонгийн амгалан жаргалант учрал нэгийг ээж өөрөө хэдийнээ олчихсон гэхдээ тэр бүгд хуурмаг мөн. Тиймээс урьдын нисваанисын адаар хөөрсний уршгаар, "дайран дээр давс нэмэв" гэгчийн үлгэрээр, өвөрчлөн зовлонт байгаа тэдгээрт дахин элдэв зовлонг учруулахгүй байх чухал аа. Асран энэрч тусалсан тэднийгээ гаслангаас нөгчигсөн нирваны амгаланд байгуулсугай хэмээн ачийг хариулах учиртай. *"Төв үзлийн гэгээ"*-нээс:

Бас урьд нисваанисын адаар хорлогдсодыг би
Шархыг урвуулан үйлдэгчийг тавих адил
Зовлонт өвчнөөр юунд зовно вэ

Бусад төрөлд алин байгаагаар
Асран өргөж тус хүргэсэн
Тэдний хариуд тус болох нь
Гаслангаас нөгчөөхөөс бусад алин буй хэмээжээ.

"Далай, сүмбэр уул зэргийн үүргээс ачийг эс хариулсны үүрэг их бөгөөд ачийг хариулах гэдэг мэргэдийн сайшаалын орон хэмээн айлджээ.

"Лусын хаан Адаагийн шүлэглэсэн судар"-аас:

Далай болоод Сүмбэр уул,
Газар дэлхий үүрэг бус
Ачийг хариулж чадаагүй алин
Тэр л миний их үүрэг мөн

Алин хүний сэтгэл үл догширон
Ачийг хариулж үйлдвээс гайхамшиг буюу
Ачийн хариуг үл шамшигдуулагч
Тэдгээрийг мэргэд машид сайшаав хэмээжээ.

б) Амьтныг сэтгэлд зохистой үзэх. Товчлон хураавaас, ээжийн минь ухаан санаа самуурч галзуураад, нүд нь харахаа больж сохроод, дагуулж хөтлөх ч хүнгүй аймшигт хадан хясаа руу алхам алхамаар шууд зүглэн одох үед, тийм болсон ээж хүүдээ горилохоос өөр хэнд горилох билээ. Тэр хүү л ээжийгээ аюулаас аврах үүрэг үүрэхээс өөр хэн үүрэх вэ. Ээжийгээ аврах л хэрэгтэй болно. Тэр адилаар эх болсон хамаг амьтан нисваанисын ад донгоор сэтгэл өвчилж хямарснаар ухаан санаа нь өөрийн эрхгүй галзуурсан, өндөр язгуур гэтлэхүйн мөрийг үзэх нүднээс хагацсан, үнэн буяны саднаар хөтлүүлж чадахгүй, агшин тутамд гэмт явдалтай учрах аюул руу алхаж явна. Ер нь орчлон болоод ялангуяа муу заяаны халил хадны ирмэг рүү дөхөх эх хүүдээ горилоно. Хүү нь ч эхийгээ татаж авах учиртайг санаж зовлонгоос магадтай гарган ачийг хариулан үйлдэх мөн. *"Суртгаалын хураангуй"*-гаас айлдахдаа:

Нисваанисаар галзуурч мунхагаар сохрон
Их халил хавцалын зааг мөрд
Алхам алхамаар ойртон одох мэт
Өвөр бусад үргэлж гаслахын суурь болсон
Амьтан бүхний зовлон адил билээ

хэмээсэн мэтээр үзэхдээ, "бусдаас гэм эрэх нь зохисгүй бөгөөд эрдэм тустайг олж харж биширэх гайхамшигтай" гэсэн хэдий ч, энэ үед ядарсан байдлын талаас бодох учиртай аж.

(2) *Тэрхүү сэтгэлийг бодитой төрүүлэхэд гурав:*

(а) Асрахуй сэтгэлийг бясалгах: Асрахуй сэтгэлийн зорих орон нь амгалан төгөлдөр бус амьтан болой. Бодол нь, амгалантай учирваас юун сайн хэмээх ба амгалантай учирсугай хэмээх, амгалантай учруулж үйлдсүгэй хэмээх болно. Тус эрдэм нь *"Бясалгалын хаан"*-аас:

Сая живаагаар тоологдох арилсан орноо
Алин олон зүйлийн тахил бүхнээр
Дээд төрөлхтнийг үргэлжид түүгээр тахих нь
Асрахуй сэтгэлийг бясалгасны нэг хувьд ч хүрэхгүй

хэмээн асар их хэмжээт бодит тахилаар эцэс, хойдын орныг цаг үргэлжид тахисан буянаас илүү их болохыг айлджээ. *"Манзуширийн орныг байгуулахуй"*-гаас: "Зүүн хойдын завсраас Санжай Ванчүгчэнбу бурханы "мянган ертөнцийн чимэг" хэмээх оронд аяга тахимлагууд амарлингуйг бясалгаж амгалан жаргалтай ажран суухтай адилаар амьтан бүхэн тэнд амгалан төгөлдөр байна. Тэнд зуун мянган сая живаа жилээр ариун явдлыг эдэлснээс, энэ оронд наанадаж ганцхан инчдэхийн зуурд хамаг амьтныг асрах сэтгэлийг эгүүсгэх нь дээрхээс үлэмж их буяныг эгүүсгэх тул өдөр, шөнөд бясалгахыг хэлэх юун" хэмээжээ. *"Эрдэнийн эрхи"*-ээс:

Ноёны хөвгүүд гурван зуун амны идээг
Өдөр бүр гурван цагт өргөх нь
Агшин эгшин төдийн асрахуй сэтгэлийн
Буяны нэг хувьд үл хүрэх

Тэнгэр хүмүүн асралдах болоод
Тэдгээр бие биенээ сахих ба
Сэтгэл амгалант, амгалан олонт болох
Хор мэсээр хорлогдохгүй ба

Шамдалгүйгээр хэргээ бүтээх ба
Эсэрвагийн ертөнцөд төрөх бөгөөд
Гэтэлж хэдий эс чадавч
Асрахуйн найман эрдмийг олох

хэмээн айлдсан ба асрах сэтгэлтэй болвоос тэнгэр хүмүүс асралдан аяндаа хураагдах, мөн бурхан бээр шумнасын аймгийг асрахуйн сэтгэлээр ялан зохиосон сахихуйн дээд болох тэргүүтэн болой. Хэдийгээр төрөхөд бэрхтэй ч шамдах хэрэгтэй. *"Суртгаалын хураангуй"*-д: "Алтан гэрэл сударт гарсан асрахуй, нигүүлсэхүй сэтгэлийг бясалгахыг заасан бадгууд бүгдийг санаж наанадаж үгийг нь уншиж бясалгаарай" хэмээжээ. Тэр үг нь:

Дээд алтан гэрэлтийн их хэнгэргийн дуугаар
Гурван мянган ертөнц энэ гурван ертөнцөд
Муу заяаны зовлон, эрлэгийн зовлон ба
Үгүйрлийн зовлонгийн зовлон амарлих болтугай хэмээх тэргүүтэн болой.

Асрахуйг бясалгах гэдэг нь: эхлээд хамаатан садан дээр бясалгаж, дараа нь завсарынханд, удаа нь дайснаа бясалгах бөгөөд явсаар хамаг амьтнаа зэрэгчлэн бясалгах мөн. Бясалгах ёс нь хэрхэн амьтан зовлонгоор зовохын ёсыг дахин дахин санаад их нигүүлсэхүй төрдөг мэт амьтнаа цувирах ба цувирахгүйн амгалан үгүй, амгалангаар хоосорсон ёсыг дахин дахин санах бөгөөд түүнийг дадуулснаар амгалантай учруулах хүсэл аяндаа гарна. Тэрхүү элдэв амгаланг сэтгэлдээ санаж тэдгээрийг амьтнаа өгч үйлдэх мөн.

(б) Нигүүлсэхүйг бясалгах нь: Нигүүлсэхүй сэтгэлийн зоригдол нь гурван зовлонгийн аль нэгээр зовсон амьтан болой. Байдал нь зовлон тэдгээрээс хагацваас юун сайн, хагацсугай, хагацуулж үйлдсүгэй хэмээх болой. Бясалгах зэрэг нь эхлээд хамаатан садан дээрээ, дараа нь завсарынханд, удаа нь дайсан дээр бодож сурах мөн. Дайснаа садантай адил хэмээн сэтгэл тэгшид агуулах цагт зэрэгчлэн арван зүгийн амьтан бүхнээ л бясалгах мөн. Тэр мэтээр тэгш агуулах болоод асрахуй, нигүүлсэхүйн орныг тус тус ялган зэрэгчлэн бясалгах ёсыг *"Илт онолын судар"*-ыг даган баримталж Ловон Камалашилагийн туурвисан тэр ном маш их аньстай, Тус тус ялгалгүй эхлээд ерөнхийд бодох нь бүдүүхэн мэт үзэгдэвч, нэг нэгээр бодоход алин ч төрөхгүй болж үзэгдэнэ. Харин ганц нэгээр бодоход сэтгэл урвахын амсуурга урьд номносон мэт гарч хэтэрхий олон болох вий. Ерөнхийлөн бодож судалваас нийлүүлсэн юм уу тус тус алинаар бодсон ч зүй ёсны бодол төрдөг.

Бясалгах ёсны хувьд эх болсон тэдгээр амьтан зовлонд унаж нийтийн ба тус тусын зовлонг хэрхэн амсаж буйг санах мөн. Зовлонгийн тухай дээр

номносон билээ. Өмнө нь дунд төрөлхтний мөрийг судалж байснаар бол өөрийн зовлонт байдалтай жишиж бясалгаваас амар хялбар төрөх мөн. Өөрийн тал дээр, тэдгээрийг санаваас магад гарахуйн санаа төрөх үндэс төрдөг бол, бусдын талаас бодвол нигүүлсэл төрөхийн үндэс болно. Гэвч эхлээд өөр дээрээ бодож санахгүй бол аньстай болж өгөхгүй. Эдгээр нь зөвхөн эхлэл төдий бөгөөд дэлгэрүүлбэл, нигүүлсэх сэтгэлийн зоригдохуун орноо зуун арван зовлон буй хэмээн *"Бодийн газар"*-аас айлдсан тул ухааны хүчтэн нар бясалгаж үйлдээрэй.

Сонсоод сонсогч зовлонгийн үнэнийг илт онох ба эцэст нь уйсах сэтгэлээр зовлонг ухаарснаас бодисадва нар нигүүлсэх сэтгэлийг бясалгаж зовлонг бодох нь илүү олон хэмээн айлджээ. Амгалан үгүй, зовох ёсыг олонтаа санаваас асрахуй, нигүүлсэхүй хоёр ч машид олонтаа төрнө. Өнө удаан бодвоос хүчтэй баттай нэгэн төрөх ба өчүүхэн төдий увдисаар цэнгэж их гол зарлигаас айлдсан номыг бясалгахаа огоорвол хүч багасах болно.

Тиймээс дээр өгүүлсэн мэт их хөлгөнөө орохын үүд бодь сэтгэл мөн бөгөөд нигүүлсэхүй сэтгэл нь язгуур болж одох ёс зэргийг тухайлан сайтар ялгаж ухаараад, тус тус онох билгээр шинжилж судалсны эцэст амсуурга нэгэнт төрөх учиртай. Ухаарсан ч зоригдлоо сайтар ялгаж чадалгүй ургасан бүхэнд хэсэг бусаг амсуурга гаргах төдийгөөр юунд ч хүрэхгүй. Анхааран авахын бусад үед ч тэр мэтээр мэдээрэй.

Нигүүлсэхүй сэтгэл төрөх хэмжээний талаар *"Бясалгалын анхдугаар зэрэг"*-ээс айлдахдаа: "Аль ч цагт энхрий хайртай хүүгээ зовж шаналахад эх хүнд өрөвдөх, хайрлах сэтгэл аяндаа гарах тэр адилаар амьтан бүхнийг зовлонгоос ашид гаргах чин хүслийг агуулсан ихэд өршөөн нигүүлсэх сэтгэл, мөн өөрийн агаараас ая зөндөө гарч ижилсэх тэр цагт тэр сэтгэл төгсөх бөгөөд их нигүүлсэхүйн нэрийг олно" хэмээжээ. Мөн "Энхрий нялх хүүхдээ зовлонд учрахад ээжид хэдий хэмжээний нигүүлсэл төрж буй төдий чинээгээр нь ээжийн сэтгэлийн хэрцэдийг хэмжигтүн. Хамаг амьтныг нигүүлсэх сэтгэл хар аяндаа төрөх хэрцэдээр их нигүүлсэхүйн бэлэг чанар төгс болно" хэмээжээ. Үгээр их асрахуй сэтгэл төрөхийн хэмжээг мэдээрэй.

Мөн энэ талаар "Эш"-ээс залгуулан: "Тийнхүү их нигүүлсэхүйг дадуулсны хүчээр амьтан бүгдийг дээш татна хэмээн тангарагт ханьцашгүй туулсан бодь хутгийг ерөөх мөн чанарт бодь сэтгэл нь хяналтгүйгээр төрөх бөгөөд" хэмээн ерөөхүйн бодь сэтгэлийн уг үндэс нь их нигүүлсэхүй сэтгэл

болохыг айлджээ. Үгээр бодь сэтгэл төрөхийн хэмжээг ч мэдэж үйлдээрэй. Гэхдээ энэ нь дээд мөрд хүрсэн бодь сэтгэл биш бөгөөд үйлийг анхдагчийн бодь сэтгэлийг ийн айлджээ. *"Хураангуй хөлгөн"*-өөс:

Сайн ерөөлийн хүчтэн ба
Баттай дуршилаар ялгамжаатай одох
Бодисадва нь цаглашгүй гурван галавт
Бүхнийг туурвиж зохиох мөн

хэмээн айлдсан тул тоолшгүй гурван галвын буяныг хураах эхийг тавьсан бодисадваад ч тэр адилын сэтгэл төрөх хэрэгтэй.

Тиймээс эдгээр орон зүг төдийг бус хамаг амьтны тусын тулд бурханыг олж үйлдсү. Түүний тухайд энэ буяныг үйлдсүгэй би хэмээх санаа төрөх төдий юм шиг их зонхи нь эндүүрч, олоогүй зүйлээ оллоо хэмээн илт омгорохон бататгах үзэгдэнэ. Бодь сэтгэлийг увдисын туйлд барьж судлалгүйгээр бусад хэн нэгнээс эрж хайх ба олон газрын эрдмийг тасалж (алгасан) олох хүсэл төдийхнөөр бодох зэрэг нь их хөлгөний аньсыг мэдэгч нарын нүдэнд инээдэм наадмын орон болж харагдана. Дээд бодисадва нар олон галавт тааллынхаа туйлд барьж судалсан гэж олон номонд айлдаад байтал зөвхөн ухаарах төдийгөөс цаашгүй хэн бүхийг хэлээд яах вэ? Энэ нь бусад мөрийг бясалгаж болохгүй гэж хэлж байгаа юм биш, бодь сэтгэлийг судлах аймагт л увдисын туйлд барьж эгүүсгэх хэрэгтэй гэж айлдсан буюу.

Ер нь урьд номносон дагуу амсуурга төрөөгүй ч их хөлгөний суртгаалыг ухаарч, түүнээ баттай сүсэглэх сэтгэл төрөөд ирвэл урьдаар бодь сэтгэлийг эгүүсгэж, тангараг санваарыг зан үйлээр авсны дараа Бодисадын явдалд орох бас бий. *"Бодичарияаватара"*-гаас айлдахдаа: "Өмнө нь санваар болон бодь сэтгэлийг барих ба, түүний суртгаал зургаан барамидын бясалгал дияаны бүлэгт бодь сэтгэлийг судлах ёсыг дэлгэрэнгүй ез номносон мэт болой.

Гэхдээ тэдгээрийн сав болохын тулд өмнө нь, олон ухааныг судлах шаардлагатай аж. Тус эрдмийг санах, долоон гишүүнтийг өргөх, авралыг одуулах зэргээр сэтгэлээ ариусгах ба суртгаалаа мэдэж, сахих хүслийг төрүүлэх зэрэг болой. Мөрд зорихуйяа хоосон чанарын онолыг судлаж дээш дээш арвижуулах шаардлагатай гэх нь нэр төдий нэгэн үзэгдэх хэрнээ бодь сэтгэлийг ч машид сайн судалж, илүү ялгамжаатайгаар дээш дээш хөгжүүлсээр мөрд зорчих шаардлагатай гэх нь нэр төдийд ч алга байна.

Эдгээрийг хорин нэгэн бодь сэтгэлийг заасан *"Ялгуугсан бүгдийн зорчих гагц мөр билиг барамидын увдис шастар"*-аас болон тэдгээр мөрд зорчих ёсыг заасан *"Их тэрэгчин"* нарын номноос мэдээрэй.

(в)Үлэмж сэтгэлийг бясалгах: Тийнхүү асрахуй, нигүүлсэхүй сэтгэлийг бясалгаж сурсны дараа "Аяа, миний сэтгэлд зохист эдгээр амьтан тэр мэтээр амгалангаар хоосорч зовлонгоор нэрвэгдчихээд байхад, тэднийг хэрхэн амгалантай учруулж, зовлонгоос гэтэлгэх вэ" хэмээн санаж, тэднийгээ аврах үүргийг үүрэхээр наанадаж үг төдий ч гэсэн сурах хэрэгтэй. Ачийг хариулахын үест энэ талаар өчүүхэн гарсан боловч энд үзүүлж байгаа нь "амгалантай учирвaас юун сайн буюу зовлонгоос хагацваас юун сайн" хэмээх асрахуй, нигүүлсэхүй сэтгэлээр хязгаарлахгүй "би бээр амьтнаа амгалан жаргаланг бүтээе" хэмээх санаа хүчийг агуулсан асрахуй болоод нигүүлсэхүй сэтгэлийг төрүүлэх шаардлагатай болохыг үзүүлнэ.

Тэдгээрийг зөвхөн тунгийн хугацаанд бус, тунгийн төгсгөлийн явдал мөр бүгдэд санаж үйлдэх зэргээр үргэлжид судалваас ахицаа их гарна.

"Бясалгалын дунд зэрэг"-ээс: "Их нигүүлсэхүй түүнийг бясалгаж байхдаа ч явдал мөр бүхэндээ ч бодох буюу цаг үргэлжид хамаг амьтныг гэж бясалгаж үйлдээрэй" хэмээсэн нь их нигүүлсэх анх төрж буй үе болоод ямар юм бодож байсан үед ч бодох хэрэгтэй. Их багш Зандрагоми бээр:

Сэтгэлийг модон тэргүүлшгүй цагаас
Нисваанисын гашуун шимээр чийглэгдэн халдсан
Жинхэнэ сайхан амтыг гаргаж үл чадах тул
Эрдмийн усан дусал дусаагаад юу болох билээ

хэмээн машид гашуун амттай дэгд модноо бурмын шүүсийг дусал дуслаар цутгавч, чихэрлэг амттай болж чадахгүйн адил тэргүүлшгүй цагаас нисваанисын гашуун шүлт халдсан сэтгэлийн үндсийг асрахуй, нигүүлсэхүй тэргүүтэн эрдэм бясалгалын өчүүхэн ганц нэг тунгаар яагаад ч урвуулж чадахгүй болохыг айлдсан тул үргэлжид суралцах хэрэгтэй.

б) Бодь хутгийг чухалчлах ухаанд суралцах

Дээрх номын зэргээр нэхэж бусдын тусыг бүтээхийн тулд бодь хутаг хэрэгтэй болохыг мэдэж, түүнийг олох хүслийг төрүүлнэ. Гэвч тэр төдийгээр хязгаарлахгүй дээр авралыг одуулахын үест номносон мэт лагшин, зарлиг, таалал, үйлс, эрдмийг санахын үүднээс эхлээд сүсгээ аль чадахаар

арвижуул. "Сүсэглэх нь дуршил төрөхийн шүтээн болно" гэж айлдсан тул тэдгээр эрдмийг үнэн сэтгэлээс олюу гэх хүслийг төрүүлнэ. Өөрийн тусад ч гэсэн Хамгийг болгоогчийг олох ёстой гэдгийг магадлан ухаарна. Бодь сэтгэл төрөх олон шалтгаан байдаг ч, нигүүлсэхүйг нэмэх замаар төрүүлэх нь ихэд ялгамжаатай болохыг "Билгийн мутрын тамгын дияан"-аас зарлиг болсныг *"Бясалгалын эхний зэрэг"*-т айлджээ.

в) Суралцсаны үр – Бодь сэтгэлийг бодитой танин барих

Ерөнхий бэлэг чанарын хувьд дээр номносон *"Илт онохуйн чимэг"*-ээс айлдсан дагуу мөн. Ялгалын хувьд *"Модон байгуулах судар"*-ын дагуу *"Бодичарияаватара"*-д айлдахдаа:

Явахыг хүсэх ба явахын
Өвөрмөц ялгааг хэрхэн мэдэх мэт
Тэрчлэн энэ хоёрын
Өвөрмөц ялгааг мэдээрэй, Мэргэд ээ

хэмээн ерөөх ба орохуйн хоёр сэтгэл байхыг айлджээ. Үүнээс бусдаар айлдсан олон боловч "амьтны тусад бурхан болсу" хэмээх буюу "Бурхан болж үйлдсү" гэж ерөөх ба, өглөг тэргүүтний явдалд суралцах ч бай, эс суралцах ч бай ялгалгүй хэзээ санваар аваагүй байх тэр хүртэл ерөөхийн сэтгэл байна. Санваар авснаас эхлэх тэрхүү сэтгэл нь орохуй сэтгэл болохыг мэдээрэй.

"Бясалгалын анхдугаар зэрэг"-ээс "Хамаг амьтнаа туслахын тухайд бурхан болсугай хэмээн эхлээд чухалчлах тэр нь ерөөхүйн сэтгэл болно. Алин тангараг авснаас хойш чуулганаа орох тэр нь орохуйн сэтгэл болой" хэмээжээ. Энэ үест эсэргэлдэх хариу олон үзэгдэвч эс цацруулвай.

б. Бодисадва Шантидэва гэгээний номоос гарснаа шүтэн суралцахад гурав

1) Өвөр бусдыг арилжих сольж бясалгахын тус эрдэм ба сольж бясалгаагүйн гэм

2) Түүнд дадаж сурваас төрүүлэх чадал

3) Өвөр бусдыг солих талаарх гэмийг арилгаж бодитой бясалгах ёс

1) Өвөр бусдыг сольж бясалгахын тус эрдэм ба сольж бясалгаагүйн гэм: *“Бодичарияаватара”*-гаас:

Алин өөрийг болон бусдыг
Түргэн аврахыг хүсэгч тэр бээр
Өөрийг бусадтай арилжих хэмээгдэх
Дээд нууцыг судлан үйлд хэмээсэн ба,

Ертөнцийн амгалан юу бүхэн
Тэр бүгд бусдад амгалан хүсэх сэтгэлээс гарах
Ертөнцийн зовлон юу бүхэн
Тэр бүгд өөрт амгаланг хүсэх шуналаас уршигдах

Олныг өгүүлэхийн хэрэг юун
Нялхас өөрийн тусыг зохиох ба
Бурхад бусдын тусыг зохиох
Энэ хоёрын ялгааг хараарай

Өөрийн амгалангаа бусдын зовлонгоор
Үнэхээр арилжиж эс чадваас л
Бурхан ямагт үл бүтэх бөгөөд
Орчлонд амгалан юу ч үгүй буюу хэмээн айлджээ.

Тиймд “өөрийгөө энхрийлэн барих” гэдэг гутамшиг бүгдийн үүд, (харин) “бусдыг энхрийлэн барих” нь хотол чуулган (сайн сайхан) бүгдийн орон мөнийг санаарай.

“Өвөр бусдыг арилжих” сэтгэлийг дадуулж чадахын тулд өөрийн дайсны нэрийг урьд нь сонсоод их айдаг байсан нэгэн, хожим эвлэрч найрамдан нөхөд болсны дараа “нөгөө садан” эзгүй болвол үгүйлж, ихэд шаналан төрөх мэтээр сэтгэлээ дадуулахын үүднээс өөрийгөө бусад шиг, бусдыг өөр шигээ хэмээн үзэж дадуулваас төрнө. Дээрхээс:

Бэрхшээлээс няцаж бүү үйлд
Энэ мэтээр бясалгасаны хүчээр л
Алин нэрийг сонсохоос айдаг байснаа
Тэр үгүй бөгөөс шаналах болох хэмээсэн ба,

Өөрийн биеэ бусдын болгон
Санах тэр ч бэрх бус хэмээжээ.

Гэвч бусдын бие миний бие биш тул түүнийг өөрийн болгож яаж бодох вэ? хэмээвээс, Энэ бие ч эх, эцгийн дусал цуснаас бүтэж бусдын биеийн тасархай болж ирсэн бөгөөтөл урьдаас сурсан болохоор "минийх" гэж үздэг шүү дээ. Түүнтэй адилаар бусдын биеийг өөрийн гэж энхрийлэн барьж дадуулваас төрнө. Дээрхээс:

Тиймд хэрхэн бусдын
Шим, дусал, цусыг
Та минийх гэж барьдаг мэт
Тэрчлэн бусдад (өөрийн гэж) дадуулж үйлд хэмээжээ.

2) Түүнд дадаж сурваас төрүүлэх чадал: Тэр мэт тус эрдэм, гэм эргүү зэргийг сайтар санаж, зүрхний мухраас түүнийг бясалгах хүчтэй дуршил төрөх хүртэл дадуулваас төрөх боломжтойг мэдээрэй.

Өвөр бусдыг арилжих ёсыг бясалгах зэрэг: "Өвөр бусдыг арилжих" хэмээх ба "Өөрийг бусад болгох, бусдыг өөрийгөө болгож үйлд" хэмээн айлдсан нь "бусдыг би болой" гэх буюу "бусдын нүд зэргийг минийх" гэх зэргийн ухаанд суралцах бус. Харин "өөрийгөө энхрийлэн барих" ба "бусдыг ясал орхих" хоёр сэтгэлийн байрыг сольж арилжих болой. Бусдыг өөр шигээ энхрийлэн барих, өөрийгөө бусад шиг ясал орхих ухааныг төрүүлэх явдал мөн. Тиймд өөрийн амгаланг бусдын зовлонгоор арилжих гэж айлдах нь ч өөрийг энхрийлэн барих сэтгэлээ дайсанд үзээд өөрийн жаргалаа ихэд хөөхийг хориглож, улмаар бусдыг энхрийлэн барих сэтгэлийг эрдэм хэмээн үзэж, бусдын зовлонг ясал орхихоо больж, түүнийг арилгах тусыг бүтээхээр орох мөн.

Тэр ухаанаа суралцахад хоёр тотгор буй. Өвөр, бусдын жаргал, зовлонгийн суурь болсон өвөр, бусад хоёрыг хөх, шар өнгө мэт тус тус алагчаалан (үнэнд) бүтсэн мэт барих бий. Үүнээс үүдэж түүнээ түшилдэх жаргал, зовлонг ч энэ нь "минийх мөн" гээд (үнэнд) бүтээх санааг арилгаарай. Тэр нь "бусдынх" гээд ясал орхидог тул тэдгээрийн ерөндөг болвоос өвөр, бусад (гэдэг) мөн чанараар тус тус ялгагдахгүй бөгөөд инагш, чинагш шүтэлцсэн тул өөрт ч бусад гэх ухаан төрөх, бусдад ч өөрөө гэх ухаан төрнө. Холын уул ойрын уул мэт. Үлгэрлэвээс, холын уулыг эндээс харахад холын уул гэх бодол төрөх. Гэтэл тэр холын уулнаа хүрсэн цагт ойрын уул гэх сэтгэл төрөх мэт болой.

Тиймд хэн хүнд хөх өнгийг хараад хөх өнгө гэдэг ухаан төрөх болохоос бусад өнгө гэх ухаан төрдөггүйтэй адил бус болой. Тийн болохыг

"Суртгаалын хураангуй"-гаас:

Өвөр бусдыг тэнцүүлэн дадуулж сурснаар
Бодь сэтгэл нь батад орших
Өвөр, бусад нь харгалзах бөгөөд
Чинагш, янагш адил хуурмаг

Хүрвээс өөрөө чинад бус болох
Алин нэгнээ харгалзан янагш болох
Өөрөө ямагт өөрөө эс бүтсэн тул
Алин нэгэн харгалзан бусад болох

хэмээн харгалзан шүтэлцсэн агуулга төдий болохоос, өөрийн мөн чанараар бүтсэн үгүй болохыг айлджээ. Мөн бусдын зовлон намайг хорлохгүй тул түүнийг арилгахаар хичээхийн хэрэг юун гэх тотгорыг арилгахдаа, "Чингэвээс хөгшрөхийн цагт зовлон ирнэ гээд, залуудаа эдийг хураах хэрэггүй болох уу. Хөгшрөхийн зовлон залуу насыг хорлохгүй шүү дээ. Түүнтэй адил хөлний өвчнийг гараар арилгаж болохгүй юу. Бусад (өөр) юм чинь" хэмээсэн буй.

Хөгшин, залуу гэх, урьд, хойд төрөл гэх ч бэлэгдэл төдий мөн. Өглөө, орой, үдээс өмнө, хойно гэхэд ч найруулаарай. Хөгшин, залуу гэдэг нь нэг юмны үргэлжлэл билээ. Гар хөл цуглаж нийлсэн нэгэн мөн. Гэвч тэд өвөр, бусад хоёртой адилгүй гэвэл болохгүй. Үргэлжлэл ба цуглах гэдэг олон агшинууд нийлж цуглахыг нэрийдсэн буюу. Өөрөө төрсөн мөн чанар байхгүй. Өөрийн би ба бусдын би-ч цуглаж бүтсэн агуулгатай тул, өвөр (би) гэдэг бусадтай харгалзан нэр төдий болохоос бус өөрийн мөн чанараар бүтээгүй болно. Гэвч тэргүүлшгүй цагаас энхрийлэн барьж дадсаны эрхээр өөрт зовлон гарахад үл тэсэхийн адилаар бусдыг энхрийлэн барих сэтгэлийг дадуулваас түүний зовлонд ч тэсэхгүй болж чадна.

3) Өвөр бусдыг солих талаарх гэмийг арилгаж бодитой бясалгах ёсон

Тэргүүлшгүй цагаас өдгөөг хүртэл өөртөө тачаасны эрхээр өөрийгөө энхрийлэн барих энэ сэтгэлээр хүсээгүй элдэв зүйлийг бий болгосон. Өөртөө сайн сайхан нэгийг бүтээхийг хүсэвч өөрийн тусыг чухалчлах буюу буруу аргад орсноор тоолшгүй олон галав өнгөрсөн ч өвөр болоод бусдын тус алиныг ч бүтээсэнгүй.

Бүтээж чадаагүйгээр үл барам харин зовлонд нэрвэгджээ. Өөрийн тусын төлөө гэх бодлоо бусдын гэж өөрчилсөн бол аль эрт бурхан болчихоод бусдын тусад хамаг сайн сайхан бүгдийг бүтээх нь осол омтоггүй билээ. Тэр адилыг эс үйлдсэн учир бэрхшээлтэй учирч дэмий их цагийг нөгчөөжээ. Эдүгээ энэ бүхнээ ойлгож энэхүү өөрийг энхрийлэн барих гэгч дайсны чуулганыг дурлан санаж, ухамсарлахуйд шүтэж олонтаа шамдахын үүднээс эс төрснийг эс төрүүлэх, төрсний үргэлжлэлд үл орсугай хэмээн сайтар санаж олонтаа хорих хэрэгтэй. *"Бодичарияаватара"*-д:

Үгээр л олон зуун удаа
Орчлонд намайг хорлон үйлдэв
Сэтгэлт та өөрийн тусыг үйлдэхийг хүссээр
Тоолшгүй олон галавт нөгчивч

Их алжаал энэ адилаар
Зөвхөн зовлонг бүтээв та хэмээсэн ба,
Хэрвээ та өмнө нь
Энэ үйлийг үйлдчихсэн болвоос

Бурхан хотол чуулсан амгалан үгүй
Орон үеэс энэ адил болох үгүй хэмээжээ.

Тэр мэт өөрийнхөө зүгийг барилгүй өөрийн бие, төгс эдлэл, буяны язгуурт хорогдохгүй байх ухаанд дахин дахин суралцах ба алин өгөх тусыг үйлдэх шаардлагатай. Түүнээс буруугаар үйлдэх зохисгүй тул тэдгээр бие тэргүүтнээ өөрийн тусад зориулах ухааныг хорьж үйлдэх мөн.

Би гэдэг бусдын эрхэт хэмээн
Сэтгэлт та магад мэдэж үйлдэх
Хамаг амьтны тусаас ангид
Бусдыг та одоо бүү сэтгэ

Бусдын эрхэт нүд тэргүүтнээр
Өөрийн тусыг бүтээх зохисгүй
Түүний тусад нүд тэргүүтнээ
Түүнээс буцааж үйлдвээс зохисгүй хэмээжээ.

Бие тэргүүтнээ бусдын тусад зориулахаа орхиж өөрийн тусыг бүтээх нь бие, хэл, сэтгэлээр бусдад хорлол үйлдэхийн шалтаг болдог байна. Урьд

энэ адилын бодлоор тоолшгүй их хорлолтой учирч байсан. Эдүгээ тустай мэт харагдах засвартай нэгнээ эндүүрч түүний эрхнээ орвоос маш барагдашгүй зовлон үүдэхийг санан хорьж үйлдэх хэрэгтэй.

Та бээр намайг сүйтгэсэн
Урьдын цаг өөр болсон
Намайг үзэгч та хааш одно вэ
Таны дээрэнгүй бүхнийг дарж үйлдсү

Эдүгээ надад өөрийн тусыг
Байна хэмээн сэтгэхийг орхисугай
Би бээр бусдад таныг зарснаар
Үл гуниглан идээ зоогийг өргөсү

Та намайг тамын
Сахиуснаа өгвөөс зохистой
Тэр адил та түр нэг
Намайг өгснөөр өнө зовох

Эдүгээ тэдгээрийг санаж үйлдээд
Та бээр өөрийн тусыг санахаа дарсугай хэмээжээ.

“Тэрчлэн бусдыг энхрийлэн барихын тус эрдмийг дахин дахин санаж зүрхний мухраас хүчтэй дурших сэтгэлийг үүсгэвээс бусдыг ясал орхих ухаан төрөөгүй нь эс төрөх ба төрсөн нь үргэлжлэн залгамжилж үл орно. Бусдыг дотночлох сэтгэлд зохистой, гуа сайхнаар үзэхийн үүднээс урьд нь өөрийгээ энхрийлэн байсны адилаар бусдыг өөртэйгээ адилтган бариарай” хэмээжээ. Тэр мэт амьтныг энхрийлэн барих сэтгэл төрөх үндэс нь, тэдний ачийг хариулах буюу надад тус болсныг ухаарах хэрэгтэй. Сайн хөрөнгийг тарьснаар намрын ургац сайн гарахыг ухаж, атар газарт сайтар хичээнгүйлэн тариснаар (үр) төрөх мэт, амьтны “тариалан”-д өглөг тэргүүтний хөрөнгийг суулгаваас орон үес эцэс, хойдын хамаг сайн амгалан бүтнэ гэдэгт магад итгэмжлэн энхрийлэн бариваас төрөх мөн тул тэдгээрийг санаарай. *“Бодичарияаватара”*-д:

Амьтан болоод бурхадаас
Буяны ном бүтэх нь адил
Бурханаа биширэн үйлдэх адил
Амьтнаа тийн бус нь хэний ёс вэ хэмээжээ.

Амьтны амийг тасалвaaс гурван муу заянд хөтлөгдөх ба амийг аварч гэтэлгэвээс сайн заяа, тэрчлэн урт наслах болно. Хулгай хийх ба төгс эдлэлийг өгөх, уурлах ба асрахуй, нигүүлсэхүйг бясалгаснаар муу заяа болон сайн заянд хөтлөгдөх тэргүүтэн ялангуяа, тэдгээрт тухайлан бодь сэтгэл төрөх ба тэдний тусад явдал мөр бүтэх тул бурхан ч тэднээ (амьтнаа) харгалздаг мөн. Амьтнаа шүтэн өглөг тэргүүтэн огоот төгсөх учрыг "Амьтныг биширч үйлдэх үгсэн тасалбар" зэргээс айлдсан дагуу санаж үйлдээрэй. *"Бодь сэтгэлийн тайлбар"*-т:

Ертөнцийн сайн муу заяа
Хүссэн ба эс хүссэн үр тэдгээрүүд
Амьтнаа тусалж үйлдэх ба
Хорлож үйлдэхээс гарах тул

Амьтнаа шүтэн байж л
Ханьцашгүй Бурханы хутгийг олох тул
Тэнгэр хүмүүний төгс эдлэл алин
Эсэр, Хурмаст, Вишнү, Ертөнцийг тэтгэгч шүтээн

Тэдгээр амьтнаа туслах төдийд
Дээшлээгүй гурван ертөнц үүнээ л
Хаана ч үгүй тул сонин гайхамшигт

Там, бирд, адгуус гээд амьтны
Элдэв зовлон тэр бүгд
Амьтны амсаж эдлэх алив
Тэр бүхэн амьтныг хорлосноос гарсан

Өлсөж ундаасах, янагш чинагш зодолдох
Хатгалдах, сөргөлдөхийн зовлон
Няцаахад бэрхтэй барагдашгүй тэдгээр
Амьтныг хорлосны үр болой

Сонсоод сонсогчийн үр бага байх нь амьтны тусыг тухайлан ихэд үйлдээгүйгээс болсон. Бурхад төгс үрийг олох нь амьтны тусыг ихэд үйлдэхээс гарах тул энэ ёсыг санаж, агшин төдийд ч өөрийн тусын төлөө шунахгүй байхыг зарлиглажээ. Түүнээс:

Амьтнаас сэтгэлээ салгахыг
Хор мэт үзэн шамдан тэвчээрэй

Сонсоод сонсогч нар сэтгэлээ салгаснаар
Доод хутгийг олсон бус уу

Амьтныг огоот орхисонгүй тул
Туулсан бурхад бээр бодь хутгийг олов
Тэр мэт тустай ба тусгүйн
Үр гарахыг сайтар ухваас

Тэд агшин зуур ч гэсэн
Өөрийн тусад шунаж хэрхэн орших вэ хэмээжээ.

Тиймд зөвхөн бусдын тусыг хичээсний үрд буюу бодь сэтгэлийн ногооноос бодь хутаг мэндлэх гэдгийг ухаарч, мөн түүний язгуурт их нигүүлсэхүй болохыг болгоож, бодисадва нар түүнийг бясалгахаар шуудран ордог билээ. Түүнийг ихэд дадуулж баттай болгож аваад бэрхтэй, аугаа их явдал дор өөрийн эрхгүй орох мөн. Түүнээс:

Нигүүлсэхүйн бат сууринаас
Бодь сэтгэлийн ногоо мэндлэх буюу
Гагц бусдын тусын үрд гарах бодь хутгийг
Бурханы шавь нар бясалгаж үйлдэх

Хэн хүн дадуулсаар баттай болгож
Бусдын зовлонг нимгэлэгч нар
Бясалгалын амгалангаа орхиод
Аюус тамд ч орж үйлдэх

Энэ л сонин гайхамшигт
Энэ л магтваас зохист
Энэ л дээдийн ёсны дээд журам хэмээжээ.

Эдүгээ тэдгээр ёсыг дээдэс мэргэдийн зарлиг зөвшөөрлөөс ч магадлан мэдэж болно. Жовужи гэгээнээс: "Асрахуй, нигүүлсэхүйн бясалгахыг мэдэхгүй хирнээ бодисадва гэвэл аяндаа танигдах биз. Юу ч боллоо гэсэн анхнаасаа эрэмбийн дагуу сурах хэрэгтэй" гэжээ. Ланри тамба гэгээнээс: "Шабүва бид хоёрт хүмүүний арван найм, морины нэг арга гээд арван есөн арга байдаг. "Хүмүүний арга" нь бодийн дээдэд сэтгэлийг эгүүсгээд юу чадахаар амьтны тусад суралцах тэр мөн. "Морины арга" нь бодь сэтгэл төрөөгүйг төрүүлэхгүй, төрснийг нь оршоохгүй, үл

арвижуулахгүй байх өөрийгөө энхрийлэн баригч тэр мөн тул түүнийг аль болохоор тусгайлан хорьж, амьтныг туйлд барин аль чадлаар туслахад суралцах мөн" хэмээжээ. Гэвш Налжорва чэнбу гэвш Донбаваад айлдахдаа: "Өөрт чинь хийгээ тэгшлэх бясалгал энэ тэр гээд олон байж болно. Чамд чихний чинь үзүүрт их хэнгэрэг дэлдсэн ч үл хагарах бясалгал байвч, асрахуй, нигүүлсэхүй бодь сэтгэл байхгүй л бол өдөр, шөнөд наминчлал үйлдэх хэрэгтэй хэмээгч газарт төрөх болно" гэж зарлиглажээ. Дүрсгүй орны эгэл төрөлхтөн төрөх чөлөөгүй оронд очихын уг болж одох нь үзэгдэнэ.

Хамлүнба гэгээнээс: "Бид нар богд болсон амьтныг үл тоомсорлож орхих болсноор амьтан ч бид нарыг ингэж үзэх мөн" гэжээ.

Их хөлгөний суурийг босгосон, босгоогүй ба, их хөлгөний сүрэгт засваргүй багтах, эс багтах эсэх энэ бүгд чухамдаа үүнд л тулах тул, цаг үргэлжид энэ ухаан явч гарсан эсэхийг үзэж, төрсөн болвоос сайн, төрөөгүй боловч тэр мэт суулгүй, түүнийг заагч буяны садныг үргэлжид шүтэж, тэр адилд суралцан судлагч нөхөр лүгээ үргэлжид нөхөрлөж, тэр адилыг үзүүлсэн эрхэм зарлиг, тааллын тайлбар сэлтийг үзээрэй.

Түүний үндэс болох буяныг хурааж, тотгорлох түйтгэрийг арилгах ёсноо өөрөө ч энэ мэтээр суралцаж хөрөнгийг гүйцэд магадтай тавиад үйл хэргээ багасгалгүй баясгалантай үйлдэх нь зохистой. Жовужэ гэгээн бээр:

Их хөлгөний номын аймагт орохыг хүсвээс
Харанхуйг арилгаж эвэршээлийг амарлиулагч
Наран, саран мэт бодь сэтгэлийг
Галавт шамдсанаар төрөх мөн хэмээн айлдсан мэт.

3. Бодь сэтгэл төрөхийн хэмжээг дээр өгүүлснээс мэдээрэй.

4. Зан үйлээр авах ёсноо гурав:

Жову гэгээн бээр:

Түүнийг эгүүсгэн суралцахыг хүсэгч бээр
Асрахуй тэргүүтэн Эсэрвагийн дөрвөн орноо
Өнөд шамдан бясалгаж үйлдсэнээр
Тачаал, шунал, атаархах сэтгэлийг арилгах буюу
Зан үйлийг үнэхээр авснаар төрөх

хэмээн айлдсан мэт оюунаар судалж, бодь сэтгэлийг магадтай болгож барих зан үйлийг үйлдсүгэй. ***Үүнээ гурав:***

а. Олоогүйгээ олж үйлдэх
б. Олсноо үл доройтуулан сахих
в. Доройтуулваас жич засахын арга

а. Олоогүйгээ олж үйлдэх:

1) Авах орон алин
2) Авах шүтээн алин
3) Хэрхэн авах зан үйл

1) Авах орон алин: *"Багшийн үйлдэх зэрэг"*-т: "Бэлэг чанар төгөлдөр" хэмээхээс цааш Жову гэгээн тодорхой зохиогоогүй бөгөөд дээдсүүд ерөөхийн сэтгэл төгөлдөр бөгөөд түүний суртгаалд оршихоор хязгаарлахгүй, орохуйн санваар төгөлдөр байх хэрэгтэй гэж таалжээ. Даланамжил бээр: "Буяны садан санваар төгөлдөр бодисадвын дэргэд очоод" хэмээсэнтэй таарч байна. *"Арван номт"*-д "Сонсоод сонсогч нар нь, бусдаар заалгаж бодь сэтгэлийг үүсгэнэ" гэж номносон тул, түүгээр шаардуулах, уйсах зэргийг заалган оруулах" гэж айлдсан нь тэрээр зан үйлээр авахгүй болохыг үзүүлжээ.

2) Авах шүтээн алин: Зидари бээр: "Ер нь язгуурын хөвгүүн ба язгуурын охид шүтээн болон санаа бодол хотол чуулган төгөлдөр бээр" хэмээн айлдсан мэт тэнгэр лус тэргүүтэнд бие болон сэтгэлийн үүднээс ерөөхүйн сэтгэлээ төрж болно. Тэр бүгдээр суурь болох боловч энэ үест *"Мөрийн зулын тайлбар"*-т: "Орчлонгоос сэтгэл уйдаж, үхэхийг санах ухаан ба их нигүүлсэхүй" хэмээн урьд номносон мэтээр мөрийн зэрэгт суралцаж, бага зэрэг боловч амсуурга олсон нэгнээ үйлдэх мөн.

3) Хэрхэн авах зан үйлд гурав:

а) Бэлтгэл ажил
б) Бодит зан үйл
в) Төгсгөлийн зан үйл

а) Бэлтгэл ажилд гурав:

(1) Ялгамжтай аврал одуулах
(2) Буяныг хураах
(3) Сэтгэлээ судлах

(1) Ялгамжтай аврал одуулахад гурав:

(а) Орноо чимэж шүтээнээ дэлгээд тахилын идээг бэлтгэх

(б) Соёрхол талбин авралыг одуулах

(в) Авралыг одуулах суртгаалыг өгүүлэх

(а) Орноо чимэж шүтээнээ дэлгээд тахилын идээг бэлтгэх: Хилэнцэт төрөлхтөн бээр аглаг газарт газар шороог ариун сайхан болгохоор, бажүнва тэргүүтнийг түрхэж, шүршиж, зандан тэргүүтний гайхамшигт үнэрт усыг түрхэх ба тансаг сайхан сэрүүн цэцгийг дэлгэ. Чухаг дээд гурвын дүрс хөрөг, цутгамал дүр болон бодь ном, бодисадвын дүрс тэргүүтнийг сайхан жижиг ширээ тавцанд байрлуулан хөшиг лавир болон цэцэг зэрэг тахилын эд эдлэл юу хэрэгтэйг нийлүүлэн дуу хөгжим, идээ зоог, зүүлт чимэг тэргүүтнийг бэлтгэж үйлд. Буяны садан орших суудал ширээг цэцгээр чимэж бэлд.

Дээр өгүүлсэн зүйлүүд нь өмнө нь хуврагийг өргөн хүндлэх ба жүнбийн балинг өргөхийн үүднээс буяныг хураах ба хэрэв тахил үгүй бөгөөс *"Сайн хувьт судар"*-аас айлдсан мэт ам даавуу өргөх зэргээр үйлдэнэ. Байгаа бол ихэд хичээнгүйлэн баттай засаж, нөхрийн ухаанд багташгүй нэгийг бэлдэх хэрэгтэй. Түвдүүд Манюл болон Самъяа хийдэд бодь сэтгэлийг айлтгахын цагт Жову гэгээн муу тахил өргөж болохгүй шүү гэж айлдсан гэдэг. Бурхан шүтээний хувьд номын ихэс дээдсийн аравнай оршуулсан лагшин дүр нэгэн хэрэгтэй ба ном судар нь "До дүдва" (Судрын хураангуй)-гаас дээш "Шэрчин" (Билгийн чинад хүрэхүйн судар) байх ёстой гэж айлдсан буй.

"Багшийн үйлийн зэрэг"-ээс номносон мэт, хутагтын чуулганыг залах бөгөөд "Тахилын үүлэн тогтоол" тарнийг гурвантаа уншиж магтаж үйлдэх болой. Шавь бээр угаалгыг үйлдэхдээ сайхан дээл хувцас өмсөх хэрэгтэй. Алгаа хавсран багш, чуулганы орны эрдэмд зүрхний мухраас сүжиг үүсгэхүйд оруулах бөгөөд Бурхан бодисадва нижгээд нижгээдийн өмнө өөрөө сууж байна гэж бодоод долоон гишүүнтийг баттай үйлдээрэй. Урьд өгүүлсэн ихэнх нь Шантидэва, Нагаржунай тэргүүтнээс дамжсан долоон гишүүнт бөгөөд Майдар, Асанга нарын дамжлагад мөргөх, тахих хоёр гишүүнээр үйлджээ.

Хилэнцээ наминчлахдаа гэмших буюу үл баясах хэрэгтэй. Бодь сэтгэл бол хөхүүлэн баярлах сэтгэл төгөлдөр байх хэрэгтэй тул, Жовужи гэгээний

"бодь сэтгэл ба санваарын зан үйлд мөргөх, тахихын зан үйл зэргийг хэмээх" тэргүүтнээр хураангуйлав. *"Багшийн үйлийн зэрэг"*-ээс долоон гишүүнтийг бодь сэтгэлийн өмнө үйлдэх хэрэгтэй гэж тодорхой зарлигласан тул учир шалтгаан энэ мэт мөн учраас Нагаржунай, Шантидэвагийн ёсноо гараагүй болохыг андгайлах хэрэгтэй.

(б) Соёрхол талбин авралыг одуулах: Цаашид багшийг бурхан хэмээх хуран мэдлийг агуулах хэрэгтэйг зарлигласан тул жинхэнэ бурхан хэмээн сүслэн мөргөнө. Мандал өргөхдөө баруун өвдгөө газарт хатгаад, алгаа хавсран бодь сэтгэлийн тухайд соёрхол талбимой.

"Хэрхэн урьдын тэрчлэн заларсан, дайснаа дарсан үнэхээр туулсан бурхад ба маха бодисадва, их газарт оршигч нар анхлан ханьцашгүй туулсан бурхад бодийн дээдэд таалал үүсгэсэн тэр адилаар, ийм нэрт надад багш та бээр, ханьцашгүй туулсан бурханы бодийн дээдэд сэтгэлийг эгүүсгэн соёрх" хэмээн гурвантаа өгүүлнэ.

Чингээд ялгамжаат авралыг одуулах буюу. Энэ мэт орон болсон бурхад ялж төгөлдөр нөгчигсөд ба их хөлгөний хорихуйг эрхэмлэн үзүүлсэн мөрийн үнэн зэрэг ном, жич үл буцах бодисадвын хутагтан хувраг та бүхнээ энэ цагаас эхлэн бодийн зүрхэн эс олох хүртэл тухайлан хамаг амьтныг аврахын тухайд, бурхан таныг авралыг заагч багш хэмээн, ном юугаан бодит аврал хэмээж, хувраг таныг аврал бүтээхийн нөхөр минь хэмээн айлтгамой" хэмээх ерөнхий бодлыг агуулан одуулна.

Ялгамжтай бодлын талаар *"Мөрийн зул"*-аас: "Үл буцахын сэтгэлээр" хэмээн айлдсан мэт, тэр адилын сэтгэлээр цаг үргэлжид үл буцна хэмээх хатуу хүчтэй бодлыг гарган урьд номносон явдал мөрийн адилаар авралыг одуулж үйлдэх буюу. "Багш та таалан соёрх. Би ийн хэмээх нэрт бээр энэ цагаас эхлэн хэзээ бодийн зүрхэн хүртэл, хоёр хөлгөний дээд бурхан ялж төгөлдөр нөгчигсөн та бүхэн дор авралыг одуулмой. Багш та таалан соёрх. Би ийн хэмээх нэрт бээр энэ цагаас эхлээд хэзээ бодийн зүрхэн хүртэл, ном бүгдийн дээд амарлингуй, хүсэл шунал лугаа хагацсан ном дор аврал одуулмой. Багш та таалан соёрх. Би ийн хэмээх нэрт бээр энэ цагаас эхлэн хэзээ бодийн зүрхэн хүртэл, чуулганы дээд хутагт бодисадва, үл буцах хувраг дор аврал одуулмой" хэмээн гурвантаа өгүүлнэ.

Чухаг дээдэд тус тус авралыг одуулахдаа таалал соёрхолыг тус тус үйлдэх ба авралын үгүүд нь бусадтай адилгүй боловч Жовужи гэгээний зохиосон заншлын дагуу мөн.

(в) Авралыг одуулах сургаалыг өгүүлэх: Аврал одуулахын сургаалын хувьд багш бээр дээр бага төрөлхтний үед номносон сургаалыг энд өгүүлж үйлдээрэй.

(2) Буяныг хураах

Буян хураахын хувьд бодь сэтгэлийн зан үйлийн энэ үест ч гэсэн мөргөх, тахих тэргүүтнийг үйлдэхийг номлосон байна. *"Тайлбар"* -аас: "Долоон гишүүнт ба бурхан бодисадва, өнө ба эдүгээгийн буяны садангуудыг сэтгэлдээ санаж үйлдэхийг номлосон дагуу үйлдэнэ. Багшийг тахих ёсыг өмнөх тахилаас мэдэж аваарай. Долоон гишүүнтийг "сайн явдлын ерөөл" болон *"Бодичарияватара"* зэргийн алин нэгээр үйлдээрэй.

(3) Сэтгэлээ судлах

Сэтгэлийг судлах хувьд *"Мөрийн зул"*-аас: "Асрахуй сэтгэлийг өмнө нь одуулж, зовлонтой амьтныг бодох бодь сэтгэлийг үүсгэх хэрэгтэй" гэж зарлигласан мэтээр урьд номносон дагуу асрахуй, нигүүлсэхүйн бодол зоригдлыг тодорхой талбиарай.

б) Бодит зан үйл нь: Багшийн өмнө баруун хөлний өвдгийг газарт хатгаж цомцойх буюу нугалан суугаад, алгаа хавсран бодь сэтгэлийг үүсгээрэй. Энэ талаар *"Мөрийн зул"*-аас:

Буцахгүй хэмээн андгайлж
Бодь сэтгэлийг үүсгээрэй

хэмээсэн ба *"Зан үйл"*-ээс: *"Бодийн зүрхэн хүртэл"* хэмээн зарлигласан тул бусдын тусад бурханы хутгийг олсугай хэмээх бодь сэтгэл төдий бус, тэр сэтгэлийг үүсгэнэ гэж зориод, бодь хутгийг эс олох хүртэл үл орхино хэмээн андгайлах мөн тул тэр сэтгэлийг зан үйлд шүтэж эгүүсгэх хэрэгтэй. Тэр мэтээр ерөөхүй сэтгэлийн сургаалд суралцаж чадахгүй бол үйлдээгүй болно.

"Амьтан бүгдийн тусын тулд би бурхан болох болтугай" хэмээх төдийг зан үйлээр төрүүлвээс бодь сэтгэлийн сургаалд суралцаж чадсан, чадаагүй бүгдэд хамаарах мөн. Ерөөхүй бодь сэтгэл дээр тэр хоёрын нэг "орохуй сэтгэлийг" зан үйлээр авсан байхад сургаалд огт суралцаагүй байна гэдэг хаана ч байж болохгүй. Тиймээс Нагаржунай болон Асанга гэгээн нараас дамжсан тангараг санваарын олон зан үйлд үйлдэж болох,

болохгүй гэж ялгамжаа гаргах нь их ухаангүйнх.

Бас зарим нэгэн бээр, үйлийг анхдагч нь номын явдалд орох санваарыг зан үйлээр дахин дахин авна гэж номлосон хирнээ ерөнхий суртгаал болон ялангуяа язгуурын уналыг огт мэдэхгүй болсноор хэрхэн үйлдэх ялгааг үзүүлээгүй байх зэрэг ихэд утгагүй зүйлийг өгүүлсэн мэт. *"Салжолд уевдислахуй"*-д айлдахдаа: "Өглөг тэргүүтний суртгаалд суралцаж эс чадсан ч бодь сэтгэл төдийхнийг төрүүлснээр их буяныг бүтээнэ" хэмээн айлдсаныг гол баримтлал болгоод, алин чинадад хүрэхээр зоригсод бүгдээр хамаг бүгдийг сурч чадаагүй ч гэсэн тэд их үрийн тухайд аргаар огоот эзлэгдсэн бодь сэтгэлийг эгүүсгэн үйлд" хэмээн *"Бясалгалын анхдугаар зэрэг"*-ээс айлдсан буй. Тиймээс "Хэдий өглөг тэргүүтний суртгаалд суралцаж чадаагүй ч, бодь сэтгэлтэй байж болох ч, тангараг санваар авахгүй бол болохгүй" гэдгийг ихэд тодорхой айлджээ.

Бодь сэтгэл авах зан үйл: "Арван зүгт оршигч бурхан бодисадва бүгд намайг болгоо. Багш болгоогтүн. Би "ийн хэмээх" нэрт бээр, энэ төрөл ба бусад төрөлд өглөгийн мөн чанар, ёс суртахууны мөн чанар, бясалгалын мөн чанар зэргээс буяны язгуурыг би өөрөө үйлдсэн, үйлдэхээр одуулсан, үйлдэхүйд даган баяссан зэрэг буяны язгуур юу байгаа түүгээр хэрхэн урьдын бурхад Ялж төгөлдөр нөгчигсөн бурхад, их газарт машид оршигч их бодисадва нар, ханьцашгүй туулсан бурхад бээр бодийн дээдэд сэтгэл эгүүсгэсэн тэр адилаар, Би "ийн хэмээх нэрт" бээр, энэ цагаас аваад хэзээ бурхан болохыг хүртэл ханьцашгүй үнэхээр туулсан их бодь сэтгэлийг эгүүсгэж үйлдмү. Гэтлээгүй амьтныг гэтэлгэж үйлдмү. Тонилоогүй амьтныг тонилгож үйлдмү. Амьсгаа ороогүйг оруулж үйлдмү. Огоот гаслангаас эс гэтэлснийг гаслангаас гэтэлгэж үйлдмү" хэмээн гурвантаа өгүүлж үйлдээрэй.

Авралыг одуулахын ёс болон энэ хоёр хоёуланг багш дагуулан урин тоолох хэрэгтэй гэж тодорхой заагаагүй ч чингэх шаардлагатай. Эдгээр нь багш байгаа үед болно. Багш олдохгүй бол хэрхэн үйлдэх хэмээвээс, Жовужи гэгээний зохиосон *"Бодь сэтгэлийн зан үйл"*-д: "Тэр мэт багш байхгүй ч, өөрөө бодь сэтгэлийг эгүүсгэхдээ, тэрчлэн заларсан бурхан багш, арван зүгийн бурхан бүгдийг сэтгэлдээ санан мөргөж, тахихын ёсыг үйлдээд, соёрхол талбих ба багш хэмээх үгийг орхиод авралыг одуулах зэргийг дээрх дарааллын дагуу үйлдээрэй" хэмээжээ.

в) Төгсгөлийн зан үйл: Багш бээр ерөөхүй суртгаалыг шавь нарт өгүүлэх болой.

б. Олсноо үл доройтуулан сахих

Түүнээ олсноо эс доройтуулан сахих суртгаалыг мэдэж үйлдэх хэрэгтэй тул түүнийг номнох болой. ***Үүнээ хоёр:***

1) Энэ насанд бодь сэтгэлээ үл доройтуулах шалтгаанд суралцах

2) Бусад төрөлд түүнээс үл хагацах шалтгаанд суралцах

***1)* Энэ насанд бодь сэтгэлээ үл доройтуулах шалтгаанд суралцахад дөрөв:**

а) Бодь сэтгэлд дурлах сэтгэлийг хүчтэй арвижуулахын тулд тус эрдмийг санан суралцах

б) Тэр сэтгэлийг бодитой арвижуулахын тулд зургаан удаа үүсгэн суралцах

в) Юуны тухайд ч амьтан ухаанаар бодь сэтгэлийг үл тэвчихэд суралцах

г) Бинавадын болон бэлэг билгийн буяны чуулганыг хураахад суралцах

а) Бодь сэтгэлд дурлах сэтгэлийг хүчтэй арвижуулахын тулд тус эрдмийг санан суралцах:

Судрын аймгийг үзэх ба багшаас сонсох, бодь сэтгэлийн тус эрдмийг санах болой. *"Гол модон судар"*-т дэлгэрэнгүй айлдсан тул тэр мэтийг үзэх хэрэгтэй. Түүнээс гадна дээр татсан "бурханы ном бүгдийн хөрөнгө адил хэмээсэн болоод "бодисадвын явдал ба хамаг ерөөл бүгдийн хураангуй" хэмээн салаа гишүүн бүгдийг дэлгэрэнгүй номносон нь олон ч, товчлон хураасан бүгдийн товчоо буюу бодисадвын мөр бүхний аньсыг хураасан "товчоо" гэж айлджээ.

"Бодийн газар"-т тус эрдмийг айлдахдаа ерөөхүй сэтгэлийн тусыг заажээ. Түүнээс анхлан сэтгэл эгүүсгэхийн тус эрдэмд хоёр:

(1) Орны дээд болох талаар

(2) Хорлолгүй буяныг огоот барих хэмээн айлджээ.

(1) Орны дээд болох талаар, "Ертөнцийн тэнгэр хүмүүний мөргөлийн орон болюу" хэмээсэн мэт бодь сэтгэл төрмөгц амьтан бүхний

эрдмийн орон болох ба, бодь сэтгэл төрснөөс эхлэн дайснаа дарсан их эздийг сүрээр дарна гэж айлдсан тул багш дээдэс болох ба, өчүүхэн төдий буян үйлдсэн ч хэмжээлшгүй их үр гарах тул буяны орон болоод хамаг ертөнцийн түших газар мэт болно" гэсэн мэт хамаг төрөлхтний эцэг адил болох мөн.

(2) Хорлолгүй буяныг огоот барих талаар: Хүрдэн эргүүлэгч хаан болон хоёр сахиулсан үргэлжид сахих тул унтах нойрсох юм уу сэрэмжгүй байхад ч ягчис, хүмүүн бус, язгуурт оршигч нарт хөнөөгдөхгүй.

Нууц тарни язгуурын тарни, хулгана яр, хорлол, халдварт өвчнийг амарлиулж үйлдэх. Амьтны гарт ороогүй зүйл ч өөрийн гарт ирж бүтэх тул бусад бүтээлийг хэлэх юун. Тиймд амарлингуй тэргүүтний үйлийн чуулган бодь сэтгэлд шүтэн байж хялбар бүтэх учир нийтийн шид бүтээлийг бүтээхэд тэр мэт байж түргэн бүтэх мөн. Аль ч орноо орших тэнд аюул гарах, ган гачиг болох, хүмүүн ба хүмүүн бусын хорлол эс гарах ба махбодь амарлих болой.

Нас егүүтгэсний сүүлд ч хорлол өчүүхэн болох бөгөөд өвөрчлөн өвчингүй болоод хорлол гаравч өнө удаан, хатуу гарахгүй, ном заах тэргүүтэн амьтны тусад оршин бие үл алжаах ба мартах сэтгэл төрөхгүй болюу. Бодисадвын язгуурт оршсоноор заяанаасаа муу авир багасаж одох. Бодь сэтгэл төрвөөс л бие, сэтгэлийн муу орон, зан авир машид багасан арилах. Тэсвэр лүгээ төгөлдөр болох тул янагш хорлол үйлдсэнээ тэсэж, чинагш эс үйлдэнэ. Бусад бусдад хорлол үйлдэхийг үзэхдээ ч машид үл баясах, уурлах, атаархах, баширлах, мөчөөрхөх зэргүүд өчүүхэн төдий нэг төрөх ч хүч багатай, төд удалгүй арилах болой.

Муу заянд төрөхөд бэрх болох ба төрөвч түргэн гэтлэх, тэнд зовлон бага амсах, түүгээр шалтгаалан орчлонгоос машид уйдах ба тэдгээр амьтныг нигүүлсэх сэтгэл төрөх болой. Бодь сэтгэлийн буяны дүрснээ бүтээвээс огторгуйд ч үл багтах ба эд өлгөөр бурханыг тахихын нэг хувьд ч үл хүрнэ. *"Балжин айлтгасан судар"*-аас:

Бодь сэтгэлийн алив буян
Түүнийг хэрвээ дүрснээ байгуулваас
Огторгуйн орон бүхнийг дүүргэх бөгөөд
Түүнээс илүү үлэмж болох тэр
Ганга мөрний элсний тооны дайтай
Бурхадын орныг хүмүүс бээр

Их эрдэнээр бүгдийг дүүргээд
Ертөнцийн сэтгэлт түүнээ өргөснөөс
Алин алгаа хавсран үйлдээд
Бодь сэтгэлээр мөргөн
Тахисан энэ л үлэмж илүү хэмээжээ.

Жовужи богд бээр "Дорж дан (Бодигаяа) хэмээх газар эргэл мөргөл хийж явтал, "Яавал түргэн бурхан болох бол гэсэн нэгэн бээр, багавтар лагшин хөрөг бүтээх үү эсвэл, их томыг бүтээвэл түргэн бурхан болох болов уу гээд алинд суралцах вэ?" гэж асуухад, "бодь сэтгэлд суралцаарай" хэмээсэн гэдэг. Мөн Ганболи балгадын дээр огторгуйд суух хөгшин эмгэнээс нэгэн залуу бүсгүй асуухад дээрх хариултыг өгсөн тул бодь сэтгэлийг ихэд таалж байна гэж ярилцжээ.

Тэр мэт их хөлгөний увдис бүгдийн аньсыг хураасан, шид бүтээл бүгдийн их хүү сан, бага хөлгөнөөс их хөлгөнийг ялгах ном, бодисадва нарыг агуу явдалд дуудагч эрхэм шүтээн бол бодь сэтгэл гэдгийг мэдээд түүнийг бясалгах дуршил сэтгэлийг хүчтэн хатуу дээш арвитган талбиад цангасан хүн усны дуу сонсох адил үйлдээрэй. Олон галавт гайхамшигт эрхэм тааллаар машид нягтлан үзэх буюу зам мөрийг шинжлээд зөвхөн энэ л бурхан болохын дээд арга гэж бурхан, бодисадва нар болгоожээ. Тийн болохыг *"Бодичарияаватара"*-д:

Олон галавт машид таалан болгоож
Бурхад бээр тэр ямагтыг тустай хэмээн таалав хэмээжээ.

б) Тэр сэтгэлээ баттай аривижуулахын тулд зургаан удаа суралцахад хоёр:

(1) Ерөөхүйн сэтгэлийг үл орхих ба
(2) Арвижуулахуйд суралцах болой.

(1) Ерөөхүйн сэтгэлийг үл орхих: Бурхан, бодисадва, буяны садан нарыг гэрчид барьж тэдний мэлмийн өмнө гэтлээгүй амьтныг гэтэлгэнэ гэж тангараг тавьчихаад, амьтны тоо тоолшгүй олон, элдэв муу үйлийг үйлдэх ба, урт удаан хугацаатай олон галавт шамдах шаардлагатай гэх буюу, хоёр их буяны чуулган цаглашгүй их, үйлдэхүй еэ бэрх зүйлүүдийг сурах хэрэгтэй болох нь гэж үзээд шантрах шалтаг болгож, бодь сэтгэлийн үүргээ

орхивоос тус тус гэтэлгэгч санваарын уналаас ч илүү хүнд нүгэл болно. *"Хураангуй"*-гаас:

Хэдий гөлт тоотой галавт буяны арван мөрөөр
Замнасан ч өөрөө ялгуугсадын дайснаа дарсныг хүсвээс
Тэр цагт шагшаавадын гэм гарч, шагшаавадаа доройтуулваас
Бодь сэтгэлийн унал тэр нь түүнээс илүү хүнд унал болох

хэмээн бодисадва түүний шагшаавад цалхайрах бөгөөд сонсогч, өөрөө ялгуугсан хоёрын сэтгэлд үйлдэх боомтоос бодь сэтгэлийн санваар нь дээд мөн тул түүнийг доройтуулваас шагшаавад нь урагдах зүйн хэрэг. Харин түүнийг орхихгүй явбал хүслийн таван эдийг цээргүй эдэлсэн ч бодисадын нийт бусын санваар урагдахгүй болно. Түүнээс:

Хэдий бодисадва хүслийн таван эдийг эдлэвч
Бурхан ном хутагт хуврагт авралыг одуулах ба
Бурханыг бүтээсү хэмээн хамгийг болгоогчийг сэтгэлдээ үйлдвээс
Мэргэн болж шагшаавадын чинад оршихыг мэдээрэй хэмээжээ.

Тэр мэт ам авсан сэтгэлээ орхивоос муу заяанд өнө удаан тэнэхэд хүрнэ. *"Бодичарияватара"*-д:

Өчүүхэн багахан эгэл нэгийг
Өгнө гэж сэтгэлдээ бодсон хирнээ
Өгч чадаагүй өнөө хүн
Түүнээс болж бирдэд төрөхийг айлдсан тул

Ханьцашгүй их амгалан жаргалд
Зочин гэж сэтгэлийн мухраас урьчихаад
Хамаг амьтныг хуурч мэхэлвээс
Сайн заяанд одно гэж хаана байх вэ хэмээжээ.

Дээрхээс:

Харалган хүн хогон овоон дотроос
Их эрдэнэ хэрхэн олох тэр адил
Ямар их зол заяагаар
Бодь сэтгэл надад төрөв өө

хэмээсэн мэт "энэ адилыг олно гэдэг ямар их гайхамшигтай вэ" хэмээн

сэтгэж хэзээ ч түүнийгээ орхихгүй буюу, ганц агшинд ч орхихгүй хамгийн чухал гэж лавтай шийдэх болой.

(2) Арвижуулахуйд суралцах: Тийнхүү орхихгүй төдийгүй өдөр, шөнөд гурав гурвантаа ихэд шамдан арвижуулаарай. Түүнийг дээр номносон хураангуй, дэлгэрэнгүй зан үйлийн ёсоор бүтээнэ. Бүтээж чадваас чуулганы орныг тодруулан бодож, тахилыг өргөж асрахуй, нигүүлсэхүй зэргийг бясалган зургаан удаа бариарай. Түүний зан үйл нь:

Бурхан ном, чуулганы дээдэд
Бодийг хүртэл авралыг одуулму би
Миний өглөг тэргүүтэн үйлдсэн тэдгээрээр
Амьтны тухайд бурхан бүтэх болтугай

хэмээн гурав, гурван удаа болой.

в) Юуны туханд ч бодь сэтгэлийг амьтныг сэтгэлээр үл тэвчихэд суралцах: *"Мөрийн зул"* болон бодь сэтгэлийн ёсны суртгаалын үест эс дурдсан хэдий ч, *"Мөрийн зулын тайлбар"*-т: "Тэр мэт амьтныг даган барих ба үл орхих сэтгэлээр бодь сэтгэлийг тухайлж, түүний тус эрдэм, түүнийг төрүүлэх зан үйл, нийтэд арвижуулах, мартахгүйн тухайд сахих" хэмээхийн үест тоолсон буй.

Үндсэн таалалтай харшихгүй тул тэдгээрийг сурах болой. Сэтгэлээр тэвчих хэмжээний хувьд үл зохилдох зэрэг зарим шалтгаанд шүтэж, би хэзээ ч үүнийг үйлдэхгүй хэмээн санах мөн.

г) Бинавадын болон бэлгэ билгийн буяны чуулганыг хураахад суралцах нь: "Ерөөхүйн сэтгэлийг зан үйлээр аваад өдөр бүр бодь сэтгэлээ нэмэхийн үндэс болгож чухаг дээдийг тахих зэргээр буян хураахаар шамдана. Эдгээр нь дээдсийн зарлигаас бусад зүйлд үзэгдэхгүй буюу тусдаа байхгүй юм шиг. Гэвч хамгийн тустай болох нь харагдана.

2) Бусад төрөлд ч үл хагацахын үндэснээ суралцахад хоёр:

а) Доройтуулан үйлдэгч дөрвөн хар зүйлийг тэвчих

б) Үл доройтуулагч дөрвөн цагаан номд суралцах

а) Доройтуулан үйлдэгч дөрвөн хар зүйлийг тэвчих: *"Чухаг дээд давхарлиг судар"*-ын "Одсүрэнгийн бүлэг"-т: "бусад төрөл дээр бодь

сэтгэлээ умартах буюу илт гаргахгүй байх дөрвөн зүйл болон бурхан болох хүртэл орхилгүй, бодь сэтгэлээ умартахгүй илт байлгах дөрвөн ном төгөлдөр байхыг" айлдсан тэдгээр нь ерөөхүйн суртгаал болохыг өгүүлжээ.

Түүнээ дөрвөн хар зүйлээс:

"Орны эзэн ба ловон болоод багш ба өглөгийн орон зэргийг хуурах гэж хоёр хоёроор мэдээрэй. Орон гэдгийн хувьд хамба, ловон гэхээр ойлгомжтой. Багш гэдэг тус хүргэх хүн бөгөөд өглөгийн орон гэж тоонд багтаагүй ч эрдэм төгөлдөрүүд болой" хэмээн *"Одсүрэнгийн бүлгийн тайлбар"*-т айлджээ.

Тэдгээр орноо ямар үйл хийвэл хар зүйл болох вэ? гэхүл, мэдсээр байж тэдгээр орон бүгдийг хуурваас хар зүйл болно. Хуурахын хувьд, тэднээр өрөвдүүлэх гэж, гэмт буруугаа худал хэлж, *"толгой эргүүлэх"* гэж *"Тайлбар"*-т номносон. Мэхэмдэх санаагаар багш тэргүүтнийг хууран үйлдэх зэргүүд бүгд багтана. Гэхдээ худал хэлэлгүй залилан мэхлэхийг дараа номнох тул энэ үест худал хэлж толгой эргүүлэх нэгэн хэрэгтэй.

"Суртгаалын хураангуй"-аас: "Харын зүгийг тэвчвээс цагаан ном болно" гэж айлдсан тул түүний ерөндөг нь дөрвөн цагаан номын анхдугаар болой. "Багшдаа зөвшил бусад нэгийг айлтгачихаад, далдуур өөр нэгэн зөвшлийг үйлдчихээд буяны садан бээр сонсохоор ирнэ шүү гэх зэргээр бүдүүн зүрхтэй шавь *"багшийн толгойг эргүүлэх"* хэмээн айлджээ.

"Гэмгүй бусдыг гэмтэй" болгон үйлдэхэд хоёр буй. Орны хувьд буян үйлдэгч буюу гэмгүй нэгэн байх ёстой. Хэрхэн үйлдэх гэвэл, гэмшүүлэх сэдлээр гэмгүй орныг гэмтэй болгож ухааруулах. *"Тайлбар"*-аас: "Зөв явдалт, суртгаалаа зөв сахигч, нэгэн мөрийн нөхөд зэргийг башир залийн үгээр толгойг эргүүлэн мунхруулж үйлдэх явдал" гэжээ. Энэ хоёрт хууртсан, хууртаагүй болон гэмшсэн, гэмшээгүйн хувьд ялгаагүй хэмээсэн нь *"Тайлбар"*-аас айлдсантай нийлж байна. Гэхдээ *"Тайлбар"*-т: "Хойтхид ч толгойг нь эргүүлэх бий" хэмээсэн буй.

Их хөлгөнөө үнэхээр оршсон бодгальсыг *"сайшаан үл өгүүлэх"* зэрэг орны хувьд, заримууд зан үйлээр бодь сэтгэлийг барьсан нэгэн гэж тооцсон бол, заримууд бодь сэтгэл олсон хэдий ч эдүгээ төгөлдөр бус тэднийг ч нэгэн адилд үзэх бий.

Гэвч судартай үл таарна. *"Тайлбар"*-аас: "Бодисадва хэмээх төдийгээс илүү тодорхой гараагүй байна" гэжээ. Бусад тохиолдолд бодисадвын

санваар төгөлдөр болж, суртгаалд суралцаж их хөлгөнөө үнэнээр оршсон нэгэн болохыг номносон нь олонтаа үзэгдэх тул бодь сэтгэл төгөлдөр болсноор тооцох хэрэгтэй юм болов уу.

Хэрхэн үйлдэх вэ? хэмээвээс, сайшаан үл өгүүлэх болон уур хилэнгээр өдөөгдөн өгүүлэх зэргээр айлдсан нь *"Тайлбар"* лүгээ таарчээ. Аль ч орныг өгүүлэхэд, бодь сэтгэлтнээ юм уу, номыг чухалчлагч нарын, их хөлгөнөө сүсэглэх ба бүтээхийн хүслийг буцаахын тухайд муугаар өгүүлэх явдал гэж *"Тайлбар"*-т номносон ч, утгын ухаарал төрсөн бол болчихсонтой адил. Тэрхүү "сайшаах бус дуу" гэдэг нь муу авирт гэх мэтээр гэм бурууг ялгалгүй өгүүлэх болой. "Яруу бус дуу" нь "ариун бусыг эдлэх" гэх зэргээр тухайлан ялгаж өгүүлэх болой. "Өгүүлэх бус" нь "Ийм ийм байдлаар ариун бусыг үйлдэв" хэмээн сайтар ялгаж өгүүлэх ба шүлгээс бусад тэднийг түрүүчийн гурвын эцэст найруулахыг *"Тайлбар"*-аас номножээ. Эдгээр нь бидэнд өөрт гарахад тун ойрхон, бас их гэмтэй болохыг дээр товчхон өгүүлсэн.

Мөн *"бодисадваг басамжлах"* бодисадва нь басамжилсан тоотой галавт тэр бодисадва тамд орших аж. Бодисадваг басамжлахаас өөр бусад ямар ч үйлээр бодисадва муу заяанд унахгүй болохыг *"Машид амарлингуйг нягтлагч рид хувилгааны судар"*-аас айлджээ. *"Хураангуй"*-аас:

Эш бошгыг эс олсон бодисадва алин бээр
Эш бошгыг олсноо уурсах сэтгэлээр тэмцэл туурвиваас
Наанадаж гэмт сэтгэлийн агшины тоо хэдүй буй
Төдий чинээ тоот галавт сууринаас хөө хуягийг өмсөх хэрэгтэй

хэмээн уурын сэтгэл хичнээн төрөх төдий чинээ галавт, сууринаас (эхнээс) мөрд зорчих хэрэгтэй болохыг айлдсан ба бодь хутгаас машид холдох учрыг өгүүлжээ. Тиймд хэзээ ямагт уурыг хорих ба гарсан ч тэр даруй наминчлан боохоод шамдах хэрэгтэй. Түүнээс:

Энэхүү сэтгэл сайн бус гэдгийг дурдан санах
Тус тус наминчилж хожим хорьж үйлдэх ба
Түүнээ үл баясаж энэ л бурханы номд суралцсу хэмээжээ.

Уур хилэнд чөлөө өгвөл, урьд байсан асрахуй, нигүүлсэхүй сэтгэлийн чадал хомсдож, өнө удаан бясалгавч урьдах нь үгүй болж, шинээр төрөхөд

бэрхтэй болсноор бодь сэтгэлийн язгуур ч тасрахад хүрнэ. Харшлах шалтгаан болох уурыг хорьж, дээр номносон дагуу бясалгаваас дээшлэн дээшилж арвижсаар хэмжээлшгүй болно. *"Тийн тайлбар"*-аас:

Үл зохилдох зүгийн хорлол үгүй аваас
Тэр сэтгэл өөрийн мөн чанарт болох хэмээсэн ба,

Алин өмнө нь язгуур зохилдох
Хөрөнгөнөөс арвижих ямагт болсон
Энэрэхүй тэргүүтэн тэдгээр ухааныг
Дадуулж бясалгаваас түүнээ л орших хэмээжээ.

"Башир болон заль мэх" бол бусадтай дотносох, сайхан сэтгэл бус. Алин бусад амьтнууд орон нь болно. Үйлдэл нь баширлах, заль хэрэглэх явдал. Үлэмж санааны хувьд өөрийн санаагаар болохыг *"Тайлбар"*-аас номносон буй. Залилах мэхлэх зэрэгт дэнс жинлүүрээр залилах буюу, "Ежүн хаан бээр, Рагмаад өгөх байснаа, цаагуур Додлүнд өгчихөөд, хожим Рагмаад өгсөн минь юун сайн болов" гэж хэлэхтэй адил хэмээн айлджээ.

"Хураангуй"-гаас: "Тэр хоёулаа олз хүндлэлд шунахын эрхээр төрсөн буюу. Тачаал, мунхагийн аймагт багтахын хувьд адил. Заль гэдэг нь эрдэмгүй байтал эрдэмтэй юм шиг байх, башир нь өөрийн гэмийг халхлах байдалт" гэж айлдсан буй. "Халхлах" гэдэг өөрийн гэмээ аргалж ил гаргахгүй байх үйлдэл.

б) Үл доройтуулагч дөрвөн цагаан номонд суралцах: *"Дөрвөн цагаан ном"*-оос: Эхний цагаан номын орон нь амьтан болой. Үйлийн хувьд нь амь нас буюу инээдэм наадмын төдийд ч, мэдсээр байж тэдэнд худал хэлэхийг тэвчинэ. Тийн үйлдвээс өөрийн багш орны эзэн тэргүүтэн ялгамжаатнаа худал хэлж толгойг эргүүлэх явдал гарахгүй.

Хоёрдугаар цагаан номын орон болвоос хамаг амьтан. Үйлийн хувьд башир зальгүйгээр үлэмж санаагаар тэдэнд хандах бөгөөд шулуун сэтгэлээр орших болой. Энэ нь дөтгөөр харын ерөндөг болно.

Гутгаар цагаан номын орон нь хамаг бодисадва болой. Үйл нь бурхан адилд үзэх хуран мэдлийг үүсгэж, тэдгээрийн утганд таарах сайшаалыг дөрвөн зүгт өгүүлэх болой. Бид буян адил бага сага үйлдсэн боловч, арвижих шинж үгүй, барагдах шинж олонтаа гарах нь бодисадва нөхөртөө уурлах, басамжлах ба шархыг гаргасан зэргээр буянаа барсан хэрэг. Тиймээс энэ болоод бодисадваад шарх гаргах хоёрыг дийлвээс

"Суртгаалын хураангуй"-гаас: "Бодгальд шүтсэн хорлол гэсэн бүгд үл тарах" гэж айлджээ.

"Бодисадва хаана оршихыг мэдэхгүй тул" хэмээн "Одсүрэн айлдсан" ёсоор хамаг амьтныг бурхан хэмээх хуран мэдлийг үүсгэж, ариун явдлын эрхээр үйлдэх мөн.

Эрдмийг өгүүлэхдээ ч, сонсогч буй үед буулгах бөгөөд дөрвөн зүгт одож өгүүлээгүй ч гэм болохгүй. Энэ нь гутгаар хар номын ерөндөг болой.

Дөтгөөр цагаан номын орон нь өөрийгөө боловсруулах амьтан болой. Үйлийн хувьд ойр зуурын хөлгийг үл хүсэмжлэн туулсан бодь хутгийг бариулахаар орох болой. Чингэхдээ өөрийн зүгээс шавь түүнтэй учрах ёстой ч, тэр шавьд тэр санаа төрөөгүй аваас гэмгүй байвч, бүтээж чадахгүйд хүрнэ. Үүгээр хоёрдугаар хар номыг тэвчинэ.

Амгалан бүгдийн туйлд бусдыг хүргэе гэх хүсэл байваас, бусдад сэтгэл таагүй, сэтгэлд гэмшил төрүүлэх учир таагүй сэтгэл үүсгэх бэлтгэлийг бүтээх хэрэггүй. *"Сэнгийн айлтггасан судар"*-аас:

Төрөл тутамд бодь сэтгэл түүнийг
Зүүдэндээ ч санаж орхихгүй байхыг
Хэвтээгүй үест ч хэрхэхийг
Хэлээд юун болох зарлиг болруун

Хот тосгон балгад буюу
Алин хөвгүүд орших оронд ч
Бодь хутагт ямагтад хичээсүгэй
Тиймд сэтгэлээ орхиж болохгүй хэмээн айлджээ.

Мөн омгоо дарах, атаа жөтөө, хармаа тэвчих, бусдын сайн сайхныг хараад сэтгэл баясах дөрөв лүгээ төгс болоод ерөөлийг эс орхихыг *"Жамбал шингод"*-оос айлдсан. *"Чухаг дээдийн үүлэн судар"*-т: "Хамаг явдал мөр бүхнээ бодь сэтгэлийн явдал болоод аливаа буян үйлдэхийн өмнө бодь сэтгэлийг талбиваас бусад төрөлд ч их эрдмийн сэтгэл лүгээ үл хагацана гэдгийг янагуухи ба үнэмлэхүйгээр олонтаа хүмүүс шинжлэх" тэргүүтнээр тодорхой үзүүлжээ.

в. Доройтуулбаас жич засах ёс

Дөрвөн хар ном болон амьтныг ухаанаар тэвчихтэй тав буюу.

Бурханыг бүтээж чадахгүй гээд сэтгэлээ орхих зургаа буй. Тунгийн хэмжээнээс хэтэрч ерөөхүй бодь сэтгэлээ орхих, тунгийн хугацаан дотор гэм гарснаар доройтохын үндэс болох, зургаан удаа авах ба хоёр чуулганаа суралцах явдлыг доройтуулах буюу доройтох төдий шалтгаан гарах нь ч орхих үндэс болох тул ерөөхүйн бодь сэтгэлийн зан үйлээ давтаж үйлдэнэ.

Доройтох шалтаг төдий дээр зан үйлийг давтах хэрэггүй, наминчилгаагаар болно гэж олонтаа ярьдаг. Гэвч энэ нь, би бурхан бүтээж чадахгүй нь гээд бодь сэтгэлээ орхиж, тэр даруйд тунгийн хэмжээгээ барих, хянах зэргийг хэрэггүй гэх үзэхэд хүргэх тул ерөөс таарахгүй.

Дөрвөн хар нь энэ насанд бодь сэтгэлээ орхихын шалтгаан бус ч, бусад төрөлд бодь сэтгэлийг төрүүлэхгүйн шалтгаан болох тул энэ наснаа хорих хэрэгтэй. *"Мөрийн зул"*-аас:

Энэ нь бусад төрөлд ч далд утгат тул
Ийн хэмээн номносон суртгаалыг огоот сахь

хэмээсний "ийн хэмээн номносон" гэдэг нь Одсүрэнгийн айлтгасанаар ийн хэмээн номножээ. Тэрхүү судрын утга энэ мөн бөгөөд "Одсүрэн! Бодисадва дөрвөн ном төгөлдөр бөгөөс төрөл тутамд, төрсөн даруйд бодь сэтгэл илт болох бөгөөд бодийг зүрхэн хүртэл завсаргүйгээр үл мартах болюу" хэмээн дөрвөн цагаан номын үест тодорхой айлдсан тул дөрвөн харын үест урд, хойд насны ялгаа тодорхой гараагүй ч сүүлийн утгаар мэдээрэй. Гэвч энэ наснаа хар номыг шүтвээс бодь сэтгэл өчүүхэн болж одно шүү.

Тэр мэт бус бөгөөс, бодь сэтгэлийн санваар төгөлдөр бээр, инээдэм наадмын тухайд ч өчүүхэн төдий худал хэлэх, амьтныг өчүүхэн төдий залилж мэхлэх, уурлан бодисадва хүнийг муулах, бусдын буяны язгуурыг үйлдэхэд өчүүхэн төдий гэм гаргах, гэмгүйгээр тасалгааны хэмжээг хэтрүүлэн бодисадвын санваарыг орхиулах, зэргээр явбаас ерөөхүй бодь сэтгэлийг алдуулж, санваараа орхиход хүрнэ.

Ерөөх сэтгэлээ орхивоос санвараа алдана гэж *"Бодийн газар"* болон *"Суртгаалын хураангуй"* хоёулангаас айлдсан буй. Чингэж үзвэл, тэдгээр нь язгуурын уналд тооцогдох хэрэгтэй болно. Гэтэл чингэж хаана ч номноогүй тул таарахгүй байна.

Бас тунгийн хэмжээг тооцох талаар *"Ниवархорын айлтгасан судар"*-т түшин үзвээс, тэр нь судрын үг биш гэдгийг *"Шагшаавадын булгийн тийн*

номлол"-оос дэлгэрэнгүйеэ би номносон тул энд номносонгүй.

Амьтныг ухаанаар тэвчих гэдэг нийт амьтныг бодоод, ийм их амьтны тусыг би үйлдэж чадахгүй нь гээд ухаанаар орхих буюу ерөөхүй сэтгэлээ орхих явдал гэдэг нь тодорхой. Тодорхой хэмжээний амьтныг бодож, тэдний тусыг хэзээ ч үйлдэхгүй хэмээх сэтгэл эгүүсгэвээс, нэг нь эвдэрвэл нөгөө цугласан хэсэг нь эвдрэхтэй адилаар, хамаг амьтны тухайд бодь сэтгэл төрүүлэхээс айхад хүргэнэ. Чингэлгүй хоёрдугаар, гутгаар, дөтгөөр зэрэг олон амьтныг орхилоо гэхэд үлдсэн бусдын тусад бодь сэтгэл төрүүлэхдээ ч, бодь сэтгэлээ төгс төгөлдөр төрүүлэх учиртай.

Бодь сэтгэлийн энэ суртгаалын талаар *"Мөрийн зулын тайлбар"*-аас айлдахдаа: "Индрабуди хаан, Нагаржунай, Асанга, Баву, Шантидэва, Зандрагоми, Шивацо зэрэг мэргэдийн ёстой тус тус байгаа" гэжээ. "Заримууд нь анхлан бодь сэтгэлийг төрүүлэх ба явдалд орох хоёрын суртгаалыг аль байгаагаар нь болой" хэмээжээ. Зарим нь судраас айлдсан бүгд сахихуй мөн гэжээ. Зарим нь чуулганы мөрийн суртгаал юу буй хэмээн таалжээ. Зарим нэг нь энэ, энэ мэтчилэн үл таалжээ. Заримууд нь авралыг одуулах суртгаалын дээр сэтгэлээ үл мартах ба мартах найман номыг сахихыг нэмжээ. Тэдгээр багш нарын ёсыг сударт номносон тул, өөр өөрийн багш нарын айлдсан тэр ёсоор барихыг миний багш айлдсан хэмээн номносон ба, энэ бүгдийг ч судрын утга мөн" гэх үзэгдэнэ.

Ер Жову гэгээн бээр, гэвш Домбовагаас дамжсан буяны их садан нарын тайлбарыг энд тайлбарлаагүй бөгөөд харин (дуун хөрвүүлэгч) Нагцоо лозова -гаас дамжсан номыг тайлбарласан байна. Тиймээс Нагцоогийн нууц ном гэж үздэг. Гэхдээ дээрх номуудад урьд алдаршсанаар Бүранд нэгэн хураангуй тайлбар зохиогоод, Самаяад заларч ахуйд Лозова нэмэлт айлтгаl дэлгэрэнгүй хийсэн тул, Жову гэгээн хураангуй тайлбар нэгийг зохиосон байна.

Зөвшин хэлэлцэхдээ суурь болгож барьсан олон номлолыг нэмэх зохистой. Илт эндүүрэн зарим ганц нэгийг барих үзэгдэх бөгөөд гол номлолд утга учрыг сайтар багтаасан нь олонтаа үзэгдэх учир би бээр, бусад үед ч эндүүрэлгүй бусдыг *"Бодь мөрийн зэрэг"*-тээ татан номнов. Дээр номносон эдгээр суртгаалын хувьд сэтгэлд баттай үл үзэгдэх бөгөөд, "сэтгэл эгүүсгэнэ гэдгийг орхихуйн сэтгэлийн суртгаалаар үйлдвээс, аврал одуулах суртгаалын дээр хар, цагаан найман номноо орох, буцах төдийхнээр хязгаарлаж болохгүй учир таарахгүй байна. Ерөөхүй сэтгэлийг

дангаар үйлдвээс, сударт айлдсан түүний суртгаал бүхэнд болон явдалд орохоос өмнөх суртгаалд суралцах хэрэггүй болно. Эс бөгөөс боомтлохын суртгаалтай ялгалгүй болно. Дээр номносон хоёр суртгаалаас бусад суртгаал нь *"Мөрийн зул"* болон "бодь сэтгэлийн зан үйл"-ийн дагуу болно.

"Долоон номын судар"-т айлдсан "Суралцахыг айлдсан" бол "илт мэдлийг түргэнээ хүсэх" хэмээсэн учир, бодь сэтгэлийн тухайд айлдсан суртгаал биш гээд бичсэнгүй.

Тиймээс миний ёсоор бол, ерөөхүй бодь сэтгэлийг үл орхих ба амьтныг ухаанаар эс орхих зэргээс бусад суртгаалтай харшлавч, бодисадвын санваар төгөлдөр бус байх хүртэл бодисадвын эрхэнд болсон унал болохгүй. Гэхдээ завсарт буянд тангарагласан суртгаалтай харшилж, гэмт явдалд урвах тул дөрвөн хүчээр наминчлаарай. Бодисадвын санваарыг авснаас хойш бол, санваарын суртгаалтай харшлах унал гарах учраас "Уналын жич засал"-ыг хэрхэн айлдсан мэтээр үйлдэх зохистой. Орохуй сэтгэлийн суртгаалд дотор хураагдахаас бус түүнээс бусдад багтахгүй нь. Гэвч зургаан удаа бодь сэтгэл эгүүсгэх нь ерөөхүй сэтгэлийн нийт бусын суртгаал болно.

В. Бодь сэтгэл эгүүсгээд явдалд суралцах ёсноо гурав:

1. Бодь сэтгэл төрүүлчихээд суртгаалд суралцах хэрэгтэйн учир шалтгаан
2. Нижгээд нижгээд арга билигт суралцсанаар бурхан үл болохыг өзүүлэх
3. Суртгаалд суралцахын эрэмбэ зэргийг номнох

1. Бодь сэтгэл төрүүлчихээд суртгаалд суралцах хэрэгтэйн учир шалтгаан:

Тэр мэт ерөөхүйн бодь сэтгэлийг олчихоод, өглөг тэргүүтний суртгаалд эс суралцвал, дээр дурдсан *"Майдарын намтарын эш"*-д гарсан мэтээр тус эрдэм ихтэй боловч, бодисадвын суртгаалын шимийг үйлдээгүй болохоор бурхан болохгүй тул суртгаалд суралцааарй.

"Гаягори"-гаас айлдахдаа: "Бодь хутаг гэдэг бүтээлийг шим болгон үйлдэх их бодисадва нарын хэрэг мөн. Бүтээлийн шимийг буруугаар баригч нарынх бус" хэмээжээ. *"Бясалгалын хаан судар"*-т ч: "Тиймээс бүтээлийг шимд үйлдээрэй. Юуны тухайд хэмээвээс, залуудаа бүтээлийн шимийг үйлдвээс ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутгийг олоход бэрх бус бөлгөө" хэмээжээ. Бүтээл гэдэг бурхан бүтээхийн арга бодисадын суртгаалд суралцах явдал мөн.

"Бясалгалын эхний зэрэг"-ээс ч: "Тийнхүү (бодь) сэтгэл төрсөн бодисадва нь өөрийгөө боловсруулахгүй бол, бусдыг боловсруулж чадахгүйг мэдээд, өөрөө өглөг тэргүүтнийг бүтээж сайтар хичээх буюу. Бүтээлгүйгээр бодь хутгийг олохгүй" хэмэсэн болно. *"Тийн тайлбар"*-аас:

Нигүүлсэлт бээр, зовлонг дарахын тулд
Арга зэрэгт илт (бэлтгэн) найруулж зохио
Аргаас гарсан түүний шалтгаан далд учир
Түүнийг номлоход бэрхтэй мөн хэмээн айлджээ.

Бусдыг хайрлах, их нигүүлсэхүй байваас, тэдний зовлонг арилгаж чадах болно. Түүнийг арилгахад зовлонгоос хагацаасай хэмээх сайхан сэтгэлээр хязгаарлахгүй, түүнийг бүтээх арганаа орох хэрэгтэй. Урьдаар тэр аргаа мэдэхгүй бол бусдыг гэтэлгэж чадахгүй. Тиймийн учир бусдын

тусыг бүтээхийг хүсвээс л, эхлээд өөрийгөө боловсруулах хэрэгтэй. Тиймд бүтээлийг шимд үйлдэх учиртай гэж айлджээ. Бүтээхдээ ч тангараг санваар авч, түүний суртгаалд суралцах ёстойг айлдсан тул бүтээлийн шимд үйлдэх газраа эндүүрэхгүй байх нь их чухал ажээ.

2. Нижгээд нижгээд арга билигт суралцсанаар бурхан болохгүйг үзүүлэх:

Тийнхүү бурхан болохыг хүсээд зогсохгүй, бурхан болох арганаа орох арга тэр нь эндүүрэггүй байх шаардлагатай. Эндүүрэгтэй мөрд хичнээн шамдавч, үр нь үл гарах буюу "сүү саах гээд эвэр шувтрахтай адил" гэлээ. Эндүүрэггүй боловч хувь эс бүрдвээс, үр үл гарах буюу. Хөрөнгө, ус, хөрс, шороо аль нэг нь эс бүрдвээс ногоо ургахгүйтэй адил. Тиймд *"Бясалгалын дунд зэрэг"*-ээс: "Шалтгааныг эндүүрвэл, өнө удаан хичээн шамдавч, хүссэн үр дүн гарахгүй нь эврээс сүү саахтай адил болой. Бүх шалтгааныг эс бүрдүүлвээс үр гарахгүй бөгөөд хөрөнгө тэргүүтний аль нэг нь дутваас ногоо тарианы үр жимс гарахгүй мөн.

Тиймийн учир үрийг хүсвээс эндүүрэггүй шалтгаан нөхцөл бүгдийг шүтэх хэрэгтэй" хэмээжээ. Тэгвэл шалтгаан нөхцөл бүрдсэн, эндүүрэггүй гэж юуг хэлэх вэ? хэмээвээс *"Намнан онжан"*-д: "Нууцын эзэн! Хамгийг болгоогчийн бэлгэ билиг тэр нь нигүүлсэхүйн язгуураас төрөв. Бодь сэтгэлийн үндэснээс төрөв. Аргаар эцэс туйлд хүрсэн мөн" хэмээжээ. Тэрхүү нигүүлсэхүй сэтгэлийг номносон билээ. Бодь сэтгэлд янагуухи ба үнэмлэхүй бодь сэтгэл хоёр буй. Арга болвоос төгс төгөлдөр өглөг тэргүүтэн болохыг их тэрэгчин Камалашила айлджээ.

Энэ мэтийн зам мөрийг чанх буруугаар ухсан Жанаг Хуушаан зэрэг зарим нэгэн бээр "Атгаг мөнөөс хойш, муу атгаг ч бай, сайн атгаг ч бай орчлонгийн хүлээс тул түүний үрээр орчлонгоос гэтэлж чадахгүй. Алтан аргамж болон дээсэн аргамжаар хүлүүлэх ба хар, цагаан үүл хоёулаа огторгуйг халхлах, хар, цагаан нохой алинд ч хазуулсан адил зовлон гарна шүү. Тиймд юу ч бодохгүй суух нь бурхан болох мөр мөн. Өглөг, ёс суртахуун зэргийг тэр мэтийн магад утгыг бясалгаж чадахгүй тэнэг хүмүүст айлдсан учир, түүний утгыг олохоор хуврагийн явдлаар явагчид нь хаан эгэл ардын газар буух юм уу, үхрээ уначихаад үхрийн мөрийг мөшгөхтэй адил" гэж хэлдэг.

Тэгээд Хуушаан юу ч бодохгүйгээ магтан сайшааж наян судраас иш

татжээ. Тэрээр чингэж аргын хувь бүгд бурхан болохын мөр бус хэмээн, янагуухийг их доромжилж, ялгуугсадын номын зүрхэн "би-үгүй" үзэл буюу хоосон чанарыг тус тус онох билгээр шинжлэх зэрэгт хориг тавьснаар үнэмлэхүйн ёсыг өнөд таягджээ.

Хэдий ялгаатай боловч, амарлих орны (сэтгэлийн) зүг төдийд хураагдах сэтгэл төдий нэгнийг мөрийн дээд гэж барих буруу үзлийн адаг болсон энэ мэтийг их бодисадва Камалашила бээр хиргүй эш, ухааны чуулганаар сайтар хориглож, бурхад баясах сайн мөрийг дэлгэрүүлэн зохиосон буй.

Гэвч дээдийн номын (наран) шингэхэд маш ойртсон, мөрийн аньсыг бүрэн төгс багтаасан магад утгыг хиргүй эш, ухаанаар үнэхээр зөв ухаарсан мэргэд дээдэс барагдсан, амьтны буян машид хомосдсон, номд сүжиглэх боловч ухааны чадал мөхөсдсөн зэрэг олон байгаа тул, одоо ч зарим нэгэн сахих, боомтлох тэргүүтний явдал мөрийг басамжилж, мөрийг бясалгахын үест тэдгээрийг орхих зэргээр Хуушаан шиг авирлах үзэгдэнэ. Зарим нь, аргын хувийг дорд үзэхээс өөр зүйлгүй Хуушааны үзэл онолд ухаарахыг сайн гэх, бас дээр тус тус онох билгийг орхиж "юуг ч үл бодох" хэмээх Хуушааны бодлыг сайнд тооцох ч харагдана. Тиймэрхүү зам мөрүүдэд хоосон чанарыг бясалгалын орон зүг юу ч үл харагдана.

Хэрвээ хоосон чанарын бясалгал мөн гээд бодовч, зөвхөн хоосон чанарын утгыг жинхэнэ зөвөөр олж, бясалгах ёсоо эндүүрэггүй мэдсэн бясалгалын эрдэм онолт мэргэд л хоосон чанарыг бясалгах билээ. Гэтэл явдал мөрийн зүгийн янагуухи сэтгэлийг бясалгах хэрэггүй хэмээж, тэдгээрийг гол болгож олон талаас бясалгах шаардлагагүй гэж өгүүлэгчид нь эрхэм зарлиг бүгдтэй харшилсан учир шалтгааны мөрөөс хэтэрсэн ямагтад үзэгдэнэ.

Их хөлгөний бүтээх орон бол "үл орших нирваан" билээ. "Сансарт (самсара) үл орших" гэдэг бол хоосон чанарыг оносон билиг ба үнэмлэхүйд шүтсэн мөрийн зэрэг буюу, гүн гүнзгий мөр хэмээх бэлгэ билгийн чуулган, билгийн хувь хэмээгдэх зэргээс бүтэх мөн. "Амарлингүйн нирваанд үл орших" гэдэг бол янагуухи ухааны билиг, янагуухийн үнэнээ шүтсэн мөрийн зэрэг буюу агуу их мөр, бинавадын буяны чуулган, аргын хувь зэргээр бүтэх мөн. Тэр талаар *"Санаанд багташгүй судар"*-т: "Бэлгэ билгийн чуулганаар нисваанис бүгдийг тэвчиж үйлдсэн мөн. Бинавадын чуулган нь амьтан бүхэн шадар амьдруулах мөн. Ялж төгөлдөр нөгчигсөн

тэр мэт тул, Бодисадва, их бодисадва нар бинавадын болон билиг билгүүний чуулганаа хичээж үйлдэх болой." хэмээжээ.

"Хутагт огторгуйн хүү сан"-гаас: "Билгийн ухаантай учраас хамаг нисваанисыг төгс орхих болой. Аргын сэтгэлтэй учраас амьтан бүхнийг огоот үл хаях болой" хэмээжээ. *"Хутагт тааллын тайлбар"*-аас: "Амьтны тусад ер үл зүглэх ба, илт хуран үйлдсэн бүхнээ ер зүглэхгүй байхыг ханьцашгүй туулсан хутаг гэж би заагаагүй болой" хэмээжээ. *"Димэддагвын үзүүлсэн судар"*-т: "Бодисадва нарын хүлээс юу вэ? Гэтлэхүй хутаг (нирваан) юу вэ? хэмээсэнд, Арга үгүйгээр, орчлонд амьтныг огоот барина гэдэг бодисадвын хүлээс буюу. Аргаар орчлонгийн амьтнаа одох нь нирваан болой. Билиг үгүйгээр, орчлонд амьтны огоот барих нь бодисадвын хүлээс болой. Билгээр орчлонгийн амьтнаа одох нь нирваан болой. Аргаар үл эзлэгдсэн билиг нь, хүлээс болой. Аргаар эзлэгдсэн билиг нь нирваан болой. Билгээр үл эзлэгдсэн арга нь хүлээс болой. Билгээр эзлэгдсэн арга нь нирваан болой" хэмээн ихэд тодорхой айлдсан буй.

Тиймд үр болсон бурханы хутгийг нэгэнт хүсвээс, мөрийн үест арга билиг хоёуланг шүтэх хэрэгтэй бөгөөд хос бусаар бол бүтэхгүй мөн. *"Гаягори"*-д: "Бодисадва нарын мөрийг товчлон хураавааас хоёр буюу. Хоёр алин хэмээвээс, энэ мэт буюу. Арга болоод билиг болой" хэмээсэн ба *"Балчогдамбу"*-гаас:

Билгийн чинад хүрсэн нь эх бөлгөө
Арганаа мэргэн нь эцэг бөлгөө

хэмээсэн *"Одсүрэн айлтгасан"*-д: "Одсүрэн! Энэ мэт буюу. Үлгэрлэвээс, түшмэдээр эзлэгдсэн хаад хэрэгтэй бүхнээ гүйцээхийн адил, бодисадва нар билиг, мэргэн аргаар огоот эзлэгдэж байж гэмээ нь бурханы зохиол бүгдийг үйлдэх болой" хэмээн айлджээ.

Тиймд өглөг тэргүүтэн аргын хувь бүгд бүрдсэн, намба байдал төгөлдөр дээд хоосон чанарыг бясалгах мөн. Хоосон чанарыг дангаар нь гэвэл их хөлгөний зам мөрийн хаана ч хүрэхгүй.

"Оройн их эрдэнийн судар"-аас: "Тэрээр асрахуйн хөө хуягийг өмсөөд их нигүүлсэхүйн орноо оршиж, хамаг бүгдийн дээд төгс хоосон чанарыг илт бүтээснээр самадийг бүтээнэ. Тэрхүү намба байдал төгс дээд хоосон чанар юун хэмээвээс, алин өглөг лүгээ үл хагацах ба шагшаавад лугаа үл хагацах, тэсвэр лүгээ үл хагацах, хичээнгүй лүгээ үл хагацах, самади лүгээ

үл хагацах, билиг лүгээ үл хагацах, арга лугаа үл хагацах тэр" хэмээн дэлгэрэнгүйгээр зарлигласан түүний утгыг *"Дээд дамжлага"*-аас:

Тэдгээрийг бичиж үйлдэх алин мөн
Өглөг, шагшаавад, тэсвэр зэргийн
Намба байдал бүгд төгс дээд болсноор
Хоосон чанарыг дүрс гэж өгүүлэх

хэмээн заримууд толгой зурж мэдэхээс бусдыг мэдэхгүй, заримууд гар зурж мэдэхээс бусдыг мэдэхгүй зэргээр олон зураач цуглаж хааны хөргийг зурахад нэг л зураач бүрдэхгүй бол, төгс төгөлдөр болохгүйгээр үлгэрлэж, "хааны дүр нь хоосон чанар, зураач нь өглөг тэргүүтэнтэй адил" хэмээн айлдсан ба, өглөг тэргүүтний арга эс бүрдвээс толгой нь хавчгар, хөл нь хомгор зэргийн дүрстэй адил болно.

Бас хоосон төдий нь бясалгалын үндэс гээд бусдыг бясалгах хэрэггүй гэж өгүүлэхийг Ялж төгөлдөр нөгчигсөн бээр урьд нь авч хориглосон билээ. Тийм байтал, бодисадвын цагт олон галавт өглөг өгсөн, шагшаавад сахих зэргүүдийг магад утгыг ухаараагүй, цалхай ухаан хэмээсэн байна. *"Намбар тагва дүйва"*-д: "Жамба аа! Ийнхүү бодисадва нар зургаан барамидыг үнэхээр бүтээх нь, туулсан хутгийн тухайд байтал, тэнэг хүмүүс, бодисадва нарыг зөвхөн билиг барамидад суралцахаас, бусад барамидад юунд суралцах хэмээн өгүүлж, бусад барамидаас залхаах сэтгэлийг барина. Мапамба аа, Үүнийг юу гэж санана вэ? Кашийн хаан болсон тэрээр, тагтааны тухайд өөрийн махаа харцаганд өгсөн тэр ухаан чинь цалхайрсан юмуу гэж Жамба бээр айлтгав. Ялж төгөлдөр нөгчигсөн, Тэр тийм биш билээ. Бурхан зарлиг болруун, Жамба аа! Би бодисадвын явдлаар явж зургаан барамид төгөлдөр буяны язгуур алив бүхнийг хураасан буяны язгуур тэдгээр минь намайг хорлох болох нь уу хэмээсэнд, Жамба айлтгаруун, Ялж төгөлдөр нөгчигсөн, Тэр тийм биш ээ. Ялж төгөлдөр нөгчигсөн бээр зарлиг болруун, Мапамба, Та ч гэсэн, жаран галавт өглөг барамидыг үнэхээр бүтээв. Жаран галавт шагшаавадын барамид, жаран галавт тэсэхүйн барамид, жаран галавт хичээхүйн барамид, жаран галавт самади барамид, жаран галавт билиг барамидыг үнэхээр бүтээж байхад, түүнийг тэнэг хүмүүн бээр дан ганц ёсоор бодь хутагт хүрэх гэх буюу энэ мэт хоосон чанарын ёсоор болчихно хэмээн ийн хэлэх нь тэдний явдал ерөөс ариусаагүй хэрэг ээ" хэмээжээ.

Тиймээс, хоосон чанарыг олсон аваас аргын хувьд ихэд шамдаж бясалгах хэрэггүй гэж өгүүлэх нь, өөрийн багшийн урьдын тэр сайн төрлийг, жинхэнэ утгыг ухааргүй цаг байжээ гэж басамжилсан хэрэг болно. Бүр цаашлаад, өглөг тэргүүтний явдал мөрийг олон үүднээс бүтээвэл, хоосон чанарын онол батгүй болох учир (харин баттай) байлгахын тулд үүгээр болно хэмээх их буруу үзэлд хүрнэ.

Тэр мэт үнэхээр мөн бөгөөс, үнэмлэхүй үнэнийг илт оносон үл атгаглахын билиг билгүүний их газарт багтсан бодисадва нар болон ялангуяа үл атгаглах билиг билгүүнээ эрх олсон наймдугаар газрын бодисадва нарт ч явдал мөр хэрэггүй болоход хүрэх учраас чингэх нь зохисгүй болно.

"Арван газар тус бүрт өглөг тэргүүтнээр голлосон нижгээд нижгээд байх мөн тул, үлдсэн бусдад эдлэхгүй байна гэж байхгүй хэмээн "Арван газар"-аас айлдсан нь зургаа зургаан барамид тус бүрт буюу арван барамид тус бүрт туурвихыг айлджээ. Тэдгээрийн утгыг Майдар, Нагаржунай, Асанга зэрэг гэгээчүүд тийнхүү тайлсан тул өөрөөр тайлбарлаж болохгүй билээ.

Ялангуяа наймдугаар газрын үест буюу, нисваанис бүгдээ барж цацрал бүгд амарлих үнэмлэхүйд оршихын цагт ч, бурхад ч хоосон чанарыг олсон энэ төдийхнээр бурхан болж үл чадах бөгөөд Сонсоод сонсогч, Өөрөө ялгуугсад бээр тийн үл атгаглах үүнийг олох болой.

"Бидний цаглашгүй лагшин, билгэ билиг, орон тэргүүтэн эдгээрийг үзэгтүн, бидний хүч тэргүүтэн танд байхгүй тул хичээлийг туурвисугай. Амьтан эс амарлиж, элдэв нисваанисаар хямралдахыг санагтун. Энэхүү тэсвэрээ ч бүү орхигтун" хэмээх зэргээр шаардуулж, бодисадвын явдалд суралцах хэрэгтэй гэж номноод байхад өрөөсгөл ганц нэг самади дияанд суучихснаар гэвэл, мэргэдийн инээдэм наадмын орон болно.

Ийн хэмээн *"Арван газар"*-аас, "Ялгуугсаны хөвгүүдийн үл хөдлөх газарт оршсон бодисадва нь урьдын ерөөлийн хүчийг эгүүсгэх, номын үүдний үргэлжлэлд оршсон түүнээ, бурхан ялж төгөлдөр нөгчигсөд, түүнчлэн залрагсадыг билгэ билгийг чухалчлан бүтээхийг захина. Ийн хэмээн түүнийг зарлиг болвой. Язгуурын хөвгүүн ээ, Сайн болой, сайн болой.

Бурханы ном бүгдийг даган онох энэ үед үнэмлэхүй тэсвэр хэрэгтэй. Тийн бөгөөтөл чамд бидний арван хүч болон үл айх тэргүүтэн хотол чуулсан бурханы ном тэдгээр байхгүй байна.

Хотол чуулсан бурханы ном тэднийг төгс эрэлцэх хичээлийг туурвигтун. Энэхүү тэсвэрийн үүдийг бүү орхигтун. Язгуурын хөвгүүн ээ, Та нар хэдийгээр амарлингуй тийн тонилохуй хутаг нирвааныг олсон боловч, элдэв нисваанисаар үл амарлих, элдэв хотол гарсан шатгаанаар алмайрч алгасрах эгэл бэртэгчин эдгээрийг болгоож санахтун. Мөн Язгуурын хөвгүүн ээ! Урдын ерөөл ба амьтны тусыг бүтээх буюу, санаанд багташгүй бэлгэ билгийн үүдийг санаж үйлдэхтүн. Бас Язгуурын хөвгүүн ээ, эдгээр нь номын жам ёс болой. Түүнчлэн залрагсад байсан байгаагүй ялгаагүй, номын агаар энэ ямагтаар орших буюу. Ийнхүү ном бүгд хоосон чанартай ба ном бүгд зоригдохуунгүй болой.

Үгээр, Түүнчлэн залрагсад эс бурхан болоход ойрхон гэж ялгаж болохгүй. Сонсоод сонсогч болон Өөрөө ялгуугсад бүгдээр тийн үл атгаглах энэхүү хоосон чанарыг олох мөн. Язгуурын хөвгүүн ээ, бидний лагшин цаглашгүй, бэлгэ билиг цаглашгүй, бурханы орон цаглашгүй, бэлгэ билгийг илт бүтээл цаглашгүй, гэр мэт хот мандал цаглашгүй, эгшиг гишүүн асар ариун цаглашгүй байх зэргийг хараад та ч энэ адилаар бүтээсүгэй" хэмээжээ.

Үлгэрлэвээс, их хөлөг онгоц далайд ороод зохилдох салхиар хөдлөн явж байгаад нэг өдөр төдийд зогсож явах нь, далайд гарахааасаа өмнө ихэд шамдаж зуун жил ч зогсохооргүй болгож засаагүйтэй адилаар, наймдугаар газарт хүрээд их шамдал харгалзалгүй нэгэн хормын төдий хамгийг болгоогчийн алив мөр юухан төдийг ч мэдэхийн тулд, тэр газарт очихын өмнө, буман галавт зам мөрд шамдавч чадахгүй тал бий гэж *"Арван газар"*-аас айлдсан бий. Гэтэл түргэн мөр байна гээд бодисадвын явдалд эс суралцваас өөрөө өөрийгөө хуурсан болно.

"Хэрвээ өглөг тэргүүтэн хэрэггүй гэж үзэх ч, юу ч санахгүй байх дээр тэдгээрийг бүрдүүлж, өгөгдөхүүн, өгөгч эзэн, өглөгийн эд зүйлд эс шунаваас, эс тухайлах өглөг гүйцэж болно. Үлдсэн зүйлүүд ч тийн бүрдэж болно. Судраас ч, тус тусын дотор зургаа зургаа хураагдана гэж айлдсан билээ" хэмээвээс, "Тэр төдийгээр бүрдэнэ хэмээвээс, тэрсүүдийн ёсны нэгэн үзүүрт амарлингуй орныг бясалгахын цагт ч, тэр мэтээр шунах явдал гарахгүй тул, чинад хүрэхүй (барамид) бүгд бүрдэх нь ээ. Ялангуяа дээр үзүүлсэн мэтээр Сонсоод сонсогчид хоосон чанарыг тийн эс атгаглахын үестээ бодисадвын явдал бүгдийг гүйцээх болох тул их хөлгөнд багтах нь ээ"

Тус тусын дотор зургаа зургаа хурахыг айлдсан тул тэр төдийгээр болно гэвээс, мандал өргөхөд ч, "бажи болон ус сэлттэй өргөх" тэргүүтэн зургаа байхыг айлдсан байх тул зөвхөн үүнийг хийчихвэл болчих бизээ.

Чингээд үзлээр ээлэгдсэн явдал, аргаар ээлэгдсэн билгийг үлгэрлэвээс, энхэр сайхан хүүгээ алдчихаад гасалж шаналж яваа эх хүнд, хэдийгээр бусадтай ярьж хөөрөх зэргийн үест өөр бодол санаа ургавч, нөгөө гаслах, харуусах сэтгэлийн хүч нь хэвээрээ байна. Түүний ухаан бодол бүгдийг гаслант гэж болохгүй. Түүнтэй адилаар хоосон чанарыг оносон билгийн хүч хариагүй байхад өглөг өгөх, эргэл мөргөл хийх, урин тоолох зэргээр үйлдэхэд хэдийгээр эдгээр бодол ухаанууд хоосон чанарыг оножˌ тухайлаагүй байсан ч нөгөө билиг ухааны үзүүр юм уу, хүч нөлөө хэвээр байхад харшлахгүй. Бясалгалын тасалгааны эхэнд бодь сэтгэлийг хүчтэй хатуу одуулсны дараа хоосон чанарын бясалгалд суух үест хэдий тэр бодь сэтгэл ил бодитой байхгүй ч түүний үзүүрээр ээлэгдэхэд харшлахгүй болно.

Тэр адилыг зоригдолгүй өглөг хэмээнэ. Өгье юү гэх сэтгэл огт байхгүй бол, өгч чадахгүйтэй адилаар бусдыг таниарай. Арга билиг өрөөсгөл байхгүйн учрыг ч үүгээр мэдээрэй. Бинавадын буяны чуулганы үрд орчлонгийн бие махбодь, төгс эдлэл, урт нас тэргүүтэн гарна гэж айлдсан байх ч, бүү эндүүрээрэй. Арганаа мэргэн болж билгээс хагацваас тэр мэт болох хэдий ч, харин тэдгээрээр ээлэгдвээс тонилохуй хутаг ба хамгийг болгоогчийн үндэс болдог аж. *"Их эрдэнийн эрхи"*-ээс:

Дүрст лагшинг товчлон хураваас
Бурхад бинавадын буянаас мэндлэх хэмээсэн зэрэг олон эш ном буй.

Гэтэл "Та ч гэсэн, заримдаа муу заяаны үндэс болдог муу явдал ба нисваанис бүгдээр ч бурхан болохын үндэс болдог гэж өгүүлээд, заримдаа өндөр язгуурын үндэс болдог өглөг, шагшаавад зэрэг сайн буянууд орчлонгийн үндэс болж, бодь хутгийн үндэс болдоггүй" гэж хэлэх явдал үзэгдэх тул сэтгэдлээ тогтоон бодогтун.

"Судар"-аас: "Өглөг тэргүүтэн зургаад илт шунаваас шумнасын үйл болой" хэмээсэн ба, *"Гурван цогцос"*-т: "Зоригдолд бариснаар өглөг өгөх, шагшаавадаа дээдэд үзэх, түүнээ сахих зэрэг тэдгээр бүгдийг тус тус наминчлан үйлдмүй" хэмээн номножээ. *"Цанба айтгасан "*-д: "Юу шинжлэх тэр бүгд нь атгаг болой. Эс атгаглах нь, бодь хутаг болой" хэмээсэн мэтийг

эндүүрэхгүй байх хэрэгтэй.

Эхний утга бол "хоёр би"-д чанх буруу шунах бүхнээр эдээгдсэн өглөг зэрэг нь ариун бусын учир шунах үйл гэж үзсэн болохоос, өглөгийг шумнасын үйл гэж заасан бус. Нөгөө зургааг мөн айлдсан тул, бясалгал, билгийг ч мөн шумнасын үйл гэж үзэх аж.

Хоёрдугаар эшийн утга нь ч гэсэн, чанх буруу илт шунаснаар, хотол эдээгдөж булингартсан тэр мэтийг заасан болохоос, өглөг тэргүүтнийг битгий шүтээрэй гэж заагаагүй юм шүү.

Тийн бус болохоор, "зоригдолдоо унаж өглөг эрэлцэх хэмээн зоригдол бодолдоо ойчих хэрэггүйгээр, ерөнхий өглөг өгснөө л наминчлах болой" хэмээснийг учир шалтгаанаас чингэж зарлиглаагүй байна.

"Бясалгалын төгсгөлийн зэрэг"-ээс: "Хариу тавих ёсыг тэр мэт зохиосон нь машид аньс ихтэй буюу. Үүнийг чанх буруугаар ойлговол явдал мөр бүхнийг бодгалийн болоод номын би-г "бэлгэст (үнэнд) барьж, бэлгэст" хэмээн үздэг болой.

Энэ эдийг өгөх хэмээх өгөх сэтгэл, энэ гэмийг боох болюу хэмээх боомтлох сэтгэл, энэ адилын буяны атгаг бүгдээр, гурван нөхөрт баригч "номын би"-д барих сэтгэл мөн болвол, номын би-үгүйн үзлийг ологсод бээр, уур хилэн, омог тэргүүтнийг хэзээд л хорих учраас, тухайлсан тэдгээрийг шүтэх хэрэггүй болох нь ээ.

Энэ нь энэ болой хэмээх атгаг бүгдийг гурван нөхөрт атгаглах "номын би" гэж бариад байвал, буяны садны эрдмийг санах, чөлөө учрал, мөнх бус, муу заяаны зовлон зэргийг бодох, аврал одуулах, энэ үйлээс ийм үр гарахыг санах, асрахуй, нигүүлсэхүй бодь сэтгэлийг судлах, орохуйн сэтгэлийн суртгаалыг судлах энэ бүгд дээр энэ нь энэ болой, үүнээс энэ гарах, үүнд ийм эрдэм, ийм гэм бий гэх зэргийг санахад ч зөвхөн гулзгай магадлал гарах билээ. Тэдгээрийг хэдий чинээ их магадлах тусам номын би-д баригч нь улам дээшлэн одно.

Мөн номын би-үгүйд магадлал хичнээн ихсэх тэр төдийгөөр, нөгөө мөрийн магадлал хомсдож одох тул, явдал, үзлийн зүг хоёулаа халуун хүйтэн харшлах мэт одож, хоёуланг нь хүчтэй хатуу, өнө удаан үргэлжлүүлэн магадлах газаргүй болно.

Тиймээс үр гарах орон үест, номын лагшинг олох ба дүрст лагшинг олох хоёр үл харшлах мэтээр мөрийн үест ч, "хоёр би"-г бэлгэст барих бодол зоригдолууд нь тоосон төдий ч үлдэлгүй бүгдээр цацралаас

хагацсан гэж магадлан мэдэх болон, үүнээс энэ гарах ба, үүнээ гэм эрдэм энэ буй зэргийг магадлан мэдэх хоёр харшлахгүй байх хэрэгтэй.

Чингэвч энэ нь суурь үзэл болсон хоёр үнэнийг нотлон буулгах ёсноо харгалзах тул, эш болон учир шалтгааны үүднээс үзвэл, сансар нирваны ном бүгдийн, өөрийн орших ёс буюу ахуй ёс нь өвөрчлэнгээр тоосон төдий ч бүтээгүй гэж нотлон буулгасан үнэмлэхүйг тийн агуулсан шалгадаг ухаан болон шалтгаан үрийн номыг өчүүхэн төдий ч холилгүй тус тус магадалж, шалтгаан үрийг тийн агуулах нэрийтгэлийн шалгадаг ухаан хоёр нь, янагш чинагш хорлогдохуун, хорлогч болох нь байтугай, нэг нь нөгөөдөө нөхөр болохыг мэдэж, улмаар хоёр үнэний утгыг оносон ба бурханы хутгийг олсон хэмээхийн тоонд тооцогдож одно. Энэ талаар *"Үлэмж үзэхүй"*-н үест номноно.

Гутгаар эшийн утга нь, тухайн судрын тэр үест, төрөх тэргүүтнийг шинжилж буй үе учраас, өглөг тэргүүтэн хоосон чанарт мөн тул төрөх үгүй хэмээж, "атгаглах болой" хэмээн атгагаар нэрийдсэн төдий болохыг заажээ. Харин тэдгээрийг шүтэж болохгүй хаягдахуун гэж заагаагүй болно. Тиймээс бурхан болохыг хүртэл явдал мөр тэдгээрт суралцах хэрэггүй үе гэж байхгүй тул, зургаан барамид тэргүүтэй явдал мөрд суралцах хэрэгтэй. Чингээд одооноос зүрхний мухраас шамдаж, бүтээл бүтээхээр хичээж бүтээгтүн.

Заримдаа хийж чадаагүйгээ ерөөлийн орон болгож, тэдгээрийг анхааран авч чадахын уг буяныг хурааж, хилэнцээ арилгах ерөөлийг олонтаа талбиваас өнө удалгүй анхааран бясалгаж ирэх болно.

Чингэлгүй зөвхөн өөрийн мэдэхгүй, чадахгүйгээ урдаа бариад, тэдгээрт суралцах хэрэггүй гэж өгүүлвээс өөрийгөө гутаах бас бусдыг ч гутааж улмаар ном "жаргахын" шалтгаан болох тул бүү үйлдээрэй.

"Хотол судрын хураангуй"-гаас: "Хуран эс үйлдсэн гэж тус тус оновч, хуран үйлдсэн буянаа огоот уйдах нь шумнасын үйл болой. Бодь мөрийг сайтар ухааравч, чинад одох мөрд үнэхээр эс суралцваас шумнасын үйл буюу" хэмээсэн ба, "мэргэн аргаас хагацсан бодисадва бээр, гүн гүнзгий хоосон чанарт илт хичээж эс үйлдэх болой" хэмээжээ.

"Санаанд багташгүй судар"-аас: "Язгуурын хөвгүүн ээ! Энэ адил буюу. Гал гэдэг шалтгаанаас бадрах бөгөөд шалтгаан үгүй бол унтрах мөн. Тэр адил бодлын орноос сэтгэл ургах ба бодлын орон үгүй бол тэр амарлих болно. Арганаа мэргэшсэн бодисадва билгийн чинадад лавтай хүрснээр

огоот ариусах тул, бодлын орон чухал амарлихыг ч мэднэ. Буяны язгуурыг бодлоо ч чухал амарлиулж үл үйлдэнэ. Нисваанисыг тухайлах боловч, хөөж үл чадах тул чинад хүрэхүйн зоригдохуун орныг агуулан үйлд. Хоосон чанарын бодлыг тус тус оножь, хамаг амьтныг их нигүүлсэхүй сэтгэлээр тухайлах бодлыг ч үзээрэй" хэмээн зоригдол байхгүй ёс болон зоригдол байх ёсыг тус тус айлдсан тул ялгаж мэдэх хэрэгтэй. Тэрчлэн нисваанисын болоод үнэнд баригчийн хүлээсийг султгах хэрэгтэй тул, суртгаалын аргамжаар чанга боох шаардлагатай. Амлашгүй хоёрыг эвдэж, буяны үйлээ эвдэхгүй байх ёстой тул суртгаалаар боомтлох ба үнэнд баригчаар хүлэгдэх хоёр адилгүй болно. Сахих санваараа сулруулах ба би-д баригчийн хүлээсийг сулруулах хоёр ч нэг зүйл биш.

Хамгийг болгоогч гэдэг олон шалтгаанаас бүтэх болохоос, ганц нэгээр болохгүй. Дүүгүүрийн нэгэн чулуугаар зуун шувууг хөөнө гэдэг шиг чөлөөт сайн шүтээнийг олчихоод олон үүднээс шимийг авах болохоос бус, ганц нэгхэн мөрийн хувьд сурсан болоод бусдад үл суралцваас, хоёр буяны чуулганыг хорих нүглийн садан болохыг мэдээрэй.

Их, бага хөлгөн гэдэг анхааран авахын цагт хэмжээлшгүй их буянд суралцсан, суралцаагүйгээр ялгагдах мөн. Бага хөлгөн ба өрөөсгөл хөлөг гэх хоёр бол нэг утгатай нэр юм. Учир нь өрөөсгөл гэдэг бол бүрэн биш, ганц талыг барихыг хэлжээ.

Эдүгээ ч багахан үр тариа, идээ ундаа зэргийг хүртэл олон шалтгаан нөхцлийн тусламжтайгаар бүтээх шаардлагатай байхад, төрөлхтөн амьтны эрхэм дээд хэрэг болсон бурханы хутгийг бүтээхдээ өрөөсгөл талыг барих нь зохисгүй буюу. Үр жимс гэдэг шалтгаанаас үүдэх шүтэн барилдахуйн жам ёст бөлгөө.

Үүнийг таалан *"Нигүүлсэхүйн цагаан линхуа"*-гаас: "Өрөөсөн ганцаас өрөөсөн ганц л гарах, хамаг бүгдээс хамаг бүгд л төрөх" хэмээжээ. *"Түүнчлэн залрагсадын төрөл гарах судар"*-аас: "Алин Тэрчлэн залрагсад гарна гэдэг ганцхан шалтгаанаас биш болой. Юуны учир хэмээвээс, Аяа, Бурханы хөвгүүн ба тэрчлэн залрагсад нь үнэхээр бүтэхийн үндэс нөхцөл болсон цаглашгүй арван буман тоот буянаас бүтнэ. Арав алин хэмээвээс, энэ мэт бөгөөд цаглашгүй бинавад болон бэлгэ билгийн буяны чуулганаар үл ханах үнэмлэхүй шалтгаан" хэмээн ихэд дэлгэрэнгүй номножээ.

"Димаддагва бээр үзүүлсэн"-ээ: "Аяа, Нөхөд минь ээ, Тэрчлэн залрагсадын лагшин нь олон зуун буянаас магадтай мэндэлжээ. Хамаг

буян ном бүгдээс магадтай төржээ. Хэмжээлшгүй их буянаас магад төржээ" хэмээн дэлгэрэнгүй айлджээ. Нагаржунай гэгээн бээр ч:

Алин хэзээ дүрст лагшингийн
Шалтгаан ч тэр ч ертөнцтэй адил
Хэмжээлшгүй тэр адил
Номын лагшингийн шалтгаан түүнийг хэрхэн хэмжих вэ хэмээн айлджээ.

Энэ мэтээр арга, билиг хоёрыг зургаан барамидад хураан суралцах нь өмнө номносон адилаар тантрын болоод судрын хөлгөн хоёуланд байх нийтлэг зүйл ээ. Тантрын олон номуудаас, бурхадын хэмжээлшгүй их орд харш, бурхадын байгуулал зэрэг юу айлдсан бүгдээ дотоод сэтгэлийн эрдэм гэж номнохын зэрэгцээ зургаан барамид, бодийн зүгийн гучин долоон ном, арван зургаан хоосон чанар зэрэг судрын хөлгөний төгс зам мөрүүдийг ч олонтаа номносон бий. Тиймээс зарим нэгэн ялгамжаатай бодгалийн хувьд хүслийн эрдмийг мөр болгох гэх мэтийн судрын хөлгөнөө авч орхихын заагтай зарим нэгээс бусад тохиолдолд, нийтийн байхыг гэж мэдээрэй. Дээр номносон зүйлийг суурь болгож сайтар тунгаан мөрийн зүг ганц нэг төдий бус, хувь бүгдийг гүйцээх ёстойг эс мэдвээс, их хөлгөний нийтийн мөрийн хөлөөр ээлэгдээгүй болох тул, ухаант мэргэд бээр үүнийг сайтар ухаарч, олон үүднээс их хөлгөний дээд язгуурын хүчээ улам дээш нэмээрэй.

3.Суртгаалд суралцахын эрэмбэ зэргийг номноход хоёр:

а. Их хөлгөнөө ерөнхий суралцах ёсон

б. Ялангуяа Очирт хөлгөнөө суралцах ёсон

а. Их хөлгөнөө ерөнхий суралцах ёсноо гурав:

1) Бодисадвын суртгаалд суралцах хүслийг төрүүлэх
2) Хүсэл төрсний дараа бодисадвын санваар авах
3) Санваар аваад хэрхэн суралцах ёсон

1) Бодисадвын суртгаалд суралцах хүслийг төрүүлэх: Винай болоод тантрын хоёр ёсноо эхлээд өөр өөрийн тангараг санваарыг авахгүйгээр суртгаалыг сонсож болохгүй гэдэг. Гэхдээ түүнтэй адилгүйгээр эхлээд суртгаалаа сайтар мэдэж сэтгэлээ ариусгаад ирэхээр түүнийг барису хэмээх дуршил төрөөд ирэхээр санваар хүртэж болдог бий.

Бодисадвын суртгаалд суралцах хүслийг судлах: Эхлээд өөр өөрийн ёсны санваарыг авалгүйгээр суртгаалыг сонсож болохгүй гэж винай болон тантр хоёуланд бий. Гэвч ингэлгүй өмнө нь суртгаалаа сайтар сэтгэлдээ судалчихаад, дараа нь авахаар дуршил төрснөөр санваар хүртэж болно. Энэ талаар *"Бодийн газар"*-аас: "Бодисадвын шагшаавад санваарыг үнэхээр авахыг хүсэгч нараа, эхлээд бодисадвын судрын аймаг савын эхээс бодисадвын суртгаалын суурь болон аливаа цээрлэх орон зэргийг сонсох ба хэрвээ зүрхнээс судлан тус тус оногч ухаанаар шинжилж хүсэл эгээрэл төрсөн болвол, чинад бусдаар баригдахын тулд бус, чинад лугаа тэнсэлдэхийн тухайд ч бус, зөвхөн бодисадвын ёсыг баттай барих учиртай гэдгийг мэдэж, шагшаавад санваарыг үнэхээр авах зан үйлийг ёсчлон хүртэхээр буулгаж үйлдээрэй" хэмээжээ.

Тиймд суртгаалаас ухаарч мэдрэн, сэтгэлдээ санаж зүрхний мухраас тэднээ суралцах хүсэл төрсний дараа тангараг авбаас тэдгээр нь баттай болох энэ л сайн арга болой. Энэ талаар энэ үест болон сүүлд ч мөн номнох тул үгийн ачаа ихдэх вий гээд хожим номносу.

2) Хүсэл төрсөний дараа бодисадвын санваарыг авах:

"Шагшаавадын бүлгийн тайлбар"-т: "Эхлээд хэрхэн авах ёс болон, тэр даруйд язгуурын унал болон гэмт үйлдлийн уналаас сэргийлэх ёс хийгээд доройтуулваас хэрхэн жич заслын ёс зэргийг дэлгэрэнгүй нотлон буулгасан учир санваар авахын өмнө лавтай магадлаж мэдээрэй" хэмээжээ.

3) Санваар аваад хэрхэн суралцах ёсон:

а) Суртгаалын суурь алин

б) Түүнээ суртгаалууд хурах ёсон

в) Түүнээ хэрхэн суралцах ёс

а) Суртгаалын суурь алин

Тодорхой ялгал хэмжээлшгүй олон ч, язгуураар хураангуйлваас бодисадвын суртгаал бүгд зургаан барамидад (чинад хүрэхүй) хураагдана. Зургаан барамид нь бодисадвын мөрийн хамаг аньсыг хураасан их товчоон болой. Дөрвөн хураангуй ч үүнээ багтана. Үүнд: "Өглөг" өгч амьтныг хураах хялбар. "Яруу үгээр" зургаан барамидыг туурвих ба шавь бүгдийг ивээх явдал. "Тусыг эдлэх" гэдэг бусдыг увдис номын утганаа байгуулана. "Тус зохилдонгүй" нь өөрийгөө ч шавь адил бүтээлд оруулах болой. Хоёр чуулган болон гурван суртгаал зэрэгт ч бодисадвын мөрийг хурааж болох ч гэсэн, зургаан барамидаар ухааруулж хураах тэр адилын бусад чадалтан байхгүй тул зургаан барамидад суурилж энэ нь дээд болой.

б) Түүнээ суртгаалууд хурах ёсноо хоёр:

(1) Бодит тооцоо учир (ялгалууд)

(2) Дашрамд магадтай эрэмбийг үзүүлэх

(1) Бодит тооцоо учир (ялгалууд):

Ялж төгөлдөр нөгчигсөн бурхан бээр зургаан барамидын товчоо төдий нэгний зохиосноо Жалцавдамба Майдар бээр тийнхүү зохиосон учир холбогдол, нарийн аньс зэргийг тааллын дагуу тайлбарлаж, магадлан мэдэх ухааныг төрүүлсэн нь эдгээр ялгал тооцоонууд болно. Эдгээр бүхнээ сэтгэл булаагдаж мэдлэг нэгнийг олвоос зургаан барамидын бясалгалыг увдисын дээдэд барих ухаан төрүүлэх тул мэдэж аваарай. ***Үүнээ зургаан зүйлээс:***

(а) Өндөр язгуурт харгалзах тооцоо нь: Бодисадвын агуу их явдлыг төгс туурвихад цаглашгүй их төрөл дамжих хэрэгтэй. Зам мөрийн ахицаа гарахад бэлэг чанар бүрэн төгөлдөр шүтээн нижгээд байхгүй бол, энэ адилын ганц нэг хувь төдийхнээр бүтээнэ гэвч, доривжилгоо юу ч гарахгүй тул хувь бүхэн бүрэн гүйцсэн хотол чуулсан шүтээн байх хэрэгтэй. Чингэхдээ алин эдлэх төгс эдлэлтэй, алинд ч эдлэгдэх бие махбодьтой,

алин хэнтэй ч хамт явах нөхөдтэй, алин туурвисан ямар ч үйлийг туйлд нь хүртэл бүтээх хэмээх дөрвөн хотол чуулган төгөлдөр нэгэн байх хэрэгтэй. Тэдгээр хотол чуулсан төдийхэн байвал нисваанисын эрхэнд одох нь элонтаа болох тул түүний эрхнээ үл одох ба, түүгээр зогсохгүй авч орхихын эрноо эндүүрэлгүй орж, буцахын бодлоо ялгаж таних нэгэн хэрэгтэй. Хэрэв аймгүй бол зэгс хулснаа тогтсон үрийг галзуу илжиг шөргөөгөөд эдлэхтэй адилаар хотол чуулган тийнхүү эвдрэхэд хүрнэ.

Ухаан байвал урьдын сайн үйлийн үр гэж мэдээд дахин үндэс шалтгаанд шамдаж дээш арвижуулана. Ухаангүй урьд хураасан үрээ эдэлж хэргэлсээр барж дуусна. Шинээр нэмэхгүй бол хожим зовохын суурийг тавина биз ээ. Тиймээс бусад төрөл дээр энэ зургаа төрөхөд ч, нөхцөл шалтгаан байхгүй болон үл зохилдох шалтгаанаас үл төрөх бөгөөд, заган зохилдох үндэс нөхцөл болоход ч зургаан барамид л магадтай тул, энэ насанд ч зургаан барамидыг үргэлж шүтэж, олон дахин дадаж сураарай. Үндэс шалтгаан нь хэдий чинээ ялгамжаатай байх тусам үр жимс нь төдий чинээ ялгамжаатай гардаг шүү дээ. Эдгээр нь орон үесийн өндөр язгуур мөн бөгөөд хотол чуулсан бие зэрэг туйлын өндөр язгуур нь бурханы газар байна. Тийн болохыг *"Судрын аймгийн чимэг"*-ээс:

Төгс эд ба хотол чуулсан бие
Нөхөр сэлт хотол чуулсан өндөр язгуур
Үргэлж нисваанисын эрхнээ үл одох ба
Үйл хэрэг нь үнэн зөв болой хэмээжээ.

Тийнхүү тэр адилын шүтээн дээр бодисадвын явдалд суралцваас бодисадвын үйл нь, өөрийн тусыг болон бусдын тусыг бүтээх хоёрт хураагдах болно.

(б) Тиймд хоёр тусыг бүтээхэд харгалзах тооцоо нь. Бусдын тусыг бүтээхэд эхлээд эд зүйлээр туслах хэрэгтэй. Өөрөө хэлбэл амьтныг хорлох хөнөөлт өглөг юу ч үл урвах тул, бусдыг хорлох шалтагаас лавтай буцах нь бусдад их тус болох учир шагшаавад хэрэгтэй. Түүнийг төгс болгоход инагш хорлолд үл тоомсорлох зэргийг нэг хоёр удаа үйлдлээ гээд асар ариун шагшаавад үл ирэх тул, инагш хорлолд үл тоомсорлох тэсвэр хэрэгтэй. Ийн тэсээд хариу барихгүй бол бусдад нүгэл хилэнц хураах олон зүйлийг эвдэх ба, тэсэхдээ дуртай болж эгээрснээр буян үйлдэх зэргээр бусдын тус ихийг бүтээнэ.

Өөрийн тус гэдэг билиг оюуны хүчээр олж авсан асар гэтэлсэн амгаланг хэлдэг юм бол, тэрээр сэтгэл алгасрах үед гарахгүй. Тиймээс дияан хийж сэтгэлээ тэгш агуулж, бодлын орноо сэтгэлээ хүслээр тогтоон эдэлж чадах чадлыг олох шаардлагатай. Залхуу нэгнээ тийм чадал үл төрөх учир өдөр, шөнө бүхнээ үл алжааж хичээлийг туурвих хэрэгтэй. Иймээс тэр хичээнгүй тэдгээрийн суурь болно. Тиймээс хоёр тусыг бүтээхэд зургаан барамид магад хэрэгтэй.

Амьтны тусад машид хичээх,
Өгөх, үл хорлох ба тэсвэрлэх
Тогтоох ба гэтэлгэхийн суурь тул
Өөрийн тус бүгдийг бүтээх хэмээжээ.

Үүнээ бусдын тус бүгд багтаагүй болой. "Тогтоох ба гэтэлгэх" хэмээх сэтгэлээ тухайн бодол дээрээ төвлөрүүлэх, тогтоон барих дияан бясалгалын "гарын ором" болон сансараас (самсара) гэтэлгэх билиг ухааны "гарын ором" гэж айлдсан үүнийг хоёр ялгаж амарлих орон ба үлэмж үзэхүй гэж бүү эндүүрээрэй.

Тэр адилаар сэтгэлээ тогтоон лавшруулахыг хүсэгч нар ч энэхүү самадийн нижгээд нижгээд хувь болох тул зургаан барамидын гол биеийг төгсгөх шаардлагатай гэдгийг ухаарах хэрэгтэй.

Бусдын тусыг бүрэн гүйцэд бүтээхүй ез харгалзах тооцоо нь Эхлээд эд өлгийн өглөг өгснөөр түүний ядуурлыг арилгана. Улмаар аль ч амьтнаа чинагш хорлол үйлдэхгүй байгаад зогсохгүй инагш тэсвэрлэнэ. Шадар нөхөд бололцоно. Үл уйсахын хичээнгүйг туурвина. Самади бясалгалд шүтэж рид хувилгаан тэргүүтнээ сэтгэлийг татна. Сав болгож ухаан билигт шүтүүлж, сайтар номноно. Доноголзол, тээнэгэлзэл зэргийг тасалж нирваанд хүргэх зэрэгт зургаан барамид магад хэрэгтэй.

Үл хоосруулах ба тийн үл хөнөөх
Хөнөөлд хэзээд тэсвэрлэх ба үл уйсах
Баясгаж үйлдэхээр сайтар өгүүлэх түүний тухайд
Бусдын тус гэдэг өөрийн тус мөн хэмээжээ.

Тэр хоёроор өөрийн болон бусдын тусыг үйлдэнэ гэвэл, зургаан барамидыг шүтэхгүй байхын аргагүй болохыг айлджээ. Тэд л өвөр бусдын тусыг бүтээх учиртайг магадлан мэдэж, тэдгээрийг бүтээхээр шамдаарай.

(в) Хамаг их хөлгөн бүгд хурахад харгалзсан тооцоо нь. Алив олз омог, эд баялагт үл шунах, олдохгүй олзны төлөө сэтгэл шаналахгүй байх, эд эдлэлд дур хүсэлгүй байвал суртгаалаа сахин чадах ба санваар төрж түүндээ сүслэж хандана. Амьтан болон амьтан бусдаас хамаарч гарах зовлонд тэсвэрлэн үл уйдана. Буяны ямар ажил гарахад шамдан тэмцэж үл уйдана. Амарлих (орон) сэтгэлийн атгаггүй егүзэр болон үлэмж үзэхүй ухааны атгаггүй егүзэрийн зургаан бясалгалд энд өгүүлэх их хөлгөн бүгд хураагдана. Тэр бүгд зургаан барамидаар зэрэгцлэн бүтээгдэнэ. Түүнээс өлон байх шаардлагагүй.

Эд баялагт илт үл баясах ба
Сайтар, бишрэхүй хоёроос үл уйсах
Тийн үл атгаглахгүй егүзэр тэдгээр
Бүгдээр их хөлгөн үүнээ багтана хэмээжээ.

Тиймээс их хөлөгнөө орохыг хүсэх хирнээ, зургаан барамидыг анхааран авахаа огоорвол харшлах болно.

(г) Хамаг мөр болон арга бүгдийн эрхэт болох тооцоо нь. Өмнө нь олчихсон байгаа эдлэл баялаг дээрээ шунахгүй байгаа мөр буюу арга нь өглөг болно. Өглөг өгч сурна гэдэг тэдэндээ шунахаас хагацах явдал. Олоогүй орон болон түүнийг олохын тухайд хичээх зэргээр алгасрал бий болоход боогч арга нь шагшаавад мөн. Аяга тахимлагийн санваарыг сахиваас үйлийн хязгаарт одох алгасрал бүгд гарахгүй болно.

Амьтныг орхихгүй байх арга нь тэсвэр буюу хорлосугай гэх элдэв зовлонгоор сэтгэл шаналахаа болино. Буян арвижихын арга нь хичээхүй бөгөөд хичээхүйг туурвиснаар тэр арвижих мөн. Хилэнц түйтгэрийг арилгах арга нь сүүлийн хоёр барамид болно. Дияаныг бясалгалаар, нисваанисын болон билгээр мэдэгдэхүүний түйтгэрийг арилгадаг болно. Тиймээс зургаан барамид баттай эрхшээх буюу

Вишай орноо үл шунах мөр
Түүнийг олоход тийм алгасралыг боомтлох
Бас бусад амьтныг үл орхих, нэмэх, арвижуулах ба
Түйтгэрийг тийн арилгахаас бусад юун хэмээжээ.

Хүслийн эднээ алгасрахын эрхэнд одолгүй шуналаас салсан нь өглөг буюу. Өмнө гараагүйг хориxдоо тусгүй ба хэрэггүй алгасралыг боох нь

шагшаавад буюу. Муу үйлт амьтан маш олон бөгөөд тэдний өдөөсөн үйлээс жич буцахын ерөндөгийг чин зоригоор дадуулах нь тэсвэр билээ. Хэмжээлшгүй их буяныг цаг үргэлжид бүтээх, арвижуулахын тулд тэдгээрийн тус эрдмийг санахын үүднээс хүчтэй тэмүүлж, өнө удаан дурших нь хичээхүй болно. Нисваанисын толгойг дарахаар дияан бясалгал хийнэ. Нисваснисын хөрөнгө, мэдэгдэхүүний түйтгэрийг дарахад билиг хэрэгтэйг үзүүлсэн эдгээр нь зургаан барамидын их танилцуулга болно.

(д) Гурван суртгаалд харгалзах тооцоо нь. *"Шагшаавадын суртгаал"* бол сахихуйн (боомтлох) мөн чанарыг агуулна. Төгс эдлэлд үл шунах өглөгийг үнэхээр бүтээвээс шагшаавад чуулах мөн. Үнэхээр (тангараг) аваад хорлоход жич үл хорлох зэргээр тэсвэрийг сахиваас, түүний нөхөр болно. "Сэтгэлийн суртгаал" бол самади бясалгалд суралцах мөн. *"Билгийн суртгаал"* бол оюун ухаанд суралцах мөн. Хичээхгүй нь гурван суртгаалд гурвууланд хамаарах аж. Тиймээс зургаан барамидад гурван суртгаал магадтай орших ба гурван суртгаалын эрхшээх учрыг зохиохдоо:

Ялгуугсан бээр зургаан барамидыг
Үнэхээр номнов эхнийд гурав,
Сүүлийн хоёрт хоёр зүйл ба
Нэгэнд нь гурав багтах хэмээжээ.

Тийнхүү хотол чуулсан заяа төрөл юу нэгнийг олсноор, өвөр бусдын тусыг бүрэн төгс бүтээх тэр адилын хөлгөнөө оршиж, арга билиг алив бүхэн төгөлдөр болсон, алив суртгаалыг бүтээхийн суурь, утга болсон, их хөлгөн, арга билиг, суртгаал бүхнийг төгс төгөлдөр үйлдэгч болсон, тэр бүгдийг хураасан чуулган болсон зэрэг тэр бүгд нь энэхүү "зургаан барамид" мөн болохыг таньж мэдээрэй. "Бодисадвын анхааран авах бясалгалын аньс бүгдийн товчоо мөн болой" гэж үзэх лавтай магадлал төрөх хүртэл тунгаагаарай.

Мөн анхнаасаа зовлонгоос эс гэтлэх буюу гарч чадахгүй байгаа хоёр үндэс бий. Үүнд эд юманд шунах болон гэртээ шунах болно. Өглөг болон шагшаавад нь тэдний ерөндөг болно.

Нэг удаа гэтлэвч эцэстээ хүрэлгүй жич буцахад хоёр шалтгаан буй. Амьтан буруу бүтээлийг хийснээр зовлонт болох ба, буяны зүгт өнөд удаан

зорьж эдлээд ирэхээр уйдах явдал тохиолдоно. Түүний ерөндөгт тэсвэр болон хичээхүйг туурвина. Алив хорлол хөнөөл, зовлон зүдгүүрийг ерөөс үл тоох ба, хэмжээлшгүй их цаг хугацааг нэгэн өдөр мэт үзэж дурлах зэргээр судлах ёсыг таньж мэдээд, олон талаас тунгааж, буцаах шалтгаан, ерөндөг болж чадах тэсвэр болон хичээхүйг төрүүлвээс аньс ихтэй мөн. Тэр тадилын бодисадвын явдал байтугай, өдгөө цагийн буяны үйл хэргийг бүтээхэд ч, хатуужил бага сагахан, тэсвэр өчүүхэн хийгээд алин бясалгах, дадуулах зам мөрдөө дуршил эрмэлзэл багатай зэргийн шалтгаанаас болоод эхлээд орохдоо олон үзэгдэвч, завсартаа буцах, хорих явдал олонтаа гардаг. Энэ нь тэсвэр болон хичээхүйн увдиснаас суралцаагүйгээс уршигдаж байгаа хэрэг.

Завсарт эс буцавч шим нь барагдах хоёр шалтгаан буй. Сэтгэлээ буяны зоригдол бодолд үл тогтоон алгасруулах ба ухаан чалхайрах явдал буюу түүний ерөндөг бясалгал болон билиг хоёр болно. Сэтгэл бусдад алгасарваас уршиг тооллого зэрэг ч хэрэггүй болохыг айлдсан тул дотоод ухааны аймаг савын утганаа асар ялгагч билгийг нээвээс орох, буцахын бүдүүн оройд ч эндүүрэн буруу эдлэх болно. Эдгээр нь үл зохилдох зүгийг тэвчих ерөндөгийн эрхнээ үйлдсэн учир шалтаан болно.

Бурханы ном бүгдийг бүтээхийн суурь орон болох учир нь. Эхний дөрвөн барамид бясалгалын чуулган болно. Тэр дөрвийг бүтээсний дараа үл алгасрах бясалгалын барамид бүтнэ. Түүнээ шүтэж үлэмж үзэхүйг бясалгаваас хоосон чанарыг онох болно.

(е) Амьтныг боловсруулах болон даган зохилдохын эрхнээ үйлдэх тооцоо нь. Өмнө номносон гуравдугаартай утга адил болой.

Эдгээр бүгдийг Асанга хутагтын болгоосныг Харибадра (Сэнгэсанбу) багш тайлсан дагуу үзүүлсэн бөгөөд зургаан барамидыг танин мэдэх нь ямар чухал их аньстай болохыг харуулж байна.

(2) Дашрамд эрэмбэ зэргийг танин барихад гурав:

(а) Төрөхийн эрэмбэ нь: Эд юм горьдолгүй, шунахайралгүй өглөг байвал шагшаавад авч болно. Буруу явдлаа сайтар боомтлох шагшаавад төгөлдөр аваас хорлолд тэсвэртэй болно. Бэрхшээл зовлонд үл уйдах тэсвэртэй аваас халширах буцах явдал багасч хичээхүйг туурвиж чадна. Өдөр, шөнөд хичээн шамдаж, сэтгэлээ буяны зоригдолд тогтоон эдэлж чадах болсноор бясалгал төрөх мөн. Сэтгэлээ тэгш тогтоож чадваас дияан

бясалгал төрнө. Сэтгэлээ тэгш тогтоон агуулваас үнэмлэхүй утгыг ёсчлон онох ухаантай болно.

(б) Дээд, доодын эрэмбэ нь: Урд урдах нь доод, хойш хойшхи нь дээд болно.

(в) Бүдүүн, нарийний эрэмбэ нь: Хойноосоо урагшаа ороход ажил нь бүдүүн, хөнгөн байна. Урд урдаас хойш ороход ажил хүнд болох тул өмнөхөөс нарийн болно. *“Судрын аймгийн чимэг”*-ээс:

Өмнөхөд шүтэж хойтхи төрөх
Доорхид шүтэж дээдхи орших учир
Бүдүүн, нарийн ялгаатай тул
Тэдгээрийг зэрэгчлэн үзүүлэх мөн хэмээжээ.



в) Түүнээ (их хөлгөнөө) суралцах ёсноо хоёр зүйл:

(1) Ерөнхий явдалд суралцах ёс
(2) Ялгавартай сүүлийн хоёр барамидад суралцах ёс

(1) Ерөнхий явдалд суралцах ёсноо хоёр:

(а) Өөрийн үндсийг бурханы номд боловсруулах барамидад суралцах
(б) Бусдын үндсийг боловсруулах дөрвөн хураангуйд суралцах

(а) Өөрийн үндсийг бурханы номд боловсруулах барамидад суралцахад зургаа:

1/ Өглөгт суралцах ёсон (чинад хүрэхүй барамид)
2/ Шагшаавадын чинад хүрэхүйд суралцах
3/ Тэсэхүй (тэсвэр)-н чинад хүрэхүйд суралцах
4/ Хичээхүйн чинад хүрэхүйд суралцах
5/ Бясалгал (самади)-ийн чинад хүрэхүйд суралцах
6/ Билгийн чинад хүрэхүйд суралцах болой.

1/ Өглөгт суралцах ёсноо дөрөв:

а/ Өглөгийн мөн чанар
б/ Түүний төрүүлэх арга
в/ Өглөгийн тийн ялгал
г/ Тэдгээрийн утгын хураангуй

а/ Өглөгийн мөн чанар: *"Бодийн газар"*-аас: "Өглөгийн мөн чанар юу вэ? Алив төгс эдлэл болон өөрийн биенээ үл шунагч бодисадвын үл шунах ба хамт төрсөн алин тэр сэтгэл мөн болюу. Түүгээр чухал өдөөгдсөн, өгөгдөхүүн бодит эдийг бүрэн өгөх бие, хэлний үйл болой" хэмээн айлдсан мэтээр өгөх буяны сэтгэл, түүгээр хөлөглөсөн бие, хэлний үйл болно. Харин өглөгийн чинад хүрэхүй (барамид) гэдэг зөвхөн эд юмсыг бусдад өгөх, амьтан хүний үгээгүй ядуурлыг арилгах төдийхнээр хязгаарлагдахгүй аж. Хэрэв чингэхгүй бол, өнөөдөр ч олон гуйлгачин ядуус байна гээд банжвал, урьд заларсан бурхад өглөгийн чинадад хүрээгүй мэт болно шүү. Тиймд бие, хэл нь гол биш, сэтгэл нь эрхэм болно. Иймээс өөрт байгаа бие, төгс

эдлэл, буяны язгуур бүгдийг харамлах сэтгэлийг дарж, сэтгэлийн мухраас амьтан бусдад өгч сурна. Түүгээр зогсохгүй өглөгийн үр жимс бүгдийг амьтнаа түгээж чадах тийм сэтгэл ухаанд төгс төгөлдөр дадаж сурснаар л сая нэг өглөгийн чинадад хүрэх ажээ. Тэр талаар *"Бодичарияаватара"*-д:

Хэрвээ амьтны үгээгүйг арилгаад л
Өглөгийн чинадад хүрэх юм бол,
Эдүгээ ч үгээгүй ядуус байх тул
Урьдын авралт нарын чинад хүрсэн гэж юу болох?

Үр сэлтэс байгаа бүхнээ амьтнаа өгөх сэтгэлээр л
Өглөгийн чинад болох хэмээн айлдсан ба
Тиймээс тэр нь сэтгэл ямагт хэмээжээ.

Чингэхлээр өглөгийн чинад хүрэхэд анхаарах зүйл нь бодитой эд эдлэлийг бусдад өгөх төдий бус ч гэсэн, өгөх сэтгэлийг л олон зүйлээр төрүүлж бий болгох, улам нэмсээр өгч сурах дадах болой.

б/ Түүнийг төрүүлэх арга: Бие болоод төгс эдлэлээ харамлах сэтгэл бүхнийг дарсан төдийгөөр өглөгийн чинадад үл хүрнэ. Харам гэдэг шунал тачаалын аймагт багтах учраас бага хөлгөний дайснаа дарагч хоёр ч түүний хөрөнгө үндэс бүгдийг тэвчиж чадна. Тиймд өглөгийн тотгор болох хармын сэтгэлийн хотол баригчийг арилгаад зогсохгүй, байгаа бүхнээ бусдад өгөх сэтгэлийг л сэтгэлийн мухраас бясалгаж үйлдэх мөн. Ямагт харамлахын атгаг гэм эрүүг болон өглөг өгөхийн тус эрдмийг бясалгах хэрэгтэй тул үүнийг өгүүлвэй. *"Дава донмэ айлтгасан"*-аас:

Өмхөрч ялзрах энэ бие болоод
Амь нас ч өөрийн эрхгүй
Зүүд, илбэтэй нэгэн адил байтал
Амьтан бид тэдгээрт шунаснаар

Машид мунхаг үйлийг үйлдэж
Хилэнц нүглийн эрхнээ одох буюу
Мунхаг түүнийг эрлэгийн эзэн унаж одох
Чингээд зогсохгүй тамд унах бий хэмээжээ.

Иймээс бие цогцос ариун бус, амь нас уулын уруу буух ус мэт хурдан өнгөрөх, амь бие хоёулаа үйл бусдын эрхэнд учраас өөрийн эрхтэй эзэн

байхгүй, зүүд, илбэ мэт хуурмаг болохыг мэдэж, тэдгээрт шунаж тачаахаа болих хэрэгтэй. Эс чингэвээс шунал тачаалын эрхнээ орж, их гэмт явдлыг хурааж муу заяанаа одохыг айлджээ. *"Хэмжээлшгүй үүдийг хураасан тогтоол"*-д:

Амьтан зарим нэг нь нөгөөтэйгээ зодолдох
Тэр суурь язгуурыг үргэлж барих буюу
Тэр мэтийн зүйлд шунахаа больж
Хүслээ тэвчиж үйлдвээс тогтоол болох буюу хэмээсэн ба,

"Суртгаалын хураангуй"-д:

Энэ мэт миний бие, сэтгэл
Агшин агшинаар одох ямагт
Гэвч мөнх бусын үнэр анхилсан
Биеэрээ мөнх бас хиргүй
Бодь хутгийг олох аваас
Энэ л үнэлж баршгүй олз болох бус уу хэмээсэн ба,

"Төрөл дараалльн цадиг"-аас:

Эзэн байхгүй, эвдрэх, шимгүй бие,
Зовлонт, ачгүй, ариун бусын биеэр
Бусдад туслан чадахдаа эс баясваас
Тэр мэргэн бус

хэмээн айлдсан мэтээр хичнээн шамдан сахивч, лавтай орхих учиртай шимгүй биеэ бусдад, сэтгэлийн угаас өгөх, өвөр бусдын тусыг олонтаа бүтээхийн ухаанд суралцахгүй бол би тэнэг хэмээн санаж, бие тэргүүтнээ бусдад өгөхийн ухааныг үйлдээрэй. *"Бодичарияаватара"*-д:

Бүгдээ өгснөөр гаслангаас нөгчих мөн
Өөрийн ухаандаа гаслангаас нөгчихүйг бүтээхээр
Байдгаа өгөхийн хамт нэгэн болсон
Амьтанд өглөг өгөх дээд нь хэмээжээ.

"Барамидын хураангуй"-гаас:

Эд юмс мөнх бусын жамтайг мэдвээс
Их нигүүлсэхүй өөрийн агаарт ургах тул
Өөрийн өглөгөө гэрт орхиж бусдын тухайд
Машид зохисон ёсоор онох буюу

Алин өглөг өгвөөс аюул үл төрөх
Гэртээ суусан түүнээс л аюул гарах
Нийтэд үл таарах зүйлээс
Үргэлж сэрэмжлэх хэрэгтэй

Өгвөөс тэдгээр гэмээр үл хорлогдох
Өгснөөр ертөнцийн чинадад амгалан бүтэх
Эс өгвөөс энэ наснаа зовлон удах
Хүний эд гэдэг сүүлт одны чанар мэт

Дутуу өгвөөс үлдсэн нь алга болох
Эс өгсөн ч эд мөнх бус тул алга болох
Өгснөөр эд тогтохын хүү сан ирэх
Амьтнаа туслахаар шамдаж өгсөн алив

Эд баялаг шимгүй хэдий ч тогтох буюу
Мэргэд алин өглөг өгөхийг л сайшаав
Энгэл нялхас хураахад баясавч
Бүгдийг атгавч хагацахгүй гэдэг хаана ч үгүй

Өгснөөр л үргэлжид хотол чуулган гарах
Өгснөөр нисваанист үргэлжид баригдах бус
Харамлах нь хутагтын мөр бус, нисваанисыг төрүүлэх
Алин өглөг өгөх тэр мөрийн дээд
Түүнээс буцваас муу мөр хэмээн хутагтууд айлджээ хэмээжээ.

Буяны язгуур их, бага алин үйлдсэн бүгдээ, амьтны энэ болон эцэс, хойдын агуу их тус амгаланг бүтээхийн тухайд сэтгэлийн мухраас зориулж өглөг өгвөөс, амьтан тус бүрийн үйлдэх тэрхүү буяныг олох учир амар хялбар буяны чуулганыг гүйцээнэ. *"Эрдэнийн эрхи"*-ээс:

Ийн хэмээн өгүүлсэн аливаа буян түүнийг
Хэрвээ дүрслэн бүтээвээс
Ганга мөрний элсний тоот ямагт болж
Ертөнцийн оронд үл багтана гэж

Түүнийг ялж төгөлдөр нөгчигсөн бээр айлдав
Тангараг тэр нь ч түүнээ үзэгдэнэ
Амьтны арга цаглашгүй тул
Туслах арга тэр ч тэр адил болой хэмээжээ.

Мөн өглөг дээш арвижихад саад болох, хармын сэтгэлээ нэмэх, төрөөгүй байгаа өгөх сэтгэлийг үл төрүүлэх, төрснийг доройтуулагч урьд байсан нөхөр, төгс эдлэл зэргийг үл баримталж, бусдаас өгсөн ч түүнийг бүү барь. *"Барамидын хураангуй"*-д:

Хармын гэмийг хэзээд арвижуулах ба
Огоот өгөх сэтгэлийг үл арвижуулах
Батад барихын тотгор бологч хуурмаг алин
Бодисадва та бээр батад бүгдийг тэвч

Алин өгөх сэтгэлийн ерөндөг болвоос
Явч бодь мөрийг түйтгэрлэн үйлдэх тул
Хэдий эд баялаг, эрдэнэс, хаан төр байвч
Бодисадва та авах нь зохисгүй хэмээжээ.

Тийнхүү үйлдэх цагт, эд баялгаа харамлаж шунал гарах тул, "байгаа бүхнээ өгч байж бодь хутгийг бүтээх хэмээн бурхан захисан болон түүнийг дагаж би суралцана" гэсэн тангарагаа санаж, өмнө нь "би өөрийн бие, төгс эдлэл хамаг буянаа амьтнаа өгнө" гэчихээд эдүгээ эд баялагт тачааж өөрөө эдлэх энэ мэт миний явдал нь "наранд халууцсан их заан усанд орж угаалга хийчихээд, хуурай газарт эргэн хөрвөөж биендээ шороо шавар наалдсанаа хараад, дахин дахин эргэж буцан усанд орохтой адил боллоо" гэж мэдэж, шунаж бүү үйлд. Дээрх судраас:

Бурхадын дээд явдлыг санан санаж
Түүнээ шамдаж өөрийн тангарагийг сэтгэ
Бултыг атгах шунал тачаалыг арилгахын тул
Сэтгэлийг таних эрхэм эдгээрийг онгтун

Амьтан бүхнээ өөрийн биеийг өгч чадах бөгөөд
Түүнийг цалгардуулагч ном бүхнийг тэвчмү би
Гадны үзэгдэлд шунан дурлаваас
Зааны угаалгатай адил тул тэр надад зохисгүй хэмээжээ.

Тэр мэтээр орхихын тус эрдмийг олонтаа санаж баясах ба үргэлжид зууралдахын гэмийг олон талаас тунгааж, айж ичих бодлыг төрүүлж чадваас өглөг өгөх сэтгэл аяндаа төрнө. Мөн асрахуй, нигүүлсэхүй сэтгэл төрсөн ч, бодисадвын нирваан тэргүүтнийг бодох, санахын эцэст ч, өгөх сэтгэлээ эгүүсгээрэй. Эгүүсгэх ёсыг *"Бодичарияаватара"*-д:

Бие болоод төгс эдлэл болон
Гурван цагийн хамаг буянаа
Хамаг амьтны тусыг бүтээхийн тулд
Харамлалгүй өгч үйлдээрэй

хэмээн айлдсан мэт бие, төгс эдлэл, буяны язгуур гурвыг бодол зоригдол болгож, хамаг амьтнаа сэтгэлээсээ өргөөрэй. Тэр мэт байгаа бүгдээ, минийх хэмээн баригч шуналаас буцааж, бусдад өгөх сэтгэлийг дахин дахин сурч чадваас бодисадва хэмээгдэх мөн. *"Барамидын хураангуй"*-д:

Энэ бүгд таны юм шүү гээд
Үнэз минийх хэмээх омог надад үгүй буюу
Энэ адилын гайхамшигт бодлыг дахин дахих
Туулсан бурхадын эрдмийг даган мөрдөх

Алин энэ л байвал бодисадва хэмээх ба,
Санаанд багташгүй дээд болов хэмээн бурхад айлджээ хэмээжээ.

Эдүгээ сүжиг сайн боловсроогүй, хүч чадал бага, сэтгэлээрээ амьтнаа бие, мах цусаа бодитой өгч чадахгүй буй заа. Гэвч амь биеэ өглөг өгөхөөр сэтгэлээр эс суралцваас, дадал бясалгал гарахгүй тул, хэзээ ч амь биеэ өгч чадахгүй болохыг *"Суртгаалын хураангуй"*-гаас айлдсан тул одооноос тэр ухаанд суралцах чухал.

Тиймд сэтгэлийн мухраас хоол унд, хувцас хунар, орон гэрээ амьтнаа өгөхөөр сэтгээрэй. Амьтны тусын төлөө эдгээрийг эдэлж байна гэх бодлоо мартчихаад, өөрийн тусад хэмээн шунаваас, нисваанист унал доройтол болно шүү. Шунахгүй ч, хамаг амьтнаа зориулах хуран мэдлийг агуулахаа умартах буюу бусад нэг л амьтны тухайд шунаваас, нисваанист бус унал болно. Бусдад зориулсан тэдгээрийг бусдын эд гэж хуран мэдэх хирнээ, өөрийн тухайд эдэлж хэрэглэвээс хулгай болж, улмаар үнэ цэнэ нь бүрдэж, тус тус гэтгэлгэгч санваарын ялагдал гарна гэж *"Суртгаалын хураангуй"*-д айлджээ.

Энэ талаар зарим нэг бээр, "Хамаг амьтнаа гэж зориулсан болохоор, нэг амьтнаа үнэ цэнэ нь бүрдэхгүй тул ялагдал гарахгүй" гэнэ. Бас зарим хүн "хамаг амьтан тус бүр дээр ч эд хэрэгслэлийг бөөнөөр нь зориулсан учраас ингэж хэлэх таарахгүй" гэх ба, зарим нэгэн "Бусдад зориулавч тэдгээрийг минийх гэж барихгүй бол ялагдал гарахгүй" гэж өгүүлнэ. Утгын

хувьд сэтгэлийн мухраас хүмүүн амьтан бүхнээ зориулсан ба тэд ч түүнийг мэдээд өөрийн болгох цагт, бусдын гэдгийг мэдсэн хирнээ өөрийн тусад хэрэглэвэл үнэ цэнэ бүрдэж, ялагдал ирэх учиртай гэсэн утга түүнээ оршиж байна. Тиймд бусдын ёсоор өгүүлж таарахгүй. Амьтан өөрийн юмаа эдлэхдээ өөрийн хэрэгт хэрэглэсү хэмээн эдэлвээс гэм гарахгүй буюу.

"Суртгаалын хураангуй"-аас:" Эзэнтэй эд юмсаар, эзэнтэй биеэ захиж эдэлсүгэй гээд эдлэхэд гэм гарахгүй. Ноёны албанд үргэлж зарагдах албат зарц нарт минийх гэх амьжиргааны эд байхгүй" хэмээжээ.

Нэгэнт амьтнаа зориулчихсан эдийг зөвшөөрөөгүй байхад эдэлвэл, гэм гарах уу, гэвэл гэм гарахгүй. Дээрхээс: "Үргэлжид ноёны албанд зарагдах зарц боол бээр, хэдий өвдөж ухаан самуурсан ноён үл зөвшөөрсөн ч эдлэхэд гэм гарахгүй" хэмээжээ. Хамаг амьтнаа бодитойгоор өгөөгүйгээс хойш, ухаанаар өгнө гэдэг тэр худал, утгагүй зүйл хэмээн үл сүсэглэн бүү үйлд. Дээрхээс: "Тэр мэтийн явдалт бодисадвын талаар, зарим нэгэн, энэ таарахгүй гээд сүслэхгүй байх нь зохисгүй. Өгөх сэтгэлийн сонин гайхамшигийг таньж мэдээрэй. Энэ ёсноо заримууд доноголзох нь зохисгүй буюу" хэмээжээ.

в/ Өглөгийг тийн ялгаваас гурав:

/1/ Хамаг шүтээн бүгдээр хэрхэн үйлдэх

/2/ Шүтээн тус бүрт харгалзах тийн ялгал

/3/ Өглөгийн мөн чанарын тийн ялгал

/1/ Хамаг шүтээн бүгдээр хэрхэн үйлдэх: Төгөлдөр дээд зургаа хэмээхийн "дээд шүтээн" нь бодь сэтгэлд шүтэх буюу түүгээр өдөөгдөж үйлдэх болой. "Дээд бодит" нь ерөнхийдээ хамаг өглөгийн бодит зүйлийг эдлэх бөгөөд ялгамжаат заримыг үйлдэхдээ сэтгэлээ орхихгүй байх явдал болно. "Дээд тухайлан үйлдэх" нь амьтан бүхэн даруйдаа амгалантай болоод алсдаа ч амгалантай байхын тухайлан үйлдэх буюу. "Дээд мэргэн арга" гэдэг тийн эс атгаглагч билгээр эзлэгдэхийг хэлж байгаа бөгөөд үйлийг анхдагч бээр, ном юмсын өвөрчлэн үгүйг оногч билгээр эзлэгдэх болой. "Дээд зориулга" нь өглөг өгсөн буянаа туулсан бурханы хутагт зориулах болой. "Асар ариун дээд" нь нисваанис болоод мэдэгдэхүүний түйтгэрээс ангижрах хэмээн тус тус *"Их хөлгөний хураангуй"*-д айлджээ.

"Зургаан барамид төгөлдөр үйлдэх" гэдэг номын өглөг зэргийг үйлдэж, Сонсоод сонсогч, Өөрөө ялгуугсад нарын сэтгэлээр боомтлох шагшаавад

болон хамгийг болгоогчийн номонд сүсэглэн тэсвэрлэх ба бусдаас ирэх доромжлолыг тэсвэрлэх, хоосон чанарт дээш дээш ахихын тул дуршилыг үүсгэх хичээхүй, бага хөлгөнтэй адилгүй, нэгэн үзүүрт буянаа төгс бодь хутагт зориулах бясалгал ба өгөх юм, өгөгч эзэн, авагч нарыг илбэ мэт болгоогч билиг лүгээ зургаан зүйл бүрдвээс машид хүчтэй болохыг *"Найман мянгатын их тайлбар"*-аас айлджээ.

/2/ Шүтээн тус бүрт харгалзах тийн ялгал: Ер нь эд өлгийн өглөгийг гэргийтэн бодисадва нар үйлдэх ба, тойн бодисадва нар номын өглөг үйлдэх гэж айлдсан буй. "Бодисадвын тус тус гэтлэхүй-гээс: "Шарибү! Алив гэргийтэн бодисадва нар, Ганга мөрний элсний тоотой сацуу бурханы орныг долоон эрдэнээр машид дүүргэж, тэрчлэн заларсан, дайснаа дарсан үнэхээр туулсан бурхадад өргөл үйлдсэн буянаас, Шарибү! Алин машид гарсан (тойн) бодисадва бээр, дөрвөн мөрт нэгэн бадаг ном заасан тэр нь түүнээс илүү их буян хураах мөн. Шарибү! Тэрчлэн залрагсад бээр, машид гарагсад эд өлгийн өглөг өгөхийг эс зөвшөөрсөн буюу" хэмээжээ. Чингэсэн нь "ном сонсох зэрэгт саад учрах болов уу" хэмээсэн гэж *"Суртгаалын хураангуй"*-д зарлигласан байна. Энэ нь тойн хуврагууд эд өлгийг тухайлан бүтээж, өглөг өгөхийг хориглосон хэрэг. Харин өөрийн буяны ажилдаа саад бололгүй урьдын буяны хүчээр олон ихийг олвоос өгөх хэрэгтэй болохыг айлджээ. Шарава гэгээнээс: "Би чамд өглөгийн тус эрдмийг үл өгүүлэх, авахын гэмийг өгүүлсүгэй. Хувраг хүн махаа барж, ясаа цайтал эдийг эрж хурааваас шагшаавадад чинь яр шарх гарна. Өглөг өгөхүйеэ үл баярлах үг энэ болой".

/3/ Өглөгийн мөн чанарын тийн ялгалд гурав:

/а/ Номын өглөг гэдэг дээдийн номыг шударга, үнэн зөвөөр заах, урлахуй зэрэг ертөнцийн гэмгүй ухаанаа суралцах, суртгаалын суурийг барих зэрэг болой.

/б/ Үл аюух өглөг гэдэг хаан, хулгайч зэрэг хүний аюул болоод арслан, бар, матар зэрэг хүмүүн бусын аюул, гал усны (байгаль) аюулаас баттай аврах явдал болой.

/в/ Эд өлөгийн (өлгийн) өглөгт хоёр зүйл:

1' Эд өлгийг бодитой өгөх өглөг

2' Санаа төдийгөөр өгөх

1' Эд өлгийг бодитой өгөх өглөг:
а' Эд өлгийг өгөх ёсон
б' Өгч эс чадваас хэрхэх ёсон
в' Өглөгт тотгорлох ерөндөгийг шүтэх

а' Эд өлгийг өгөх ёсноо дөрөв:
1" Өглөгийн орон алин
2" Өгөх сэтгэл алин
3" Хэрхэн өгөх үйл ажил
4" Бодит өглөг өгөх алин

1" Өглөгийн орон алин: Түүнээ арван зүйл буюу. Надад туслагч садан төрлүүд, хорлогч дайсан, тус хорлол алиныг ч үл үйлдэгч нар, эгэл нэгэн санваарыг сахигч тэргүүтэн сайчууд, ёсыг залхайруулагч зэрэг муучууд, надаас доордос, надтай сацуу нэгнүүд, надаас дээд нэгнүүд, баян жаргалтай, ядуу зовлонт зэргүүд болой.

2" Өгөх сэтгэл алин: *Санаанд хоёр зүйлээс:*

а" Ямар санаатай байх вэ? Үнээ шүтэж ханьцашгүй бодийн чуулган, өглөгийн чинадад хүрэх хэрэгтэй хэмээн тухайлах буюу эхлээд бодь сэтгэлээр хамаг байгаа бүхнээ амьтанд өгөх хэрэгтэй. Хайснаа олох адил өгөх гэж буй өөрийн эд баялгаа бусдынх мөн хэмээн бодит зүйл дээр тухайлах мөн. Гуйлгачин болоод үл гуйгч эдгээр орон л миний өглөгийн чинадыг гүйцээж өгөх тул, миний садан мөн хэмээн өгөх орноо тухайлах хэмээх гурван санаа лүгээ төгөлдөр байх хэрэгтэй. *"Барамидын хураангуй"*-д:

Гуйлагчин өмнө нь ирвээс
Бодисадва тэр бээр
Туулсан бодийн буяныг арвижуулахын тул
Бусдын (хүний) гэсэн хур мэдлээ, өөрийн болгож
Буяны садан хэмээх хур мэдлийг тэднээ эгүүсгэх хэмээжээ.

Нижгээд нижгээд бодит юмсыг өгөх хэрэгтэй. Энэ болоод үүний тухайд өгөх хэрэгтэй хэмээн хэрэг зорилгоо онцолсон санаа дэлгэр байхыг *"Лагсан айлтгсан судар"* болон *"Барамидын хураангуй"*-гаас мэдээрэй.

Өмнө нь номнсон орноо тухайлан санах нь бүгдэд хамааралтай ерөнхий санаа мөн. Ялгавартай санах гэдэг хорлол үйлдэгчнээ асрах сэтгэл гаргах ба зовлонтой нэгнийг энэрэн нигүүлсэх сэтгэл, эрдэм номтойд баясах сэтгэл, тус хүргэгч нарт тэгш агуулахын сэтгэлээр өглөг өгч үйлдээрэй. Орноо бодохдоо ч, тэгш сэтгэлээр хандах хэрэгтэй. Өглөг өгөх буяны үрээ ч гуйлагчин зэрэг амьтнаа өгөх бөгөөд ялангуяа зовсон амьтныг машид энэрэн хайрлаж үйлдээрэй. Даваадагва бээр:

Аливааг өгөхдөө хармаас салж
Сав болоод сав бус алинд тэдэнд
Тэгш хандах сэтгэлээр өгөх буюу
Өглөг өгөх буюу, өглөгийн эзнээс

Нигүүлсэх сэтгэлээр өгөх өглөгийн үр
Хоёуланг нэгэн зэрэг чухалчлан өгөх
Өглөгт ямар ч харамгүй байх
Түүнийг дээдэс сайшаажээ хэмээсэн ба,

"Хэмжээлшгүй эрдмийн магтаал"-д ч:

Аливаа доод төрөлхтөн, ядуус тус бүрийн горьдох сэтгэлийг мэдэвч
Энэрэлгүйгээр үрийг хүсвээс, сав бус болох, эрдэм ухааныг эрэлцэвч,
Салбархай санаат тэрээр өглөг өгөвч, гуйлгачинтай адил буюу хэмээжээ. Тийм бодол санааг тэвчих хэрэгтэй.

6" Ямар санааг тэвчих хэрэгтэй вэ? *Буруу үзлийг дээдэд баригч сэтгэлгүй байх нь.*Өглөг өгөөд үр гарахгүй гэх юм уу, хорлол хөнөөлийг өгөх нь буян болох гэх, буяны билэгдэл, өлзий дэмбэрэлтэй хамтруулан өгөх, өглөг гүйцлээ гэх төдийхнээр ертөнц болоод ертөнцөөс нөгчигсөдийн шуналаас хагацав гэх зэргээр өгөхгүй байх бий.

Дээрэнгүй санаагүй байх нь: Гуйлагчинг доромжлох, бусадтай мөчөөрхөх, өглөг өгөвч өөрийгөө өгөн чадагч хэмээх ба бусдыг тийн бус хэмээн сагсуурч бүү үйлдээрэй. *"Үйлийн түйтгэр тийн арилах судар"*-аас: "Эгэл төрөлхтөн нар өглөг өгөхийн цагт, харамч хүмүүст дургүйцэн улмаар уурлаваас тамд одох тул өглөгт тотгортой" хэмээн айлдсан ба, "Шагшаавад сахих үест ч ёсоо цалхайруулагчыг муугаар хэлэх нь, олон хүний сүжгийг алдуулж, эс сүжиглэх тэрээр муу заяанд унах буюу. Тэсвэр тэргүүтнээ оршоод, тэдгээрийн үл зохилдох зүгт оршлоо гэж үл сайшаан

өгүүлэх нь, шагшаавад тэргүүтнийг түйтгэрлэнэ" хэмээн айлджээ. Тиймд "*Хэмжээлшгүй эрдмийн магтаал*"-д айлдсан дагуу үйлдэх хэрэгтэйг:

Та бээр сонсох болон ухаан ихтэй байхдаа өөрийгөө магтсангүй
Харин эрдэм багатай бусад амьтныг өндөрт өргөн хүндлэх
Эрдэмтэд чуулан орших цагт өөрийн гэмт явдал өчүүхэнийг ч хэлэх буюу хэмээсэн мэт болой.

Шүтэгдэх бодолгүй байх нь: Яруу алдрыг горилж өгвөл өглөгт тооцохгүй болой.

Мятрахын санаагүй байх: Эртнээс өглөг өгөхдөө сэтгэл баясах, өглөг өгөхийн цагт сүжигтэй баяртай байх, өгсөн хойноо ч гэмшихгүй байна. Бодисадвын өглөг гэдэг маш агуу их болохыг сонсож сэтгэл шантралгүй, өөрийгөө дорд үзэлгүй, хүсэл эрмэлзлэлээр арвижуулах мөн.

Араар зүглэхийг санаагүй байх нь: Дайсан, садан, эгэл ардыг ялгалгүйгээр тэгш энэрч нигүүлсэх сэтгэлээр өглөг өгөх болой.

Хариу харах санаагүй байх нь: Цаад хүн надад туслах болов уу гэж горьдож өглөг өгөх биш, амьтан гэдэг амгалан жаргалаар хоосорсон, шуналын галаар түлэгдсэн, зовлонгоо арилгах ямар ч чадал байхгүй, уг чанараараа зовлонт гэж үзэх явдал болой.

Тийн боловсролыг горилох сэтгэлгүй байх нь: Хойд төрөлдөө төгс эдлэл, бие хотол чуулсан байх тийн боловсролын үрийг үл горилох бөгөөд, хурсан бүгд шимгүйг ухаарч, ханьцашгүй бодь хутгийг эрдэмтэйд үзэх мөн. Орон үесийн тийм үрд горилохыг хориглох бус ч, орчлонгийн бие, төгс эдлэл зэргийг олзонд үзэхийг хориглох мөн.

Мөн өглөг өгвөөс, хаан тэргүүтэн бээр, эр чадалтай юм гэж мэдэж өргөн хүндлэх болов уу хэмээх буруу амьжиргааны санаагүй байх ба, ядуурчих болов уу хэмээгээд үл өгөх ба, гуйлгачинг хуурах мэхлэх, сэтгэлээр үл баясах, уурлах ба сэтгэлийн алгасрал зэргээр өглөг өгөхгүй байх, хэдий элдэв буруу амьжиргаанд үл уйдах, өөрийгөө хуурах зэрэг гуйлгачны гэмийг үзэвч, бусдад хэлэх санаагүй байх учиртай. Бусдын амыг дагалгүй, тус тусыг өглөгөөс тус тусын үр гарна гэдэгт сэтгэл итгэмжлэн өглөг өгөх болой.

3" Хэрхэн өгөх үйлд хоёр зүйлээс:

а" Ямар зүйлүүд өглөг болохгүй вэ?: Түргэн өгөлгүй удааж өгөх; нисваанист муу санаагаар өгөх; ном буюу ертөнцийн ёстой зохилдохгүй үйлд оруулж өгөх; урьд нь амласнаасаа хасаж өгөх; тааруу муу болон цөөнийг өгөх; ач тус хүргэснээ тоочиж өгөх; нэг дор өгөхөө цувруулж бага багаар өгөх; хаан болчихоод бусдын эхнэр хүүхдийг булааж өгөх; эх, эцэг, албат нарын эд эдлэлийг сэмхэн булааж бусдад өгөх; бусдыг хорлох аргаар өглөг өгөх; өөрөө зүгээр суучихаад бусдыг явуулах, гуйлгачинг муушаан доромжлох, өө сэв эрэн гаргах, ширүүн үг хэлэх зэргээр айлган сүрдүүлж өгөх; бурханы цааз суртгаалтай харшуулан өгөх; төгс эдлэл даруй гарсан ч өгөлгүйгээр өнө удаан хураасны дараа өгөх зэрэг нь тэвчих ёстой ажил тул тэдгээрийг орхиорой.

Мөн бодисадва бээр хурааж өгөх нь амлашгүй нүгэлтэй болох ба, төгс эдлэл гарсан даруйд өгвөөс амлашгүй нүгэл гарахгүй. Ийнхүү хурааж байгаад нэг дор өгөхөд илүү буян гарахгүй. Хураах явцад юм гуйсан олон гуйлгачинг буцаах, тэднээ уурлах уцаарлах учраас эхлээд гуйсан заримд өгөх хэрэгтэй. Чингэхийг *"Бодийн газар"*-т айлдсан нь чухал хэрэгтэй. Учир нь чингэх завсар харамлах зэргээр олон нисваанис төрж, хамгаалах зэрэг төвөг бэрхшээл гарснаар их буяны ажилд саад зэтгэр тохиолдоно. Ихэнхдээ замын зуурт эвдэрч өглөг буян эцэстээ хүрч чадахгүйд хүрэх нь үзэгдэнэ.

б" Ямар байдалтай өгөх: Эхлээд нүүр дүүрэн баясан мишээж, шударга өгүүлэн, өглөгийн орон алин түүнээ хүндэтгэх, өөрийн гараар, цаг хугацаанд бусдад хорлолгүй, хатуу бэрхшээлийг тэсвэрлэн өгөх болой. Тэдгээрийн үрийн талаар *"Үнэнчийн бүлэг"*-т "Өргөн хүндэлж өгвөөс садан тэргүүтэн өргөн хүндлэх, алгаа дэлгэж өгвөөс алд дэлэм хүндлэлийг олох, цагт нь өгвөөс үйл ажил ч бүтэх" хэмээсэн ба "Бусдад хорлолгүй өгвөөс төгс эдлэл баттайг олох, зовлонд тэсч өгвөөс зүрхний нөхөд ойртох" хэмээжээ. *"Авхидхарма"*-д: "Алгаа дэлгэж өгвөөс агуу их төгс эдлэлийг олно" гэжээ. Төгс эдлэл баттай байна гэдгийг бусдаас төгс эдлэлд саад зэтгэр учруулахгүй, гал, усны аюулд өртөхгүй зэрэг болохыг *"Авхидхармагийн тайлбар"* зэрэгт номложээ.

Мөн бусдын өглөг буяны нөхөр болох үйлийн хувьд, "Өөрт эдлэл юм байвч харамлаад өгч сураагүй зарим нэгний гэрт очиж, баясгалантай, аажуу тайвуу суугаад ийн өгүүлээрэй. Надад маш их эд таваар байна.

Өглөгийн чинад хүрэхийн тулд түүнийгээ өгөх гуйлгачин хайж байна. Та гуйлгачинтай тааралдвал буцаалгүй нааш явуулаарай. Миний эд юмнаас тэдэнд авч өгөгтүн. Бас миний дэргэд авчраад миний өглөгт баясагтун хэмээн захиарай. Нөгөө хүн ч эдийн гарзгүй, баясгалантай яа тэр дагуу үйлдэнэ. Ингэснээр тэднээ харамлахын хир арилах хөрөнгө суух мөн. Зэрэгчлэн дадаж сурахад, эхлээд өөрөө багахан эдийг өгч сурах ба, бага юман дээр шунах сэтгэл багасаад ирэхээр дунд зэрэгт сурч, түүнээ шүтэж их сэтгэлийг олох болой.

Цаашлаад өөрийн багш, орны эзэн, шавь болон өгч чадахгүй, шуналт нөхөд дээр тийн бус ч, түүнээс бусад, эд юмгүй хүмүүст өглөг өгөх ба чухаг дээд гуравт ч өглөг өргүүлэхээр оруулна. Өөртөө өргүүлж үйлдэхгүй. Чингэснээр өөрийн буян машид нэмэгдэж, бусад заримын нисваанис номхрох, зарим нэг нь номын хүслээ гүйцэлдүүлэх, амьтныг хураан боловсруулах ч болно. Тэрчлэн өөрийн төгс эдлэл байхгүй ч, урлаж бүтээх зэргээр эдийг бүтээн өгөх ба ялангуяа ядуу болоод харамч нарт өглөг буяныг хүсэх номын яриаг бусдад өгөх хэрэгтэй. Мөн гуйлгачин ирэхэд сүсэгт бишрэл, эд баялагтын гэрт хүргэж, өөрөө тэнд очиж юу чадахаар өглөг өгөхийн нөхөр болох хэрэгтэй. Бас өгөх эдээс шилэн сонгож сайныг өгөх ба өгөхийг бэлдсэн зүйлээ бүгдийг гүйцээж өгөх мөн.

4" Бодит өглөг өгөх зүйлд алинаа хоёр:

а" Өгөх, эс өгөх бодит юмсыг хураангуйлан үзүүлэх

б" Дэлгэрэнгүй номнох

а" Өгөх, эс өгөх бодит юмсыг хураангуйлан үзүүлэх:

Аливаа өгч байгаа зүйл маань даруйд муу заяаны үндэснээс салсан амгалант амсуургыг гаргах ба, алс хэтдээ тустай, нүглийг тэвчих буюу буянд байгуулах ба, даруйд амгалантай бус ч, алсдаа тустай болвоос бодисадва бусдад өглөг өгч болно. Алин өгсөн юм нь даруйд шаналал зовлон гаргаж, алсдаа хорлолтой болох ба, даруйд жаргалтай ч, алсдаа хорлолтой аваас бусдад өглөг өгч бүү үйлдээрэй.

б" Дэлгэрэнгүй номноход хоёр:

1* Дотоодын эд зүйлээ өгөх ба эс өгөх

2* Гадны эд зүйлээ өгөх, эс өгөхийг дэлгэрэнгүй номнох болой.

1* Дотоодын эд зүйлээ өгөх ба эс өгөх:

Дотоод эд зүйлээ үл өгөх ёсыг мэдвээс түүнээс буцсан зүйлийг өгөх гэдгээ ухаарах учиртай тул эхлээд үл өгөх ёсыг номносу. ***Түүнээ гурав:***

а* *Цагийн үүднээс үл өгөх нь:* Бодисадва нар эхнээсээ амьтанд бие тэргүүтнээ сэтгэлийн мухраас өгөх мөн боловч, биеийн мах цус зэргийг гуйх үед бэрхшээл хатуужилд сэтгэл гансарч үл урвах их нигүүлсэхүй сэтгэл төрөх хүртэл бие махбодио гуйвч өгөхгүй мөн.

"Суртгаалын хураангуй"-гаас: "Уйсах хичээхүй гэж юу вэ? Хэн нэгэн хүч бага байтал хүнд үүрэг өгөх, урт удаан хугацаагаар ажиллуулах буюу, дур сүсэг сайтар боловсроогүй байх зэрэг үест хийхэд бэрхтэй үйлийг туурвих буюу. Үлгэрлэвээс, өөрийн махаа өгөх тэргүүтэн мэт". Тиймээс энд амьтанд биеэ өгч болох ч, цаг бусаар эдлүүлэхээс буцах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, тиймэрхүү амьтан бодисадвааг уйдаах ба, бодь сэтгэлийн хөрөнгө шим барагдах тул, үр болсон их цогцос махбодийн шим тасрахад хүрнэ. Тийм учиртайг *"Хутагт огторгуйн хүү сангийн судар"*-аас: "Цаг бусыг хүсвээс шумнасын үйл болой" хэмээн зарлиглажээ. *"Бодичарияаватара"*-д:

Нигүүлсэхүй сэтгэл эс төрөхийг хүртэл
Биеэ өгч үл болох бөгөөд
Хэрхэвч үүнийг бусдад өгөхдөө
Их хэргийг бүтээхийн үндэс болгоорой хэмээжээ.

б* *Хэрэг шаардлагатай үүднээс үл өгөх нь:* Дэмий балай хэргийн тухайд биеэ өгч үл болно. Дээрх шастарт:

Дээдийн номонд эдлэх биеийг
Дэмий балайд зольж бүү үйлд
Тэр мэтээр үйлдвээс амьтны
Сэтгэлийг түргэн гүйцээж үйлдэх хэмээжээ.

Өөрийн талаас, харамлах зэрэг өглөгийн тотгороос ангижирч, нөгөө талаас биеэ өгөлгүй олон амьтан тусыг бүтээх их хэрэгтэй үест, биеийг чинь гуйсан ч бүү өг. Өөрийн болоод бусдад хорлолтой амь таслах зэрэгт оруулахын тулд ч гуйваас, түр боловч, өөрийгөө өөрөөс бусдад бүү өгөөрэй.

в* *Гуйлгачингийн зүгт өгч болохгүй зүйл нь:* Шумнасны язгуурын тэнгэр болоод тэдгээрт хөөрөмшсөн амьтас бээр басамжлах сэтгэлээр гар, хөлийг чинь гуйваас өгөхгүй мөн. Тэдэнд өөрсдөд нь зовлон ирнэ. Галзуу солиотой эсвэл, сэтгэл хямрагсад гуйваас өгч болохгүй. Учир нь тэд үнэн санаанаасаа гуйж байгаа бус, ухаан мэдрэлээ алдчихсан амьтас. Тэднээ эс өгвөөс буруу зүйл гарахгүй. Харин өгвөөс унaлд унах болно. Тэдгээрээс бусад тохиолдолд гуйхад өгч болох бөгөөд гар, хөлөө хуваагаад ашид өгөх юм уу бусдын ном буяныг бүтээхийн тухайд боол, зарц болох зэрэг орон үесийн эрхээр үйлдэх хоёр өглөг буй.

2* Гадаад зүйлээ өгөх ба эс өгөхийг дэлгэрэнгүй номноход хоёр:

а* Гадаад зүйлээ эс өгөх ёс

б* Гадаад зүйлээ өгөх ёс

а* Гадаад зүйлээ үл өгөх ёсноо таван зүйлээс:

*1** Цагийн үүднээс эс өгөх нь.* Үлгэрлэвээс, тойн хуврага болон мацаг баригч нарт үдээс хойш амны идээ өгөх зэрэг буюу.

*2** Өгөх зүйлийн үүднээс өгч болохгүй нь:* Санваар сахигч нарт идээ ундааны үлдэгдлээ өгөх; баас, шээс, нус, цэр, бөөлжис, идээт бээр болсон ба, түүгээр халдварласан идээ ундааг өгөх; сонгино, сармис, мах иддэггүй, архи уудаггүй тэдгээрт уулгах, идүүлэхийг хүсэх; тэдгээрийг хэрэглэхийг цээрлэсэн хүмүүст сонгино тэргүүтнийг далдлан өгөх; өглөг өгөхийг сайн мэдэж баясах хэрнээ садан бус, ягчис, мангас болоод хатуу хүчээр дарамтлагч нар, ачийг үл хариулагчид, мартагч нараас гуйлга гуйхад хөвгүүд, албат нараа өгөх; шингэхгүй идээ хоолыг өгөх; шингэх ч хэмжээг нь барихгүй өвчтэй гуйлгачинд өгөх; хэтэрхий шунаж тэмцсэн амны идээг алагдах гуйлгачинд өгөх; гэм хайсан тэрсүүд болон номын утгыг мэдэх хүсэлгүй, эдийн хүслээр гуйсан гуйлгачинд ном өгөх зэргүүд болой.

"Бодийн газар"-аас тэр мэт айлдсан эдгээрийг *"Бодийн газар"*-ын байдлыг ийн *"Нотлон буулгагч хураангуй"*-д гарснаар мэдэх буюу "Ийн хэмээн, Хэрвээ бичсэн ном судрыг нялхасын ухаант гуйлгачинаа өгвөөс амлашгүй нүгэл болно. Тэд нарт өгөхөөр бусдаас гуйсан нь ч амлашгүй нүгэл болно. Харин би энэхүү гүн гүнзгий номыг суралцаж үзсү, сүсэглэн үйлдсү хэмээх энэ мэтийн сэтгэлээр өглөг өгвөөс амлашгүй болохгүй.

Хэрэв дээдийн ном мэтээр засварласан ном буюу, тэрсүүдийн шастар дэвтэрт сүсэглэн бишрэгчдээр түүнийи бичүүлэхээр явуулах юм уу, гарт байгаа бичмэл нэгийгээ өгөх буюу, бусдаас гуйж аваад тараавaас амлашгүй нүгэл гарна.

Бодисадва бээр гар дээр байгаа бичмэл дэвтэр ном түүнийгээ нээж, бурханы эрхэм зарлигийг бичихээр орох буюу. Өөрийн тусад бол шимгүй ямагт болохыг мэдэж зөвхөн бусдад хэрэгтэй юу байгааг алдаршуулах мөн. Нэгэн цагт ном бичдэггүй нэг гуйлгачин ирэхэд, бодисадва түүнээс “та үүгээр юу хийх вэ?” гэж асуувал “болвол зараад юм авмаар байна” гэжээ. Бодисадва бээр, энэхүү судар ном чинь номын бэлтгэл мөн учраас түүнд өгөлгүй байх нь үнэд хүрч, үнэтэй өглөг болно. Хэрвээ үнэ хүрэхгүй ч, өгсөнгүй гээд амлашгүй болохгүй.

Маш буруу номыг асууж гуйвaас тэр дагуу буюу. Мөн дунд зэргийн номыг асуусан ч тэр дагуу болой. Илүү ялгамжаат номыг асуусан аа эс өгвөөс амлашгүй болохыг мэдээрэй.

*3** Шутээний үгднээс өгч болохгүй нь:* Өөрөө номын хэрэг тусыг бүтээгээгүй байсан ч, харамлах сэтгэлийн хиргүй цагт, мэдэхийг хүсэж гуйсан нэгнээ ном өгөх мэт. *Үүнийг өгч болохгүйн учир нь:* Энэ мэтээр номын өглөг өгөхөд гурван хэргийн аль нэгийг бүтээвэл үл өгөх ба хойд хоёр хэрэг илүү аваас өгөх мөн. Илүү байхгүй бол анхдугаар хэрэг бүтэхгүй билээ. Энэ мэтээр өөрт хармын сэтгэл үгүй тул харамлах нисваанисыг арилгах хэрэггүй буюу. Чингэж өгөхгүй байснаар билгэ билгийн чуулганыг олонтаа үзэх ба өгвөөс их үйл болохгүй бий. Өгөхгүй байснаар, амьтан бүхний тус амгалангийн тухайд билгэ билгийн буяны чуулганыг бүтээх тул, энэ амьтад болоод бусад амьтныг баясуулж үйлдэх мөн. Харин өгвөөс, энэ гагцаар баясах төдий мөн болно. *“Бодийн газар”*-аас: “Хэрэг их, бага болохыг энэ мэтээр айлдсан” ба *“Бодичарияаватара”*-д: “Багын тухайд ихийг бүү өг” хэмээн айлдсан тул, өгөхгүй байна гэдэг гэм гарахгүйн төдийд ч бус болой.

Эс өгөх ёсны хувьд: Үүнийг чамд өгөхгүй хэмээн шулуун үгээр хэлэлгүй уран аргаар ойлгуулж өгөх мөн. Уран арга нь энэ буюу. Бодисадва бээр анхдугаар газраас арван зүгийн бурхан бодисадва бүхнээ хамаг байгаа эд зүйлээ сэтгэлийн мухраас зориулдаг. Үлгэрлэвээс, Аяга тахимлаг бээр багш, ловон нартаа номын хувцас тэргүүтнээ асар ариулан зориулж хадгалдаг мэт. Тэр мэт зориулах нь хэдийгээр хураасан эд мөн боловч,

хутагтын язгуурт оршигч бодисадва хэмээгдэх тул буян нь хэмжээлшгүй мөн. Тэдгээр эд зүйлийг бурхан, бодисадва нар эрэлцэх мэт хадгалах болой.

Хэрэв гуйлгачин ирэхэд өнөө эд зүйлээ түүнээ өгөх хэрэг гарваас бурхан, бодисадва нараас амьтнаа өгөхгүй эд зүйл ерөөс байхгүй билээ гээд өгөх мөн. Тийн хэрэг гарахгүй бол ёс журмын дагуу асар ариунаар тэдгээрт зориулан тахиваас сайн. Энэ чинь бусдын юм шүү. Танд өгч болохгүй хэмээн зөөлөн үгээр ухуулж үйлдээрэй. Мөн энэ нь номын үнийг хоёр буюу гурав дахин нэмээд өгөх зэргээр, яав ч тэрээр, их шуналаасаа болоод бодисадваад өгөхгүй байгаа хэрэг биш. Үүнийг өгөх эрхгүй нэгэн юм шүү дээ гээд тэр мэт үйлдэх нь ухаантны өглөг болой.

*4** Бодит зүйлийн талаас өгч болохгүй нь:* Өөрийн эх, эцэг болон амьд амьтантай хоол унд, таньдаг таньдаггүй ч бай үл сүслэх хүүхэд, эхнэр, зарц, албат тэргүүтэн ба жаргаах учиртай хөвгүүн, эхнэр зэргийн хүмүүс болно. Эдгээрийг зарц, албатын тухайд өгч болохгүй гэж заасан ч, эдгээр бодит зүйлүүд их зонхи заагдсан тул бодит зүйлийн тоонд орно.

"Бодийн газар"-ын *"Нотлон буулгасан хураангуй"*-д: "Номын гурван хувцаснаас бусад төгс эдлэлийн үлдэгдэл буюу, бурханаас даган зөвшөөрсөн зүйлсийг, харамлахын сэтгэлгүйгээр буяны зүгт хэрэглэн чухалчлагч мөн бол гуйлгачинаа эс өгсөн ч гэм гарахгүй" хэмээсэн ба "Ийн хэмээн, Тойн бодисадва бээр, номын гурван хувцаснаас бусад эд зүйлийн үлдэгдлийг бурханаас даган зөвшөөрсөн дагуу, биеийн төгс эдлэл болон амгаланг ухаарч мэдсэн оронтой зохилдох тэдгээрийг, гуйж хүссэнээ тус тус шинжлэн өгч үйлдвээс, амлашгүй нүгэл гарахгүй болно. Энэ нь буяны зүгт харгалзсан мөн. Харин хүслийн зүгт хамаарахгүй тул өгөхгүй байсан ч амлашгүй гарахгүй мөн" хэмээжээ.

"Бодисадвын тус тус гэтэлгэгч судар"-аас: "Шарийн хөвгүүн ээ! Хэрэв бодисадва номын гурван хувцасаа бүгдийг өгчихөөд, гуйлгачинг эрхэм гэж үзэж байна гэвэл, түүнийг бага хүслийг шүтэгч хэмээхгүй буюу" хэмээн зарлигласан нь номын гурван хувцасаа өгвөөс, тойн бодисадвад унал гарах болой.

*5** Хэрэгтэй үүднээс өгч үл болох нь.* Өөртөө болон бусдад хорлол үйлдэхийн тулд гуйсан хүнд хор, мэс, гал, архи өгөх ба, муу заяанд явахын үндсийг хураах хоригдохуун болох зүйлст баясах ба, тоглоом тохууны

зүйлийг гуйхад тэдгээрийг өгөх; амьтныг хөнөөхийн тухайд тор, нум саадаг зэрэгт суралцуулах, тэдгээрийг сурахаар гуйгч тэдгээрт заан сургах, өгөх мэт. Чингэвээс тэдгээр нь амьтны амь, бие, төгс эдлэлд хор хөнөөл хүргэх тул тийм зүйлийн увдисыг заан сургаж болохгүй. Тэрчлэн хуурай буюу чийгтэй газарт оршигч амьтнаа хорлол хүргэхээр газар шороо, ус мөрөн гуйхад өгөх ба, энэ улс орны хүмүүс болон бусдын хүн олныг хөнөөхөөр хаан төрийг гуйхад тэдгээрийг өгөх ба, садан бус хүмүүн гуйснаар түүний дайсныг өгөх зэргүүд болой.

б* Гадаад бодитой юмсыг өгөх ёсон:

Тэрхүү шүтээнийг бурханаас хориглоогүй, цаг болсон, тэр хүнд өгөхөд зохистой, түүнд таарах аваас өгөх хэрэгтэй. Шүтээний хувьд дээр өгүүлснээс буцсан байх ба, номоо харамлах сэтгэл байваас номын үйл үйлдсэн болохгүй ч, сурахыг эгээрэн хүсэх гуйлгачинаа өгч болно. Хэрэв хоёр ном байвал тэр дагуу өгөх хэрэгтэй. Байхгүй бол ном бичсэн үнээр өгөх хэрэг гарна. Хэрвээ өгөхгүй бол, би энэ насандаа хэлгий болох амархан ч, хармын эрхээр бүү явсугай хэмээн санаж магадтай өгөх болно.

Бодит зүйлийн хувьд ч, дээр номносноос бусад үест болон, хаан байхын үест бусдын хөвгүүн, эхнэр зэргийг эзэн сэлтээс нь хагацуулж өгч болохгүй ч, орд харш сэлтэстэй нь гуйваас өгөх мөн. Тэрчлэн муу заяаны уг болохгүй баясгалант тоглоомын зүйлс, бусдад хор болохгүй тор шүүр тэргүүтэн, амьтнаа хорлолгүй амьтан амьдрах хуурай газар, ус үндтай нутаг, амьтангүй идээ ундааг гуйснаа өгөх хэрэгтэй. Өөр болон бусдад туслахын тухайд гуйваас хор, мэс, гал, архийг ч өгч болно.

Тийнхүү эд өлгийг өгөхийн цагт хоосон гуйлгачин, хөрөнгөтэй баян хоёр гарваас хэрхэх вэ хэмээвээс, анхнаасаа тийм хоёр хүн гарвал хоёулангийн хүслийг гүйцээх чадал байгаа бол хоёулангийн хүслийг гүйцээнэ. Эс чадваас ядуугийн хүслийг гүйцээж үйлдэх хэмээсэн тул, хоёулангийн хүслийг гүйцээж эс чадахын үест “Сайхан ааль зангаар, Энэхүү эдийг би эхлээд ядуу хүнд өгөхөөр бэлдсэн билээ. Таныг буцаая гэж бодоогүй” гэх зэргээр зөөлнөөр хэлж ойлгуулаад эд хөрөнгөгүй нэгний хүслийг гүйцээж үйлд. Энэ мэтээр өглөг суралцах ёс эдгээр нь бодисадвын санваар авсан үйлийг анхдагч нарт тун хэрэгтэй гэж үзэгдэх тул бичлээ. Онцгойлох тохиолдолгүй зүйлсийг *“Бодийн газар”*-т номносон ёсоор болгосон болой.

б' Өгч эс чадваас хэрхэн үйлдэх нь:

Гуйлгачин гуйхын цагт харамлах сэтгэл босоод ирвэл, "энэхүү эд зүйлээс би хэзээд салах нь, энэ ч намайг орхих нь лавтай, тийм болохоор үүнийгээ өгчихөөд шимийг аваад үхье хэмээн" ийн санах болой. "Үүнийгээ өгчихвөл, үхлээ гэхэд эд юмандаа хорогдохгүй, харуусал гэмшил ирэхгүй болох тул амар амгалант болму" хэмээн санах болой. Тэр мэт санавч өгч эс чадваас, "Эдүгээ би, хүч багатай, буяны үндэс боловсроогүй, их хөлгөний үйлийг эхлэн суралцагч, үл өгөхийн сэтгэлийн эрхэнд автагч, нисванисын үзэлтэн, "би" хийгээд "Минийх хэмээн баригч" үзлээр баригдсан нэгэн билээ. Дээд төрөлхтөн тэсвэрлэн айлдагтүн, шаналган бүү зохио.

Хэрхэн таны болон амьтан бүхний санаа төгсгөх тэр мэтээр би ч үйлдэх буюу" хэмээн гуйлгачинд гурвантаа ухааруулж үйлдсээр, ухааруулан үйлдэхийг *"Дагшүлжан айлтгасан судар"*-аас айлджээ. Энэ нь янагш, чинагш үл сүсэглэхийн бусад гэмийг тэвчихийн тухайд мөн. Харамлах гэмгүй үг биш. Бодисадва нарын харамлах сэтгэлийг муушаан *"Суртгаалын хураангуй"*-д айлдсан буй. Хэрвээ ингэж үйлдвээс харамлаж ном, эдийг үл өгсөн ялагдал (унал) арилах адил. *"Барамидын хураангуй"*-д:

Хэрхэн гуйлгачин өмнө минь ирэхэд
Би үнэхээр өчүүхэн төдий өглөг өгч чадахгүй ч
Хэрхэвч түүнийг гомдоож доошлуулалгүй
Зөөлөн үгээр түүний сэтгэлийг тэжээ
Хожим дахиад өмнө минь ирвээс
Хэзээд сэтгэлий нь хугалалгүйгээр
Харамлах гэмүүдээ арилган үйлд
Харамлах сэтгэлээ тэвчихээр дахин шамдан үйлд хэмээжээ.

в' Өглөгт тотгорлох ерөндөгийг шүтэх:

Өглөгийн тотгорт дөрвөн зүйл байхыг "Хураангуйгаас гарсан"-д:
1" Үл дадах, 2" Доройтох, 3" Шунах, 4" Үрийг үл үзэх хэмээжээ

1" Үл дадах: Өгөх эд зүйл байсаар атал гуйлгачинаа өгөхийг үл хүсэх буюу. Түүний ерөндөг болгож "Энэхүү гэм нь эртнээс миний өглөгт дадаж сураагүйгээс уршигдав" гэж түргэн таньж мэдээд, "хэрвээ өгч эс чадваас хойд төрөлдөө зовлонт болно" гэх зэргийг тус тус шинжилж, дадаагүйн эрхэнд үл өгөх болой.

2" Доройтох: Төгс эдлэл хэтэрхий багатайгаас өгөх сэтгэл төрөхгүй байх болой. Түүний өөрөндөгт "Ийн байвaас би орчлонд эргэлдэхийн цагт, бусдад эс тусалж урьдын үйл болоод бусдын эрхнээ одох тул, өлсөж үндаасах тэргүүтэн тэсэхүй еэ бэрх олон зовлонг амсах тул, хэрвээ бусдад тусалснаар энэ насанд зовлон магадтай гардаг юм бол, би үхэхэд ч надад зөвхөн өглөг л сайн тус болох тул гуйлгачинг тийнхүү буцаах бус аа. Тийм их эд эдлэл байхгүй ч, өвс ус юу төдийгөөр амьдарна хэмээн санаад, ядуугийн зовлонд сэтгэл төвдөлгүй, өгч үйлдэх болой.

3" Шунах: Өгөх ёстой зүйл маань машид сэтгэлд зохист, эрхэм дээд учраас түүнээ шунан тачаaснаар гуйлгачинд өгөх сэтгэл төрөхгүй байдаг. Түүний өөрөндөгт шунан тачаасны гэм эргүүг түргэн таньж мэдээд, "би зовох нь жаргалтай хэмээх хур мэдлийг чанх буруугаар бариваас, хойд төрөлд зовлон үүднэ" гэдгийг ойлгож түүнийг тэвчээд тэрхүү эд зүйлийг өгч үйлдэх мөн.

4" Үрийг үл үзэх: Өглөг өгснөөр туулсан бурханы хутаг гарах зэрэг тус эрдмийг бодолгүйгээр, их эд эдлэлтэй байх нь тустай төдий (хожоо) бодож, өглөг өгөх сэтгэл төрдөг. Түүний өөрөндөгт тийм бодол гэм буруутай гэдгийг түргэнээ ухаарч, ер нь хурсан бүхэн агшин агшинаа эвдрэх ба, ялангуяа эд баялаг ч эвдэрэх, салах, хагацах жам ёстойг санан, өгсөн өглөг юу бүхнээ их бодь хутгийн тухайд зориулж үйлдэх мөн. Эд хөрөнгө зэргийн тийн боловсрол (ачит үр) төдийхнийг горилж, их үнэд хүрч байгаа эд бүхнээ харамлалгүй зарах нь арилжаа наймааны ашиг олохоос бус буяныг олохгүй адилаар, эд хөрөнгө нилээдийг олохоос бус нирваaныг олохгүй.

"Дөрвөн зуут"-аас:

Үүнийг өглөгт өгснөөр
Их ашгийг олно гээд
Омтгойлон авч өгөлцөх нь
Арилжаа наймаанд тооцогдож муушаагдах буюу хэмээжээ.

2' Санаа төдийгөөр өгөх нь. Аглагт суугаад сэтгэлээ дотогш агуулж, ариун сэтгэл, чин зүрхнээс, өгөх элдэв зүйлээ агуу хэмжээлшгүй их болгон сэтгэлээр хувилгаж амьтнаа өгөх сэтгэлийг үйлдэх явдал. Чингэснээр бэрхшээл багатайгаар, хэмжээлшгүй ихээр буян арвижих ба, ийнхүү бодисадва сэтгэлээ ухаанаар өглөг өгч болохыг "Бодийн газар"-аас айлджээ. Эд хөрөнгөгүй болвоос энэ адилаар үйлдэж болохыг "Лагсан

әйлтгсан судар"-т айлдсан ч, эд баялагтай ч гэсэн ингэж үйлдэж болно. Төгс эдлэлгүй үед сэтгэлээр өглөг үйлдэх явдал "үлэмж сэтгэлийн ариун газар болоод анхдугаар газрыг эс олох хүртэл" байдаг. Түүнийг олсны дараа төгс эдлэлээр хоосорно гэж үгүй.

"Бодийн газар"-т: "Тиймд бодисадва хэдүй асар ариун сэтгэлийг эс олох хүртэл тэдгээр төгс эдлэл байхгүй ч гэсэн сэтгэлийн өглөг өгч үйлдэнэ. Асар ариун газрын бодисадва хэрхэн муу заяанаас тонилох хутгийг олсон тэр адилаар, төрөл тутамдаа барагдашгүй төгс эдлэлийг эрхшээх болно" хэмээн айлджээ.

г/ Тэдгээрийн утгын хураангуй

Бодисадвын тангараг санваарыг барьж, дээд зэргийн өглөгт суралцахаар ерөөл тавих ба, дээр өгүүлсэн дагуу эдүгээс эхлэн өглөг өгөхөөр суралцагсадын зөвшөөрөл, цээрийг ухаж суралцах мөн. Ялангуяа бие, төгс эдлэл, буяны язгуураа харамлах сэтгэлийн ерөндөгийг туурвиж, өгөх сэтгэлээ улам нэмэгдүүлэн өглөгт шамд. Тэр мэтийг анхааран авахдаа баясгалантай байх бөгөөд эс сурваас сэтгэлдээ шаналалыг эгүүсгэх хэрэгтэй.

Тэр ёсоор үйлдэж чадвал *"Лагсан айлтгасан судар"*-т айлдсан мэтээр, төрөл бусад дээр ч төвөг багатайгаар өглөгийн чинад хүрч болно. Тэдгээрийг эрхивоос энэ насанд ч машид хүнд нүглээр үргэлжид халдах тул бусад төрөлд ч (өглөгт) орох зүрх хүрэхгүй болж, улмаар бодисадвын явдалд ороход машид бэрхтэй болно. Энэ талаар *"Барамидын хурангуй"*-д:

Энэ адил өглөгийн язгуур нь бодь сэтгэл ба
Энэ адил өглөг өгөх сэтгэлээ бүү орхи
Ертөнцийн дотор өгөх сэтгэл төгөлдөр байх л
Өглөгийн дотроос эрхэм гэж бурхан зарлиглажээ

хэмээн айлдсан мэт явдлын шүтээн болсон бодь сэтгэлийг дурдан санаж бясалгах ба бодь хутгийг бахдан ерөөл тавих нь өглөг бүгдийн үндэс, хамаг өглөгийн дээд болох тул түүнээ шамдаж үйлдэх мөн. Эдгээр нь *"Лагсан айлтгасан судар"*-ын утгын хураангуй дээд увдис буюу.

2/ Шагшаавадын чинад хүрэхүйд (барамид) таван зүйл:

а/ Шагшаавадын (ёс суртахуун) мөн чанар
б/ Түүнийг бясалгалд орох арга
в/ Шагшаавадын ялгал
г/ Тэдгээрийг бүтээхийн үест хэрхэн үйлдэх
д/ Тэдгээрийн утгын хураангуй

а/ Шагшаавадын мөн чанар:

Бусдыг хорлохын үндэс сэлтээс сэтгэлээ буцааж, тэвчих сэтгэлийг шагшаавад (ёс суртахуун) гэнэ. Тиймээс тэрхүү сэтгэлийг дадуулж, дээш дээш төгс болгосноор шагшаавадын чинадад хүрнэ. Гадна талаас, амьтныг хорлож хөнөөх аюулаас хагацаж салах үүднээс шагшаавад төгс төгөлдөр болох бус. Хэрэв тийн бус бол, эдүгээ ч амьтан бүгд хорлол хөнөөлөөс хагацаагүй байх тул, мөн урьд заларсан бурхад ч шагшаавадын чинадад хүрээгүй болоход хүрнэ. Тэдгээр амьтан ч хорлол хөнөөлгүй зүгт хөтлөгдөж чадахгүйд хүрнэ. Тийм учир амьтан бүхэн гадна талын хорлолоос хагацах юм уу, хагацахгүй байх нь хялбар буюу. Харин өөрийн үндэснээс тэдгээр хорлох сэтгэлээ буцаах, тэвчих сэтгэлийг дадуулж үйлдэх л шагшаавадын анхааран авах бясалгал болдог. *"Бодичарияаватара"*-д:

Загас тэргүүтэн аливаа амьтан
Хөнөөгдөх вий гэж тэд айцгаах буюу,
Тэвчих сэтгэлийг олсноор
Шагшаавадын чинад хүрэхийг номнов хэмээжээ.

Гурван зүйлийн шагшаавад байдаг ч, энэ үед голлон боомтлох шагшаавадын эрхнээ үйлдэн тэвчихийн сэтгэл хэмээн номнов.

Тэрчлэн хотол өдөөгч сэтгэл зэргийн үүднээс, арван хорыг тэвчих арван тэвчил болоод өөрийн мөн чанарын үүднээс, долоон нүглийг тэвчсэн бие хэлний үйлийн долоон тэвчил зэрэг буй.

"Орохуйн тайлбар"-т: "Шагшаавад түүнийг, нисваанисыг ая зөнд нь авахгүйн учир, нүгэл хилэнц гаргахгүйн учир, сэтгэлийг хугалагч уур хилэнг арилгах учир, амгалангийн шалтгаан учир дээдэс шүтдэг мөн. Тэрээр долоон тэвчлийн бэлэг чанарт мөн. Үл тачаах, үл уригнах, дээд үзэл хэмээх

тэдгээр гурван номын өдөөгч болно. Тиймд хотол өдөөгчтэй шагшаавад болох үүднээс үйлийн мөр болохыг тийн номножээ" хэмээсэн буй.

б/ Түүнийг бясалгахаар орох арга:

Тийнхүү бодь сэтгэлийг үүсгэж, явдал мөрд суралцахаар тангараглагч тэрээр, хамаг амьтныг туулсан бурханы шагшаавадын чимэг төгөлдөр болгохоор тангараг тавьж, түүний хэргийг бүтээх хэрэгтэй. Урьдаар өөрийн шагшаавадыг огоот ариун байлгах хүчийг эгүүсгэх хэрэгтэй. Шагшаавад ариун бус агаад доройтох аваас муу заянд унах тул бусдын тус байтугай, өөрийн хэргийг ч бүтээж чадахгүйд хүрнэ. Тиймд бусдын тусыг хичээгч бээр, шагшаавадаа эрхэмлэн сулруулахгүй барьж, сайтар боомтлон хянамгай явах нь чухал. *"Барамидын хураангуй"*-гаас:

Туулсан бурханы шагшаавадын чимэг төгөлдөр болгохоор
Хамаг амьтны тус хэргийг туурвигч алин бээр
Өөрийн шагшаавадыг эхлээд сахь
Ариун шагшаавадын хүчин чадлыг үүсгэ хэмээжээ.

Шагшаавад доройтвоос, өөрийн тусыг бүтээж чадахгүй болох тул бусдын тусыг бүтээх чадал хаанаас ирэх вэ. Тиймд бусдын тусыг сайтар хичээгч бээр түүнээ өргөл хүндлэлийг горьдох зохистой бус. Шагшаавад ариун байна гэдэг хэрхэн цааз журмын дагуу авч орхихын орныг гарын авлага болгож авахтай харгалзана.Тэр нь хүчтэй, баттай сүрэгнэж сахих хүсэл ухаанаас хамаарах тул /1/ сүрэгнэж сахихгүйн гэм эргүү болоод /2/ сүрэгнэж сахихын тус эрдмийг өнөд удаан тунгаан бодохын үүднээс сахих сүрэгнэх эрмэлзлийг төрүүлнэ.

/1/ Дээрх судраас:

Тиймд муу аюул ослыг мэдэх бөгөөд
Тэвчвээс зохистой өчүүхэн төдийг ч тийн тэвчиж үйлдэх

хэмээсэн мэтээр гэм ослоос айж, өчүүхэн төдий амлашгүй нүгэл байсан ч шамдан тэвчих мөн. Шагшаавадын үл зохилдох зүг болсон бүдүүн, нарийн арван хар нүглийн гэм эргүүг дээр номлосон мэтээр санаарай.

/2/ Тус эрдмийн талаар дээр номносон бөгөөд Балдан бавуу бээр айлтгасныг дээрх судрарт:

Баясгалангийн уг тэнгэрийн эд баялаг ба хүмүүний төгс эдлэл
Амгалангийн дээд, эрхэм амтат тэнгэрийн хотол чуулган тэд
Шагшаавадын үндэснээс төрөх тул, маш их гайхамшигтай яа
Бурхадын ном ч түүнээ харгалзан гарахыг үзээрэй хэмээжээ.

Мөн түүнд шүтэн байж, сэтгэл дээш дээшээ дэгжин одох буюу их нигүүлсэхүй сэтгэлт их бодисадва нарын суртгаал нь ариусан одох бөгөөд гэмт явдлын хөрөнгө бүхнийг тэвчсэн ариун билгэ билгийг олох болно. Түүнээс бусад гоёл чимгүүд нь хэтэрхий залуу хүнд юм уу, хэтэрхий хөгшин хүнд зүүвээс, басамжлахуйн орон болж үзэсгэлэн бус болдог бол, шагшаавадын чимэг хөгшин, залуу, дунд алин бүгдэд баяслыг төрүүлэх чимгийн дээд болдог байна. Бусад анхилам сайхан үнэр нь мөрий нь дагаваас үнэртэвч, үл дагаваас үл ирэх тул өрөөсгөл нэгэн байна. Шагшаавадын алдрын үнэр болвоос зүг бүгдэд түгэх билээ. Халууны эвэршээлийг арилгагч зандан тэргүүтний түрхлэг нь хувраг тойнд харшлавч, нисваанисын халуун энэлгээг арилгах түрхлэг нь хувраг харшлахгүй, харин зохилдох мөн. Тойн хуврагийн тэмдэг төдий байлаа ч, шагшаавадын эд зүйлтэй төгөлдөр байваас, бусдаас илүү гайхамшигтай болно. Дээрх судраас:

Шагшаавад тэр нь ялгамжааг олсон мөр буюу
Их нигүүлсэхүйн ааль авир лугаа хамт бүтэх
Туйлын гэгээн билгийн мөн чанарт бөгөөд
Гэм арилсан чимгийн дээд хэмээгджээ.

Гурван орноо сэтгэлд зохист үнэр анхилуулах тэр
Тойн хуврагад харшлах түрхлэг болмуй за
Авир ёс зохиолдож, шагшаавад төгөлдөр бөгөөс
Хүний дотроос тэр ямагт үлэмж мөн хэмээжээ.

Мөн зусардах үгийг хэлэхгүйгээр буюу зовж зүдэрч бүтээх шаардлагагүйгээр төгс эдлэл аяндаа хурах ба, хатуу үйлт зүхлэг заналага бололгүй байхад төрөлхтөн бүхэн мөргөх, хүндлэх, өөрийн садан удам угсааны биш хэрнээ, урд тусыг хүргээгүй, таньж мэдэхгүй ард аяндаа асарч энэрэх, хөлийн мөрийн тоосыг ч тэнгэр, хүмүүн бүгд тэргүүнээрээ шүтэж, олж авснаа тахилын орон болгож хүндлэх зэргийн тус эрдэм бүгд шагшаавадаас төрсөн буюу. Дээрх судраас:

Үгээр үл хэлэх ба бэрхшээл зүдрэл бололгүй
Анхаарах бясалгалын төгс эдлэл, өргөн хүндлэл хурж ирэх
Зандарч загнаагүй атал хамаг ертөнцийнхөн мөргөх бөгөөд
Төвөггүй эс бүтээлээ ч, эрх баялгийг олох буюу

Өгүүлж мэдэхгүй язгуур угсаа гарах ба
Ач тус хүргэх, аглаг алиныг үйлдээгүй байхад
Танихгүй, мэдэхгүй олон ардууд ч
Шагшаавад төгөлдөр төрөлхтөн түүнээ сөгдмүй

Өлзий болсон хөлийн тоос шороог ч
Оройн дээдээр хүндлэн авч тэнгэр болоод хүмүүний
Мөргөлийн тэргүүнд хүргэхээр бүгдээр авч одно
Тиймд шагшаавад төгөлдөр тэр нь язгууртны дээд хэмээжээ.

Тийн тус эрдэм болоод гэм эргүүг сайтар санах учиртайг мэргэд бээр "дээрх судар"-т:

Бодисадва бээр сахиваас зохист шагшаавадаа
Өөрийн жаргалд шунах сэтгэлээр шамшааж бүү үйлд хэмээсэн ба,

Өөрийн эрхнээ болгож анхааран авч амгалант болгохоор
Мэргэдийн сайшаасан чимэг төгөлдөр шагшаавадаа сахь
Суртгаалын орноо огоот төгс болгоод
Хотол төгс хиргүй шагшаавадаа үнэхээр шүтсүгэй

хэмээн айлдсан ёсоор сахих хэрэгтэй. Мөн өөрөө муу заяанаас айх төдийд буюу, тэнгэр болоод хүний хотол чуулганыг хүсэх төдийг горилохыг орхиж, хамаг амьтныг шагшаавадад байгуулахын тухайд сахиж сүрэгнэх учиртай.

Дээрх судраас:

Алин ертөнцийн хэмжээлшгүй амьтан бүхэн
Тэд бүгдийг ариун шагшаавадаа байгуулъю хэмээн ерөөх ба
Ертөнцөд туслахын тухайд шагшаавадыг шүтэж үйлдсү хэмээх
Тэр нь шагшаавадын чинадад хүрсэн хэмээн зарлиглажээ

Тиймээс муу заяаны аюул болоод хаан төр хийгээд
Өндөр язгуурын хотол чуулганаа горилохыг цээрлэж
Хир үгүй үнэнээр шагшаавадыг сахин үйлдэх ба
Амьтны тусыг хичээх шагшаавадыг шүтэх мөн хэмээжээ.

в/ Шагшаавадын тийн ялгалд гурван зүйл:
/1/ Боомтлох шагшаавад
/2/ Буяны номыг хураах шагшаавад
В. Амьтны тусыг үйлдэх шагшаавад болой.

/1/ Боомтлох шагшаавад нь: *"Бодийн газар"*-аас: "Тус тус гэтэлгэх долоон зүйл гэж айлдсан бий. Тус тус гэтэлгэх санваар төгөлдөр бодисадва нь санваарт оршсон болно. Гэргийтэн буюу тойн хуврагийн зүгийн тус тус гэтэлгэх санваар бодитой болоод тэдгээртэй хамтрах нийтийн тэвчил, боомтууд нь боомтлох шагшаавад болно. Тус тус гэтэлгэх санваарын шүтээн байхгүй ч, бодисадвын санваар төгөлдөр мөн болоход, тус тус гэтэлгэхтэй нийтийн буюу, мөн чанарын амлашгүй болон цаазын амлашгүй хоёрын аль нэгийг тэвчсэн тэвчил боомт нь боомтлох шагшаавад болно.

/2/ Буян номыг хураах шагшаавад нь: Зургаан барамид тэргүүтний буянд зорьж, өөрийн үндсэнд эс төрснийг төрүүлэх, төрснийг үл доройтуулах ба дээш дээш нь арвижуулан үйлдэх болой.

/3/ Амьтны тусыг үйлдэх шагшаавад нь: Амьтны арван нэгэн зүйлийн тусад зорьж, тэдгээрийн энэ ба хойдын тус хэргийг болоод амлашгүй нүгэлгүйгээр, зохистойгоор бүтээх мөн. Энэ талаар миний бие *"Шагшаавадын бүлгийн тийн номлол"*-д дэлгэрэнгүй үзүүлсэн тул түүнээс магадалж дахин дахин үзээрэй.

Чингэхээр тус тус гэтэлгэх санваар цааз нь бодисадвын санваар төгс хувраг тойны сартгаалын нэгэн зүг мөн тул, бодисадын сартгаалаас ангид зүйл бус. Гурван шагшаавадын дотроос боомтлох шагшаавад нь тусад гэтэлгэгчийн бодитой цааз буюу орох, буцахыг үйлдэхдээ түүнтэй нийтийнх болно. Бодисадвад ч анхнаасаа их хэрэгтэй тул тэр ямагтад суралцах мөн.

"Бодийн газар"-ын *"Нотлон буулгасан хураангуй"*-д: "Шагшаавадын гурван зүйл тэдгээрээс энэ мэт буюу боомтлох шагшаавад энэ нь, хураах ба учруулан үйлдэх мөн. Түүнийг боомтлох ба сахиваас түүнээс бусад нугуудыг ч боомтлон сахиж болно. Түүнийг эс боомтлон, эс сахиваас түүнээс бусдыг эс боомтлон, эс сахихад хүрэх тул, бодисадвын санваар шагшаавадыг доройтуулваас санваар бүгд доройтно хэмээн өгүүлсүгэй" хэмээн айлджээ. Тиймд тус тус гэтэлгэх санваар нь Сонсоод сонсогчийнх болой гээд түүний орох буцах цааз нугуудыг орхиж, бодисадвын санваар бусдад суралцах нь мөн гэж хэлэх нь бодисадвын шагшаавад сартгаалын

аньсыг мэдээгүй хэрэг болно. Тиймээс боомтлох шагшаавад бол бусад хоёр шагшаавадын суурь болно гэдгийг олонтаа зарлигласан бий.

Боомтлох шагшаавадын гол зүйл нь мөн чанарын амлашгүй нүглийг тэвчих явдал мөн. Мөн чанарын амлашгүйн их гэм буруутай аньсыг хурааж арван хар нүглийг тэвчих хэмээн дээд, доод хөлгөн бүхнээ айлдсан тул тэдгээрийг сэдэх төдийд ч сэтгэлээ оруулахгүйн үүднээс гурван үүдээ үнэхээр боомтлох хэрэгтэй. *"Барамидын хураангуй"*-д:

Өндөр язгуур, нирваны амгалант мөрд урвуулагч
Арван буяны үйлийн мөрөөс доройтуулж бүү үйлд
Түүнээ оршсоноор амьтнаа туслах санааны
Ялгамжаат сэтгэлийн үр гарах буй

Бие, хэл, сэтгэл юүгээн үнэнхээр боомтлон үйлдэхүйг
Шагшаавад хэмээн хураангуйлан хэлэх мөн хэмээн бурхан айлджээ

Хамаг ёс суртахууныг хураасан суурь мөн тул
Тэдгээрийг асар сайнаар судалж үйлд хэмээсэн ба,

Чандракирти гэгээн бээр: "Шагшаавадын барамидын үест арван хар нүглийг тэвчих талаар номносон бий. "Арван газар" зэрэг судрын олон аймгаас тэр мэтээр айлдсан учир эхлээд урьд номносон мэт боомтлох сэтгэлд суралцваас үлдэх шагшаавадууд амар хялбар бүтэх болой.

г/ Тэдгээрийг бүтээхийн үест хэрхэн үйлдэх:

Тэдгээрийг бүтээхдээ, зургаан дээд төгөлдөр буюу зургаан барамидыг төгөлдөр болгож бүтээнэ. Зургаан барамид төгөлдөр бүтээхийн үест өөрөө шагшаавадаа сахин сүрэгнэж, бусдыг шагшаавадад байгуулах ёс нь шагшаавадын өглөг болох бөгөөд үлдсэн бусад нь дээрхийн адил болой.

д/ Тэдгээрийн утгын хураангуй:

Явдлын шүтээн бодь сэтгэлийг үл доройтуулж дээш арвижуулах нь шагшаавад тэргүүтний явдалд орох үндэс болно. Хамаг амьтныг хорлохоос буцах дээд ч мөн. Дээд газрын шагшаавадыг анхааран бясалгах мөрийг ерөөлийн орноо тавиад, явдал болоод үйлийн анхдагч бээр сэтгэлийн мухраас, одооноос эхлэн шагшаавадаас орох, буцахын орноо суралц. Ялангуяа арван хар нүгэл тэргүүтэн мөн чанарын амлашгүй нүгэл зэргийг таньж мэдээд, өдөр нижгээд нижгээдээр боомтлох сэтгэлийг

олонтаа талбих ба тэдгээрийн дотроос алин ам авсан тангаргийн язгуурын уналыг боомтлох сэтгэлийг дахин дахин авахаар шамдаж үйлд. Тэр мэт үйлдвээс үйлдсэн лүгээ зохилдох үр гарч, бусад төрөлдөө алжаал өчүүхэн, төвөг багатайгаар бодисадвын суртгаалыг төгөлдөр үйлдэж чадна. Эдүгээ тэдгээрийг орхивоос машид хүнд нүглийн гэм уналаар халдагдах бөгөөд олон төрөлдөө бодисадвын суртгаалд суралцаж чадахгүйд хүрч болох тул одооноос шамдаарай.



3/ Тэсвэрлэхүйн чинад хүрэхүйд суралцахад тав:

а/ Тэсвэрлэхүйн (тэсэхүй) мөн чанар
б/ Түүнийг бясалгахаар орох арга
в/ Тэсвэрийн ялгал
г/ Түүнийг бүтээхээр хэрхэн үйлдэх
д/ Тэдгээрийн утгыг хураах

а/ Тэсвэрлэхүйн (тэсэхүй) мөн чанар: Бусдаас хорлол үйлдэхэд юунд ч үл тоох, өөрийн үндэснээ зовлон гарахад аянд нь авах, номонд магадтай бодож бат сүжигтэй орших болой. Тэдгээрийн үл зохилдох зүгт гурван зүйл буй. Үүнд:

/1/ Уур хилэн

/2/ Уурлан мятарч сэтгэлээр унах

/3/ Үл биширэн үл сүслэх болой.

Энд “тэсэхүйн чинад хүрнэ” гэдэг уур хилэн тэргүүтнээ хорих сэтгэлийн дадал бясалгалыг бүрэн төгс гүйцэх зэргээр буюу. Хэрцгий догшин хамаг амьтнаас ангижирсан төдийхэнд харгалзах хэрэг биш. Зөвхөн түүгээр бүтээж чадахгүй учиртай. Өөрийн сэтгэлээ номхотгосноор л хэрэг бүтнэ. *“Бодичарияаватара”* -д:

Догшин хэрцгий амьтан гэдэг огторгуй мэт
Тэд бүгдийг дарж яахин барах вэ
Уурлан хилэгнэх сэтгэлээ дарваас л
Тэдгээр дайсан бүхнийг дарсантай адил буюу

Газар дэлхийг ширээр бүрсү хэмээвээс
Түүнээ хүрэх шир хаанаас байх
Гутлынхаа өлмий төдийг ширлэвээс
Хамаг газар дэлхийг ширлэсэнтэй адил буюу

Тэрчлэн гадна талын бодит (дайсан) олон ч
Хариулж няцааж яахин барах би
Өөрийн сэтгэлээ л жич хариулчихваас
Бусдын хариулахын хэрэг юу вэ хэмээжээ.

б/ Түүнийг бясалгахаар орох арга: Олон үүд байдаг ч энэ удаа */1/ тэсэхийн тус эрдэм болоод /2/ тэсэхгүйн (уурлахын) гэм эргүүг* бодохыг номносу.

/1/ Тэсвэрийн тус эрдэм: Түүний тус эрдмийн тухай *"Бодийн газар"*-аас: "Бодисадва хүн эхлээд тэсвэрлэхүй сэтгэлийн тус эрдмийг санах мөн. Тэсвэртэй хүн гэдэг хойшдоо олон дайсангүй болох, олон юманд салж омтгойрохгүй, амар тайван, сэтгэлийн их амгалантай болох, гэмших зовлонгүй насаа барах ба, хэдий бие эвдрэвч өндөр язгуурт ертөнцийн тэнгэрийн дотор төрнө. Тэр мэтийн тус эрдэмтэйг мэдэж, өөрөө тэсвэртэй болох, бусдыг тэсвэр хатуужилтай болгохоор баттай оруулж, тэсвэр хатуужилт сэтгэлийг сайшаан өгүүлэх ба хатуужил тэсвэртэй хүнийг үзээд сэтгэл үргэлжид баясах болно" хэмээжээ. *"Барамидын хураангуй"*-д

Бусдын тусыг огоорох сэтгэлтний
Дээдлэх ёс журам нь тэсвэр мөн хэмээжээ.
Ертөнцийн сайн сайхан хотол чуулган бүхэн
Уураар гэмтэх ба, тэсвэрээр баттай аврагдах

Хүчтэн чадалтан нарын чимгийн дээд буюу
Хатуужих ёсын хадгалагч нарын чадлын манлай буюу
Хорлох сэтгэлийн "хээрийн галнаа усны үргэлжлэл"
Өвөр, бусдын хамаг хорлолыг тэсвэрлэн арилгах

Дээд төрөлхтний тэсвэрийн хөө хуягнаа
Догшин тэрсүүд төрөлхтний үгийн сум хугарч
Магтаалын сайхан цэцгэс болон дэлгэрч
Сэтгэлд зохист яруу алдарын эрхи болох хэмээсэн ба,

Үзэсгэлэн төгөлдөр эрдмийн билэг найргаар чимсэн
Дүрст лагшинг бүтээж урлах орон бол тэсвэр мөн

хэмээн амьтны буруу бүтээлээс болж бусдын тусаас үл няцах, олон буяны язгуурыг дарах уур омгийн дайснаас аврах, өчүүхэн төдий хорлолд ч тэсэж гарах сэтгэл булаам чимэг билээ. Нисваанисыг энэлгэж, хатуужигч нарын дээд хүч, хорлолын их галыг дарагч усны үргэлжлэл, догшин тэрсүүд нарын буруу үзлийн суманд үл нэвтрэх хөө хуяг, амьтны нүд сэтгэлийг булаагч алтан өнгөт сайхан дүрст лагшин бүтээгч уран дархан зэргийн олон тус эрдмийн үүднээс сайшаасан болой. *"Бодичарияаватара"*–д: "Алин хянамгайлж уураа дарах, түүнээс илүү амгалан хаана ч үгүй" хэмээн

айлдсан мэт тэсвэрийг үргэлжид шүтвээс сэтгэлийн баясал үл доройтож, энэ нас төдийгүй нас тутамд амгалант болно. Хойд насанд ч муу заяаг хорьж, ялгамжаат сайн заяат болоод эцэст нь нирвaанд хүргэх тул энэ болоод хойдын хамаг бүхнээ амгалант болно. Тэр мэтийн тус эрдэм бүгд тэсэхүй сэтгэлээс үүдэх учир шалтгааны барилдалгыг баттай ухаарах хүртэл тунгааж бясалгаарай.

/2/ Уурлахын гэм эргүүг үл мэдэхийн гэм нь:

"Бодичарияаватара"–д:

Мянган галавт хураасан
Өглөг өгөх бурханыг тахих зэрэг
Сайн явдал алин тэр бүхнийг ч
Гагцхан агшины уур даран чадах

хэмээсэн бөгөөд үүнийг хутагт Бавуу айлдсан дагуу *"Бодичарияаватара"*-д үзүүлсэн байна. *"Манзуширийн тийн цэнгэх судар"*-т: "Зуун галавт хураасан буяныг дарна" гэдгийг айлдаад, "Орохуй"-д ч: "Зуун галавт өглөг, шагшаавад, барамид зэрэгт суралцаж хураасан буян тэргүүтнийг ганцхан агшин төдийд төрсөн уурлах сэтгэлээр дарахыг" айлджээ.

Ямар оронд уурласнаар ийм болох учиртай хэмээвээс, заримууд, бодисадва нарт хэрэгтэй гэж номносон, зарим нэгэн ерөнхий бүгд оронд гэж болгоосны өмнөх болно.*"Орохуй"*-д:

Алины тул бодисадва нарт уурлаваас
Зуун галавт өглөг шагшаавадаар
Хураасан буяныг нэгэн агшинаа дарна

хэмээн айлдсан дагуу үзэгдэнэ. "Уур төрөх суурь болж, бодисадва хүн уурлаваас буянаа дарах тул, бодисадва бус хүн бодисадвад уурлахыг хэлээд яах вэ" хэмээн *"Орохуйн тайлбар"*-аас айлдсан буй. Тухайн орон нь бодисадва заавал байх уу, үгүй юү гэх, уурлах шалтгааныг мэдэхдээ зөв, буруу байсан эсэх дээр, урьд номносон мэтээр буяныг дарахын хувьд адил байна.

Ер нь буяны язгуурыг дарахад нь бодисадвад уурлах төдийгээр хэрэггүй. *"Суртгаалын хураангуй"*-д: *"Хамаг хутагт буй хэмээн өгүүлэгчийн шастар"*-аас ч, Аяга тахимлаг нараа! Аяга тахимлаг нар, тэр мэтээр үс хумсны суварганд биеийн гишүүн бүхнээр мөргөх нь, сүсэглэх

сэтгэлд харгалзах мөн. Хувраг тэр адил болой. Тэр аяга тахимлаг бээр, газарт дарсан тэр төдий буюу газрын найман түм дөрвөн мянган багцадын доорх алтан хүрдэн тулах хүртэл хичнээн тоотой элс байгаа тэр төдийгээр, Загарбадийн хааны хаан төрийг мянгантаа эзлэх буян хураана" хэмээгээд, "түүнээс насан гавъяат Нивархор бээр, Ялж төгөлдөр нөгчигсөн алин байгаа зүгт алгаа хавсран машид сайн мөргөж, Ялж төгөлдөр нөгчигсөнөө ийн хэмээн айлдав. Ялж төгөлдөр нөгчигсөн бээр, аяга тахимлагийн буяны язгуур энэ мэтээр их болохыг айлдав. Бурхан багш аа, Эдгээр буяны язгуур хэзээ барагдах, нимгэрэх, огоот арилах, огоот барагдах вэ? хэмээсэнд, Хэрхэн ариун явдалт нэгнээ өө сэв эрж, яр шарх гаргасан Нивархор таны энэ адилыг би үзсэнгүй. Нивархорын хураасан буяны их үндэс эдгээр нимгэрч, огоот арилж, огоот барагдах болой. Нивархор оо, энэ мэт юм юмтай харшилдаж, сэтгэлийн хорлолыг бүү үйлд. Тэр тусмаа сэтгэл ухаантай амьтныг ч хэлээд яах вэ? хэмээн уншсан" хэмээн айлджээ.

"Буяны язгуураа дарах" хэмээх утгын хувьд, урьд хийсэн буяны үр түргэн гарах чадлыг дарах ба, үр гарах нь удаашрч хойшлох буюу харин урьтаж уур хилэн зэргийн үр гарах явдал юм. Эдүгээ шалтгаан нөхцөл нь бүрдчихсэн бол, өөрийн үрээ гаргахгүй гэсэн үг биш ээ. "Ертөнцийн ямар ч зам мөрөөр, тэвчигдэхүүний хөрөнгийг тэвчиж чадахгүй тул, ерөөс нисваанисын хөрөнгийг тэвчиж чадахгүй" гэж зарим мэргэд айлдсан буй. Гэхдээ энэ үндэслэл баттай биш шиг санагдана. Учир нь эгэл ард бээр, дөрвөн ерөндөгөөр нүглээ судлан ариусгах нь хэдийгээр хөрөнгийг тэвчсэн бус ч, эдүгээ шалтгаан лугаа учравч тийн боловсрох (ачит) үр нь гарахгүй шүү дээ. Өөр өөрийн тийн боловсролын үрээ гаргаж барагдах буян нүглийн үр алин ч бай, хөрөнгөө тэвчээгүй ч, хойшид шалтгаан лугаа учравч тийн боловсролын үрээ гаргахгүй учиртай. "Найрлагын мөрийн үзүүр"-ийн егүзэр болон "тэсвэрлэх" езүзэрийг олох үест буруу үзэл болоод муу заяаны үндэс болсон нүглийн хөрөнгийг тэвчээгүй хэдий ч шалтгаан лугаа учравч буруу үзэл болоод муу заяанд төрөхгүй болдог учиртай.

Мөн дээр татсан мэт, "үйлээр орчлонд хүнд, хөнгөн болох" хэмээн айлдсан мэт, нүгэл буяны үйл аль түрүүлж боловсорсон нэг нь, нөгөө бусад үйл боловсрох орон үесийг түр нэг хаавч, тэр төдийгээр буян буюу нүглийг дарж чадахгүй бөгөөд зарлиглаагүй байна. Түр нэг тийн боловсрол удаашрах төдийгээр, буяны язгуур дарагдлаа гэсэн утга бус. Эс чингэвээс их хүчтэй нүглийн үйл бүхэн буяны язгуурыг даран үйлдэгч гэж айлдах хэрэг гарна. Тиймд энэ талаар Ловон Лэгданжэд бээр, урьд номносон мэт

дөрвөн хүчээр нүглийг арилгах ба, буруу үзэл болон хорлох сэтгэлээр буяны язгуурыг дарах хоёулаа, ногооны хөрөнгө доройтсон байхад ямар ч шалтгаантай учравч үл ургах мэт, эдүгээ шалтгаан лугаа учравч үрээ гаргаж чадахгүйг айлдсан болой.

Чингээд урьд номносон мэт, хураасан хилэнц нүглээ дөрвөн хүчийг судалж арилгах болон дээд мөрүүд төрөхөд удаашрах явдал нь харшлахгүй адилаар, зарим нэгнээ өглөг өгөх, шагшаавад сахисны үрд, төгс эдлэл, хотол чуулсан бие гарахгүй дарагдах байвч, өгөх, тэвчих сэтгэлдээ дадсан шалтгаан зохилдох үйлээр жич дахин өглөг болоод шагшаавадын буяны язгуур төрөхдөө хялбар болох буюу дарагдахгүй болно. Мөн заримууд дээр дотоод шагшаавад тэргүүтний чадал зохилдонгүй шалтгааны язгуур адилын үргэлжлэл гарах явдал нь дарагдавч, бие болоод төгс эдлэл тэргүүтэн хотол чуулган гарах явдал дарагдахгүй ч бий. Зарим тохиолдолд дээр номносон мэт, эш бошгот бодисадвад уурлаагүй бол нэгэн галавт төгс явж гүйцэх байсан зам мөрийн онол эрдэм нь, заримдаа нэгэн удаа уурлах сэтгэл төрснөөр тэдгээр нь сэтгэлээс хаягдахгүй хэдий ч, нэгэн галвын энгээр зорчих мөр нь удааширч одохтой адил болно. Товчилвоос, нүгэл арилах боловч түүний чадал хүч бүгд нь арилахгүйтэй адил буян дарагдахад ч түүний аливаа чадал хүч бүгдээр дарагдах албагүй гэдгийг санаарай. Гэхдээ энэ маш их хэрэгтэй бөгөөд гагцхүү бурханы ном зарлиг болон түүнд түшсэн учир шалтгааны ухаанаар шинжлэх нь чухал гэж үзэгдэх тул эрхэм зарлигийг үзэж сайтар судлаарай.

Тийнхүү өөрийн талаас, сэтгэлд зохисгүй, хэтэрхий хатуу, тийн боловсролын үрээ гаргах хэрнээ, бусдын талаас сэтгэлд зохист, хэмжээлшгүй их тийн боловсрол гаргахад хориглох нь "үл үзэхийн гэм эргүү" болой.

"Энэ насны гэм эргүү" нь, уурлаж хилэгнэхээс болж сэтгэл амгалан тайван байхаа болих, урьдын баясал, жаргал эвдрэх, хойшдоо гарахаа болих, нойр хүрэхээ байх, сэтгэл санааны амар тайван алдагдах, ихээхэн уурлаад ирвээс ачилж тусалсан амьтнаа мартаж алах хөнөөх ба, ах дүүсээ аашилж загнаад холдуулах, өглөгөөр хураавч тогтож суухгүй зэрэг явдал гарна. *"Бодичарияаватара"–д*:

Уур мэт эвэршээлт сэтгэлийг хадгалваас
Сэтгэлийн амгалан эдлэх үгүй буюу

Баясал, жаргалыг үл олох ба
Нойр хулжиж, амар тайвангүй болох

Алин эд баялаг зэргээр өргөн хүндэлсэн
Ач тус хүргэх түүнийг л шүтэх буюу
Тэдгээр ард ч уур хилэнт
Ноён түүнийг алахаар эсэргэлдэх

Улмаар амраг садан уйдах
Өглөг өгөвч эргэж үл ирэх
Товчилвоос, ууртай газар амгалан орших гэж
Угаас тэр нь хаана ч үгүй хэмээжээ.

"Төрөл дарааллын цадиг"-т:

Уурт хүний зүс царай гундаж
Гоёл зүүвч муухай харагдах
Сайхан орон дэвсгэрт хэвтэвч
Уурын хатгуураар сэтгэл нь өвдөнө

Өөрт чинь тус болсны ачийг мартаж
Уур омогтоо шатаж буруу замд орох
Алдар нэр, ажил үйл ч доройтох
Шинийн сарны нигуур мэт цог жавхлан ч буурах

Амраг садан машид хайрлаж байвч
Ааш уураар зохисгүй халил хясаа руу унах
Тус тусыг ялгах ухаан балартаж
Их зонхи харшилдан сэтгэл мунхрах

Уурлаж нүглийн үйлд дадсанаар
Тамд олонтаа ойчиж зовлон эдлэх
Их хорлол үйлдсэнээр арьсаа атируулсан
Аймшигт дайсан үлэмж ихдэхийг хэлэх юун

Уур хэмээх энэхүү доторхи дайснаа
Тэр мэтээр ухаж мэдээд би
Түүний чадлыг буцаах төрөлхтөн
Хэн боловч, тэсвэрийг зохио хэмээн зарлиглажээ.

Тэдгээр гэм буруу бүхэн уурлахаас л үүдэх гэдгийг магадлан мэдэх хүртэл дахин дахин бясалгаж үйлдээрэй. Тэр талаар *"Бодичарияаватара"*-д:

Уур адилын нүгэл үгүй
Тэсвэр адилын хатуужил үгүй
Тиймд үргэлж тэсэхэд шамдаж
Элдэв ёсоор бясалгаж дадаарай

хэмээн айлдсан мэт тус эрдэм болоод гэм эргүүг урьдаар мэдэж, олон үүднээс тэсвэрийг бясалгаж дадуулахаар шамдаарай. Эхний мөрийн утга нь *"Орохуйн тайлбар"*-т: "Их далайн усны хэмжээг жингээр хэмжиж чадахгүйн адил, түүний тийн боловсрох үрийн хэмжээг магадалж чадахгүй болой. Тиймээс тэр адилаар сэтгэлд зохисгүй үр гаргах ба, буянд хорлол үйлдэх хилэнц гэвэл үл тэсэхүйгээс илүү дээд зүйл байхгүй болой" хэмээн айлдсан мэт сэтгэлд зохисгүй тийн боловсрох үр ихийг гаргавч, буяны язгуурыг дарахгүй байгаагаар их хилэнц болохгүй.

Харин тийн боловсрох үр ихээр гаргах болон буяны язгуурыг дарах хоёр нийлж гэмт явдал болохын хувьд уураас бусад олон бий. Үйлийн үрийг басамжлах буруу үзэл, дээдийн номыг тэвчих, бодисадва болоод багш тэргүүтнийг басамжлан дорд үзэх, омог гаргах зэрэг багтахыг *"Суртгаалын хураангуй"*-аас мэдээрэй.

в/ Тэсвэрийн ялгалд гурван зүйл:

/1/ Хорлол үйлдэхэд юунд ч үл тоох
/2/ Зовлонг аян зөнд авах
/3/ Номыг магадлах сэтгэлийн тэсвэр

/1/ Хорлол үйлдэхэд юунд ч үл тоох тэсвэрийг үүсгэхэд хоёр:

/а/ Хорлогч хорлол үйлдэхэд үл тэсэх байдлыг хориглох
/б/ Хорлол үйлдэх бэлтгэл ажилд үл баясах ба доройтоход үл баясахыг хориглох

/а/ Хорлогч хорлол үйлдэхэд үл тэсэх байдлыг хориглоход хоёр:

1' Амгаланд тотгорлож зовлонт болоход үл тэсэхийг хориглох
2' Өргөн хүндлэл зэргийг тотгорлож басамжлал тэргүүтэн гурвыг үйлдэхэд үл тэсэхийг хориглох

1' Амгаланд тотгорлож зовлонт болоход үл тэсэхийг хориглоход хоёр:

а' Уурлах зохисгүйг үзүүлэх

б' Энэрэх нигүүлсэх зохистойг үзүүлэх

а' Уурлах зохисгүйг үзүүлэхэд гурав:

1" Орныг шинжвээс уурлах зохисгүй

2" Оронтыг шинжвээс уурлах зохисгүй

3" Шүтээнийг шинжвээс уурлах зохисгүй

1" Орныг шинжвээс уурлах зохисгүй болох нь: Өөрийн эрх буй, үгүйг шинжвээс эс зохист болой. Хорлол үйлдсэнээ уурлах зохистой шалтгаан юун хэмээн шинжлэх мөн. Тэр мэтийг шинжвээс, тэрээр эхлээд хорлол үйлдэх санааг агуулж бэлтгэлээ базааж миний жаргалыг хорьж, бие болоод сэтгэлийн зохисгүй зовлонг тарьсан шүү дээ? хэмээвээс, Хэрвээ тэрбээр өөрт хорлол үйлдэлгүй өөрийн эрхээр хорлол хүргэсэн бол уурлах мөн юмуу? хэмээвээс, Түүнд өөрийн эрх огт байхгүй, өөрийн эрхгүй бусдаар шаардуулан хорлолыг үйлдсэн учраас уурлах болжээ дээ. Эхнийхээр нь гэж үзвэл уурлах нь зохисгүй бөгөөд тэрбээр хорлол үйлдэхдээ ч, өөрийн эрхгүй байсан байна. Тэр мэт урьд дадсан нисваанисын хөрөнгө байгаа бөгөөд орон лугаа ойртоод ёс бусын сэтгэлийг үүсгэжээ хэмээн эс бодовч, шалтаг шалтгаан тэдгээрээс үүссэн учир ийн буюу. Тэдгээр шалтаг шалтгаан эс бүрдвээс, чингэсү хэмээн санавч ерөөс төрөхгүй болой.

Тийнхүү шалтаг шалтгаан тэдгээрээс хорлох хүсэл төрж, түүгээр хорлох бэлтгэлээ базаах ба, цаашдаа бусдад зовлон үүсгэх тул тэрхүү бодгальд өөрийн эрх өчүүхэн ч байхгүй. Тэрбээр нисваанис бусдын эрхэнд орсон учраас түүний боолын боол мэт оджээ. Өөрт ч өөрийн эрх ерөөс үгүй тул бусдын эрхэнд эрхгүй ороод хорлол үйлдсэн болохоор ихэд уурлах нь зохисгүй болно. Үлгэрлэвээс, адаар хорлогдож, түүний эрхэнд одсон зарим нэгэн бээр адаас гэтэлгэхээр тус хүргэсэн нэгнийг хорлохыг хүсэх бий. Зодож цохих зэргээр аашлавч, туслахыг хүсэгч бээр, "энэ минь адаас болж өөрийн эрхгүй ингэж байгаа тул ингэлээ" гээд түүнд өчүүхэн ч уурлалгүй, адаас яахнаа ч хагацуулахын тулд хичээхтэй адилаар, бодисадва бээр хорлогч хорлолыг үйлдэх үед "энэ минь нисваанисын адаар өөрийн эрхгүй тийнхүү үйлдэх мөн" хэмээн санаж, тэрхүү бодгальд

өчүүхэн төдий ч уурлалгүй, "энэхүү амьтныг нисваанисаас хагацуулахын тухайд би бодисадын явдалд шамдах болой хэмээн бодь сэтгэл үүсгэх хэрэгтэй. Энэ талаар *"Дөрвөн зуут"*-д:

Уурлавч, адаар баригдсан нэгнээ
Оточ эмч хямрахгүй байхын адилаар
Бурхан бээр, нисваанист тэднийг болгоож
Барьсан ниваанист болохоос бодгальд бус хэмээжээ.
Чандракирти гэгээн бээр:

Энэ үест амьтанд гэм үгүй
Нисваанис үүнд гэмтэй мөн
Сайтар ажиглаад мэргэд бээр
Амьтан тэдэнд уурлаж үл үйлдэх хэмээн айлдсан мэт болой.

"Бодичарияаватара"-гаас олон шалтгааныг айлдсан бөгөөд энэ ямагтыг танин мэдэхэд хялбар бөгөөд уурын өрөндөг болох нь хэрэг ихтэй үзэгдэнэ. *"Бодийн газар"*-аас: "Ном төдий хуран мэдэл бясалгаж хорлолд тэсэж болно" гэж айлдсан. Үүн лүгээ утга нэгэн тул, түүнээ магадлал олох хүртэл бясалгаарай. Хэрвээ амьтан тэдгээрт өөрийн эрх байвал, хэзээ ч зовлонтой болохгүй. Зовохыг үл хүсэхийн тухайд түүнд л өөрийн эрх байх хэрэгтэй болно. Мөн тэдгээр хатуу нисваанист туугдаж, машид хайртай, энхрий өөрийгөө ч хөнөөх ба халил хад руу унах, өргөс, мэс зэрэгт хатгуулах, хоол ундаа хасуулах зэрэгт хүрэх болохоор бусдыг хорлохыг хэлэх юун гэж санаад уур омгоо хорих буюу. *"Бодичарияаватара"*–д:

Тэр мэт бүгдээр бусдын эрхэт
Түүний эрхээр өөрийн эрх үгүй
Тэр мэтийг ухаж хувилгаан адилын
Бодитой бүхнээ уурлахын хэрэг үгүй хэмээсэн ба,

Тиймд дайсан буюу садан хэмээн
Дайсагнан хоорондоо үйлдэхийг үзээд
Энэ мэтийн шалтгаанаас үүдсэн болой хэмээн
Тэр мэтийг тунгааж сэтгэл амар суу

Хэзээд өөрийн жаргалыг бүтээхдээ
Хэзээд зовлонг үл хүсэх учир
Амь биет амьтан хүн бүгдэд
Хэнд нь ч зовлон бүү үүдэх мөн хэмээсэн ба,

Алин цагт нисваанисын эрхэнд орсноор
Өөрийгөө хүртэл зовоож хөнөөх тул
Тэр цагт тэдгээр бүхэн бусдын биенээ
Хорлож үйлдэхгүй нь хаанаас байх вэ хэмээн айлджээ.

а" Түр зуурын юм уу, төрөлхийн араншин алин болохыг шинжилж эс зохистой болох нь. Бусдыг хорлох тэр гэм нь, амьтны араншин мөн биш хоёроос давахгүй тул, хэрэв араншин мөн болвол амьтанд уурлах огт зохисгүй юм. Гал бол байгалиасаа халаах, шатаах араншинтай тул, түүнд уурлах зохисгүйтэй адил. Бас хэрвээ түр зуурын байсан бол уурлах бүр ч зохисгүй. Огторгуйд суунаглах утааг харчихаад түүний гэмээр будантах огторгуйд уурлах нь зохисгүйтэй адил гэж санаж уур омгоо хорих буюу

"Бодичарияаватара"-д:

Хэрвээ бусдыг хорлон хөнөөх үйлүүд
Нялхас эглийн араншин мөн болвоос
Түүнд уурлах нь зохисгүй бөгөөд
Шатаахын араншинт галыг өслөхтэй адил

Хэрвээ тэр гэм алдас түр зуурын болвоос
Амьтны араншинг ухаарч авснаас хойш
Түүнд уурлах нь зохисгүй билээ
Огторгуйд утаа хөшиглөхөд өслөхтэй адил хэмээжээ.

б" Бодитой болон далдын аливаа хорлолыг шинжээд эс зохистой болох нь. Бодитой хорлол хүргэсэн хорлогч түүнд уурлах ёстой гэвэл, хүнд уураа гаргасан шигээ бэрээ, саваа мод, таяг зэрэгт ч уурлах хэрэгтэй. Дамнаж буюу дамжуу замаар хорлол хүргэснээ уурлана гэвэл, саваа мод зэргийг хүн турхирснаар хорлоход хүргэх тул хүнд уурлах болно. Хүнийг уур хилэнд турхирсан тул явсаар уур хилэндээ л уурсах хэрэгтэй болно. Саваа мод зэрэгт уурсаж, бас цохих үйлдэлд уурлах гэтэл тэр бүгд уураар турхирагдсан байна. Тиймээс (хэргийн эзэн, хэнгэргийн дохиур-орч.) гэм буруу болсон уур хилэндээ л уурлах хэрэгтэй хэмээжээ. Тиймээс саваа мод болоод, зодоочид ч уурлах нь зохисгүй тул, зодоочид уураа гаргаснаас уур омогтоо л уурлах хэрэгтэй болж байна. Хэрэв тэр адилаар эс бариваас, сэтгэл, ухаан минь зохисгүй зам мөрд одох болно. Учир шалтгааны олон

талаас зүйрлэн тунгааж, ухааны нь олоорой. Тэр цагт саваа модонд уурлах зохисгүйн адилаар, хүмүүн бодгальд уурлах учиргүйн зүгт сэтгэл татагдана. Саваа мод болоод зодоочид хорлох сэтгэл байгаа үгүйг ялгаж чадахгүй байна гэх нь дээр номносон мэтээр өөрийн эрх мэдэл байхгүй хэмээх шалтгаантай холбож ухаарай.

в" Хорлолд хүргэх уг үндсийг шинжилж уурлах зохисгүй болох нь: Хорлол хүргэснээс үүдсэн зовлонг амсана гэдэг ямар нэг шалтгаангүйгээс юм уу, эсвэл зохилдохгүй шалтгаанаас үүдэхгүй. Харин даган зохилдох үндэс шалтгаанаас үүддэг. Чингээд урьдын нүглийн үйл буй тул, өөрийн үйлийн эрхээр хорлогч лугаа өөрийн эрхгүй учрах шалтгаан гарчээ. Тиймээс өөрийн тарьсан уршигаас болж бусдад уурлах зохисгүй хэмээж, өөрийн уршгаа хөөн гаргаж, хамаг уураа хааж үйлдэюү. Үлгэрлэвээс, өөрийн муу үйлээр тамын сахиусан нарыг бүтээчихээд өөрөө эргэж хорлуулахтай адил буюу.

Би гэдэг урьд нь амьтнаа
Энэ адилын хорлолыг үйлдэж
Түүгээр амьтныг хөнөөж сүйтгэжээ
Тиймд надад энэ зэргийн юм гарах зохист хэмээх ба

Нялхас зовохыг үл хүсэвч
Түүний шалтгаанд шүлэнгэтэх
Өөрийн гэмээр хорлогдох тул
Бусдыг өслөхийн хэрэг юун

Үлгэрлэвээс, тамын сахиусан болоод
Мэсэн навчит ой цэцэрлэг тэдгээрийг
Өөрийн үйлээр урлаж бүтээсэн тул
Хэнд ч юундаа уурлах билээ дээ

Өөрийн үйлээр минь хөтлөгдөж
Өөрийг минь хорлогч гарсан буюу
Түүгээр амьтныг тамаас гаргах бил үү
Би тэднийгээ эвдсэн бил үү хэмээжээ.

Шавува гэгээнээс ч: "Би бээр уршигдаагүй гэж хэлвээс, утгандаа номын авьяасгүйгээ харуулсан болно" хэмээжээ.

2" Оронтыг шинжвээс уурлах зохисгүй болох нь. Хорлогчид уурлаж, зовлонд тэсэхгүй байх гэдэг тэр харштай зүйл болно. Эдүгээ нарийн зовлон нэгнээ эс тэсвээс, хэмжээлшгүй их муу заяаны зовлонд аажим, аажимдаа дарагдах болно доо. Чингэвээс би маш тэнэг амьтан өөрөө өөрийгээ ичгүүрт байдалд хүргэх нээ гэж бодоод, ууpаа гаргахгүйн төлөө хичээж үйлдэх буюу.

Эдүгээгийн зовлон энэхэн төдийд
Тэсэж эс чадахгүй бол би
Тамын зовлонгийн үндэс болсон
Уураа яаж буцааж чадах вэ хэмээжээ.

Тэрхүү хорлолоор үүдэх зовлон гэдэг урьдын муу үйлийн үр бөгөөд түүнийг амссанаар урьдын муу үйл барагдах ба тэсэж чадваас нүгэл хилэнц шинээр хураалгүй, их буяныг хураах мөн. Тиймээс хорлол үйлдэгч түүнийг миний буяныг доройтуулагч гэж үзэлгүй, харин миний хилэнцийг арилгахын тухайд орших ачтан буянтан гэж үзэх хэрэгтэй.

"Төрөл дараалпын цадиг"-аас:

Алин өөрийн номыг доройтуулахыг саналгүй
Миний нүглийг арилгахын тухайд оршсон мэт
Ийм байхад тэсвэрлэж үл үйлдвээс би
Түүнтэй адил ачтан бусад хаана байх хэмээсэн ба,

"Орохуй"-гаас:

Урьд хийсэн нүглийн үйлийн үр алин
Барж үйлдэх гэж өгүүлэгдэх тэр ямагт бөгөөд
Бусдад хорлол хүргэж уурлаваас зовлон болох тул
Хөрөнгө болж хэрхэн юунд хөтлөх хэмээжээ.

Тиймээс их өвчнийг анагаахын арганаа төөнүүр, хатгуурыг үйлдэхэд ч тэсэх мэтээр, их зовлонг буцаахын учирт өчүүхэн зовлонд ч тэсэх нь маш зохистой болой.

3" Шүтээнийг шинжвээс зохисгүй нь: Хорлолын шалтгаан гэмтэй, гэмгүйг шинжих буюу.

Түүний зэвсэг ба миний бие
Хоёулаа зовлонгийн шалтгаан бөгөөд

Тэрээр зэвсгээ, би биеэ гаргах болохоор
Хэнд нь ч уурлах вэ

Идээ бээрт баригдсан хүн адилын дүрст
Тэсэшгүй аймшигт зовлонг амсагч
Сохор шуналд баригдсан над адилыг
Хорлохоор хэн уурлах билээ хэмээсэн ба,

Зарим нь мунхагаар хорлол үйлдэх
Зарим нь мунхагт уурлах тул
Түүнийг гэмгүй хэмээн яаж хэлэх
Гэм зэмтэй болно алин тэд хэмээжээ.

Өөрийн ам тангарагаа шинжих. Сонсоод сонсогч нар зөвхөн ганц өөрийн тусыг үйлдэгч ч үл тэсвэрлэн уурлах нь зохисгүй гэдэг. Би болвоос бодь сэтгэлтэй болсон цагаас хамаг амьтны амгаланг бүтээхээр ам аваад, бусдын тусыг үйлдэхээр хамаг амьтныг баттайяа барихад (чингэх хэрэгтэйг) хэлээд яах гэж санаад тэсвэрлэх хуягийг өмсөх хэрэгтэй. Бодова гэгээнээс: "Бурханы шашин ном гэдэг хилэнцийг эс үйлдэх мөн. Өчүүхэн төдий хорлол гарахад тэсвэрийг үл бясалгаваас түүнээс болоод шашин ном үндэснээсээ эвдэрнэ. Хүчийг гаргана гэжээ. Тэгээд санваараа алдана. Түүгээр шашин ном үндэснээсээ эвдэрнэ. Ерөнхий шашин ном бидэнд үгүй болно. Өөрийн санваараа алдваас илүүтэй балрана" гэж айлдсан буй. Бодова гэгээнээс: "Сүүл савагтаа хайртай сарлагт тохом тохош тавих гэхэд шилгээж хөмрөөд хөл шийрээ цохино. Тохом чангалах гэхээр булгиж унагачихаад амар аажим явж одно. Харин хорлол ирэхэд /сахиж байгаа зүйлээ/ сулруулалгүй, түүнийхээ нөхөр болгож улам зовох шиг харагдана." хэмээн айлдсан байна.

б' Энэрэх нигүүлсэх зохистойг үзүүлэх. Тэргүүлшгүй цагаас хамаг амьтан нь бидний эх эцэг, элгэн садан болж яваагүй гэж ерөөс байхгүй билээ. Тиймээс цаг бусаар амь насаа алдах, гурван зовлонгоор энэлж шаналах, нисваанисын адаар галзуурах зэргээр өөрсдийн энэ болоод хойдын тус хэрэг тусаа бусниулах тэдгээр амьтныг хайрлаж энэрэх сэтгэлийг эгүүсгэх хэрэгтэй би. Уурлаж хөнөөж яаж болох хэмээн зүрхний мухраас бодох болой.

2' Өргөн хүндлэл зэргийг тотгорлож басамжлал тэргүүтэн гурвыг үйлдэхэд үл тэсэхийг хориход хоёр:

а' Магтаал тэргүүтэн гуравт тотгор болоход үл тэсэхийг хориход гурав:

1" Магтаал зэргүүд тус эрдэм байхгүй ёсыг санах

2" Гэмтэй болохыг санах

3" Тиймээс тэдгээрийг хорихдоо баясах

1" Магтаал зэргүүд тус эрдэм байхгүй ёсыг санах: Миний алдар нэр цуурайтав, урт наслав, удаан жаргав, энэ насны заяа буянаа хураалаа гэх зэргээр, бусад олон төрөл заяанд минь ямар ч ач тусгүй хоосон магтаалаар, намайг хөхүүлэн сайшаах бий. Гэтэл харин намайг магтсангүй гээд сэтгэлээр унах байна. Энэ үед, орон гэрийн ямар ч тусгүй, элсэн байшинг дэвсэлж нураахад, цурхиран уйлах нялхас бид хоёр адилхан болжээ дээ хэмээн бодоод, өөрийгээ муушааж, шуналгүй үйлдэх мөн.

Магтаал сайшаал, алдар, хүндлэл гэдэг
Буян үл болох, нас ч үл болох,
Намайг хүчтэй ч үл болгох, өвчингүй ч үл болгох,
Биеийг жаргалтай ч үл болгох
Би гэдэг өөртөө тустайг мэдэхийг хүсэвч
Надад өөрт тустай юу байна даа хэмээсэн ба,

Элсэн байшинг дэвслэхэд
Эрхлэх нялхас гаслах адил
Сайшаал, нэр алдар унахад
Миний сэтгэл нялхас адил болох хэмээжээ.

2" Гэмтэй болохыг санах: Магтаал, сайшаал болвоос, сэтгэлийг хэрэггүй зүйлд алгасруулах, уйслыг эвдлэх, эрдэмтэй тустайд атаархах, буяны үйлийг доройтуулах хэмээн санаж, тэдгээрээс сэтгэлээ буйд байлгаж, шунахгүй байх учиртай.

Магтаал тэргүүтэн намайг алгасруулах
Тэгснээр уйдан, эвдэрч болох
Эрдэмтэн хүнд атаархах болоод
Хотол чуулган бүхнээ эвдлэн үйлдэх хэмээжээ.

3" Тиймээс тэдгээрийг хорихдоо баясах: Тиймээс харин миний магтаал, яруу алдар, олз хүндлэлийг минь доройтуулагч бол, намайг муу заяанд одохоос хамгаалагч, шуналын хүлээсийг таслагч, зовлонд учрахын үүдийг хаагч бурханы адистит адил мөн хэмээн санаж, зүрхний мухраас уур хилэнгээ хорихоор баясаж үйлдээрэй.

Тиймд миний магтаал сайшаалыг минь
Эвдэхээр дөтлөн ойртогч алин тэдгээр
Харин намайг муу заяанд унахаас
Сахин хамгаалахаар орших бус уу

Би гэдэг нирвааныг чухалчлах учир
Олз хүндлэлийн хүлээс хэрэгггүй
Алин намайг хүлээснээс гэтэлгэгч
Түүнээ би юунд хилэгнэнэ вэ

Зовлонд орохыг хүсэгч намайг
Бурханы адистит адилаар
Үл унагах хаалт үүд болсон
Түүнээ би яахин уурсана вэ хэмээжээ.

б' Басамжлал тэргүүтэн гурвыг үйлдэхэд үл тэсэхүйг хорих. Сэтгэл бол биет биш учраас, бусдууд шууд хорлож чадахгүй. Биед бодитой хорлол ирж, түүгээр дамжин сэтгэлд хорлол ирэх болохоор басамжлах зэрэг чинь шууд биеийг хорлож чадахгүй. Ингэхээр бие, сэтгэл хоёуланг хорлохгүй учир баясах учиртай гээд сэтгэл зовохоо болих мөн. Түүнийг эвдвээс уур төрөхгүй болой. Тэр талаар:

Сэтгэл биет бус тул
Хэн ч, хаана ч дарж үл чадах
Биедээ илт шунасанаар
Биеийн зовлон намайг хорлох

Басамжлах ба ширүүн үгийг хэлэх
Яруу бусын тэр үгээр
Биенээ хорлол болох зүйлгүй тул
Сэтгэлдээ та юунд ихэд уурлах хэмээжээ.

Шарава гэгээнээс: "Хамлунба, Ниусурва, Давба гурав анхандаа чихэнд нь юу ч айлтгасан хад чулуунд хэлсэн адилаар явахдаа их амгалантай байжээ. Хожим тэд хүний үгээр явах болсноор амаргүй болсон гэдэг. Шэндон гэгээнд, "Энэ ингэж, тэр чингэж гэхэд, хаандаа ч нууцхан ингэж шивнээ биз дээ. Гэхдээ та нар хов жив зөөвөл наминчилж байгаарай" гэсэн гэдэг. Бас Налжорва Шаравдоржид, "Хүмүүс багшийн дэргэдийн шавь биднийг дэндүү алмай хойрго гэх юм" гэхэд "хэлж байгаагийн гол нь, хүний нь хэлснээс бус өөр юу байх билээ, хов жив ярихаа турхирч таслахтун" хэмээх сэлтийг айлджээ. "Басамжлах нөгөө хүмүүс, намайг гомдоож байгаа учраас, би гомдох хэрэгтэй биз дээ?" хэмээвээс "Бусад надад гомдсон болохоор, намайг хорлох нь зөв байх л даа. Чингэснээр надад юу ч өөрчлөгдөхгүй тул, гомдохоо тэвчих буюу.

Бусад хүмүүс надад үл баясах
Тэгээд энэ нас болоод хойд насанд ч
Намайг идэж эс үйлдэх учраас
Би юунд тэднийг үл орхино хэмээжээ.

"Гомдлоо гээд надад хорлол ирэхгүй. Гэсэн ч түүндээ шүтэж, олз олоход минь саад зэтгэр болох тул, басамжлах, муушаах, яруу бусаар өгүүлэхэд нь уурлах нь зохистой буюу?" гэвэл "Хэдий олз оловч түүнийгээ орхих хэрэгтэй болдог. Тэр олз чинь уур хилэнгийн нүгэл дагаж ирсэн болохоор олз биш шүү дээ. Ийм олзгүйгээр түргэн үхэх ба буруу амьжиргаагаар өнөд амьдрах хоёрын түрүүч сайн биз ээ. Олз олж, урт удаан амьдравч үхэхээс хэтрэхгүй учир, мөнх бусын жамыг дагах л хэрэгтэй болно.

Үхэхийн цагт урьд нь зуун жил жаргал эдэлсэн ба, нэг жил жаргал эдэлсэн хоёр адилхан. Хоёулаа дурдан санахын орон төдийд барагдана. Тэр цагт жаргал зовлонгийн ялгаа юу ч байхгүй. Үлгэрлэвээс, зүүдэнд зуун жил жаргал амсах ба агшин төдийд жаргал амссан хоёр нь, сэрэхийн цагт зовлон, жаргалын ялгаа юу ч байхгүйтэй адил. Тэр мэтийг санаж олз хүндлэлд шунахаас буцаж, яруу бусыг өгүүлэх зэрэгт сэтгэлээ зовоохоо болих мөн. Бусдын нигуурт өөрийгээ илүү мэтээр бүтээхээр чухалчлахаа огоорох ба, илүүтэй сайныг бүтээхгүй учраас сэтгэл зовох явдал гарахгүй.

Энэ талаар:

Олзны зэтгэр болох учир гээд
Хэрвээ эдгээрийг би эс хүсвээс
Өөрийн олзоо ч энд орхих болсноор
Хилэнц нүгэл л баттай орших буюу

Миний өнөөдөр үхэх нь амар биз
Буруу амьжиргаагаар өнөд амьдрах учиргүй
Над мэт нь өнөд удаан оршлоо ч гэсэн
Үхэхийн зовлон тэр ямагт мөн

Зүүдэндээ зуун жилийн жаргал эдлэвч
Сэрэхийн цагт ямар байдаг билээ
Заримдаа агшин төдий жаргал эдлэвч
Сэрэхийн цагт ямар байх билээ

Сэрж босоход тэр хоёулангийн
Жаргал тэр нь ч эргэж ирэхгүйн адил
Урт, богино наслах хоёр байлаа ч
Үхэхийн цагт тэр адил барагдах

Их олон олз ашиг олж
Өнө удаан жаргалыг эдлэвч
Хулгайчид булаагдсан адилаар
Гар хоосон гуйлгачин шиг буцдаг шүү хэмээжээ.

/б/ Хорлолд үйлдэх бэлтгэл ажилд үл баясах ба доройтоход нь үл баясахыг хорих нь: Амьтны тус амгаланг бүтээхийн тухайд бодь сэтгэлийг төрүүлчихээд, амьтан өөрөө жаргал олсонд нь уурлах ба, хамаг амьтныг бурхан болгоно гэж амлачихаад тэдэнд өчүүхэн төдий олз хүндлэл ирэхэд нь сэтгэл таагүй байдаг чинь машид харшлах болно хэмээгээд, бусдын алив учралд ч атаархахаа тэвчиж, сэтгэлийн мухраас баярлаж баясах хэрэгтэй. Эс чингэвээс бодь сэтгэлт болох ба амьтны тус амгаланг бүтээнэ гэдэг нь нэр төдий болчихно шүү.

Хамаг амьтныг жаргалтай болгоно гэж
Бодийн дээд сэтгэлийг үүсгэчихээд
Өөрөө жаргалаа олоод ирэхэд нь
Юунд амьтанд уурлан хилэгнэнэ вэ

Гурван ертөнцийг итгэл бурхан болгохоор
Амьтан хүний хүсэл юу байна гэчихээд
Хэсэг бусаг олз хишиг юухны нь харахаараа
Юуны тулд тэдэнд шаналана вэ

Анагаах алинаа анагаах учиртай та бээр,
Өгөх юмаа та өгөх ёстой та бээр,
Харин амраг садан амьжиргаа юугаа олоход
Үл баясаж, жич уурлах юуных вэ

Амьтанд таагүй, дургүй байсан юм бол
Бурхан болгоно гэж юунд хүсээ вэ
Бусдын алив сайн учралд уурлах түүнээ
Бодь сэтгэл хаанаас төрөх вэ

Хэрвээ тэрээр, түүнээс авсан олз болон
Өглөгийн эзэн гэрт байгаа юмс
Алин бүгдийг танд байхгүйгээс хойш
Өгсөн, өгөөгүй хэмээж (атаархаж-орч.) юу хийх вэ хэмээжээ.

Дайсан доройтоход баясах ба эвдрээсэй хэмээн муу санах тэр төдийгээр, дайсанд хорлол хүргэхгүй харин өөрт зовлон болж барагдана. Хорлов гэхэд өвөр, бусдыг гутаах алдаа гэм гарах учиртайг л санаж үргэлжид буцаах мөн.

Хэрвээ дайсан нэгнээ уурлав гэхэд
Түүнээс танд жаргалтай юу болов
Та сэтгэлээр баярлах төдий болсон бол
Түүнийг хорлохын үндэс гарахгүй

Таны хүслээр зовлон тэр бүтэвч
Танд юуны баясгалан ирэх билээ
Хэрвээ шатсугай хэмээн бодвоос
Түүнээс илүү гутамшиг хаана байх

Нисваанисын загасчины талбих
Гох дэгээ тэр элэгдэшгүй маш хурц
Түүнд баригдсан сэтгэлийн "тамын бумбандаа" ч
Тамын сахиусан бээр намайг шатаах нь магадтай хэмээжээ.

Тэр мэтээр өөрөө өөрийнхөө буяны садны хүсэлд тотгорлох ба үл хүсэх зүгийг бүтээж, өөрийн дайсны хотол чуулган сайн сайхныг үргэлжид үзэн ядахын үүднээс хандваас сэтгэлийн амгалангүй болж, түүнээс цаашлаад уур хилэн буцлах болно. Үргэлжид үзэн ядахаас буцвал сэтгэлийн зовлон харих бөгөөд түүнийг буцаавaас уур хилэн төрөхгүй болно. Иймд дээр өгүүлсэн учир шалтгааны үүднээс тэдгээрийг байнга үзэн ядах бодлыг буцааж, олон талаас нь уур хилэнгээ хорьж үйлдэх буюу. Эс чингэвээс маш их гэм буруу гарна.

Хорих увдисын хувьд, дээр үзүүлсэн бодисадва нарын арга ухаан болон өөрийнхөө нисваанистай тэмцэж, амыг дотогш нь эргүүлэх буюу дайсны дээд болсон уур хилэнгээ няцаах эдгээр ёсон билээ. Тиймд тус тус шинжлэх билгээр сайтар шинжилж, учир шалтгааны олон талаас хорьж чадваас, уур хилэнгийн дотоод олон язгуур учгууд эвдэрч, олон талаас тэсвэр төрнө. Үнэн зөв эш номын утгыг хиргүй ухаанаар шинжиж олсон, ухаарлын язгуураас төрсөн, бясалгалаар нотлогдсон туршлага мөн тул машид баттай авьяас болно. Тус тус шинжлэх билгээр ажиглах бясалгалыг орхих болвоос, тэдгээр зэргийн бодисадвын агуу их явдлыг огоорсон болох тул өөрийн болоод бусдын чөлөө учралын шимийг авах явдалд ханьцашгүй тотгор болно гэж ухаарч хор адил тэвчээрэй.

/2/ Зовлонг ая зөнд нь авах тэсэхүйг төрүүлэхэд гурав:

/а/ Зовлонг ая зөнд магадтай авах хэрэгтэйн шалтгаан

/б/ Түүнийг төрүүлэх арга

/в/ Суурийн үүднээс дэлгэр номнох болой.

/а/ Зовлонг ая зөнд магадтай авах хэрэгтэйн шалтгаан:

"Бодичарияаватара"-д:

Амгалангийн шалтгаан ганц нэг
Зовлонгийн шалтгаан олон төрөх

хэмээн айлдсан мэт, бидэнд аливаа зовлон болох шалтгаан үргэлжид гарна. Харин түүнийг мөрд хөтлөхийн (эрдэмд урвуулан бясалгах-орч.) ухаан байхгүй гэж үзэж болохгүй. Хэрэв тийн бус бөгөөс тэр бээр *"Суртгаалын хураангуй"*-д айлдсан мэтээр, дахин уур гарахад дахин мөр бясалгах гэхээр зориг шантрах тул буян бүтээхэд саад зэтгэр гарна. Тэгээд ч зарим зовлонг бусдаас үйлдэх ч бий. Зарим нь аль нэг зам мөрд хичээсэн,

хичээгээгүй ялгалгүй урьдын үйлээр үүсэх ч байна. Зарим нь дээр номносон мэт буяны ажилд орсноор төрөх ба ороогүй бол гараагүй ч байна. Тэр мэт урьдын үйл болоод даруйдын шалтгааны эрхээр магадтай төрсөн тэдгээр түр нэг буцах байвч түүнийг зөнд нь авах хэрэгтэй. Тэгэхгүй бол язгуурын зовлон түүний дээр өөрийн атгагаар үүдсэн сэтгэлийн сэмрэх зовлон нэмэгдэж машид тэсэхэд бэрхтэй болдог.

Зөнд нь авбаас зовлонгийн суурь орхигдож, буцаж гарахгүй, түүнийг бодсон энэлгээт сэтгэлийг үүдэх сэмрэх сэтгэлийн зовлон ашид гарахгүй. Бусад зовлон ч мөрд хөтлөх арга болдог тул их зовлонгоо бага болгон тэсвэрлэж чадах болно. Тиймд зовлон зөнд авах тэсвэрийг төрүүлэх нь аньс ихтэй болно.

/б/ Түүнийг төрүүлэх арга:

1' Зовлон гарахад ерөөс баясахгүй байхыг хориглох

2' Зовлонг зөнд нь авах зохистойг үзүүлэх

1' Зовлон гарахад ерөөс баясахгүй байхыг хориглох: Зовлон бол дахин засрах учраас, сэтгэл зовох хэрэггүй. Огт засрахгүй юм бол сэтгэл зовоод ч тусгүй тул ямар ч хэрэг тус байхгүй харин гэм ч болох юм. Бааш ихэдвэл зовлон бага ч тэсэхэд бэрхтэй болно. Бааш бага шиг байвал зовлон их ч тэсэж давж чаддагтай адил.

Хэрвээ засрах аваас
Түүнээ зовохын хэрэг юун
Хэрвээ засрахгүй аваас
Түүнээ зовоод юу туслах хэмээсэн ба,

Халуун, хүйтэн, хур бороо, салхи шуурга
Өвчин, зовлон, хүлэх, зодуулах зэрэгт
Тэсэж эс үйлдэх би
Тэр мэт үйлдсэнээр л хорлол аривжих хэмээжээ.

2' Зовлонг зөнд нь авах зохистойг үзүүлэхэд гурав:

а' Зовлон өөрийн эрдмийг санах

б' Зовлон бэрхийг давагч тэсвэрийн тус эрдэм

в' Багаас нь дадуулбал үл зовохын ёс болой.

а' Зовлон өөрийн эрдмийг санахад тав: Таван эрдэмт бөгөөд энэ мэт зовлон байхгүй бол түүнээс магад гарахын хүсэл үл төрөх тул, тонилохуйд сэтгэл татагдах эрдэм, зовлон гарахад сагсууран өндөр гэж боддог омог дээрэнгүй арилдаг эрдэм, зовлонгийн хатуу амсуурга амсаад ирэхээр энэ чинь нүглээс гарч байгааг ч мэдээд үрийг үл хүсэх улмаар уг үндэсээс буцах хэрэг гарах учир энэ нүглээс цээрлэх эрдэм, зовлонгоор энэлээд ирэхээр амгалан жаргалыг хүсэх болно. Тэр жаргал хэрэгтэй учир үндэс шалтгаан болсон буяныг бүтээх хэрэгтэй учир буян бүтээхэд баясах эрдэм, өөрийн зовлонгоор жишээд бусад амьтан ч энэ мэт зовлонтой болой хэмээгээд орчлонд тэнэгч нарт энэрэн нигүүлсэх сэтгэл төрөх болно. Тэдгээр өөрт магадтай байгаагаар жишээд өөрөө ч бусад эрдмийг мэдэж, энэ зовлон гэдэг хүсэх орон болно гэж дахин дахин ухаандаа судлаад

Зовлон үгүй болвоос магад тонилох үгүй
Тиймд ухаант та баттай бясалга хэмээсэн ба,

Бас дахин зовлонгийн эрдэм нь
Уйдсанаар дээрэнгүйг арилган үйлдэх
Орчлонд оршигчоо нигүүлсэхүй төрөх
Нүглээс цээрлэн, буянд баясах хэмээжээ.

б' Зовлон бэрхийг давагч тэсвэрийн тус эрдэмд хоёр:

1" Нирваан тэргүүтэн их тус эрдэмтэйг санах
2" Хэмжээлшгүй зовлонг буцаах тус эрдмийг санах

1" Нирваан тэргүүтэн их тус эрдэмтэй санах: Бид өмнө нь орчлонд эргэлдэхийн цагт хэрэг багатай, өчүүхэн хүслийн тухайд зовлон үүдэхийг мэдсэн хэдий ч олон зовлонг үл тоомсорлох ба хожим нь хэмжээлшгүй зовлон амсахын уг болсон хэрэггүй олон зовлонг зөнд нь авч байжээ. Эдүгээ ч өвөр бусдын тус амгаланг хэмжээлшгүй бүтээх буянаа орохыг мэдсэн тул урьдаас зуу зуун сая живаа тоогоор илүү их зовлонг зөнд нь авах зохистой болох тул тэр бага зэргийг хэлээд яах вэ хэмээн дахин дахин ухаандаа бататгаарай. *"Бодичарияаватара"*- гаас :

Хүслийн хэрэгт шатаалгах зэргээр
Тамд зуун мянгантаа амссан ч
Би бээр өөрийн тус болоод
Бусдын тусад ч юу ч үйлдсэнгүй

Энэ нь тэр төдий хорлол үгүй
Их хэргийг ч бүтээх тул
Амьтны хорлолыг арилгагч зовлонд
Зөвхөн баярлан үйлдвээс зохистой хэмээн айлдсан мэт.

Өмнө нь өвөр, бусдын тус алиныг ч бүтээгээгүй хатуужил бэрхшээл төдий чинээ үйлдсэнээ санаж, эдүгээ их хэргийг бүтээхийн тулд юунд үл тэснэ вэ. Тиймд зовлон байхад тэр мэтээр ажил байгаа тул би ч сайн олз оллоо хэмээгээд сэтгэл урамшуулан магтах хэрэгтэй.

Мөн буяны садан дээдсийг хуураад хэрэггүй дэмий буруу замд ч гурван үзүүрт жад баригчийг тахих, таван голыг шүтэх зэргийн хатуужил бэрхшээлд тэсэх ба ертөнцийн чухал хэрэггүй хэргийн тухайд тариалангийн үйл, арилжаа наймаа, дайн байлдаан зэрэг олон зовлонд тэсэж чадсанаа санаж, хатуужил бэрхшээлээс айж бүү үйлдээрэй.

2" Хэмжээлшгүй зовлонг буцаахын тус эрдмийг санах: Алагдах байсан хүнийг, гарын хуруу төдийг таслах зэргээр алахаас гэтэлгэж явуулахад хичнээн их баярлахтай адил хүний өчүүхэн төдий зовлон бэрхшээл ялангуяа, там тэргүүтний муу заяаны зовлонг ашид буцаах чадалтай машид сайн болой хэмээн даруйдын болоод өнө холын хоёр зовлонгийн ялгааг сайтар санаж, хатуужил бэрхшээлээс үл айхын чин зоригийг төрүүлэх мөн.

Алагдах байсан хүний гарыг таслах төдий
Тэгээд тавьчихвал баярлахгүй гэж үү
Тийнхүү хүний зовлонгоо барж
Тамаас хагацаваас сайнгүй гэж үү хэмээжээ.

в' Багаас нь дагуулбал үл зовохын ёсон:

Дадуулваас хялбар бус болох
Бодит тэр алин ч үгүй
Тиймд өчүүхэн хорлогд дадваас
Их хорлолд ч тэсэж чадах

хэмээн айлдсан мэт зовлонг зөнд авахын хөө хуягийг өмсөөд зовлон бага зэрэгтэй холилдуулан (ээлжлэн) үйлдвээс зовлонг зөнд нь авахын хүч дэлгэрэх болно. *"Суртгаалын хураангуй"*-д: "Эхлээд бага зовлонд

дадсаар, бэрх болоод машид бэрхтэйд дадаж сурна. Үлгэрлэвээс, дадсаны эрхээр амьтан бүхний зовлон ч амгалант хэмээхийн хуран мэдсэн тэрчлэн, зовлон гарах бүхнээ амгалант хур мэдлээр агуулан дадуулваас амгалант хур мэдэлд ойртуулан бататга" хэмээжээ.

Тэдгээр ирэхэд *"Дагшулжан айлтгасан судар"*-т: "Модны хөвөнгийн навч мэт сэтгэл лүгээ хагацаж үйлд" хэмээсэн ба *"Модон байгуулах судар"*-т: "Охин! Чи хамаг нисваанис бүгдийг дарахын тулд чадахад бэрхтэй сэтгэлийг үүсгэж үйлд" хэмээсэн мэт сэтгэл машид баттай байлгах чин зоригийг хэрэгтэй тул хөнгөн сэтгэлээр ирэхгүй болно.

Тиймд эхлээд чин зоригоо багасгалгүй үйлдвээс их зовлон ч нөхөр дор одох болно. Үлгэрлэвээс, зарим баатар дайнд орохдоо өөрийн цусыг (шунх) үзээд түүгээр зориг зүрх орохын шалтгаан болдогтой адил болой. Анхнаасаа энэ мэтийг сонсоогүй бөгөөд сонссон ч тэр мэтийг ирэхгүй гээд өөрийгөө басамжлан үзвээс бага зовлон ч замаас буцахын шалтгаан болно. Үлгэрлэвээс,

Урьд нь зарим эх бусдын цусыг үзээд
Чичрэн ухарч оддог шиг
Зарим баатар өөрийн цусыг үзээд
Баатар зориг үлэмж төрөх бий

Зарим нь бусдын цусыг үзэвч
Чичрэн муужрах ч бий
Энэ сэтгэлийн ир хүч болоод
Урьдын ёсноос урвасан мөн хэмээн айлдсан мэт.

/в/ Суурийн үүднээс дэлгэрэнгүй номнох:

Зовлон гарахад зөнд нь авах хэрэгтэй болвоос юунаас гарсан зовлонг зөнд нь авах хэмээвээс, түүнээ найм:

1' Орноо шүтэх нь. Номын хувцас, хоол хүнс, ор дэр, суудал, өвчнийг анагаах эм, эд хэрэглэл эдгээр нь ариун явдал арвижихын орон болно. Тэдгээр муу болоод бага зэргийг олох, чинадаас үл биширэх ба өнгө удаан холдуулах, өгөхдөө үл бясалгах, сэтгэл тасрахгүй ба тэдгээрээс гарах зовлонт зөнд авах болой.

2' Ертөнц номонд шүтэх нь. Үл олох, үл алдарших, муушаагдах, зовлонт болох, аймшигтайгаар барагдах, өтлөх, өвдөх, үхэх, жам зэргээс

айгаад үхэх есөн зүйл ертөнцийн ном мөн. Эдгээр бүгдэд нижгээд нижээдээр шүтэх зовлонг тус тус шинжээд зөнд нь авах болой.

3' Явдал мөрийг шүтэх нь. Явах, босох, суух, хэвтэх нь явдлын дөрвөн мөр мөн. Тэдгээрийн анхдугаар, гутгаар сүүдрээр шөнөд сэтгэл (төвдвөөс) судалваас түүнээс гарах зовлонг зөнд авах ба цаг бусаар ширээ, жижиг ширээний буюу үндэс дэвссэн навчин дэвсгэр дээр цээжээрээ таглан бүү үйлд.

4' Номыг огоот барихад шүтэх нь. Чухаг дээд гурвыг тахих, өргөн хүндлэн үйлдэх, багшийг тахин үйлдэх, номыг барих, барьсан номоо бусдад ихэд заах, сан, магтаалыг амандаа үйлдэх, ганцаар аглагт суух, сайтар санах, егүзэрт сэтгэлээ одуулсанаар амарлингүй сэтгэл үлэмж ухаан хоёрыг бясалгах зэрэг номыг баригч долоо болой. Тэдгээрт хичээхүйд зовлон гарваас зөнд нь авах болой.

5' Гуйлгачингийн амьжиргааг шүтэх нь. Үс сахлаа ургуулах зэргээр зүсээ муухай болгох ба ноорхой өнгө муут хувцсыг өмсөх; ертөнцийн явдал бүхнээс буцан өөр ёсоор амьдрах; тариалан эрхлэхээ болиод бусдаас хишиг гуйн амьдрах буюу бусдаас харгалзан амьдрагч болох; олз ашгийг хураан эдлэхгүйгээр хэзээ үхэх хүртэл бусдаас ном, хувцас зэргийг эрэлцэх; ариун бус явдлыг тэвчин хэзээ үхэхийг хүртэл хүслийн ажлаас буцах; бүжиг дуу, инээдэм наргиан зэргийг орхиж хамаатан, садан, энхрий хайрт найз нөхөд лүгээ цэнгэн зугаацах явдлыг огоорон хэзээ үхэхийг хүртэл хүний баясал цэнгэлээс холдох зэрэг гуйлгачины долоон амьжиргаа болой. Тэдгээрээс гарсан зовлонг зөнд нь авах болой.

6' Илт хичнээн алжаалыг шүтэх нь. Буяны зүгт хичээн бие болоод сэтгэлийн алжаал хямралаас үүдэн гарсан зовлон зүдгүүрийг зөнд нь авах болой.

7' Амьтны тусыг үйлдэхэд шүтэх нь. Үйлдэх арван нэгэн тус буй бөгөөд түүний зовлонг хүлээн авах болой.

8' Даруйдаа ажлыг шүтэх нь. Бадар аяга болоод номын хувцасны үйл тэргүүтэн машид гарсан (хувраг), нүгэлгүй тариалангийн үйл, худалдаа, хаанд алба гувчуур өргөх амьжиргаа зэрэг гэргийтний зуурдын ажил болон түүнээс гарсан зовлонг зөнд нь авах болой.

Тэр мэтийн найман сууринаас гарсан зовлон алин ч гарлаа тус тусын хичээлийг орхилгүй бодь хутаг лугаа оруулбаас, буцаж тотгор гарахгүй бөгөөд сэтгэлийн зовлонгүйгээр орох мөн.

/3/ Номыг магадлах сэтгэлийн тэсвэр: Сүсэглэх орон нь найм буюу. "Бишрэх орон" нь чухаг дээд гурвын эрдэм болой. "Илт үйлдэх орон" нь хоёр би-үгүйн тэр ямагт чанар болой. "Хүсэх орон" нь бурхан болоод бодисадва нарын их хүч буюу илт мэдлийн хүч, зургаан барамидын хүч лүгээ хамт төрсөн гурван хүч болой. "Авч, орхихын орон" нь сайн явдал болоод муу явдлын үндэс, тэдгээрийн үрийг хүсэх, эс хүсэхийн хоёрыг ялгах болой. "Бясалгах орон" нь олох утга бодь хутаг ба түүнийг олж үйлдэгч арга бодисадвын суртгаалын мөр бүгд тэрхүү хоёрыг үйлдэх болой. "Сонсох, санах бээр даган бүтээх орон" нь мэдэгдэхүүний явдлын орон, тэрхүү мөнх бус тэргүүтэн болно гэж Долүнба гэгээн болгоожээ.

"Хүчний язгуурын бүлэг"-т "Арван хоёр эрхэм зарлиг тэргүүтэн дээдийн номыг найм гэж айлдсан тул тэр адилыг үйлдэх хэрэгтэй" хэмээсэн буюу. Сүсэглэх ёсны хувьд тэдгээр орныг хэрхэн мөн байгаа ёсыг танин мэдэж, зохилдуулан барих ба дахин дахин санах, зовлонг зөнд авах ба номыг магадлах сэтгэлийн хоёр зүйлт, найман аймагт гэж "Бодийн газар"-аас айлдсанаар байгуулав. Ялангуяа энэхүү номыг магадлах сэтгэлийн талаар дэлгэрэнгүй үзэгдэнэ.

г/ Түүнийг бүтээхээр хэрхэн үйлдэх хэмээвээс, аль нэг тэсвэрийг бүтээв ч, зургаан дээд төгөлдөр буюу зургаан барамидтай гүйцээж бүтээх мөн. Бусдыг тэсвэрт байгуулснаар тэсвэрт өглөг болох зэргээр бусад нь дээр номносон лугаа адил болой.

д/ Тэдгээрийн утгыг хураангуй: Явдлын шүтээн бодь сэтгэлийг дурдан санаж бясалгах нь хамаг амьтныг цувирал барагдсан тэсвэрт байгуулах хүслийн үндэс болно. Түүнийг дээш аривжуулж, дээд газрын тэсвэрүүдийг ерөөлийн оронд үйлдэж судлана. Үйлийг анхдагчийн тэсвэрийн суртгаалудыг тусгайлан бодолдоо агуулж, ёсчлон түүнээ суралцах ба хэрхэн номносон хязгаараас хэтэрвэл, жич засахаар хичээх хэрэгтэй болно.

Тэдгээрийг анхааран авахын үест, ясал орхивоос амлашгүй их нүглүүд олноор үргэлжид халдах ба бусад төрөлд ч бодисадвын сонин гайхамшигт явдлыг анхааран авахад маш бэрхтэй болох учир зам мөрийн дээд аньс гэж үзээд, хүч чадлаар одооноос эхлэн бүтээж, бүтээж чадаагүйгээ санаж бодвоос *"Лагсангийн айлтгасан судар"*-аас айлдсан мэт, багахан бэрхшээл, багахан хатуужлаар тэсвэрийн чинадад төгс хүрч чадах болно.

4/ Хичээхүйн чинад хүрэхүйд (барамид) суралцахад таван зүйл:

а/ Хичээхүйн (хичээнгүй) мөн чанар
б/ Түүнийг бясалгахаар орох арга
в/ Хичээхүйн тийн ялгал
г/ Бүтээхийн үест хэрхэн үйлдэх
д/ Тэдгээрийн утгын хураангуй

а/ Хичээхүйн мөн чанар:

Зоригдол болох буяныг (зөв сайн зүйл) бодож, түүнээ илтээр дурших (цацрах) байдалт болой. *"Бодичарияаватара"*-гаас: "Хичээхүй бол буянд дурших болой" хэмээжээ. *"Бодийн газар"*-аас: "Буяныг бүтээх ба амьтны тусыг үйлдэхийн тулд зөв юманд сэтгэлээ илтээр цацруулах ба түүгээр өдөөгдөж гурван үүдний үйл хөдлөх" гэж номножээ.

б/ Түүнийг бясалгахаар орох арга:

Хичээхүйг туурвихын тус эрдэм болон эс туурвихын гэм бурууг олонтаа санаж, тэднээ дадаж сурваас хичээнгүй сэтгэлийг төрүүлэх болно. Түүний тус эрдмийн талаар *"Улэмж шаардахуй судар"*-аас:

Хамаг зовлон, мунхаг бүхнийг арилгах
Муу заяаг бүрэн таягдахын суурь болсон
Бурхад бүгдээр "хичээхүйг үлэмж" хэмээн сайшаасан
Алин түүннийг үргэлжид шүтээрэй

Энэ ертөнцөд урласан юу бүхэн
Ертөнцөөс нөгчигсөнд урласан юу бүхнээ
Хичээж шамдваас олдохгүй гэж байхгүй тул
Мэргэд хэн бээр хичээхийн чадлаас уйдах билээ

Алин заларсан бурхан бодисадва тэд нар
Балартаж унтахыг гэмтэй гэж болгоогоод
Үргэлжид хичээж туурвин явах
Үүнийг л би та бүхнээс айлтган шаардах буюу хэмээсэн ба,

"Судрын аймгийн чимэг"-ээс:

Буяны чуулганы дотроос хичээхүй эрхэм
Энэ мэт түүнээ шүтэж дараах эрдмийг олох

Хичээснээр даруйд амгалангийн дээд орон ба
Ертөнц болон ертөнцөөс нөгчигсөнд багтах эрдэм төрөх

Хичээснээр орчлонгийн хүссэн эрдмээ олох
Хичээснээр машид ариусан боловсрох
Хичээснээр эвдрэх чуулган үзлээс гэтлэх
Хичээснээр гэгээрхүйн дээд бурханы хутаг хүрэх хэмээсэн ба,

Төгөлдөр хичээнгүй тэрээр эд баялагаар үл хоосрох
Төгөлдөр хичээнгүй тэрээр нисваанист үл ялагдах
Төгөлдөр хичээнгүй тэрээр уйтгарт үл дарагдах
Төгөлдөр хичээнгүй тэрээр (эрдэм) оллоо гээд үл ханах хэмээсэн ба,

"Бодийн газар"-аас: "Иймийн учир, бодисадвын ном буян тэдгээрийг үнэхээр бүтээх гол үндэс буюу эрхэм дээд нь зөвхөн хичээнгүй мөн. Бусад тэр адил биш тул, ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутгийг олж үйлдэгч болой хэмээн түүнчлэн заларсан бурхад бээр үзүүлжээ" хэмээсэн ба,

"Барамидын хураангуй"-гаас:

Огт уйсалгүй нөр их хичээж шамдваас
Олохгүй бүтэхгүй зүйл гэж ердөө ч үгүй хэмээсэн ба,
Хүмүүн бус бүгдээр түүний тустайд баясах
Бясалгал дияан бүхнийг олох буюу

Өдөр, шөнө бүхнийг үр ашигтай өнгөрөөх
Эрдэм чуулсан тул доошлох гэж үгүй
Хүмүүний номоос хутагтын ном хүртэлх утгууд
Удвал цэцэг шиг улам дээш дэлгэрэх хэмээжээ.

Гэм буруугийн талаар: *"Лодойжамцын айлтгасан судар"*-аас:

Залхуу нэгнээ бодь хутаг холоос хол, маш хол буюу
Залхуу түүнээ өглөгөөс билиг хүртэл үгүй буюу
Залхуу түүнээ бусдын тус гэж байхгүй дээ хэмээсэн ба

"Чухал дурдан санах судар"-аас:

Нисваанис тэдний нэгэн суур нь
Залхуу болохоос өөр юу байх
Хаана залхуу байна
Тэнд л ном бүхэн үгүй мөн

хэмээн айлдсан мэтээр, хичээж шамдалгүй, залхуугийн эрхэнд орвол цагаан зүгийн ном бүхнээр хоосорч, амьтны орон үес, эцэс хойдын тус амгаланг бүтээх хамаг үйл ажил доройтох болно.

в/ Хичээхүйн тийн ялгалд хоёр:

/1/ Бодит тийн ялгал

/2/ Хичээнгүйг төрүүлэх арга

/1/ Бодит тийн ялгалд гурав:

/а/ Хөө хуягийн хичээхүй

/б/ Буяны номыг хураах хичээхүй

/в/ Амьтны тусыг үйлдэх хичээхүй

/а/ Хөө хуягийн хичээхүй:

Бодисадва нар хичээхүйг туурвихдаа урьдаас бэлтгэж чин хатуу зориг эрмэлзлэл буюу хөө хуяг адилын санааг өмсдөг. Ганцхан амьтны зовлонгоос ангижруулах буюу улмаар зөвхөн тамд суугаад бурхан болгохын тухайд ч, би бээр их мянган галвын энтэй тэнцэх буяныг нэг өдөр хураах ба тоолшгүй гурван их галвын буянаа зуун буман живаа дахин их болгож хураахын төлөө дурлан тэмүүлж, туулсан бодь хутгийн төлөө хичээж шамдана. Нэгэнт хичээж орсноос хойш түүнийгээ үл орхих бөгөөд цагийн эн түүнээс богино хугацаанд машид их зовлонгоо багасгахын төлөө зүтгэхийг хэлээд яах вэ хэмээх энэ бүхэн нь хөө хуягийн хичээхүй болой.

Аливаа бодисадвад энэ адилын хичээл шамдалд сүслэх, бишрэх төдий нэг төрснөөр, улам хичээл зүтгэл нь баттай болж, ханьцашгүй бодийн тухайд хэмжээлшгүй ихээр хичээхийн үндсийг тэвээрүүлэхэд ийм хичээхүйтэй төгөлдөр байх учиртайг хэлээд яах вэ Тэр байхад бодь хутаг болоод бусдын төлөө хатуужил бэрхшээл шаардах, сэтгэл мохох, шантрах явдал ерөөс гарахгүйг *"Бодийн газар"*-аас айлджээ. Энэ адилын сэтгэлийг дадуулж чадваас, их хөлгөний язгуурын чадал магадтай сэргэхийн үндэс гарах учир судлаарай.

"Барамидын хураангуй"-гаас:

Урьд, хойд орчлонгийн хязгаартай эн тэнцэх
Өнө их урт удаан өдөр, шөнөд
Тэр адилыг хураасаар жил болох цагийн уртад
Галвын тоот далайн усны дуслын тоогоор

Бодийн дээд сэтгэл нэгэн төрөх буюу
Тэр адилын байдлаар
Бусад буян нижгээд нижгээдийг
Бүтээх шаардлага гарсан ч, нигүүслэлээр үл уйсаж

Бодийн дээдийг хойш суулгүйгээр бүтээх ба
Орчлонд эргэх өөрийн зовлондоо сэтгэл үл төвдөж
Баттай хөө хуягийг цаглашгүй эгүүсгэвээс
Их нигүүлсэхүйн авирт баатрын ёс журмыг
Үнэхээр авсан анхлагч гэж өгүүлэх буюу

хэмээн айлдсан нь хөө хуягийн хичээнгүй болно. Мөн орчлонгийн тэргүүлшгүй цагаас аваад эдүгээ хүртэлхийг нэг хоног гээд, гучин хоногоо нэг сар, тэрхүү арван хоёр сарыг нэг жил болгож, түүнийгээ нэг зуун мянган жил болгоход нэг бодь сэтгэл төрөх ба зөвхөн нэг бурханыг үзэхийн тулд, тэр адилын Ганга мөрний элсний тоотой сацуу нэгнээр, нэг амьтны сэтгэл болоод явдлыг жишиж мэдэх болно.

Энэ мэтээр хамаг амьтны сэтгэл болоод явдлыг мэдэх шаардлагатай байсан ч, үл шантрах хөө хуягтын хөө хуяг нь хэзээ ч барагдахгүй байна хэмээн *"Лодой Мэсадва айлтгасан"*- аас зарлиг болсон учир ханьцашгүй нь хөө хуяг энэ болой.

Товчилвоос, энэ адилын сэтгэл нижгээдийг үүсгэж чадваас, хэмжээлшгүй буяныг амар хялбар хураах ба тоолшгүй түйтгэрийг арилгахын няцашгүй эрхэм шалтгаан болж, хичнээн өнө удаан хугацаанд баясан хичээх тэр чинээгээр, гэгээрэх хутагийг түргэн олно. Хэмжээлшгүй явдал мөрд болон урт удаан хугацаанд зүтгэж чармайгаагүй хэрнээ маш түргэн хугацаанд бурхан болохыг хүсэх нь бурханаас машид холдож байгаа хэрэг бөгөөд, бодисадва нарын гайхамшигтай чин зориг сэтгэл төрөхөд болдог шүү. Энэ адилын хөө хуягийг өмсөөд алив хэргийн тухайд хичээнгүйлэн туурвихад хоёр зүйл буй.

/б/ Буян номыг хураах хичээхүй: Зургаан барамидыг үнэхээр бүтээхийн төлөө хичээж шамдах болой.

/в/ Амьтны тусыг бүтээх хичээхүй: Арван нэгэн тус хэргийг бүтээхийн төлөө зүтгэж хичээх үйл бөлгөө.

/2/ Хичээхүйг төрүүлэх арга:

Дээр номносон мэт хоёр чуулганы буяны ном төрөх, орших, аривжих бүгд үүнээ харгалзах учир түүнийг төрүүлэхэд анхаарах нь чухал болно. Их мэргэн бүтээлчин Шантидэва гэгээний шастар нь ухаарахад хялбар, судлахад амар, бүрэн төгөлдөр нэгэн тул түүний ёсоор өгүүлж үйлдсү.

Түүнээ дөрөв:

/а/ Хичээхүйн тотгор буюу харшлах шалтгааныг тэвчих

/б/ Зохилдох шалтгаан буюу өмөг буяны чуулганыг хураах

/в/ Эл хоёр түшиж хичээхүйг ая зөнд нь бүтээх

/г/ Түүнээ шүтэж бие, сэтгэлээ эдлэхүүн (эзэмших) болгох ёсон

/а/ Хичээхүйн тотгор буюу харшлах шалтгааныг тэвчихэд хоёр:

1' Үл зохилдох зүгийг танин мэдэх

2' Түүнийг тэвчихийн аргыг үзүүлэх

1' Үл зохилдох зүгийг танин мэдэхэд:

Зам мөрд орохгүй болгох хоёр зүйл буй. Үүнд, *а' бүтээх чадал байвч орохгүй байх ба, б' би энэ мэтийг яаж чадах гэж шантарч орохгүй байх болой*. Бүтээж чадах, эс чадахаа ч мэдэхгүйгээс шамдахгүй явдал байх ч, энэ үест нирвааныг чухалчлах явдлыг номнож байгаа тул тэр үе биш болой.

а' Бүтээх чадал байвч орохгүй байхад хоёр: 1" *Одоохондоо чөлөө зав байна гээд хойш тавих залхуу болон 2" туймгүй ч, муу ажил болон эгэл бэртэгчингийн үйлд шунаж сүрд дарагдах хоёр болой.* Тэр талаар *"Бодичарияаватара"*-гаас:

Түүний үл зохилдох зүйлийг номнож үйлдсү
Мууд шунах залхуу ба
Хойш суух, өөрийгөө дорд үзэх болой хэмээжээ.

1" Залхуу төрөх үндэс нь: Амар аажуурах болоод таарууxан идээний амтанд шунах ба нойрны амгаланд автах, орчлонгоос үл уйдах зэрэг болно.

Аажуу тайвны амтнаа согтуурах ба
Нойрсож унтахын шуналд автагдахаас

Орчлонгийн зовлонгоос ч үл уйдах зэргээс
Залхуу хойрго шадар төрөх мөн хэмээжээ.

Заримууд эхний хоёр мөрөөр ямар байдлаас төрөхийг үзүүлсэн хэмээдэг.

Түүнийг тэвчихийн аргыг шүтэхэд гурав ба, үүнээс хойш сааруулагч залхууг хориход гурав буюу, Олсон энэ бие түргэн эвдрэх, үхсэний дараа муу заяанд унах, дахин сайн төрлийг олоход бэрхтэй гурвыг бясалгаад чөлөө цаг байна гэх залхууг хорин чөлөө завгүй гэдэг ухааныг сэтгэлд төрүүлэх болой. Эл гурвыг дээр бага төрөлхтний үест номносон буй.

2" Муу ажилд дурлахыг хориглох нь: Дээдийн ном гэдэг энэ болоод хойдын хэмжээлшгүй баясгалан амгалан гарахын үндэс мөн. Хэрэггүй дэмий балайг чалчих, онгирох, хөөрөх зэрэг алгасрал зэрэг нь түүний их хэрэг тусыг доройтуулдаг ба хойшдоо хэрэг тусгүй элдэв зовлонг төрүүлэхийн орон гэж үзээд тэдгээрт сурч дадах явдлыг хорих мөн.

Хязгааргүй баясгалангийн үндэс
Дээд номд баясахаа бүр тэвчиж
Зовлонгийн үндэс болсон тийн алгасрал лугаа
Хөөрсөн онгиргон тэргүүнээ сэтгэл юунд баясна вэ

Хойргоших ба өөрийгөө дорд үзэхийг хорих. Тэр мэт хойш тавих ба муу ажилд шунахаа хорьж, дээдийн номноо дур, эрмэлзлэл төрөх авч, түүгээр зогсолгүй их хөлгөнөө суралцах хэрэгтэй байтал түүнийг над шиг амьтан яаж бүтээж чадах хэмээн мятрах сэтгэлийг арилгаж үйлдээрэй.

2' Түүнийг тэвчихийн аргыг үзүүлэх (*Хойргоших ба өөрийгөө дорд үзэхийг хорих*) **гурав:**

а' Олох зүйлдээ хойргошихийг хорих
б' Түүнийг олохын арганаа хойргошихыг хорих
в' Хаана оршивч бүтээхийн орноос мятрахыг хорих

а' Олох зүйлдээ хойргошихийг хорих: Ологдохуун бурхан маань хамаг гэм бурууг дарсан, хамаг эрдэм бүгдийг төгссөн нэгэн билээ. Би гэдэг, ганц нэг гэмээ хорих ба ганц хоёр эрдэм сурахдаа ихэд бэрхшээж үзэх тул, над мэт тэр адилын үрийг олно гэж хаанаас байх вэ хэмээн

лавтайяа шантарвал, бодь сэтгэлээ алдах хүртэлх гэм алдаа их гарна. Чингэвч эхнээс нь түүний хязгаарыг хорих хэрэгтэй. Хорих ёсны хувьд, бурхан болвоос, үнэн болоод үнэмлэхүйг айлдагч, худал хуурмагийг үл өгүүлэгч шалгадаг төрөлхтөн билээ. Тэрбээр зөгий хүртэл бурхан болж болно гэж айлдсан байхад, би чинь хүн болж сайн төрлийг авсан авч орхихыг шинжлэх ухааны хүч байгаа тул хичээл шамдлаа орхихгүй аваас, олохгүй зүйл гэж хаана байх хэмээн нөрдөн магтах буюу.

Миний бурхан болох хаанаас хэмээн
Хойш сууж залхууралгүйгээр
Энэ мэтээр амгалан залрагсад бээр
Үнэнийг айлдах тул энэ айлдсан нь үнэн буюу

Зөгий, хөхтүрүү, шумуул ба
Тэрчлэн хорхой, шавьж алин
Тэд нарч хичээхүй хүчийг үүсгэвээс
Олоход бэрхтэй ханцашгүй бодь хутгийг олох

Миний адил хүний язгуурт төрөөд
Тус ба усыг танин мэдэх
Бодийн явдлыг эс орхивоос
Бодийг үл олох гэж хаанаас байх би хэмээжээ.

Мөн урьд бурхан болсон, буюу өнгөрсөн, эдүгээ бурхан болж буй, ирээдүйд бурхан болох тэдгээр ч анхнаасаа бурхан байж байгаад мөрийг бүтээж байгаа бус. Бидний ижил нэгэн байж байгаад дээш дээш ахиулан дэвшүүлсээр бурхан болсон тул болж болно гэж үзээд шантрах явдлаа хорих учиртай.

"Чухаг дээдийн үүлэн"-д: "Бодисадва нар аа, энэ мэтээр тэрчлэн заларсан дайснаа дарсан үнэхээр тугуулсан бурхан болчихсон алин, үнэхээр туулсан бурхан тэдгээр, алин үнэхээр туулсан бурхан болох гэж буй тэдгээр ч ёс энэ адил, мөр энэ адил, хичээнгүй энэ адилаар илт туулсан бурхан болном зэ. Илт туулсан бурхад, илт туулсан бурхан бологсод, илт туулсан бурхан болохоор дөхөгсөд" хэмээхээс, "бурхад тэдгээр ч зөвхөн бурхан болчихоод, илт туулсан бурханы хутагт хүрч байгаа бус. Юу боловч би, ханьцашгүй үнэхээр туулсан бодь буюу, илт тугуулсан бурхан болохоор хамаг амьтантай нийтээр хичээх болоод хамаг амьтнаа зорисон хичээл

шамдлаар, би ч тэр адилаар хичээн шамдах болой" хэмээжээ.

"Цаглашгүй эрдмийн магтаал"-аас:

Хэн нэг заримууд бээр, бурханы хутгийг олсон тэд ч
Машид муушаагдах орон үест унах буюу хэмээх вий
Түүний тухайд та доройтох газар унахын үест өөрийгээ дорд бүү үз
Өөрийг муушааж үл болох, идэр ард шантарч үйлдэж магад хэмээжээ.

Шантрахын хувьд, бурханы эрдэм хэмжээлшгүй бөгөөд үндэс шалтгаан байж гэмээ нь үр гарахын тул, мөрийн үест хэмжээлшгүй эрдмийг бүтээх, хэмжээлшгүй гэм буруугийн үүдийг хорих хэрэгтэй учир зэргийг сайтар ухаарах ба, тэр бүгдийг өөрийнхөө дээр бууж ирэх нь гэж бодоод шантрах мятрах сэтгэл төрдөг байна.

Хэмжээлшгүй бурханы эрдэм тэдгээрийг бясалгахын цагт, эрдмийн нарийн хувийг дан дангаар хөөж, нэг нэгээр босгож бүтээх юм хэмээн мөрийн ухаарлаа нөгөө тийш хандуулбал, одоо шиг шантрал дандаа төрөхгүй. Гэвч энэ сайн шинж бус. Мөрд одох ёсыг магадлалгүй, хагас дутуу ухаарсан болоод өөрөө гарын авлагад аваагүй хэрнээ, хялбархан юм шиг үзэх зэргээр уршигдах болно. Анхаарал бясалгалыг гартаа оруулж, мөрийн эхлэл, төгсгөл бүдүүн, нарийнийг жигдэлсэн гүйцэд бие нижгээдийг заалгавч, тэд хэдий хэрэгтэй ч, хэн чадна хэмээн шууд хориглох үзэгдэнэ.

Шарава гэгээнээс: "Гарын авлага болгоогүй бодисадва нь, харвах сум ониндоо зөв орсон бол буцалтгүй одох мэт ном бүхнийг сайтар гүйцээх өөрийн эрхгүй тул, явдал мөр бүхнээсээ шантарч буцах ба өөрийгөө басамжлах цагт юманд хүрнэ гэж байхгүй. Сайтар бүрдүүлж чадваас үл шантрах, доорд үзэх явдал буруудаж, машид муушаагдах мөн" хэмээжээ.

б' Түүнийг олохын арганаа хойргошихыг хорих: Бурханы хутгийг бүтээхэд хөл гар тэргүүтнээ өгөх ёстой гэж сонсоод, тэр мэтээр бие яахин чадах хэмээх тэр төдийн зовлонд тэсвэрлэх хэрэгтэй. Явдал мөрд оролгүй, өөрийн байдгаараа суулаа ч, орчлонд орчиж эргэлдэх зуур, бие махаа таслуулах, цавчуулах, цоолуулах, шатаалгах зэрэг хэлж баршгүй их зовлонг амсаж эдлэсэн ч, өөрийн хэргээ огт бүтээгээгүй байх юм. Бодь хутгийн тухайд хатуужил эдлэж зовох нь дээрх зовлонгийн ганц хувьд ч үл хүрэх бөгөөд харин ч өвөр бусдын тусыг бүтээх их хэрэгт болой.

Гэвч хөл, гар тэргүүтнээ
Өгөх хэрэгтэй гээд би айваас,
Хүнд хөнгөнийг шинжилгүй
Мунхарсаар эвдэрч барагдах би

Сая живаа тоолшгүй галавт
Хичнээн олон дахин таслуулах
Нүхлүүлэх шатаалгах, эвдэрсэн ч
Бодь хутагийг олж эс чадав аа

Миний бодь хутгийг бүтээхээр
Энэ зовлонгийн хэмжээ хэрцэд
Дотроос хатгах хорлолыг арилгахын тул
Биенээ шарх гарах төдийн зовлон юун адил

Эмч бүхэн анагааж үйлдэх тул
Зовлонг минь өвчингүй болгон үйлдэх
Тиймд элдэв олон зовлонгоо дарахын тухайд
Өчүүхэн зовлонд тэсэн үйлд хэмээжээ.

Биеэ өгөхдөө эхнээсээ айж өгөх бус. Аажим аажим өгч сурсаар, өөрийн биенээ шунахаа болих мөн. Их нигүүлсэхүйн сэтгэлийн хүч бүрэн гүйцэд болох цагт их тустай болох ба өгөх цаг ирэхэд ямар ч бэрхшээлгүй болно.

Эглийн анагаах засал энэ адилд
Их эмчилгээ шаардалагагүй бөгөөд
Машид зөөлөн арга заслаар
Хэмжээлшгүй их өвчинг ч анагаан зохиох

Зутан тэргүүтнийг өгөх өглөгт
Эхлээд бурхад сурсан гэдэг
Түүнээс хойш өгч дадсаар хожим
Зэрэгчлэн өөрийн махаа өгсөн буюу

Алин өөрийн биедээ
Зутан мэтийн ухааныг төрүүлснээр
Тэр цагт мах цусаа өгөх
Түүнээ бэрхшээл гэж юу байх хэмээжээ.

Тийм учир заримууд амь биеэ өгөх нь гээд их хөлгөнөөс жийрхэх ба, үйлдэхэд бэрхтэй хэцүү мөр гээд энэ номноос ихэд цээрлэх нь үзэгдэнэ. Үйлдэхэд бэрхтэй мэдрэмж төрөхөд, эн тавилгүйгээр, зутан зэргийг өгөх зэрэг машид хялбараас өгч сурах хэрэгтэй шүү.

в' Хаана оршивч бүтээхийн орноос мятрахыг хорих. Хаана ч байсан мөрийг бүтээх орноо шантрах явдлыг хорих буюу. Бурхан бүтээх гэдэг орчлонд хэмжээлшгүй олон төрлийг авч байж бүтэх ёстой аж.

Тэр зуур орчлонгийн зовлонд хорлогдох тул, тэр адилыг яаж бүтээх вэ гэвэл, Бодисадва бээр, нүглээ барахын тулд, "үндэс болсон нүглээс буцсан тул, үр болсон зовлонгийн амсуурга үл гарна" гээд, "ертөнц гэдэг мөн чанараас бүтээгүй илбэ мэт гэх ухаан баттай төрснөөр, "сэтгэлд зовлонгүй болж, бие сэтгэл амгалангаар дэлгэрэх болсноор, орчлонд оршсон ч ядрах уйдахын явдал гарахгүй" гэж санах мөн.

Хилэнц арилсан тул зовлон үгүй
Мэргэн болсон тул зовох юмгүй
Энэ мэт буруу онох ба
Нүглээр бие, сэтгэлээ хорлох

Буянаар бие жаргалтай
Бусдын тусад орчлонд оршивч
Зөвхөн нигүүлсэлт тул
Юунд уйдах вэ хэмээсэн ба

Тиймд алжаал уйсал бүхнийг арилгагч
Бодь сэтгэлийн морийг унаад
Амгалангаас амгалантайд одох
Сэтгэлийг танихад хэн хойрогшин суух вэ хэмээжээ.

Тийнхүү хэмжээлшгүй их удаан хугацаагаар эргэлдэвч, сэтгэлээр шантарч бүү үйлд. Урт удаан байлаа гэх уйдахын шалтгаан бус болой. Энэ мэт зовлон хүнд хэцүү, их байгаад хугацаа нь богино байвч уйддаг. Зовлонгүй удаан жаргавч уйдахгүй байдаг шүү дээ.*"Их эрдэнийн эрхи"*-ээс:

Зовлон ирэхэд хугацаа богино ч
Өнөд удаан тэсэхэд бэрхтэйг хэлээд яах

Зовлон үгүй жаргалтай байхад
Хэмжээлшгүй цаг байгаад ч юуг ч хорлох

Түүнээ биеийн зовлон үгүй бол
Сэтгэлийн зовлон хаанаас байх
Тэр л нигүүслээр ертөнцийн зовлонд
Тэр ямагтаар өнө суух

Тиймд бурхан өнө хол хэмээн
Ухаантан нар юунд хойш суух
Гэм арилсан мэргэд амьтны тусад
Үүний төлөө үргэлжид шамдаж үйлдэх хэмээжээ.

Мөн бурхан болоход хэмжээлшгүй буяныг хураах хэрэгтэй. Энэ машид бэрхтэй тул хаанаас чадах хэмээн шантрахын хэрэггүй. Тухайлан үйлдэх хамаг амьтны тухайд, олох учиртай бурханы хэмжээлшгүй эрдмийг олохоор сэтгэл өдөөгдөж хэмжээлшгүй их цагт оршино гэж бодоод, хэмжээлшгүй их буяныг бүтээх болой хэмээн тангарагыг сахиж, нойр хоол, бусад зүйлд сэтгэл алгасралгүй, огторгуйн эн сацуу буяныг тангараг барих тэр хүртэл, үргэлж хураах тул хэмжээлшгүй их буяныг төгс хураахад бэрхгүй болно. Дээрхи шастараас:

Зүг бүхнээ орших огторгуй сацуу
Шороо, ус болоод гал, хий
Хэрхэн хэмжээлшгүй адил
Зовлон амгалан хэмжээлшгүй буй

Хэмжээлшгүй амьтан тэдгээр нь
Бодисадвын их нигүүслээр
Тэдгээрийг зовлонгоос татаж гарахад
Бурханы хутагт байгуулсан түүгээр

Тэр мэт батад оршигч тэр
Хэвтэх, эс хэвтэх алинд ч
Үнэхээр барин авах ба
Сэрэмжгүй байсан ч амьтан бүгд

Хэмжээлшгүй тул, амьтан тэр адил
Хэмжээлшгүй буяныг үргэлжид хураах

Хэмжээлшгүй тэр адил бурхан ямагтыг
Хэмжээлшгүйг олох бэрхгүй хэмээгээд

Алив хэмжээлшгүй цагаас орших
Хэмжээлшгүй амьтны тусад
Хэмжээлшгүй бодийг хүсэн
Хэмжээлшгүй буяныг үйлдэх

Тэр бүх хутаг хэмжээлшгүй ч
Хэмжээлшгүй дөрвөн зүйлийн
Буянаар өнө их удалгүй
Ягаад ч гэсэн эс олох билээ хэмээжээ.

Тиймд асар хүчтэй асрахуй, нигүүлсэхүй бодь сэтгэлээр сэтгэл санаа хөдлөж, амьтны тусад богинохон хугацаанд олсугай хэмээвэл машид гайхамшигт болно. Тэдгээрт зүглээгүй үест цаг хугацаа маш урт, хэмжээлшгүй их ажил явдалд суралцах шаардлагатай, олон төрлийн хатуу бэрхшээлийг туулах хэрэгтэй юм байна гэцгээж, тийн болвоос хэн чадах хэмээлдэж ойр дөт зам олохор хэлцдэг. Гэвч чингэх нь ерөөхийн бодь сэтгэл төрөхөд далдуур хорлох ба орохуйн бодь сэтгэлд шууд хорлоно. Их хөлгөний язгуурын чадлыг машид доош одуулваас бурхан болох гэдэг машид удаашрана. Бодь сэтгэлийн хүчийг машид дээшитгэн дээшитгэн үйлдэх учиртай бурханы тааллыг, Нагаржунай, Асанга гэгээдээс нотлон сайтар буулгасантай харшлах билээ. Тэр мэт шантран хойш сууваас хэнд ч туслахгүй тул, хэдий шантрахаар явдал ирэвч, бодь хутгийг бүтээх аргыг сайтар ухаж, оюун ухаанаа урамшуулан магтваас хэрэг бүтэж гарт ирэх буюу. *"Төрлийн цадиг"*-аас:

Шантарвал үгээгүйгээс гэтлэхэд үл туслах
Тиймд гаслангаас зүрх шимширч үйлдэлгүй
Тус хэргийг бүтээх мэргэдийг шүтвээс
Машид бэрхтэй ч хялбар гэтлэх болно

Тиймд айж зовж үйлдэлгүй
Алив болох аргаар хэргээ бүтээх
Мэргэдийн бат сүр жавхлангаар урамшин магтваас
Хэрэг зориг бүхэн бүтэж гарт орох буй хэмээжээ.

Агуу их явдалд суралцах ёсыг сайтар ойлгож шантрахгүй байх, хэсэг бусаг эрдэм сурсандаа ханаж мэдэхгүй байх хоёр төгөлдөр нэгэн байх хэрэгтэй гэж Асанга гэгээн олонтаа зарлиглажээ. Эдүгээ үед тааруухан ганц нэг эрдэм юмуу, билэг чанарт эрдэм байлаа ч, ганц нэг зүгийн төдий нэгэн төрөхөд, мөрийн эрдмээр их газрыг таслав (мэдэв) хэмээж, түүгээр болчихлоо гэлцэнэ.

Мөрийн увдиснаа мэргэжсэн нэгэн бээр, "Эш онол дангаар төрвөөс эрдмийн нэг хувь мөн. Гэвч тэр төдийгээр хаана ч хүрэхгүй" хэмээн тайлбарлажээ. Ухаарал нэгэн гарваас, сэтгэл машид мятран одох үзэгдэх тул, эрдмийн ганц нэг зүгийг барьснаа ханалгүй, ялгаатай илүү дээдийг эрэлцэж, хэмжээлшгүй сургаал номонд суралцах шаардлагатай байтал шантрахгүй байх нь ховор үзэгдэнэ.

/б/ Зохилдох шалтгаан буяны өмөг чуулганыг хураахад дөрөв:

1' Сүсгийн хүч
2' Батдах хүч
3' Баясахын хүч
4' Орхих хүч

1' Сүсгийн хүч: Эрмэлзэх хүсэл нь хичээхүйн шүтээн болно гэж айлдсан учир энэ үест сүсэг гэдэг дуршил эрмэлзлийг илэрхийлжээ. Түүнийг төрүүлэх хэрэг нь:

Би өмнө болоод эдүгээ ч
Номд сүслэхээс хагацсан тул
Энэ мэт үгээгүй нэгэн болсон
Хэн бээр номд сүслэсүгэй

Хамаг буян номын зүгийн
Үндэс нь сүсэг хэмээн
Бурхан зарлиг болов хэмээсэн мэт болой.

Хэрхэн сүсэгтэй болох вэ?

Түүний язгуур болвоос үргэлжид
Тийн боловсролт үрийг бясалгах болой

хэмээн, сэтгэлд зохистой бол зохисгүйгээр төрөх хар, цагаан үйлийн үрийн ёсыг бясалгах явдал гэж номножээ.

Сүсгээр дурших эрмэлзэхийн суурь төрнө гэж айлдсан тул, итгэмжлэх хоёр сэтгэлээр, огоорох ба авах хоёр хүслийг төрүүлнэ. Ерөнхий үйлийн үр ба, ялангуяа бодисадвын явдлын тус эрдэм болон тэдгээрээс хэтрэх гэм эргүүгийн учир шалтгааныг санах мөн. Тухайн үеэс мэдээрэй.

Тэр мэт их хөлгөнд сүжиглэж, түүний үүдээр орсон болвоос өвөр бусдын гэм бүгдийг арилгах бөгөөд хамаг эрдмийг бүтээхээр тангараг тавьдаг. Ганц нэг гэм буруу, муу авьяас зэргийг арилгах ба ганц нэг эрдмийг эцэст нь хүртэл боловсруулж үйлдэхэд л олон галавт сурч дадуулах хэрэгтэй байдаг. Надад тэдгээрийг арилгах, бүтээхийн хичээх шамдал өчүүхэн төдий ч үл үзэгдэх тул, би олсон чөлөө учралаа дэмий өнгөрөөчих вий гэж бодож, өөрөө өөрийгөө шаардах хэрэгтэй.

Өөр болоод бусдын гэм
Хэмжээлшгүй олныг би бээр дарах бөгөөд
Алинд байгаа гэм нижгээд нижгээдийг чү
Зуун галавт барж дуусах бил үү

Гэмээ барахаар хичээж шамдах түүний
Ганц хувь ч надад үл үзэгдэх тул
Хэмжээлшгүй зовлонгийн оронд
Би яахан байна хэмээн зүрх шимшрээд

Өөр болоод бусдын эрдмийг
Машид олныг би бээр бүтээх бөгөөд
Тэдгээрт нижгээд нижгээд эрдмийг ч
Зуун галавт залгуулан чадах

Эрдмийн хувь төдий нэгийг ч өөртөө би
Хэзээ ч дадуулж төрүүлээгүй бөгөөд
Арай хийж, олж авсан төрлөө
Ашиггүй дэмий үйлдвээс гайхамшигтай гэж үү би хэмээжээ.

2' Батдах хүч: Алин хичээж туурвих түүнээсээ, буцалгүй эцэс туйлд нь хүргэх болой. Тиймд анхнаас нь, болох болохгүйг сайтар шинжиж, чадах болвоос орох мөн. Эс чадваас үл орох ба, орчихоод завсарт нь орхисноос, анхнаасаа туурвихгүй байх нь дээд мөн. Түүний шалтгаан нь, тангаргаа завсарт нь орхихгүй байх, орхиж сурваас, бусад төрөлд ч түүний үндэс зохилдсон шалтгаанаар, авсан тангаргаа орхих тохиолдоно. Энэ насанд

ч нүгэл арвижих ба бусад төрөлд ч түүний үр болох зовсон нь арвижина. Өмнөхөө хиймээр бодовч, бусад буян нь үл бүтнэ. Өмнөх зүйлээсээ буцсан тул, түүний үр доройтож ба өмнөх нь эцэстээ хүрээгүй тул, төгс гүйцэд бүтэхгүй болно.

Товчлон хэлвэл, алин үйлдэхээр тангарагласан түүний толгой нь үл гарах буюу эхлэл нь тавигдахгүй бол бусад зүйлийг бүтээхийн тотгор болж, үндэс зохилдож авсан санваар тангараг ч суларна. Тиймийн тулд:

Эхлээд ажлаа шинжиж үзээд
Туурвих буюу эс туурвихаа шийдэх
Эс туурвих аваас дээд мөн
Туурвиваас буцаж бүү үйлд

Бусад төрөлдөө түүнийг дадуулах буюу
Эсвээс зөвхөн нүгэл аривжих мөн
Бусад үр боловсрох цаг нь ч
Уруудах бөгөөд тэгээд үл бүтэх мөн хэмээжээ.

Тиймийн тулд тангаргаа эцэст нь хүргэхийг хүсвээс гурван омгийг бясалгаж үйлдэх буюу.

Үйл болоод нисваанис, чадалт
Гурвууланд нь омгийг үйлдэх хэмээжээ.

Үйлийн омог нь: Бусад хэнд ч миний зам мөрийг бүтээх нөхрийн горьдлого тавилгүйгээр зөвхөн өөрөө бүтээх мөн. Би ганцаар үйлдэнэ хэмээгч, энэ нь үйлийн омог ямагт хэмээжээ. *"Садангийн захидал"*-д:

Тонилох гэдэг нададхаргалзах тул
Бусадтай нөхөрлөн үйлдэнэ гэж хаана ч үгүй хэмээсэн болой.

Энэ нь бусдаас горьдолгүй, зөвхөн өөрөө бүтээнэ хэмээсэн омог лугаа адил энд багтаасан болой.

Чадлын омог нь: Амьтан бүхэн нисваанисын эрхэнд байснаар өөрийн тусаа бүтээж чадах байтугай, бусдын тусыг ч үл бүтээж, эс чадахыг хэлээд юу хийх. Өвөр, бусдын тусыг би бүтээж чадна гэж бүтээх хэрэгтэй.

Нисваанист баригдаж эрхгүй болсон энэ ертөнцөд
Өөрийн тусаа бүтээхийн чадалгүй тул

Бусад амьтан нар ч чадалгүй
Тиймд би л үүнийг үйлдэж чадна хэмээжээ.

Мөн тэд нар муу үйлд хичнээж шамдсаар байхад, гайхамшигт сайн үйлийг би юунд үл бүтээнэ хэмээн санаж бүтээх мөн.

Бусдад дордын үйлийг үйлдсээр байхад
Юунд би зүгээр сууна хэмээжээ.

Гэхдээ энэ хоёрыг бүтээхэд бусдыг доромжлоод, өөрийгээ хөөргөн бүтээх бусаа.. Нигүүлсэхүйн сэтгэлээр үзэж, омог лугаа нийлүүлэлгүй үйлдэх учиртай.

Омог гаргаж үүнийг үл үйлдэн
Өөртөө омоггүй байх нь дээд хэмээжээ.

Бусдууд чадахгүй, би чадна гэдэг нь омог лугаа байдаг зохилдонгүй тул омог гэж нэрийджээ.

Нисваанисын омог нь: Нисваанисыг үргэлжид дорд үзэж, тэдгээрийг би ялна, тэд намайг хэзээ ч ялахгүй хэмээн бурууг ялах ухааны баатар зоригийг төрүүлэх явдал мөн.

Би бүгдийг ялан дийлэх хэмээх ба
Баатар зоригийг төрүүлэх явдал мөн
Би бүгдийг ялан дийлэх ба
Хэн ч намайг үл ялах

Ялгуугсан арслангийн хөвгүүн би бээр
Энэ л омогт орших үйлдсү хэмээжээ.

Тэр мэт үйлдэлгүй шантарваас өчүүхэн төдий бэрхшээл саад гарахад ялагдахад хүрнэ.

Үхсэн могойтой учрахдаа
Болжмор бээр, гарьд адил авирлах
Хэрэв би дорой үзэгдэх аваас
Хир өчүүхэн алдаа ч хорлож үйлдэх
Үлбэрэн шантарч шамдлаа орхивоос
Үгээгүйгээ ядуугаас гэтлэнэ гэж үү дээ

Шарава гэгээнээс: "Номоо орхисон жаргал гэдэг түрүүчийн жаргалаас илүү юу ч үгүй. Өнөөдөр номоо орхино гэдэг хойшдоо хязгааргүй зовлон эдлэх хэрэгтэй болохыг сана. Өөрөө шамдаж, хичээж эс үйлдвээс нисваанист эзлэгдэж, нигүүлсэхүйг үл үзнэ. Ерөндөг байвч, та бясалгаж чадаагүй тул өөрсдөө гүйцээж үйлдэх ёстой гээд үл ирнэ. Бурхан бодисадва нар ч аварч чадахгүй" хэмээжээ. Дээр өгүүлсэн омог тэдгээрийг бясалгаваас их саад бэрхшээл гарсан ч зэтгэрлэж чадахгүй. Тиймд тэдгээр омгийг бясалгах шаардлагатайг:

Омгийг хичээн үйлдвээс
Их байлаа ч, чадагдахад бэрх
Чингээд сэтгэл бат болсноор
Алдаа эндлийг дарж үйлдэх хэмээжээ.

Чингэхгүйгээр бүтээлчин маань алдаа эндэлдээ ялагдчихвал, гурван орны нисваанисыг ялна гэсэн хүсэл нь мэргэдийн ичгүүр, сонжуурын орон болно биз дээ. "Алдаа эндэлдээ ялагдаваас, гурван орныг дийлэх миний хүсэл инээдэм наадам болно биз" хэмээжээ. Тийнхүү нисваанисаа доромжилж дарахыг хүсэх сэтгэлийг нисваанисын омог хэмээн нэрийджээ. Тайлбар номлол зохиогчид үүнтэй адилгүйгээр номлосон байж болно. Гол ном шастарт түрүүчийнхээр болгоосон юмуу даа. Тэр мэтээр бусдаас горьдохоо болиод ганц өөрөө үйлдэх ёстойг ухаарах хэрэгтэй.

Бас ч бусдууд минийх шиг хийж чадахгүй. Өөрөө чадна гэж тангараг тавь. Тэр мэтээр үзэн бүтээхийн цагт нисваанисыг гадагш дарах, дотогш хэзээ ч дийлдэхгүйн ухааныг баттай олоод тангараглах завсар орхихын гэм бурууг сана. Сайтар ажиглан, алин үйлдэхээр тангарагласан бүхнээ туйлд хүргэхийн төлөө ухаанаа баттай болох хүртэл судалж үйлдээрэй.

3' Баясах хүч: Тэр мэт хүчтэй эрмэлзэх зоригт сүсгийн хүчээр төрөөгүй байгаа хичээхүйг төрүүлэх, төрснийг үл буцаахын үндсийг баттай болгогч хүч буюу омгийг бүтээхээр анхлан орохын цагаас баясгалантай орох ба, орсон үедээ ч энэ үйлээ үргэлжлүүлэн таслахгүй байхын хүслээр үл ханах сэтгэл нь баясгалангийн хүч болох учир түүнийг төрүүлж үйлдэх болой.

Түүнээ үл ханахын ёсыг төрүүлэх гэдэг:

Тоглоом наадмын жаргалант үрийг хүсэх мэт

Үгээр үйлдсэн алин үйл мөн
Тэрхүү үйлд л шимтээд
Тэр үйлээр ханалгүй баясаж үйлд хэмээсэн мэт.

Нялхас тоглоом наадгайд улайран шимтэх адилын ухаан төрүүлэхээр шамдах хэрэгтэй. Амгалан жаргалтай үед үл ханахтай адилаар, түүний үндэс болох үйлнээ ч үл ханах ёстой. Эгэл ардууд жаргалтай үр гарах, гарахгүйд тээнэгэлзсэн хирнээ шамдан ордог. Учир нь ямар үйлийг үйлдвээс жаргал гарах вэ гэдгийг магадлахын эрмэлзлэл байдаггүй тул

Жаргахын төлөө үйлийг үйлдэх ч
Жаргал бололгүй барагдах байна
Жаргал болох алив үйлийг
Тэрээр үл үйлдэх тул юунд жаргах вэ хэмээжээ.

Эл учир шалтгаан төдийгээр ханах нь зохисгүй.

Хутганы ирнээ тогтсон зөгийн бал адил
Хүсэл шуналд эс цадах атал
Үр жимс нь амгалан нирваан болдог
Буяны сэтгэлд бид юунд ханана вэ хэмээсэн мэт.

Тансаг сайхан чихэрлэг амтыг өчүүхэн төдий амсуулах учиртай ч, долоовол хэл хэрчих хурц тонгоргоны ирнээ тогтсон зөгийн бал шиг даруйдаа өчүүхэн жаргал цэнгэл байвч, энэ хойдод хүнд хэцүү зовлонг авчрах, сэтгэлдээ зохисгүй хүслийн таван эрдмийг эдлэхдээ сэтгэл ханахгүй байдаг.

Алин амлашгүй нүгэл болдоггүй, зуурдын болоод ашдын хамаг амгаланг хайрлагч бурханы чуулганд юунд ханах хэмээн сэтгэж, үл ханахын сэтгэлийг төрүүлж үйлдээрэй. Тиймд хаана ч орсон буяны үйлээ төгс төгөлдөр болгохын тулд тэдгээрт орвоос, наранд халсан их заан үд дундын үед сэтгэлд таатай линхуат нууранд орох адилын ухаан төрөхийг хүртэл судлан үйлд.

Тэр адил төгс туйлд хүрнэхээр
Үд дундын үест энэлсэн
Их заан нууранд чинь очиж умбах мэт
Тэр л үйлдээ шамдан орсугай хэмээжээ.

4' Орхихын хүч: Хичээн шамдсанаар бие, сэтгэл ядардаг. Тиймд түр нэг амсхийж алжаалаа тайлах хэрэгтэй. Хэрэв чингэхгүй бол машид уйдан, залхах ба хойшдоо хичээн чармайхад саад учирч болно. Алжаал тайлагдсан даруйд хичээн шамдах хэрэгтэй. Урьдын ажлаа эцэст хүргээд тэр төдийгээр ханан мэдэлгүй, дээд бусдыг үйлдэхээр хичээн шамдах хэрэгтэй.

Хүч доройтох лугаа даган барилдваас
Дараа үйлдэхийг орхин үйлдсүгэй
Сайтар гүйцээгээд дараа болтол
Дараа хийхээр түүнээ орхин үйлд хэмээжээ.

Энэ нь үүнийгээ хойш тавих бол хэрэгтэй. Эхлээд нэг дор бүгдийг мэднэ гэвэл дээш дээш ялгарах эрдмийг олоход их тотгор болдог мөн. Тиймд хэтэрхий хүчлэн зүтгэх буюу хичээл шамдлаа хэтэрхий чангалах, эсвэл хэтэрхий сулруулах хоёрыг тэвчээд, усны үргэлжлэл адилаар хичээх шаардлага нь хичээнгүйг туурвихын ёсон болно. Балданхол бээр:

Үлэмж ялгааг үйлдэхээр
Та хэтэрхий сулруулж бүү үйлд
Тиймд дээд ялгамжааг олохдоо
Эхний зэрэг лүгээ ялгаж бүү үйлд хэмээжээ.

Бодава гэгээн бээр: Үлгэрлэвээс, "Өт хорхой зогсолгүй аажуу аажуу мөлхсөөр нүхэндээ хүрдэг. Нохой бөөс том том харайн буувч хүрч чадахгүйтэй адил" хэмээжээ.

/в/ Эл хоёр түшиж хичээхүйг ая зөнд нь бүтээх

Тэр мэтээр хичээнгүйн гурван харшлах шалтгааныг танин барьж, ерөндөгийг шүтэж, үл доройтохын зохилдох шалтгаан болсон сүсэг ба, орчихсон хойно үл буцахын үндсийг бататгах, хэдий үйлийг эхэлсэн ч залгамжлааг таслахгүйг хүсэх баясгалант хүчийг төрүүлэн, орхихын хүчээр хичээнгүйг туурвих ёсноо мэргэжин чадваас хичээнгүйг зөнд туурвих хүчийг төрүүлэх шаардлага тавигдах учир түүнийг номносу. Тэвчигдэхүүнийг тэвчигч хичээнгүйг туурвих цагт хэрхэн үйлдэх:

Хуучин дайсан лугаа зэрэгцэн тэмцэлдэхээр
Байлдаан тулаанд сэлмээ сугалах сацуу

Нисваанисыг мэснээс онцгойлон хянан үйлдээд
Нисваанисыг дайсныг хянан шинжил хэмээсэн мэт.

Үлгэрлэвээс, хуучин дайн тулаанд мэргэжсэн мэргэд дайсан сэлмээ далайхын цагт зөвхөн гадаад дайснаа дарахыг тооцдоггүй ч, өөрт мэсийн аюул буухаас онцгойлон анхаардаг байна.

Чинадыг дарах хоёр үйлийг бүтээхийн адил, бүтээлчин (бясалгалч) ч нисваанис лугаа тэмцэхийн үест нисваанисууд дотор сэтгэлд шарх үүсгэхээс сэрэмжлэн, онцгойлон хянах явдал, гаднаас ерөндгийг шүтэн, дарах хоёуланд мэргэжихээр хичээнгүйлэн үйлдэх хэрэгтэй. Тэр мэт бус аваас нисваанисын нэг хувийг ерөндгөөр хаах боловч нөгөө хэсэг нисваанис буяны бусад хувийг булаан авдаг.

Мөн сэтгэлд амлашгүй нүгэл мэдсэнээр хоёул тэнцүү болж, буяны ажлыг хийхэд бэрхтэй болно. Үүнийг үлгэрлэвээс, ном сурахад ухаан хэрэгтэй гээд зөвхөн мэдэх төдийг шинжиж барихыг гол болговол, үл мэдэхийн мунхагийг сонсголонгоор арилгавч, бусад нисваанисыг хянаж чадахгүйд хүрч, тэр завсар олон гэм халдварлан, сэтгэл машид мунахардаг. Мэдэхээс гадна сэтгэлээ номхотгох тун чухал хэмээгээд бясалгалыг гол болгож, мунхагийн дайснаа хянахаа орхивоос ном сонсохоо байж, номонд сурахад орхиход хүрэх ба ам авсан санваар тангаргийг сахих цаазыг орох, буцахын ёсноо машид ихээр мунхран үргэлжид алдаа эндэл гаргах болно.

Тэр мэт нисваанистай байлдахын үест ч, дайн тулааны үест ч гараасаа сэлмээ алдваас алуулах аюулаас тэр даруйд эзлэгдэх мэт. Тэвчих авахын орноо орох, буцахын зоригдол орныг үл мартан санамсаргын (санахуйн) мэсийг алдваас муу заяанд унах аюултай тул тэр даруйд санамсаргыг шүтэх хэрэгтэй.

Дайнд сэлмээ унагаваас
Айн түргэн авдаг адил
Тэр адил санамсаргын мэсээ алдваас
Тамын аюулыг санан түргэн ав хэмээжээ.

Дурдан санах (санамсарга) чухал хэрэгтэй болохыг Нагаржунай гэгээн ч айлдсан бөгөөд:

Вишну (тэнгэр) биенээ багтахыг санаж бурхан бээр
Гагцаар зорчих мөрд ойрхон очихийг үзүүлэв.
Түүнийг хянамгайлан илт сахиж үйлдэх ба
Санамсарга үл доройтуулваас ном бүхэн эвдэрнэ хэмээжээ.

Алив санамсаргад түшилдсэн орон ч гэсэн ухаанаар сайтар ялгагдан санамсаргад баригдсан болно. Санамсарга өөрийн эрхээр орноо ялгахын үндэс байхгүй.

Хэдийгээр ухаанаар ялгах хэрэгтэй ч, ер эрхэм зарлигаас номносон орох буцахын орон бүгд, ялангуяа өөр өөрийн ам авсан санавaарыг авч орхих ном мөн тул тэдгээрийг санамсарга ба, ухамсар хоёр шүтэн байж, бясалгаж төгсгөх мөн. Сэтгэл бодолдоо ганцхан сэжгийг санах, ухамсарлах төдийгээр юунд ч үл хүрнэ. Тиймд тулалдахдаа эхнээсээ л алдахгүйн төлөө шамдах ёстой.

Хэрвээ алдваас тэр даруйд авах нь алах вий гэдэг аюул үг төдий бус, үнэхээр ойлгосны шинж буюу. Мөрийг бясалгагч бээр эхнээсээ авч орхихоо үл мартах санамсаргаа алдахаас сэрэмжлэх ба алдваас тэр даруйд нь авч байгаа нь санамсарга доройтож гэм алдваас эрхээр муу заяанд одох аюулд хүрнэ гэх бодол үг төдий бус, сэтгэлд жинхэнэ ёсоор төрснийг илтгэнэ.

Тэр нь үйлийн үрийг гол болгон санахад харгалзах учир тэдгээрийг гүнзгий увдис хэмээн мэдээгүй бид мэтийн хүмүүст, мөрийн дээд хөл, мэргэд баясах бүтээлийн эрдмийн язгуур хэмээн номножээ. Тэгвэл “Өчүүхэн бага гэмээс айн, үргэлжлэлд оролгүй, тэр даруйд нь хориглох хэрэгтэй биш үү” хэмээвээс, Үлгэрлэвээс: Бие нэгэнт хорт суманд шархлаваас түүнээс болоод удалгүй хамаг биенд хор түгэх учир тэр шархыг авч хаях хэрэгтэйн адил, сэтгэл өчүүхэн төдий гэм буруугаар шархлахад түүнийг эс тоовоос машид түргэн сэтгэлд түгээд багасдаггүй, харин улам ихэддэг тул анхнаас нь халдаахгүй хориглох мөн. Хэрвээ халдваас тэр даруй залгамжааг таслах хэрэгтэй болдог.

Хэрхэн цус шунхнаа харгалзан
Хор биенээ түгэн гүйх
Тэрчлэн чөлөө олдвоос л
Сэтгэлд гэм эргүү түгэх хэмээжээ.

Гэвч нисваанисын тулаанд ялахыг хүсвээс санамсарга ба ухамсарыг ёсчлон шүтнэ хэмээвээс,

Тосоор дүүргэсэн савыг өргүүлэн
Сэлэм тулгаж сөгдүүлэн суулгаад
Хөдөлвөөс алуулахын аюул ирнэ хэмээн айдаг мэт
Ёс журмаар түүнчлэн хяна

хэмээсэн мэт хянах хэрэгтэй бөгөөд үүнийг "Гадяанагаас гарсан лүн"-гээс айлдсаныг мэдээрэй. Тэр мэт хянахын цагт ор гэмт явдал болоод ялангуяа нойр тэргүүтэн, залхуурах уг гарваас зөнд нь тавилгүй, эхнээс нь буцаах ёстой.

Тиймийн учир өвөр дээр могой ирэхэд
Хэрхэн холдуулан босдогийн адил
Нойр залхуу хүрэх аваас
Түргэнээ тэдгээрийг буцааж үйлд хэмээжээ.

Зөвхөн залгамжааг таслах төдий бус, гэм гарахад сэтгэл баярлахгүй байх хэрэгтэй. "Би өмнө нь ч энэ адил байсаар эдүгээ хүртэл орчлонд тэнэв. Ялангуяа бодь сэтгэлийн санваар аваад түүний суртгаалын үл зохилдох зүгт оршвоос машид муушаагдахын орон болно шүү гэж санах ба үүнээс хойш ийм гэм гаргахгүй хэмээн боомтлох өчиг хоёуланг олон дахин талби.

Нижгээд нижгээд гэм гарахад
Намайг муушаах лавтай
Хожим би түүнийг үл гарган
Тэр мэт үйлдэнэ хэмээн өнө сана хэмээжээ.

Тэр мэтийн санамсарга хүчтэй, үргэлж баттай төрөхийн үндэс алив гүнзгийд шамдан үйлдээд, дээдийн буяны садан лугаа нөхөрлөх түүний шалтгааныг олонтаа сонсох зэрэг үйлийг шүтээрэй. Тийн болохыг:

Хэрхэн орон үес эдгээрт
Санамсаргыг дадуулан үйлдэнэ хэмээн
Энэхүү үндэс лүгээ учрах юм уу
Зохилдох үйлийг хүсч үйлд хэмээжээ.

Тэр мэтийг хураангуйлваас, бодисадвын суртгаал авч орхихыг сайтар ялгах сонсголонг үйлдээд, мэдэх ёстой утга учрыг явдал мөр бүхэнд

үргэлжлүүлэн шүтэн хичээнгүйг туурвих хэрэгтэй тул хичээл шамдлаа аривжуулах нь хэрэг ихтэй болно.

/г/ Түүнээ шүтэж бие, сэтгэлээ эдлэхүүн (эзэмших) болгох ёсон

Эрхнээ урвуулах хүч бөгөөд, *"Сэрэмжийн бүлэг"*-т номносон мэт бодисадвын суртгаалд суралцах хэрэгтэй ёс, ам авснаа эс сахиваас машид их гэмтэй тул нисваанисыг дайснаа гэж үзэх ёс, тэр цагт хатуужил бэрхшээлийг үүргэнээ авалгүй, чимэгт үзэгч сэтгэлийн хүчийг үүсгэх ёс зэргийг тэрхүү үйлд орохын өмнө нь бясалгаад, бие сэтгэл буянд үл эдлэгдэх (зорчих) бусармаг үзэгдэл бүхнийг буцаан, бодисадвын явдалд суралцааас ачаа хөнгөрөх болно. "Яагаад ч болов урьд үйлээс гарсан тул, Бүгдэд хүч байх мөн. Тэр мэт сэрэмжийн үрийг санан өөрийн суудлаа хөнгөлж үйлд" хэмээжээ.

Тэр мэтээр шамдаад хичээнгүйг ямар нэг хэмжээгээр төрүүлвээс, модны навч нааш, цааш хийсэх нь салхины эрхээр байдаг адил бие, сэтгэл буянаа эрмэлзэх бат зоригийн эрхэнд орно. Түүнийг даган үйлдвээс хичээнгүй сайтар бүтнэ. Тэр төрвөөс хамаг буяны чуулган гарт хялбар ирнэ. Хэрхэн салхиар одох, ирэх модны навч эрхшээгдэх, Тэр адил эрмэлзлэл зоригоор эрхшээгдэх тул, тэдгээрийг бүтээж болох мөн" хэмээжээ. Тэр мэтээр үйлдэхэд бэрхтэй ч хаялгүйгээр шамдах хэрэгтэй юм. Балдан Махол бээр: "Бэрх хэцүү үйлийг (давалгүйгээр) үйлдэлгүйгээр олоход бэрхтэй хутгийг яахин олох хэмээн, түүний тухайд өөрийгөө болгоомжгүй, хичээнгүйгээр сайтар арвижуул та" хэмээжээ.

г/ Тэдгээрийг бүтээхийн тулд хэрхэн үйлдэх

Алин хичээнгүйг туурвихдаа зургаан дээд лүгээ төгөлдөр үйлдэх буюу зургаан барамид лугаа барилдуулан бүтээх шаардлагатай. Хичээнгүйн өглөг нь өөрөө түүнээ оршоод бусдыг түүнээ байгуулах мөн. Үлдсэн нүгүүдыг өмнө номносон бөлгөө.

д/ Тэдгээрийн утгын хураангуй

Явдлын шүтээн бодь сэтгэлийг даган санаж бясалгахдаа хамаг амьтны хичээнгүйд байгуулахын тусад суралцан шаардах мөн тул түүнийг дээш арвижуулан тавих ба түүнээс цааш дээд газрын хичээнгүйг туурвих

ёсыг ерөөлийн орноо үйлдэн явуулна. Үйлийг анхдагчийн хичээнгүйд суралцах ёс лугаа тааруулан шамдах ба ялангуяа нийт бусын хичээнгүйн тэвчигдэхүүнээс шантрах явдлыг сайтар хориглон, олох бодь хутагт тухайлан зорьж, хамаг амьтны жаргалыг бүтээн, зовлонг арилгах ба машид урт цаг хугацаа, хэмжээлшгүй их буян, цаглашгүй хатуужил бэрхшээлд эрмэлзэн тэмүүлэгч хөө хуягийн хичээнгүй сэтгэлээр өмсөх тэр адилын санааг машид агуу ихээр төрүүлэх төдий агуу их буяныг хураах мөнийг *"Лагсан бээр айлтгасан"*–аас зарлигласан тул шамдан үйлдээрэй.

Тэр адил эс үйлдвээс язгуурын чадал ашид бат үл дэлгэрэх ба олон гэмээр үргэлжид холдон бусад төрөлд ч бодисадын явдалд ихэд сайн суралцахад бэрхтэй болох эдгээрийг санан ёсчлон бясалгаж чадахгүй ч ухаанаар тэр зүгт чиглүүлэн аль чадахаар хичээнгүй туурвин үйлдвээс *"Лагсан бээр айлтгасан"*- аас зарлигласан мэт бусад төрөлдөө бага төвөг бэрхшээлээр зовлонгүй болж хичээнгүй чинадад хүрэхийг айлджээ.



5/ Бясалгалын (самади) чинад хүрэхүйд суралцахад тав:

а/ Бясалгалын мөн чанар
б/ Түүнийг бясалгахаар орох арга
в/ Бясалгалын ялгах
г/ Бүтээхийн үест хэрхэн үйлдэх
д/ Тэдгээрийн утгын хураангуй

а/ Бясалгалын мөн чанар. Бодлого зоригдолоос бусдад үл алгасран оршигч нэгэн үзүүрт буян болно. *"Бодийн газар"*–аас: "Бодисадвын аймаг савыг сонсох, санах өмнө одуулан бодисадва нарын ертөнц болоод ертөнцөөс нөгчигсөн, нэгэн үзүүрт тогтсон буяны сэтгэл буюу амарлингуй болон үлэмж үзэхүй хоёрын зүг, тэр хоёр хослон орох мөр хоёулангийн мөн. Үүнийг бодисадва нарын бясалгалын мөн чанар гэж ухаараарай" хэмээжээ. *"Бодичарияаватара"*–д: "Тэр мэт хичээнгүйг төрүүлээд, сэтгэлээ бясалгалд агуул" хэмээжээ.

б/Түүнийг бясалгахаар орох арга. Бясалгалыг бясалгахын тус эрдэм ба эс бясалгахын гэм эргүүг санахыг амарлингуй сэтгэлийн үест номноно.

в/ Бясалгалын ялгах. Урьд татсан мэт мөн чанарын үүднээс ялгаваас ертөнц болоод ертөнцөөс гэтэлсэн хоёр байна. Зүгийн үүднээс гурав байдаг: а. Чадлын үүднээс ялгаваас энэ наснаа бие, сэтгэлийг амар байлгагч бясалгал, б. Эрдмийг илт бүтээгч бясалгал, в. Амьтны тусыг үйлдэгч бясалгал болой.

/1/. Чадлын үүднээс ялгаваас энэ наснаа бие, сэтгэлийг амар байлгагч бясалгал. Алинаа юуг ч тэгш агуулан бясалгаваас бие, сэтгэлийг машид ариусган үйлдэгч бясалгалууд багтана.

/2/ Эрдмийг илт бүтээгч бясалгал. Зөн мэдэл, тийн тонилохуй, дүүргэх, сүрээр дарах зэрэг Шарвагаг зэрэг нийтийн эрдмийг бүтээгч бясалгалууд байна.

/3/ Амьтны тусыг үйлдэгч бясалгал. Тусыг үйлдэгч арван нэгийн утгыг бүтээгч бясалгал болно.

г/ Бүтээхийн үест хэрхэн үйлдэх. Аливаа буяны бясалгалыг бүтээхдээ зургаан дээд лүгээ төгөлдөр бүтээх буюу зургаан барамид лугаа баригдуулан бүтээнэ. Өөрөө бясалгалд оршин бусдын түүнээ байгуулваас бясалгалын өглөг болно. Бусдыг урд номносон адилаар мэдээрэй.

д/ Тэдгээрийн утгын хураангуй. Явдлын шүтээн бодь сэтгэлийг санан бясалгах нь хамаг амьтныг цувиралтгүй бясалгалд байгуулахын тулд суралцахад шаардах бөгөөд түүнийг баттай болгон арвитгаад дээших бясалгалыг ч ерөөлийн орноо үйлдэн судлах ба бясалгал гүйцээж эс чадваас цаг цагт нэгэн үзүүрт сэтгэлийн адилтгах ба бясалгалд аль чадахаар суралцах хичээл шамдалаа хаяхгүй шамдах хэрэгтэй.

Чингэж эс үйлдвээс суртгаал лугаа харшлах гэмээр түргэн халдах ба бусад төрөлд ч бодисадва нарын бясалгалын олон үүднээс орох суртгаалд суралцахад машид бэрхтэй болох болно. Тэр мэт үйлдвээс энэ насанд ч сэтгэл өөр зүйлд алгасрах өчүүхэн болж одох ба хураасан буян ч хүчтэй болж дараа төрөлдөө *"Лагсан айлтгасан"*- аас зарлигласан мэт бие, сэтгэл амгалан төгөлдөр болсноор бясалгалын чинад хүрэхэд хялбар болно. Үүнийг дэлгэрүүлэн сэтгэл амарлингуйн бүлэгт номнох тул энд дурдсангүй.

6/ Билгийн чинад хүрэхүйд суралцахад тав:

а/ Билиг ухааны мөн чанар
б/ Түүнийг төрүүлэхээр орох арга
в/ Билгийн машид ялгал
г/ Бүтээх үед хэрхэн үйлдэх
д/ Тэдгээрийн утгын хураангуй

а/ Билиг ухааны мөн чанар. Ер билиг ухаан гэдэг шинжлэх /вишай/ орныхоо мөн чанарыг сайтар ялгаж таних үйл юм. Энэ үест ухааны таван орноо мэргэжих зэрэг билиг ухаан багтана. *"Бодийн газар"*-аас: "Хамаг мэдэгдэхүүнээ орох ухаан ба, хамаг мэдэгдэхүүн бүхнээ оршиж, мөн чанарыг тийн ялгаж үйлдэх алин тэр л билиг болой. Ухааны таван орон буюу дотоод ухаан, учир шалтгааны ухаан, тэжээхүйн ухаан, дууны ухаан, урлахуйн ба үйлийн орон зэргийг мэдэхээр зорин орох эдгээрийг бодисадва нарын оюун ухааны мөн чанар мөн гэж мэдээрэй." хэмээжээ. Түүнээ "орохын ухаан" хэмээх нь газрын эрдмийг олоогүйгээс дээшхи ба "орших" нь газрын эрдмийг олсноос хойшхи багтана.

б/ Түүнийг төрүүлэхээр орох арга. Билиг ухааныг төрүүлэхийн тус эрдэм, эс төрүүлэхийн гэм эргүүг санах мөн. Үнэмлэхүй утга буюу хоосон чанарыг оносон билиг байх, байхгүйн тус эрдэм болоод гэм эргүү зэргийг үлэмж үзэхүйн үест номнох тул энд бичсэнгүй, зарим хэсгээс өчүүхэн өгүүлж үйлдсү.

Эхлээд тус эрдмийг заах. Энэ болоод хойдийн эрдэм бүгдийг язгуур болох талаар Нагаржунай гэгээн бээр:

Олсон ба олох эрдэм эдгээр
Бүгдийн язгуур нь билиг мөн.
Тэр мэт хоёуланг бүтээхийн тухайд
Билгийг баттай барьж үйлдэх

Номын утгыг ухаарах ба нирваанд
Хүрэхийн их орон нь ухаан мөн
Тиймээс эхлээд биширэх сэтгэлээр
Их ээж- ухааныг бариарай хэмээжээ.

Билиг ухаан бол өглөг тэргүүтэн таван мөрийн нүд нь болж өгдөг. *"Хураангуй"*-гаас:

Алин цагт билгээр батад эзлэгдвээс
Тэр цагт нүдээ олж өөрийн нэрээ мэдэх
Үлгэрлэвээс зургаа зурчихсан ч нүд гаргахгүй аваас
Хэдүй нүд зурах хүртэл үнэ хүрэхгүйтэй адил хэмээжээ.

Бусад эрдэм хэрэгтэй ёс. Сайн алтаар бүтээсэн ялгамжаат чимгэнд индранил зэргийн хээгээр хээлэхэд урьдныхаасаа ч илүү сайхан, сэтгэл булаам болдогтой адилаар "өглөгөөс бясалгал хүртэлх таван алтан чимгийг", мэдэх,мэдэхгүй явдлыг сайтар ялгагч "билиг оюуны индранилын хээ хуартай" барилдуулваас машид сонин гайхамшигт болдог. Үгээр л өглөг тэргүүтэн тавыг асар сайнаар бүтээнэ.

Дотоод ухаан нь нүд тэргүүтэн таван эрхтний орноо оршиж, алдаа гэм, тус эрдмийг тус тус ялгаж, оруулж буцааж үйлдэхтэй адил. Энэ талаар Балдан Баву бээр:

Өглөг тэргүүтний буян тэдгээр
Итгэлт билиг сэлттэй үлэмж хүчтэй болох
Сайн алтан чимэг элдэв зүйлийг
Их эрдэнээр хээлвээс тунгалаг гэрэлт болох

Тус тусын утгат тэдгээрийн эрдэм чадлыг
Энэ л их ухаанаар бүтээх
Эрхтэн өөр өөрийн орны ялгааг
Бусдын чадалт сэтгэлээр тодорхой үзүүлэх адил хэмээжээ.

Тэрчлэн сүсэглэх зэрэг бусад эрхтэнд ч ухаан билиг эрхэм билээ. Итгэлт билиг байх аваас өглөг өгөх, сүслэх бишрэхийн болон харамлах зэргийн гэм, эрдмийг сайтар ялган мэдэж, нисваанисаа барах, эрдмийг арвижуулахын арганаа мэргэжих билээ.

Сүсэг тэргүүтний эрхтэнээ хэзээд л
Эрхтэн бусдад ялгалгүй ухаан билиг эрхэм
Итгэлт тэрээр тэдний гэм эрдмийг таних тул
Нисваанисаа барахын ёсны мэргэн болох хэмээжээ.

Бодисадва бээр гуйлгачинд махаа өгөхдөө эмийн модноос авах адилаар омогших ба шантрах мятрах зэргээр буцахгүй орох зэрэг нь хоосон чанарыг ухаанаар илт болгоосны үр билээ. Сансар нирваны доройтлыг онох ухаанаар, шагшаавад бусдын тусыг бүтээх тул шагшаавадыг асар ариун болгоно. Үл тэсэх ба тэсвэрлэхийн гэм, эрдэм зэргийг ухаанаар л оножбайж, сэтгэлээ номхотгохдоо буруу бүтээл болон зовлонгоор үл булаагдана. Ухаанаар, алив хичээл шамдал туурвихын суурийг сайтар мэдэж, түүнийг туурвиснаар газрын ахицаа их гарна.

Хоосон чанарын утганаа орших бясалгалын дээд амгалан гэдэг ухааны ёсноо суурилсан ухаан билгээс бүтэх тул, өглөг тэргүүтэн тавыг төгс төгөлдөр болох нь ухаан билигт л харгалзах буюу.

Ухааны нүдийг тодруулан тийн ялгаваас
Бодисадва өөрийн махаа өгөвч
Эмийг мод мэт тийн эс харамлах буюу
Өндөрт болоод доошлон унах зүйлгүй хэмээсэн ба

Өөрийн тусын төлөө шагшаавад эс бүтээх нь
Ухаантан сансрын гяндангийн гэмийг мэдсэнийх
Түүнээс хамаг ертөнцийн тусын төлөө сүслэх тул
Сансрын тухайд бүтээхгүйг хэлээд яах хэмээсэн ба

Ухаантан нарыг хорлох хорлогч байсан ч
Тэсвэрийн эрдмийг олсон тул үл хорлох
Машид номхорч сурсан зааны манлай
Элдэв үйлийн ялгамжаа олон ч тэсэх адил

Ганцхан хичээж зүтгэх алжаалын туйлыг
Ухаантай нөхөр лүүлж тэтгэвээс их хэрэг бүтэх хэмээсэн ба,

Тэр адил амгалан баясгалан төгс бясалгал
Гэм хураасан их алдаагаар халхлагдах бий
Мөр алгасах ухааны ёсноо шүтэх
Доод төрөлхтөн сэтгэлдээ яаж бүтээх хэмээжээ.

Харштай мэт үзэгдэх хоёр эрдмийг төгөлдөр ухаантан харшилгүй бүтээх нь ухааны хүч буюу, бодисадва нар дөрвөн тивийг эрхшээгч Хүрдэн

эргүүлэгч хаан болсон ч, хүслийн эрдмийн эрхнээ одохгүй байх нь ухаант түшмэдтэй байсны хүчээр болой.

Тэрчлэн амьтныг сэтгэлд зохистойд үзэх асрахуй сэтгэл хүчтэй хатуу байвч, тачаах шуналтай өчүүхэн ч ижилсэхгүй байх, амьтны зовлонд үл тэсэх нигүүлсэхүй хүчтэй хатуу, өнө удаан байвч, уйтгарт дарагдаж, буянд үл дурлах залхуу төрөхгүй байх, цаглашгүй баясгалан төгс авч, сэтгэл зоригдолоос муруйж хазайх алгасралгүй байх, тэгш агуулах амгаланд үргэлжид оршивч, амьтны тусаас нэг ч агшин үл алгасрах зэрэг бүгд ухааны чадлаас болно. Ийнхүү ижилхэн чадалт бүтээлийн тотгорыг ухаан билгээр хорьдог мөн. Тэр талаар:

Эрхтэний орон вишайд тэнгэрийн хив мэт дурайвч
Хаан төрийн эзэн эрдэм төгс бодисадва нар
Ёс бусын араншинд урвуулахгүй онох нь
Ухаант эрдэм төгс түшмэдийн хүч
Бусдад туслахын агаар нэгэн асрахуй сэтгэлтэн
Хүсэл шуналаа юугаа төгс тэвчих ба
Бусдын зовлонд үл тэсэх нигүйлсэхүйгээ
Гасланг үүрэх залхуугаар доошлуулахгүй байх

Дээдийн баясгалан төгс боловч үнэхээр үл алгасрах ба
Амьтны тусаас үл алгасарч, ихэд тэгш агуулах ба
Эрдэм тэдгээр болон тэдгээрийн ерөндөг мөр зэргийг
Их ухаанаар хориж, бүтээх нь үзэсгэлэнтэй

Мөн *"Магтваас зохист магтаал"*-аас:

Үнэмлэхүй номыг орхин зохиолгүй
Янагуухи лугаа даган зохилдох

хэмээсэн мэт "бэлгэст барих зоригдохуун нь тоосны төдий ч үл бүтэх"-ийг онох их магадлалаар олдох үнэмлэхүй номын чанарыг орхилгүйгээр, гадаад, дотоодын учир шалтгаанаас, үр дагаварууд тус тус гарахыг онох магадлалаар ёроолоос олдох янагуухитай харшлахгүй даган зохилдох мөн. Бусад лугаа бол машид харшилавч, ухаан лугаа үл харшилан зохилдох. Мөн түүнээс:

Зөвшөөрөх, хориглох зэрэгтэй таны зарлигыг,
Заримууд нэг юм шиг ухаарах
Заримууд магадалж үл чадах буюу
Янагш чинагш харшилах мэт болович тийм бус болой

хэмээн айлдсан мэт дээд, доод хөлгөнд ба, судар, дандрын хоёуланд зөвшөөрсөн, хориглосон харилцан адилгүй олон тохиолдоно. Тэдгээрийг нэг бодгаль анхааран авахад хоёр шинж буюу. Агуу ужим эрхэм зарлигийн утгыг эрж явахад, ухааны чадал хүрэхгүй мунхагт харшлавч, мэргэн ухаантнаа үл харшилах нь ухааны чадлаас болно.

Ухаангүй нэгнээ харшлах ба ухаантнаа харшлахгүй байх тэр мэтээр хэмжээлшгүй олон ч, хоёр үнэний агуулгад болоод, эрхэм зарлигт инагш чинагш зөвшөөрсөн, хорисон олон зүйл байдаг ч, таалал утгыг харшлуулалгүй онох нь ухааны чадал хэмээж, оюун ухааныг ханьцашгүй ихээр сайшаасан буй.

Товчилвоос, ухаанаас хамаг эрдэм төрөх тухай:

Хүүгээ асрах эх мэт мэдэх ухаанаас
Тэр адил хотол чуулган төрөх гайхамшигт
Бурханы арван хүч чадлын манлай
Ханьцашгүй хамаг дээд бүгд ба,

Эрдмийн бусад чуулган бүгдээр
Энэ адилын ухааны үндэснээ шүтэж гарах
Ертөнцийн ид хав, хүү сангийн дээд буюу
Нүд болсон шастар ном юу байгаа бүхэн

Огоот аврагч, эрдэм ухаан, ид шид
Сайтар жигдрэх юмсын тус тусын ялгамжаа
Олон зүйлийн тоо тооцоо, түүх цадигууд зэргүүд
Ертөнцөд тустай байдал тэр болоод тэр гээд

Бодисадвын их хүчтэн нарт заан үзүүлсэн
Энэ бүгд ухааны хүчнээс гарах хэмээжээ.

Ухаан муутай байхын гэм алдааны талаар, өглөг тэргүүтэн нүдгүй мэт болно гээд *"Хураангуй"*-гаас:

Сая живаа нүдгүй болсон харалган тэд
Замаа үл мэдэх тул,хот балгад руу яахин орох
Билиг үгүй аваас нүдгүй таван барамид
Баримжаагүй тул, бодийг мэдэж чадахгүй мөн хэмээжээ.

Тиймд өглөг тэргүүтэн сайтар боловсрохгүй, улмаар үнэмлэхүй үзлийг ч олж чадахгүй.

Ухаангүй аваас үрийг чухалчлавч
Өглөгийн чанар үл боловсрох
Бусдын тусад өглөг дээд хэмээн айлдсан
Үлдсэнийг эндүүрэлгүй аривжуулах хэргийг бүтээх мөн хэмээсэн ба,
Билгийн гэгээгээр мунхагаа арилгахгүй бол
Ёс суртахуун ч гэгээн ариун болохгйш
Их зонхи ухаангүй аваас, ёс суртахуун
Сэтгэлийн гэмээр, нисваанисын булингарт болох хэмээсэн

Буруу ухааны гэмээр сэтгэл булингартах
Тэсвэрийн эрдэм түүнээ үл орших буюу
Сайн мууг ялгахдаа үл баясах ёсыг хадгалах
Эрдэмгүй хаан алдарших адил хэмээсэн ба

Мэргэд нарыг өргөмжлөн сайшаах буюу
Түүнээс нарийн гүн бусад үгүй тул
Хүслийн гэмээр үргэлж түйтгэрлэгдэлгүй
Сэтгэлийн мөрийг шулуутгаж ухаантай яв хэмээсэн ба,.

Ухааны ёсноо үл хичээх сэтгэлийг агуулваас
Түүний үзэл бодол баттай сайжрахгүй хэмээжээ.

Хаанд алдарших гэдэг эрдэмгүй хаан нэг л удаа алдаршихаас цаашид доройтон буурдаг. Тиймд мунхаг эндүүрлийн харанхуйд ухааны их гэрэл мандах хүртэл буцахгүй байна. Тэр хэзээ мандсан цагт буцах буюу ухаан төрүүлэхийн ямар хүч чадал байгаагаар шамдах хэрэгтэй.

Түмэн гэрэлт наран мандахын цагт
Амьтны сэтгэлийг халхалсан алив мунхаг болон
Ухааны гэрэл гэгээний их хүч гарахад
Хамаг бүгд арилж нэр төдий үлдэх хэмээсэн ба,

Тиймд бүгд миний хүч чадалд тулах тул
Тэрхүү оюун ухааны ёсноо шамдаарай

Мунхрах шалтгааны талаар. Муу нөхрийг шүтэх, залхуурах, алмайрах, их унтах, тус тус шинжлэхээс дургүйцэх, агуу явдалд үл сүсэглэх, мэдээгүй байж мэдлээ хэмээн омгорхох, буруу үзэл ихдэх, над шиг юм чадахгүй хэмээн шантрах, сайн мэргэдийг шүтэхээс дургүйцэх зэрэг нь мунхрахын үндэс болдог.

Залхуурах, алмайрах ба шүтвээс мууг шүтэх
Нойрны эрхэнд автах, үл шинжлэхийн авирт болох
Чадагчийн дээд билиг оюунд үл сүслэх
Буруу үзлийн омогт баригдаж утгыг мушгих ба

Өөрийгөө баримлах, доорд үзэх зэрэг шалтагаар
Мэргэд сайчуудыг үл шүтэх, үл сүсэглэх
Буруу атгаг сэжиг ихдэх, хор нэмэгдэх, буруyд үзэх нь
Мунхагаас үндэслэх мөн хэмээн айлджээ.

Тиймд шүтвээс зохист багшаа өргөн хүндэлж,
Ухаант болохын тул, сонсож мэдэхийг эрмэлз

хэмээсэн мэт мэргэдийг шүтэж чадалдаа тохирох нижгээд сонсголонг үйлдэх шаардлагатай. Тэр үгүй бөгөөс сонсохоос үүдсэн ухаан болоод санахаас үүдсэн ухаан үл төрнө. Тэр мэтээр бол юуг бясалгаад ч үл мэдэх л ирнэ. Сонсвоос түүний утгыг санана. Санаснаар санахаас үүдсэн ухаан төрнө. Түүгээр дамжиж бясалгалаас үүдэх бясалгал төрдөг учиртай. Балданбавуу бээр:

Бага сонссон, бясалгах ёсыг үл мэдэх харалган
Юу ч мэдэхгүй тэрээр, тэр бүхнийг яаж санах
Тиймд сонсохоор хичээж, түүний үндэснээс нь санан сэтгэж
Бясалгаваас, уужим ухаан төрнө хэмээсэн ба,

Майдар гэгээн бээр:

Гурван нөхрийг тийн атгаглах
Тэр нь мэдэгдэхүүний түйтгэр буюу
Харамлах зэрэг тийн атгаг
Тэдгээр нь нисваанисын түйтгэр болой

Ухаанаас ангид тэдгээрийг
Тэвчихээс ангид аргагүй тул
Эрхэм ухаан түүний суурь
Сонсох мөн тул сонсох эрхэм хэмээжээ.

"Суртгаалын хураангуй"-гаас:

Тэсвэрлэн сонсохыг эхлээд үйлдэх,
Чингээд аглаг ойд орших ба,
Тэгш агуулах бясалгалд хичээн шамдаж үйлд хэмээсэн ба,

"Өөрийн тайлбар"-аас: "тэсвэргүй байх гэдэг бэрхшээлээс залхаж, дааж давах чадваргүй болсон байдаг тул, сонсох зэргийн хичээл шамдал доройтсон байдаг. Сонсголон эс төгс тул, бясалгах арга болон нисваанисаа арилгах аргыг мэдэхгүй болдог. Иймийн тулд уйдалгүйгээр, сонсохоор тэмүүлж үйлдээрэй" хэмээжээ.

"Сэрдмэдийн хөвгүүн айлтгасан"-аас: "Тийнхүү язгуурын хөвгүүн сонсголон төгөлдөр аваас, ухаан төрөх мөн. Ухаан лугаа төгөлдөр аваас, нисваанис машид амарлих болно. Нисваанис үгүй аваас, шумнас чөлөө олохгүй болой" хэмээжээ.

Тиймд номыг ёсчлон бүтээхээр хүсэгч нарт, мөрийн дээд амин сүнс сайн ялгаж мэдэх билиг ухааныг хөгжүүлэх ханьцашгүй үндэс болсон, хиргүй эрхэм зарлиг болоод шастар номыг олонтаа сонсох шаардлагатай хэмээн олон эш ном, ухаанаар айлдсан бий. Гэвч тэр хэрэгтэй гэчихээд, үл бүтээвээс энэ нь бясалгал анхааран авахын үест, тус тус онох ухаанаар шинжлэх бясалгал хийх шаардлага гарахад юу ч мэдэж чадахгүй болно. Үүний дээр хэрэггүй, шаардлагагүй хэмээх чанх буруугаар ойлгох төдий гэм алдаа ч гарна. Өөрийгөө сайн болгоё гэж хүсвэл, тэр зүйлээ хор адил тэвчих ёстой.

Налжорва чэнбу гэгээнээс: "Жову гэгээн бээр, хамгийг болгоогчийн хутаг бүтээхдээ сарлагийн ачмаг төдий боть ботиор заана гээгүй ч, гарын алганы толио төдийг зааж ухааруулж чадна. Заахгүй бол дэмий нуугаад юу хийх билээ." гэжээ.

Пүчинва бээр, "Зарлигийн ботийг задлаж нээгээд дэрэн дээрээ тавьж бай.Бид нар суралцаж байгаа тул, үзэл онол олоогүй ч энэ бүхнийг сайшааж үзээрэй. Ном мэдэхгүй ч хэрхэн үйлдэхийг асууж байгаарай" хэмээн айлдсан буй.

Жан-а-ва багшийн шавь бээр, Бодава гэгээнийг ойртон морилохын үест, "та амар сайн байна уу" гэж гурвантаа айлтгаж өгүүлсэнд, "Буяны садан огторгуйг бүрхсэн шороо мэт байгаа тул бусдад горилохын хэрэггүй, үндэс номын тайлбарыг улайтал эвдэж үзэх хэрэггүй учир номын ажил хэрэггүй, үйлийн үрийг бодож санах хэрэггүй тул сэтгэл амар амгалантай, энэ тарниар энэ үйлийг бүтээх тул олноор цэнгэлтэй гэцгээж, жаргалтай суугаа биз дээ, та нар минь" хэмээсэн (гэмийг өгүүлсэн захиас үг-орч.) гэдэг.

Шарава гэгээнээс: "Бурхан болоогүй л бол, ном сургууль төгсөх учиргүй, бурхан болоход л төгсөх мөн" хэмээжээ. Гамбава гэгээнээс: "Ном бүтээхэд юм мэдэх хэрэгтэй.Өөрөө муу бол энэ амьтан биднийг сонсох нь багадаж буцах гэм гарна. Шамдавч мэдэхийн хэрэг юун гэвэл их гэмтэй шүү.Номд шамдаж байж ухаарч мэдэх ёстой. Энэхүү богинохон насанд төгс сурч амжихгүй тул чөлөө учралтай боломжоо завсарлаж алдалгүй, үргэлж тасралтгүй ном сонсож үйлдэхийг сана. Бясалгалчинд хэрэггүй, номлогчид хэрэгтэй хэмээвээс, тэрхүү номлогчид нүгэлд унахын гэм гарна. бясалгалчинд ч хэрэгтэй" гэж айлдсан буй.

Тиймд тэр мэт бүтээл туурвихад ухаан болоод түүний үндэс болсон сонсох явдал зайлшгүй хэрэгтэйг машид сайн магадлах хэрэгтэй. Энэ нь, бясалгалын үест шинжлэх бясалгал хэрэгтэйг эс мэдвээс, түүнд хүрэхэд маш бэрхтэй болно гэсэн үг. Хатуужил хүсэх аймаг савыг баригч нэгэн бээр, бясалгалын удиртгал төдий юм уу, жинхэнэ увдис болголгүй "арын уул адил" ухаарах ч бий.

Ийм учраас өөрөө түргэнээ бурханы хутагийг бүтээх хэрэгтэй. Бурханы номыг сонсох хэрэгтэй гэчихээд шашнаа туслах болон бүтээлчин хоёрыг тус тус салгаж үзвээс ихэд хайш яайш харшуулан өгүүлэгч болох вий.

"Дээдийн номон (шашин) эшийн болон бүтээлийн ном хоёроос өөр бусадгүй. Эхнийх нь бүтээх ёсыг мэдүүлж үйлдэгч мөн. Удаах нь мэдсэн зүйлээ гарын авлаганд буулгагч мөн." Тиймээс бүтээх номоо эндүүрэлгүй ухаарах тэрээр, дээдийн номыг баригчийн эрхэм болно. Учир нь бүтээлийн номыг эндүүрэлгүй барина гэдэг эшийн номоог эндүүрэлгүй ухаарсанд харгалздаг байна. Өмнө нь олон эш ном үзэж мэдэж байж, бясалгахын үест тэдгээрийн утгыг бүтээх хэрэгтэй умартаж болохгүй учиртай.

Эхнээс мэдээгүй ч, шантарч мятралгүй ухаандаа тааруулан их, багаар сонсох үеийг тааруулан хичээ. Энэ нь сонсохоо нэг янзаар үйлдэх, бүтээлээ

нөгөө байдлаар үйлд гэсэн үг биш. Алин бүтээх ёстой тэр л орноо сонсох санахыг үйлдэх хэрэгтэй тул, ганц нэг зүгийг барилгүй, мөрийн хувь төгс бүрдсэн, бодисадвын үйлийг анхдагчын бясалгах мөрийн зэрэг нижгээдийг баттай шүтэх шаардлагатай.

Ухааны ир чадал бага байх үест тэр төдийгээр бясалгана.. Ухааны ир чадал нэмэгдэх юмуу, эхлээд бага багаар бясалгасаар их болохын үест, мөрийн зэргийг ахиулан дээшлүүлж, хиргүй эрхэм зарлиг болоод таалалын тайлбар лугаа барилдуулж оруулах тул, тусгай сонсголонг эрэлцэх шаардлагагүй.

Тиймд эндүүрэггүй, төгс төгөлдөр увдис аваас, товч хураангуй байсан ч, судар, тарни болоод, дээд доод хөлгөн бүгдийн мөрийг мөрийн цээр хорио бүгдийг багтаасан байдаг. Дэлгэрэнгүйг тайлбарлахад ном бүгдэд ухаарч чадах нэгэн хэрэгтэй учир, тэр адилыг олох хүртэл бясалгалын ганц нэг талыг нэхэж олж болох биз.

Гэвч номын бие бүрэн гүйцсэн бясалгалын аньснаа магад таниж мэдэж чадахгүй. Иймд дээд буяны садан ба нөхрийг шүтэх ба ам авсан ариун санваар шагшаавадыг суурь болгож, дахин дахин увдисыг сонсож, дөрвөн тун хэсэгт хувааж, ухааны зоригдохуун / вишай/ болгож судлаарай.

Багш болоод бурханаа хүчтэйгээр соёрхол талбиж, буяныг хураах, нүглээ арилгахын тулд олон талаас үндсийг бүрдүүлж шамдваас, түүнээс улбаалан ухааны чадвар дээш дээш аривжих магад суурь тавигдана.

Урьдын дээдэс нараас: "Урьд сонссон номоо ухаандаа шигтгэн, шигтгэн байж, дахин дахин дурдан санасаар, ухаарч, оножшаардлагатай. Номоо марталгүйгээр сэтгэлдээ дагнан барьсан төдийгээр, сурах зүйлээс хоцроно гэж үгүй.

Дээд бясалгалчид дээд сайн багш болох ба дунд бясалгалчид дунд багш болно. Хэдий чинээ бясалгаж чадах төдий чинээ номын танин мэдэхүй дээшилдэг жамтай. Тэр мэтийг санаж, магадлэх мэдэл батжиж байтал, "нүгэл буяны санаа бодол бүгд атгаг тул тэвчигдэхүүн болно" гэж хилэнцэт нөхөр өгүүлвэл, "ном тийн үл зарлиглав, буяны садан тэр мэт болгоогүй" хэмээн түүний амнаа яруу бус нэгийг буулгаарай. Чингэхгүй сүсэглээд байвал, ганц нэг сэрэмж байвч, ухаангүй түүний уйлах амыг харж нэг уйлах, дошигрох амыг харж нэг дошигрох ба, /бурантагтай тэмээ шиг- орч./ юу хэлсэн үнэн гээд, аль чирсэн газар руу чирэгдэн одох болюу" хэмээн зарлиглажээ.

в/ Билгийн тийн ялгалд гурав:

/1/ Үнэмлэхүйг онох билиг

/2/ Янагуухийг онох билиг

/3/ Амьтны тусыг үйлдэхийг онох билиг болой.

/1/ Үнэмлэхүйг онох билиг. "Би-үгүй" буюу хоосон чанарыг донжийн үүднээс болон илт болгоохын үүднээс онох болой.

/2/ Янагуухийг онох билиг. Ухааны таван орноо мэргэжсэн ухаан. *"Судрын аймгийн чимэг"*-ээс:

Ухааны таван орноо хичээн эс үйлдвээс
Дээд хутагт боловч, хамгийг болгоогч үл болох
Тиймд бусдыг эслэн таслах,даган барих ба
Өөрөө бүгдийг мэдэхийн тухайд түүнээ шамдаж үйлдэх

хэмээсэн мэт, дээдийн номын сүсэгтэн бус нарт эслэн таслахын (ойлгуулах-орч.) тулд дуун болоод учир шалтгааны ухаанд, сүсэгтэн нарт туслахын тул урлахуй болоод тэжээхүй (анагаах) ухаанд, өөрөө бүгдийг мэдэхийн тулд дотоод ухаанд суралцах нь өвөрмөц хэрэгцээ шаардлага болдог.

/3/ Амьтны тусыг үйлдэхийг онох билиг. Хамаг амьтны энэ насны болоод хойд насны хэргийг үнэн зөвөөр бүтээх ёсыг мэдэх болой.

г/ Бүтээхийн үест хэрхэн үйлдэх. Эдгээр гурван билгийг төрүүлэхийн үест дээд зургаа лугаа төгс буюу зургаан барамид лугаа барилдуулан үйлдэх мөн. Өөрөө түүнээ оршож, бусдыг ухаантай болгох нь ухааны өглөх болох ба бусад нь урьд номносонтой адил.

д/ Тэдгээрийн утгын хураангуй. Хоосон чанарыг оносон ухаан байвч бодь сэтгэлгүй бөгөөс, тэр нь бодисадвын явдал үл болох тул явдлын суурь шүтээн болсон бодь сэтгэлийг дээшитгэн хөгжүүлээд, дээд газрын билиг барамид зэргийг ерөөлийн орноо талбиж судлаад, ханьцашгүй бэлгэ билгийг төгс болгогч арга болсон гурван билгийг төрүүлэхүйеэ одооноос шамдаж, сонсохоор эрмэлзэх шаардлагатай.

Тийн эс үйлдвээс, суртгаалын эрхэм лүгээ харшилж, гэм уналаар дарагдах, бусад төрөлд ч олныг сонсохоос дургүйцэх зэргээр бодь сэтгэлийн суртгаалд сурч чадахгүйд хүрнэ. Иймд энэ насандаа ухаан суух аргад шамдаж, эндээс үл сурахын уналыг эвдвээс, бусад төрөлдөө ч

"Лагсан бээр айлтгасан"–наас зарлиг болсон мэт билгийн чинадад амар хялбар хүрч чадна.

Тэр мэт судар тандр хоёулангийн мөрийн гол мод болсон зургаан барамидаас бясалгал дияныг анхааран авахын эрэмбэ зэргийн үйл ажил өчүүхэн төдий үзэгдэнэ.Бусад тавыг анхааран авахын эрэмбэ зэрэг нилээд балархай үзэгдэх тул, тэдгээрийг анхааран авахын аньсыг хураангуйлж сайтар мэдэх ухаан төрүүлэхийн арга болгож өчүүхэн номносон болно. Үнэмлэхүй болоод янагуухид тухайлан зорисон ухааны мөн чанарт үлэмж үзэхүйг хэрхэн анхааран авахын эрэмбэ зэрэг болон бясалгал дияны мөн чанарт амарлингуйг анхааран авах эрэмбэ зэргийг гол ном шастаруудаас номносон дагуу утга учирыг дэлгэрүүлж дараа номнох болно.

Бодисадва нар аль ч ёсоор бурхан боллоо гэсэн зургаан барамидад шүтэж байж бурхан болох тул өнгөрсөн, ирээдүй, эдүүгээ заларсан бодисадва нарын зорчих ганц мөр хэмээн мэдэх учиртай. Эл зургаа нь цагаан зүгийн хамаг номын их далай мөн тул анхааран авахын ханьцашгүй аньст товчоо бөлгөө. *"Бодийн газар"*-аас: "Зургаан барамид эдгээрээр ханьцашгүй туулсан бодь хутгийг олж үйлдэх бодисадва нар бээр, цагаан зүгийн номын их мөрөн, цагаан номын их далай хэмээх ба, хамаг амьтан бүгдийн хамаг сайн хотол чуулганы үндэс ихээс их эрдэнийн өглөг буян болой. Тэр мэт тэдгээрээр бинавадын болоод бэлгэ билгийн буяныг үнэхээр хэмжээлшгүй бүтээх ба, энэ адилын бусад хаана ч үгүй болой" хэмээжээ.



(б) Бусдын үндсийг боловсруулан үйлдэгч дөрвөн хураангуйд таван зүйл:

1/ Дөрвөн хураангуйн мөн чанар
2/ Дөрөвт хураахын учир шалтгаан
3/ Дөрвөн хураангуйн чадал
4/ Нөхдийг хураасан тул тэднийг шүтэх хэрэгцээ
5/ Өчүүхэн дэлгэрэнгүй өгүүлэх

1/ Дөрвөн хураангуйн мөн чанар. (1)"Өглөг өгөх" нь дээр барамидын үест номносон лугаа адил. (2)"Яруу өгүүлэх" гэдэг шавь нарт барамидыг заах болой. (3)"Тусыг хүргэх" гэдэг нь хэрхэн заасан утгыг хэрэгжүүлэхээр шавь нарыг оруулах буюу үнэхээр авахуулан оруулах болой. (4)"Утга зохилдох" гэдэг бусдыг оруулсан тэр утганаа өөрөө ч зохилдон суралцах мөн. *"Судрын аймгийн чимэг"*-ээс:

Өглөг нь адил ба түүнийг заах авахуй яа орох
Өөрөө дагнан орох зэргээр
Яруу өгүүлэх ба утгыг үйлдэгч ба
Утга зохилдон ямагтад хүсэх мөн хэмээжээ.

2/ Дөрөвт хураахын учир шалтгаан. Юуны тул дөрвөн хураангуйд магадлав хэмээвээс, Нөхдөө буянд оруулахоор хурааж цуглуулж байгаадаа баярлах хэрэгтэй. Ер эд өлөгийн өглөг өгөх нь биенд нь туслаж буй хэрэг. Тийнхүү баярлаж, зам мөрд ороход эхлээд, хэрхэн юу хийхээ мэдэх шаардлагатай. Мөн яруу өгүүлж, ном номносоор үл мэдэх ба доноголзох байдлыг орхиж, утгыг зөвөөр барихаар оруулна.

Тийнхүү номын утгыг ойлгоод ирэхээр, тус хүргэж буян бүтээхээр ордог. Өөрөө бүтээж чадаагүй байж, бусдад орох, буцахын тийнхүү үйлдэх хэрэгтэй юм уу хэмээвээс номносу. Та өөрөө бүтээгээгүй хирнээ бусдад бүтээнэ гэж юунд хэлнэ вэ. Та өөрөө эдүгээ ч бусдаар засуулах хэрэгтэй гэчихээд бүтээлийг үл сонсох бий. Өөрөө бүтээнэ гэхэд чинь,алин шамдах буян түүнээ бид өөрсдөө ч оршиж үйлдэх тул, үүнийг бүтээвээс бидэнд тустай амгалантай болно гээд шинээр орох, орсон болвоос буцахгүй баттай болгохын тулд түүнээ утгыг зохицуулах шаардлагатай болдог.

Тусыг үйлдэх арга хийгээд
Барьж үйлдэх, орж үйлдэх ба
Тэрчлэн давтан орж үйлдэх
Дөрвөн бодит хураангуйд мэдэж үйлд хэмээжээ.

3/ Дөрвөн хураангуйн чадал. Эл дөрвөн хураангуйгаар шавь нарт ямар тус болох вэ хэмээвээс, Өглөг өгснөөр ном сонсохын сав болгон үйлдэх, номноочийг баярлуулан үйлдэхийн тулд болой. Яруу өгүүлэх гэдэг зааж буй утга түүндээ сүсэг оруулж үйлддэг. Өвөрмөц утгыг мэдэх ба доноголзлолыг тасалдаг. Утгыг эдэлсэнээр (мэдсэнээр) заасан дагуу бүтээж үйлдэнэ. Утга зохилдсоноор орсон түүнээсээ буцалтгүй өнө удаан бүтээж чадна.

Эхнийхээр бодитой сав болно
Хоёр дахь сүсэг орох
Гутгаараар бүтээх ба
Дөтгөөрөөр тийн судлах болой хэмээжээ.

4/ Нөхдийг хураасан тул тэднийг шүтэх хэрэгцээ. Хамаг шавийн хэрэг бүхнийг бүтээх сайн арга хэмээн бурхан зарлигласан тул, нөхөр хураахыг хүсэгч нар бүтээх хэрэгтэй.

Нөхрийг хураахыг хүсэгч нар
Эл ёсноо үнэхээр шүт
Бүгдийн хэргийг бүтээхэд
Сайн арга хэмээн машид сайшаажээ хэмээжээ.

5/ Өчүүхэн дэлгэрэнгүй өгүүлэх

Яруу өгүүлэхүйд хоёр: а.*Ертөнцийн ёс лугаа төгөлдөр яруу өгүүлэх нь.* Уур уцааргүй, нүүр царай тунгалаг мишэлзэнгүй зэргийг өмнө нь одуулаад амар мэндийг айлтгах зэргээр ертөнцийн ёсоор амьтныг баясган үйлдэнэ.

б. Үнэн дээд номыг заах зэргээр төгөлдөр яруу өгүүлэх нь. Сүслэх, шагшаавад, сонсох, өгөх ухааныг төрүүлэх зэргээс эхлэн тус, амгалангийн тухайд амьтнаа ном заах болой. Өөрийг чинь алсан дайснаа гэмтэйд үзэхгүй сэтгэлээр туст үгийг өгүүлэх ба ухаан машид доройтох сэтгэл

гансралгүй, уйсалгүй, зөнд хүлээн авагч номын яриаг өргүүлэн, буянд оруулна. Арга баширт амьтан багш дээдсийг хууран мэхэлсэн ч, уурлалгүй тустай үгийг өгүүлсэнээр өгүүлэхэд бэрхтэй ч яруу өгүүлэхүйд суралцдаг.

Үндэс эс боловсорсноо түйтгэрийг тэвчих ба сайн заяанд төрөхийн тухайд өмнө хийсэн номын өглөг ба шагшаавадын яриаг хийх, үндэс боловсрон, түйтгэрээс хагацсан, сэтгэл тэгш амгалан төгс нэгнээ үнэхээр дээд ном, хутагтын дөрвөн үнэнийг заана. Гэргийтэн болоод тойн хувраг, сэрэмжгүй нарт сэрэмжтэй байлгахын тул шаардах ба доноголзох сэтгэлийг арилгахын тул ном заан, яриа хөөрөө үйлдэхийг яруу өгүүлэхийн үүд болно.

"Тус хүргэх" гэдэг эс боловсорсныг боловсруулах ба боловсорсныг гэтэлгэж үйлдэх хоёр буй. Түүнээс гурав байдгаас:

Энэ насны тусыг барихаар орох нь: Төгс эдлэлийг бүтээх, сахих, арвижуулахын арга ном лугаа зохилдуулан үйлдэх болой.

Хойд насны тусыг барихаар орох нь: Төгс эдлэлийг тэвчээд, гуйлгаар амьдрах хувраг болох ба энэ бээр хойдхид магад амгалантай ч энэ насваа магадгүй.

Энэ хойд хоёр насны тусыг барихаар орох нь:. Гэргийтэн болоод хуврагад ертөнц болоод ертөнцөөс гэтлэх ба, шуналаас хагацуулахаар орох үүгээр энэ насваа бие, сэтгэлийн машид боловсролыг төрүүлж, хойно нь асар ариун тэнгэр ба нирвааныг олохын тулд болой.

"Тусыг хүргэхэд" илүү бэрхшээлтэй зүйлд орно. Өмнө нь буян язгуурыг хураагаагүй бол буяныг барихаар ороход бэрхтэй. Төгс эдлэл хотол их чуулган гэдэг сэрэмжгүй их суурьнд оршсоноор, тэдгээрт тус хүргэхэд эдлэхэд бэрхтэй бий. Тэрсүүдийн үзэл тэргүүтнээ дадаж сурсан болохоор энэ номд уурлах, мунхарч ухааныг үл ойлгох, тэдгээрт тус хүргэхэд бэрхтэй болдог. Тус хүргэхийн тухайд нялхасын ухаант нарыг эхлээд хялбархан ойлгох ном увдист оруулдаг. Дунд зэргийн ухаантнаа дунд увдис, их ухаантнаа гүн гүнзгий ном увдист оруулж үйлдэнэ.

"Утга зохилдох" гэдэг нь өөрөө цаад хүнтэйгээ тэнцүү юмуу, эсвэл илүүтэй байх ёстой. Тиймд эхлээд туслах ёстой амьтны тусыг сайтар тухайлан, сэтгэлээ амьтны тус бүтээхээс хагацуулахгүйгээр бэлтгэж өөрийгөө номхотгох хэрэгтэй. *"Цаглашгүй эрдмийг магтаал"*-аас:

Зарим нэг өөрөө номхороогүй байж ухаант үгийг өгүүлэвч
Өөртэй харшлах учир бусдыг номхоруулж чадахгүй хэмээн
Та бээр тунгааж, түүний тухайд амьтан бүхнийг таалалдаа багтааж
Түр нэг боловсроогүй бол өөрийгээ боловсруулахын тухайд хичээх мөн хэмээжээ.

Хураангуй дөрөвд эд өглөгөөр хураах ба номоор хураах хоёр бий. Өлгийн өглөг нь анхдугаар мөн. Үлдсэн гурав нь номоор хурааж буй хураагдахуун мөн. Тэр нь тухайлах ном, бүтээх ном, тийн судлах ном болно.

Эд өлөг болоод ном буюу
Тухайлах ном тэргүүтэн
Хоёр хураангуйн үүднээс
Дөрвөн хураангуйд үздэг хэмээжээ.

Энэ нь гурван цагийн бурхан бодисада бүгдээр бусдын тусыг зохиодог ганцхан зорчих мөр болно.

Хураах ба хураангуйлан үйлдэх ба
Алин эдүгээ хураан үйлдэх
Энэ бүхэн энэ адил тийн тул
Энэ л амьтныг боловсруулагч мөр хэмээжээ.

Ер нь бодисадвын явдал хэмжээлшгүй боловч их товчоо нь барамид болоод дөрвөн хураангуй мөн. Бодисадва өөрөө бурхан болох үндэс чуулганыг боловсруулан үйлдэх ба, амьтны үндсийг боловсруулах ажил үйлс тус тус зүйл тул, тэр хоёрыг барамид болон хураангуйгаар бүтээдэг.

Тэр талаар *"Бодийн газар"*-аас: "Барамид нугуудаар би бурханы номыг огоот боловсруулан үйлдэнэ. Хураангуйн бодит зүйлсээр хамаг амьтныг огоот боловсруулан үйлдэнэ. Товчлон хураангуйлваас, "Үүнийг бодисадва нарын буяны номын үйл гэж мэдээрэй" хэмээжээ. Тиймийн тулд хоёр зүйлээр байгуулах бөгөөд, дэлгэрэнгүйг мэдэхийг хүсвээс *"Бодийн газар"*-аас эрэлцээрэй. Тэдгээрт тэгш болоод дагах хоёроор хэрхэн бүтээх ёсыг Жову гэгээн бээр:

Бодисадвын явдал нь
Агуу их явдал зургаа барамид зэрэг
Тэгш агуулахуйгаас босох егүзэр бээр
Чуулганы энэ мөрийг баттай бүтээх

хэмээсэн мэт бодисадвын санваарыг барьсан үйлийг анхдагч бодисадва, чуулганы мөрд орших тэр бээр, тэгш ба дагаж орох алиныг үйлдэвч, зургаан барамидаас үл хэтрэх тул зургаан барамидыг тэгш агуулж судлах ба заримдаа даган орж судлаж, бясалгалын мөн чанарт амарлих сэтгэл болоод ухааны мөн чанарт үлэмж үзэхүй зарим нэгийг тэгш агуулан бясалгана.

Эхний гурван барамид болоод бясалгал, билгийн зарим хувийг даган орохуйд бясалгах болой. Хичээнгүйг ч тэгш ба дагах хоёуланд, тэсвэрийн зарим нэг хувь гүн гүнзгий магадлах зэрэг нь тэгш агуулахуйд багтана.

Жову гэгээн бээр:

Тэгш агуулахуйгаас босох цагт
Илбэ мэтийн найман жишээ мэтээр
Ном бүхний үзэлд дадуулж
Дагахын үзлийг судлахдаа

Арганаа суралцахыг эрхэмлэ.
Тэгш агуулахуйн цаг үргэлжид
Амарлингуй ба үлэмж үзэхүйн хувь тэнцүү тул
Түүний үргэлжлэлийг үлэмжид бясалга хэмээжээ.

Тэр мэтийн явдал машид сонин гайхамшиг гарсан, үйлдэхэд бэрхтэйг ухаан боловсроогүй нэгэн сонсоход сэтгэлд энэлгээ төрдөг ч, бодисадва нар ч анхнаасаа анхааран авч чадахгүй ч, мэдэж танихаар наад зах нь ерөөлийн орон болгож дадуулах аваас, хожим шамдал хичээлд харгалзалгүйгээр өөрийн аяар ордог болох тул дадуулах нь их хэрэгтэй. Шууд орж чадахгүй гээд тэдгээрт суралцах, дадах явдлаа огоорвол асар ариун зам мөрөөс машид холдон одох болно.

"Цаглашгүй эрдмийн магтаал"-д:

Алин сонсох цагт энэ ертөнцийн үйлд хорлолтой буюу
Алин та бээр, өнө удаан машид доройтох хэмээгээд үл эдлэх бий
Явдал тэдгээрт дадаж сураад ирэх цагтаа өөрөө аяндаа болох

Тиймд тэдгээр эрдмийг төгс дадуулж эс үйлдвээс арвижихад бэрх болно хэмээжээ. Тиймд бодисадва тангаргийг баригч нарт явдал мөрд суралцахгүй байхын арга байхгүй. Орохуйн бодь сэтгэлийг зан үйлийн авагч нар ч, суралцахаар тэмүүлж, судлахаар шамдаж, явдал мөрд

суралцах эрмэлзлэл хүслээ арвитгаваас, авсан тангараг улам батдах тул шамдаж бүтээх мөн.

Их төрөлхтний мөрийн зэргээс ерөөхүй бодь сэтгэлийг судлах ба бодисадвын ерөнхий явдалд суралцах мөрийн зэргийг номнон барив.

/Үргэлжлэл дараагийн дэвтэрт бий. Өлзий орших болтугай./



ХАВСРАЛТ

སྐྱེས་བུ་ཆེན་པོའི་ལམ་གྱི་རིམ་པ་སྦྱང་བ་ལས།

༡༽ ཐེག་ཆེན་གྱི་འཇུག་སྒོ་སེམས་བསྐྱེད་ཁོ་ནར་བསྟན་པ།—— 173

༢༽ བྱང་ཆུབ་སེམས་སྦྱང་བ་རིམ་པ་ལ་ཇོ་བོ་ནས་བརྒྱུད་པ་རྒྱུ་འབྲས་མན་ངག་བདུན།—— 184

༣༽ སྦྱང་བའི་འབྲས་བུ་སེམས་བསྐྱེད་ངེས་གཟུང་བ།—— 203

༤༽ ཞི་བ་ལྷའི་གཞུང་ལ་བརྟེན་ནས་སྦྱང་བ།—— 204

༥༽ སེམས་བསྐྱེད་ནས་སྤྱོད་པ་ལ་སློབ་ཚུལ།—— 232

༦༽ ཞར་ལ་གོ་རིམ་ངེས་པ།—— 255

སྤྱོད་པ་སྤྱིར་ལ་སློབ་པ་ལས།

༡༽ སྦྱིན་པ་ལ་སློབ་པ།—— 256

༢༽ ཚུལ་ཁྲིམས་ཀྱི་ཕར་ཕྱིན།—— 282

༣༽ བཟོད་པའི་ཕར་ཕྱིན།—— 289

༤༽ བརྩོན་འགྲུས་ཕར་ཕྱིན།—— 316

༥༽ བསམ་གཏན་ཕར་ཕྱིན།—— 339

༦༽ ཤེས་རབ་ཕར་ཕྱིན།—— 341

སྐྱེས་བུ་ཆེན་པོའི་ལམ་གྱི་རིམ་པ་ལས། སྨོན་སེམས་སྦྱོང་བ་དང་རྒྱལ་སྲས་ཀྱི་སྤྱོད་པ་སྤྱི་ལ་བསླབ་པའི་ཚུལ།

༄། །རྗེ་བཙུན་དམ་པ་ཐུགས་རྗེ་ཆེན་པོ་དང་ལྡན་པ་རྣམས་ཀྱི་ཞབས་ལ་གུས་པས་ཕྱག་འཚལ་ལོ། །དེ་ལྟར་འཁོར་བའི་ཉེས་དམིགས་སྒོ་སྣ་ཚོགས་ནས་རྒྱུན་རིང་དུ་བསྒོམས་པ་ལས་སྲིད་པ་ཐམས་ཅད་མེ་འབར་བའི་ཁྱིམས་ལྟར་མཐོང་སྟེ། ཉོན་མོངས་པ་དང་སྡུག་བསྔལ་ཉེ་བར་ཞི་བའི་ཐར་པ་ལ་ཐོབ་འདོད་ཀྱིས་ཡིད་ཀུན་ཏུ་གདུངས་པ་དེས། ལམ་བསླབ་པ་རིན་པོ་ཆེ་གསུམ་ལ་བསླབས་ན་འཁོར་བ་ལས་གྲོལ་བའི་ཐར་པ་འཐོབ་ཅིང་། དེ་ཡང་མཐོ་རིས་ཀྱི་དཔལ་ལྟར་སླར་ལྡོག་པ་ཡང་མ་ཡིན་མོད། འོན་ཀྱང་སྐྱོན་ཟད་པ་དང་ཡོན་ཏན་ཐོབ་པ་ཕྱོགས་རེ་བ་ཡིན་པས་རང་གི་དོན་མ་རྫོགས་ལ་དེ་ཉིད་ཀྱིས་ན་གཞན་གྱི་དོན་ཡང་ཉི་ཚེ······བར་ཟད་ཅིང་། མཐར་སངས་རྒྱས་ཀྱིས་བསྐུལ་ནས་ཐེག་ཆེན་དུ་འཇུག་དགོས་པས་ན། བློ་དང་ལྡན་པ་རྣམས་ཀྱིས་ནི་ཐོག་མ་ནས་ཐེག་པ་ཆེན་པོར་འཇུག་པར་རིགས་ཏེ། ཕར་ཕྱིན་བསྡུས་པ་ལས། འཇིག་རྟེན་དོན་སྒྲུབ་ཚུལ་ལ་མཐུ་མེད་པའི། །ཐེག་པ་གཉིས་པོ་གཏན་དུ་སྤངས་བྱས་ཤིང་། །ཐུབ་རྒྱལ་ཐེག་པ་སྙིང་རྗེས་བསྟན་པ་ལ། །གཞན་ཕན་རོ་གཅིག་རང་བཞིན་དེ་དག་འཇུག །ཅེས་དང་། བདེ་དང་མི་བདེ་ཀྱི་ལམ་འདྲར་བགྲངས་ཤིང་། །གཏི་

སྨུག་སྤྲིན་གྱིས་དམའ་བའི་འགྲོ་མཐོང་ན། །ལས་ཀྱི་དམ་པ་གཞན་དོན་དགའ་བོར་ཞིང་།།
རང་གི་དོན་ལ་དེ་ཀོ་ཙི་སྟེ་བརྩོན། །ཞེས་གསུངས་པ་ལྟར་རོ། །དེ་ལྟར་རང་ཉིད་སྲིད་
པའི་མཚོར་ལྷུང་བ་དང་འདྲ་བར་འགྲོ་བ་རྣམས་ཀྱང་བླང་དོར་འབྱེད་པའི་ཤེས་རབ་ཀྱི་མིག…
བྲལ་བས་ཉམ་ང་བ་དང་བྲལ་བའི་ཕྱོགས་སུ་བགྲོད་མི་ནུས་པར་གོམ་འགྲོས་འཁྱོར་བ་མཐོང…
ན། རྒྱལ་བའི་རིགས་དང་ལྡན་པ་རྣམས་གཞན་ལ་བརྩེ་བ་མེད་པ་དང་དེ་དག་གི་དོན་དུ་མི་
བརྩོན་པ་ནི་མི་རིགས་ཏེ། དེ་ཉིད་ལས། ཤེས་རབ་མིག་བྲལ་འགྲོས་འཁྱོར་གྱུར་པ་ལ། །
འཇིག་རྟེན་དོན་སྒྲུབ་རྒྱལ་བའི་རྒྱལ་རིགས་ན། །སྙིང་རྗེ་མི་སྐྱེད་སྐྱེས་བུ་གང་ཞིག་ཡོད། །
དེ་དག་སྡོངས་བསལ་བརྩོན་འགྲུས་སུ་མི་རྩོམ། །ཞེས་སོ། །འདི་ན་སྐྱེས་བུ་རྣམས་ཀྱི་
བདེ་བ་དང་བརྗོད་བག་དང་སྐྱེས་བུའི་ཚུལ་ནི་གཞན་གྱི་དོན་ཁུར་དུ་འཁྱེར་བ་ལ་བྱ་བར……
རིགས་ཏེ། རང་གི་དོན་ཙམ་ལ་དམིགས་པ་ནི་དུད་འགྲོ་རྣམས་དང་ཡང་ཐུན་མོང་བ་ཡིན་
པའི་ཕྱིར་རོ། །དེའི་ཕྱིར་ཆེན་པོ་རྣམས་ཀྱི་ངང་ཚུལ་ནི་གཞན་གྱི་ཕན་བདེ་ལ་མཐའ་གཅིག་
ཏུ་གཞོལ་བ་ཡིན་ཏེ། སློབ་མ་ལ་སྤྲིངས་པ་ལས། ཤིན་ཏུ་རྙེད་སླའི་རྩྭ་ཁམ་འགའ་ལྟ་ཕྲུགས
ཀྱང་རང་ཉིད་ཟ། །ཤིན་ཏུ་སྐོམ་པས་གདུངས་པའང་ཆུ་ཞིག་རྙེད་ན་དགའ་མགུར་འཐུང་།།
འདི་ན་སྐྱེས་བུ་གཞན་དོན་བྱེད་པར་བརྩོན་པ་གང་ཡིན་པ། །དེ་འདིའི་བརྗོད་བག་ཡིན་ཏེ་
དེ་བདེ་སྐྱེས་བུའི་ཚུལ་དེ་འཕགས། །ཉི་མ་རླབས་ཆེན་རྟ་ཞོན་རྒྱུ་བ་སྣང་བྱེད་གང་ཡིན་དང་།།
ཁུར་ལ་མི་རྟེག་ས་ཡིས་འཇིག་རྟེན་འདེགས་པ་གང་ཡིན་དེ། །རང་དོན་འགའ་མེད་ཆེན་པོ་
རྣམས་ཀྱི་རང་བཞིན་དེ་འདྲ་སྟེ། །དེ་དག་འཇིག་རྟེན་ཕན་དང་བདེ་བའི་རོ་ལ་གཅིག་ཏུ
གཞོལ། །ཞེས་སོ། །དེ་ལྟར་འགྲོ་བ་སྡུག་བསྔལ་གྱིས་ཀུན་ཏུ་གདུངས་པར་མཐོང་ནས་དེ་
དག་གི་དོན་དུ་བྲེལ་བ་ལ་སྐྱེས་བུ་ཞེས་བྱ་ལ་མཁས་པ་ཞེས་ཀྱང་དེ་ལ་བྱ་སྟེ། དེ་ཉིད་ལས།
འཇིག་རྟེན་མ་རིག་དུད་སྲིན་འཁྲིགས་པས་འགྲོ་བ་འཇུགས་གྱུར་པ། །སྡུག་བསྔལ་མེ་རབ་

འབར་བའི་ནང་དུ་དབང་མེད་ལྷུང་མཐོང་ནས། །ཐོད་ལ་མེ་མཆེད་འབར་བ་ལྟ་བུར་ཡིད་
ལ་བརྩོན་པ་གང་། །འདི་ན་དེ་དག་སྐྱེས་བུ་ཡིན་ཏེ་མཁས་པའང་དེ་དག་ཡིན། །ཞེས་
སོ། །དེའི་ཕྱིར་རང་གཞན་གྱི་ལེགས་པ་ཐམས་ཅད་ཀྱི་འབྱུང་གནས། རྒུད་པ་ཐམས་ཅད་
སེལ་བའི་སྨན། མཁས་པའི་སྐྱེ་བོ་ཀུན་གྱིས་བགྲོད་པའི་ལམ་ཆེན་པོ། མཐོང་བ་དང་ཐོས་
པ་དང་དྲན་པ་དང་རེག་པས་ཀྱང་འགྲོ་བ་ཀུན་གྱི་གསོས་སུ་འགྱུར་བ། གཞན་གྱི་དོན་དུ་
ཞུགས་པས་རང་གི་དོན་མ་ཚང་བ་མེད་པར་ཞར་ལ་འགྲུབ་པའི་ཐབས་མཁས་པ་ཆེན་པོ་དང་
ལྡན་པའི་ཐེག་པ་ཆེན་པོ་ལ་འཇུག་ཏུ་ཡོད་པ་ནི། ཀྱེ་མའོ་བདག་གིས་རྙེད་པ་ལེགས་པར་
ད་དོ་སྙམ་དུ་བསམས་ལ། སྐྱེས་བུའི་རྩལ་ཅི་ཡོད་ཀྱིས་ཐེག་པའི་མཆོག་འདིར་འཇུག་པར་
བྱའོ། །དེ་ཡང་ཕར་ཕྱིན་བསྡུས་པ་ལས། ཤེས་རབ་རྣམ་དག་མངོན་སྒྲུབ་ཐེག་པའི་མཆོག །
ཐུབ་ཆེན་ཐམས་ཅད་མཁྱེན་པ་དེ་ལས་འབྱུང་། །དེ་ནི་འཇིག་རྟེན་རྣམས་ཀྱི་མིག་བཞིན་
ནི། །འོད་ལྡན་ཉི་མ་ཤར་བའི་འོད་དང་འདྲ། །ཞེས་གསུངས་པ་ལྟར། སྒོ་སྣ་ཚོགས་
ནས་ཐེག་པ་ཆེན་པོའི་ཡོན་ཏན་མཐོང་བས་ཡིད་དྲངས་པའི་གུས་པ་ཆེན་པོ་བསྐྱེད་ནས………
འཇུག་པར་བྱའོ།།

དེ་ལྟར་ན་སྐྱེས་བུ་ཆེན་པོའི་ལམ་གྱི་རིམ་པ་ལ་བློ་སྦྱོང་བ་ལ་གསུམ། ཐེག་ཆེན་གྱི་འཇུག་
སྒོ་སེམས་བསྐྱེད་ཁོ་ནར་བསྟན་པ་དང་། སེམས་དེ་ཇི་ལྟར་བསྐྱེད་པའི་ཚུལ་དང་། སེམས་
བསྐྱེད་ནས་སྤྱོད་པ་ལ་སློབ་པའི་ཚུལ་ལོ། །དང་པོ་ནི། དེ་ལྟར་ཐེག་པ་ཆེན་པོ་ལ་འཇུག་
དགོས་ན་འཇུག་པའི་སྒོ་གང་ནས་ཡིན་སྙམ་ན། དེ་ལ་རྒྱལ་བས་ཕ་རོལ་ཏུ་ཕྱིན་པའི་ཐེག་པ་
ཆེན་པོ་དང་གསང་སྔགས་ཀྱི་ཐེག་པ་ཆེན་པོ་གཉིས་གསུངས་ཀྱི། དེ་ལས་གཞན་པའི་ཐེག་པ་
ཆེན་པོ་ནི་མེད་དོ། །དེ་གཉིས་གང་གི་སྒོར་འཇུག་ཀྱང་འཇུག་སྒོ་ནི་བྱང་ཆུབ་ཀྱི་སེམས་ཁོ་
ན་ཡིན་ཏེ། དེ་རྒྱུད་ལ་ནམ་སྐྱེས་པ་ན་གཞན་གང་ཡང་མ་སྐྱེས་ཀྱང་ཐེག་ཆེན་པར་འཇོག་པ་

ཡིན་ལ། དེ་དང་ནམ་བྲལ་བ་ན་སྟོང་པ་ཉིད་ཀྱི་རྟོགས་པ་ལ་སོགས་པའི་ཡོན་ཏན་ཅི་ཡོད་ཀྱང་ཉན་ཐོས་ལ་སོགས་པའི་སར་ལྟུང་ཞིང་། ཐེག་ཆེན་ལས་ཉམས་པ་ཡིན་པར་ཐེག་པ་ཆེན་པོ་བའི་གཞུང་དུ་མ་ལས་གསུངས་ཤིང་རིགས་པས་ཀྱང་འགྲུབ་པ་ཡིན་ནོ། །དེས་ན་དང་པོར་ཐེག་ཆེན་པར་ཆུད་པ་ཡང་། སེམས་དེ་བསྐྱེད་པ་ཙམ་གྱིས་འཇོག་ལ། ཕྱིས་ཐེག་ཆེན་པའི་ནང་ནས་འཐོན་པའང་དེ་དང་བྲལ་བ་ཙམ་གྱིས་འཇོག་པས་ན་ཐེག་ཆེན་པ་ནི……སེམས་དེ་ཡོད་མེད་ཀྱི་རྗེས་སུ་འགྲོ་ལྡོག་བྱེད་དོ། །དེ་ལྟར་ཡང་སྤྱོད་འཇུག་ལས། བྱང་ཆུབ་སེམས་སྐྱེས་གྱུར་ན་སྐད་ཅིག་གིས། །འཁོར་བའི་བཙོན་རར་བསྡམས་པའི་ཉམ་ཐག་རྣམས། །བདེར་གཤེགས་རྣམས་ཀྱི་སྲས་ཞེས་བརྗོད་བྱ་ཞིང་། །ཞེས་དང་། དེ་རིང་སངས་རྒྱས་རིགས་སུ་སྐྱེས། །སངས་རྒྱས་སྲས་སུ་ད་གྱུར་ཏོ། །ཞེས་སེམས་བསྐྱེད་མ་ཐག་ཏུ་རྒྱལ་སྲས་སུ་འགྲོ་བར་གསུངས་ལ། འཕགས་པ་བྱམས་པའི་རྣམ་པར་ཐར་བ་ལས་ཀྱང་། རིགས་ཀྱི་བུ་འདི་ལྟ་སྟེ་དཔེར་ན། རྡོ་རྗེ་རིན་པོ་ཆེ་ནི་ཆག་ཀྱང་གསེར་གྱི་རྒྱན་ཁྱད་པར་དུ་འཕགས་པ་ཐམས་ཅད་ཟིལ་གྱིས་གནོན་ཞིང་རྡོ་རྗེ་རིན་པོ་ཆེའི་མིང་ཡང་མི་འདོར་ལ་དབུལ་…བ་ཐམས་ཅད་ཀྱང་རྣམ་པར་ཟློག་གོ །རིགས་ཀྱི་བུ་དེ་བཞིན་དུ། ཐམས་ཅད་མཁྱེན་པར་སེམས་བསྐྱེད་པའི་རྡོ་རྗེ་རིན་པོ་ཆེ་ནན་ཏན་དང་བྲལ་ཡང་ཉན་ཐོས་དང་རང་སངས་རྒྱས་ཀྱི་…ཡོན་ཏན་གྱི་གསེར་གྱི་རྒྱན་ཐམས་ཅད་ཟིལ་གྱིས་གནོན་ཞིང་། བྱང་ཆུབ་སེམས་དཔའི་མིང་ཡང་མི་འདོར་ལ་འཁོར་བའི་དབུལ་བ་ཐམས་ཅད་ཀྱང་རྣམ་པར་ཟློག་གོ །ཞེས་སྤྱོད་པ་ལ་མ་བསླབས་ཀྱང་སེམས་དེ་ཡོད་ན་བྱང་ཆུབ་སེམས་དཔར་གསུངས་པ་དང་། མགོན་པོ་ཀླུ་སྒྲུབ་ཀྱིས་ཀྱང་། བདག་ཉིད་དང་ནི་འཇིག་རྟེན་འདིས། །བླ་མེད་བྱང་ཆུབ་ཐོབ་འདོད་ན། །དེ་ཡི་རྩ་བ་བྱང་ཆུབ་སེམས། །རི་དབང་རྒྱལ་པོ་ལྟར་བརྟན་དང་། །ཞེས་དང་། ལག་ན་རྡོ་རྗེ་དབང་བསྐུར་བའི་རྒྱུད་ལས་ཀྱང་། བྱང་ཆུབ་སེམས་དཔའ་ཆེན་པོ་གཟུངས་

སྔགས་ཆེན་པོའི་དཀྱིལ་འཁོར་ཤིན་ཏུ་རྒྱ་ཆེ་བ་འདི་དང་ཤིན་ཏུ་ཟབ་པ་འདི་དང་གཏིང……
དཔག་དཀའ་བ་དང་གསང་བ་བས་ཀྱང་ཆེས་གསང་བ་སེམས་ཅན་སྡིག་ཅན་རྣམས་ལ་བསྟན་
ཏུ་མི་རུང་བ་འདི་ནི་ལག་ན་རྡོ་རྗེ་ཁྱོད་ཀྱིས་ཤིན་ཏུ་དགོན་པ་ཞིག་སྨྲས་ཏེ། འདི་ནི་སྟོན་མ་
སོས་ན་འདི་སེམས་ཅན་ཇི་ལྟ་བུ་དག་ལ་བཤད་པར་བྱ། ལག་ན་རྡོ་རྗེས་སྨྲས་པ། འཇམ་
དཔལ་གང་དག་བྱང་ཆུབ་ཀྱི་སེམས་སྒོམ་པ་ལ་ཞུགས་པ་དང་གང་གི་ཚེ་དེ་དག་གི་བྱང་ཆུབ…
ཀྱི་སེམས་གྲུབ་པར་གྱུར་པ་དེའི་ཚེ། འཇམ་དཔལ་བྱང་ཆུབ་སེམས་དཔའི་སྤྱོད་པ་གསང་
སྔགས་ཀྱི་སྒོ་སྤྱོད་པའི་བྱང་ཆུབ་སེམས་དཔའ་དེ་དག་ཡེ་ཤེས་ཆེན་པོར་དབང་བསྐུར་བའི……
གསུངས་སྔགས་ཀྱི་དཀྱིལ་འཁོར་དུ་གཞུག་པར་བྱ་ཡི། གང་དག་གི་བྱང་ཆུབ་ཀྱི་སེམས་
རྫོགས་པར་མ་གྱུར་པ་དེ་དག་ནི་གཞུག་པར་མི་བྱ་སྟེ། དེ་དག་ནི་དཀྱིལ་འཁོར་ཡང་བལྟར་
མི་གཞུག་གོ །དེ་དག་ལ་ནི་ཕྱག་རྒྱ་དང་གསང་སྔགས་ཀྱང་བསྟན་པར་མི་བྱའོ། །ཞེས་
གསུངས་སོ། །དེས་ན་ཆོས་ཐེག་པ་ཆེན་པོའི་ཆོས་ཡིན་པས་མི་ཆོག་གི གང་ཟག་དེ་
ཐེག་པ་ཆེན་པོ་བར་ཆུད་པ་ཞིག་གལ་ཆེའོ། །ཐེག་ཆེན་པར་བྱེད་པའང་བྱང་ཆུབ་ཀྱི་སེམས་
ཉིད་ལ་རག་ལས་པས་ན། སེམས་དེ་གོ་བ་ཙམ་ལས་མེད་ན་ཐེག་ཆེན་པའང་དེ་དང་འདྲ་
འོ། སེམས་དེ་མཚན་ཉིད་ཚང་པ་ཞིག་ཡོད་ན་ཐེག་ཆེན་པའང་རྣམ་པར་དག་པ་ཞིག་འོང་
